




GaVaL.net



*Энэ номыг «Мөнхийн үсэг» ХХК  
ивээн тэтгэж хэвлүүлэв.*

ISBN 99929-6-096-5

---


**МОНГОЛ ОРНООР ЖУУЛЧЛАХ ЗУУН ЗАМ**

---

Зохиогч:	Монгол улсын гавьяат багш ШУ-ны доктор, профессор Ш.Шагдар
Редактор:	доктор, дэд профессор Ч.Батдэлгэр
Хэвлэлийн дизайн:	Ж.Батбаатар

Цаасны хэмжээ 13x19.5 см  
Зохиогчийн зөвшөөрөлгүй орчуулж буюу хэвлэж олшруулахыг хориглоно.

---



### Оршил

“Монгол орноор жуулчлах зуун зам” гэдэг энэ ном Монгол орны бүх аймаг, сумын байгальтай танилцахад Тань тусална.

Монгол орон бол **Төв Азийн их цөл, Сибирийн их хөвч тайга** хоёрын торгон зааг газарт оршдог учраас байгалийн эрс тэс онцлог нөхцөл бүрдсэн үзэсгэлэнт газар элбэгтэй болсоноос гадна хүн таруу суурьшдаг учраас байгалийн онгон төрх нь хэвээр хадгалагдан үлдсэн дэлхийн цөөн орны нэг. Үүнд: **Монголын өмнөд хэсгийн говь цөл нутаг, Дорнод хэсгийн хээр тал нутаг, Хэнтий, Хангай, Хөвсгөлийн уулсын их тайга** эдгээр болно.

Хүний аж ахуйн үйл ажиллагаанд өртөөгүй онгоноороо байгаа байгалийн эдгээр гурван төрх байдлыг монгол оронд үзэж болно. Уулын хурдан урсгалт болор тунгалаг гол горхи, рашаан усны амт, цэлмэг тэнгэрийн гайхам хөх цэнхэр өнгө, уул тал хээрийн агь ганганы анхилуун үнэр, цэн тогоруу, хүн галуу зэрэг түмэн зүйлийн шувуудын шуугиан чимээ, давхиад давхиад барагдахгүй их уул тал энэ бүхэн Таны мэдрэхүйн таван эрхтэнд нөлөөлөх Монголын байгалийн үнэн төрх болой.

Монгол орон бол тэр аяараа байгалийн музей билээ. Өөр хаана ч үзэж чадахгүй газарзүйн өвөрмөрц тогтоцыг Та монгол оронд үзнэ.

Монгол орон бол тэр аяараа амьтан, ургамлын хүрээлэн билээ. Дэлхийд өөр газар үзэхгүй ховор ургамал, амьтад жигүүртэн шувуудыг Та Монголд үзнэ. Монголын хээр тал, говь цөлд өдөр нь тарвага, зээр, гөрөөс тоолж, шөнийн тунгалаг цэлмэг тэнгэрт нь од тоолж болно. Товчоор хэлбэл Монгол орны байгалийн онгон зэрлэг нөхцөл байдал нь хүмүүсийн ялангуяа гадаадын хүмүүсийн сонирхлыг ихэд татдаг юм. Энэ бол Монголд аялан жуулчилж ирэгсэдийн сонирхлыг татдаг 1-р шалтгаан, учир холбогдол болно.

Ш.Шагдар.

Монгол орноор жуулчлах зуун зам

Монгол орон тэр аяараа түүхийн музей билээ. Түүх соёлын дурсгалт зүйл тааралдахгүй зам Монголд байхгүй. Гадаад дотоодын хүмүүсийн сонирхлыг ихэд татдаг 2-р шалтгаан, учир холбогдол орших Монголын түүх соёлын дурсгалыг 2 зүйлээр товч авч үзэж болох юм. Юу гэвэл; 1-рт хүн үүсэн бий болсон цагаас хойших бараг бүхий л нийгмийн түүх соёлын дурсгал Монгол оронд бий. 2-рт Монгол орон бол XIII-р зуунд тухайн үедээ нээгдээд байсан дэлхийн хуурай газрын тэн хагасыг байлдан дагуулан эзлэж байсан эзэн Чингисийн өлгий нутаг билээ. Эзэн Чингисийн өлгий нутгийг үзэхсэн гэж гадаадынхан их сонирхдог юм.

Монгол орон бол бэлчээрийн мал аж ахуйн орон билээ. Мянга, мянгаараа сүрэглэн багширах мал сүрэг бол танд үзүүлэх гэж цуглуулан хураасан сүрэг биш, байгаа нь л энэ. Бэлчээрийн мал аж ахуй эрхлэн амьдардаг монгол ард түмний ёс заншил, амьдрал ахуйтай Та танилцах болно. Энэ бол гадаадын хүмүүсийн Монголд ирэхсэн гэж хүсдэг сонирхлыг нь татах 3-р учир шалтгаан болох юм.

Монгол хүний зочломтгой чанарыг Та мэдрэх болно.  
Монголчууд таныг найр тавин хүндэтгэн угтах болно.  
Монголчууд Таныг ерөөл өргөн үдэх болно.

Энэ бүхэн бол монголын гайхамшигийн зөвхөн нэг хэсэг нь, Та Монголоор аялахдаа биеэрээ мэдрэх учраас олон юм ярих нь илүүц зүйл болох тул үүгээр өндөрлөв.

**Таны аяны алтан шар зам өлзийтэй байх болтугай!**

Монгол Улсын гавьяат багш,  
Монголын боловсролын шинжлэх  
ухааны академийн дэд ерөнхийлөгч,  
академич, шинжлэх ухааны доктор,  
профессор

Амбагайт Шаравын Шагдар

2003 оны 1-р сар



### УНШИГЧДЫН АНХААРАЛД

Энэ ном миний сүүлийн 60 шахам жилийн турш төр улсын буянаар эх орныхоо бүх аймаг болон бүх сумын нутгаар энэ номонд орсон бүх замын ихэнх буюу ойролцоогоор 80-аад мян.км зам туулан явах хугацаанд биеэр үзэж харсан, ажигласан, цуглуулж тэмдэглэсэн материалын дээжийн эмхтгэл болно. Монголын орноор аялан жуулчлахыг хүссэн дотоод гадаадын аялагчид, багш, оюутан, сурагчид, сонирхогч өргөн олонд зориулан энэ номыг бүтээв.

Монгол оронтой танилцулахад зориулагдсан аялалын 70 чиглэлийн зуугаад замыг багтаасан болно. Эдгээр чиглэлүүдийг хосолсон буюу дамжсан зам гаргаж болох бөгөөд тэгвэл аялах зам маш олон болно. Чухам үүнд зориулж аймгуудын бүх сумдын хоорондох зайг хүснэгтээр үзүүлэн ашиглахад дөхөмийг бодож аймгуудын газрын өнгөт зурагтай нэг нүүрэнд оруулав. Аяллын зам нь зөвхөн байгалийн байдалтай танилцах сэдэвчилсэн зам биш, байгаль, түүх соёлын дурсгалт зүйлийг үзэж болох нэгдсэн зам юм. Энэхүү номыг ашиглахад зориулж дараах зүйлийг зөвлөө.

1. Монгол орны байгалийн ямар байдалтай танилцах замаа сонгохын тулд эхлээд чиглэл бүрийн аялах зам, тайлбартай танилцана. Чиглэл бүрийн эхэнд аймгуудын товч танилцуулга оруулсан. Харин энэ чиглэлүүдийн ихэнхэд одоодоо аялал жуулчлалын тусгай бааз олныг байгуулж амжаагүй байгааг дурдая.
2. Замаа сонгоод аялалд гарахын өмнө чухам хаана явахад юу үзэж болохыг танилцуулгаас урьдчилан тодруулаарай.
3. Нутаг орны байдалтай тавтай танилцах нь зүйтэй гэж үзэж хугацааг голдуу 5-7 хоногоор бодож авсан. Гэвч хугацааг боломжоороо ихэсгэж, багасгаж болно.
4. Аялах зарим замын зайг авто замын сүлжээнээс авсан бөгөөд сүлжээнд байхгүйг ойролцоогоор авав.

Сумдын хооронд олон замтай учраас яс нэг тоогоор авахад бас төвөгтэйг дурдая. Аялах замын зайг аялах хугацаандаа тохируулж сунгаж, богиносгож болно. Явсан замаараа буцах шугаман биш өөр замаар ирэх тойрог зам гаргахыг бодов. Аяллын замд ороогүй нутгаар орьё гэвэл аль ойртсон замаасаа тэр хүссэн газраараа орж болно. Монгол оронд байгаль, түүхийн дурсгалт болон үзэсгэлэнт газар нутаг маш олон учраас тэр бүрийг энэ жижиг товхимолд багтаах аргагүйг ойлгоно биз. Энэ номын “Түүхийн хуудаснаас” гэсэн хэсэг болон түүхийн дурсгалт зарим зүйлийн тайлбарыг доктор Т.Намжил бичсэн болно.

5. Монгол орноор аялах замын дотор орсон улсын тусгай хамгаалалттай газар нутаг, түүхийн дурсгалт газраар аялахдаа тэдгээрийн хамгаалалтын хууль, дүрэм журмыг баримтлах нь зүйн хэрэг билээ.
6. Аяллын замд үзэх гол үзмэрүүдийг тайлбарт дугаарлан оруулав.
7. Аяласан замаасаа өөр замд шилжих замыг чиглэл бүрийн эцэст дурдаж өгөв.
8. Аймгуудын танилцуулгад орсон цаг уурын үзүүлэлтүүдийг олон жилийн дунджаар авав. Хүн амын тоог 2000 оныхоор, малын тоог 2002 эцсийн оны байдлаар авсан болно.
9. Дамжин өнгөрөх байдлыг харгалзан чиглэлүүдийг ойроос нь хол руу дугаарлав.
10. Том масштабын зураг хавсаргаагүй болохоор энэ номонд орсон аяллын зам нь усан замын мөн уулын, явган зэрэг спортын аялалд сайн гарын авлага болж чадахгүйг дурьдая.
11. Сэдэвчилсэн аяллаар үзэж болох зүйлсийн жагсаалтыг ард хавсралтад оруулав.
12. Улсын хамгаалалттай түүх соёлын 119 дурсгалын товч тайлбарыг зохих зохих замд нь оруулав.

13. ЮНЕСКО-гоос “Дэлхийн гайхамшигт үнэт зүйлс” зэрэглэлээр хамгаалалтад авсан байгаль, түүх соёлын 14 зүйлийн товч тайлбарыг мөн зохих замд нь оруулав.
14. Улсын тусгай хамгаалалттай газруудыг бүгдийг оруулав.
15. Манай улсын авто замын сүлжээний эхлэл 0. 00 цэгт зориулсан цагаан саарал гантиг хөшөө Улаанбаатар хотын Сүхбаатарын талбайн баруун захад Төв шуудангийн зүүн талд цэцэрлэгийн баруун хойд захад оршдог, харин замын тэмдэг нь түүнд ойрхон дөрвөн замын уулзварт бий 1-р чиглэлийн эхэнд байгаа зургийг үз. Алив хот суурин газрын хоорондох зай нь хоёр хотын доторх шуудангийн салбарын хоорондох зай байдаг билээ.
16. Зарим жуулчны бааз, зочид буудлын тухай зэрэг зарим чухал мэдээллийг 1-10 хавсралтаар үзүүлэв.

Номонд хэдийгээр 70 дугаартай зам байгаа боловч энэ замууд доторх А. Б. В гэхчлэн замын 40 гаруй хувилбар, өөр замд шилжих 200 гаруй хувилбаруудыг оруулж тооцвол нийт зам 300 гаруй дугаартай болох юм. Гэвч номоо өргөн олонд танил болсон **“Монгол орноор жуулчлах зуун зам”** гэдэг хуучин нэрээр нь нэрлэж гаргав.

Аялалд гарахын өмнө 11-р хавсралтад байгаа “Жуулчдад өгөх товч зөвлөмж”-ийг уншаарай.

Ш/Х-2005

Ш/С-48

Улаанбаатар 210648


Утас: 91157550

461110

E-mail: shagdar@hotmail.com

**Товчилсон үгс**

- Д.т.д - далайн төвшинээс дээш  
Мян - мянган  
Км - километр  
М - метр  
Дөр - дөрвөлжин  
МНТ - Монголын нууц товчоо  
ОУУН - Байгаль түүний нөөц баялагийг хамгаалах  
Олон Улсын Холбооны улаан ном  
ОУ - олон улсын  
УТХГ - Улсын тусгай хамгаалалттай газар  
МУН - Монголын улаан ном  
МОГ - Монголын онцлог газар  
См - сантиметр  
УИХ - Улсын Их Хурал  
Н - нуур  
А - аймаг  
Х.Ө - хойд өргөрөг  
З.У - зүүн уртраг  
Сол - солбицол  
Т - тонн  
/1.26/ - 1 - ашигласан номын дугаар  
26 - хуудасны дугаар



## 1 БҮЛЭГ МОНГОЛ ОРНЫ ГАЗАР ЗҮЙ, ТҮҮХИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ

### Газарзүйн ерөнхий тойм



**Газарзүйн байрлал.** Манай Монгол улс Ази тивийн төвд 1564116 ам.км талбайг эзлэн оршино. Нутгийн хэмжээгээр дэлхийн нийт улсын дотор 17-р байр эзэлнэ. Манай улсын нутгийн хойд захын цэг хойд өргөргийн **/хө/ 52 градус 09 минутад** орших **Монгол Шарын Даваа**, Өмнөд захын цэг х.ө 41 градус 35 минутад орших **Орвог Гашууны Бортолгой** хоёрын хооронд 1259 км зайтай юм. Манай улсын орших энэ өргөрөгт Оросын Холбоот Улс, Хятад, Казак, Украин, Румын, Унгар, Австри, Швейцари, Франц болон Итали, Испани, Америкийн Нэгдсэн Улс, Канадын нутгийн хэсэг буюу нийтдээ 30 улс оршдог ажээ.



Манай улсын нутгийн хамгийн зүүн захын цэг з.у 119 градус 56 минутад орших Соёлз уулын Модот Хамар, хамгийн баруун захын **цэг з.у 87 градус 44** минутад орших **Таванбогдын Мааньт** уул хоёрын хооронд 2392 км зайтай ажээ. Энэ уртрагт Оросын Холбоот Улс, Хятад, Бангладеш, Бирм, Тайланд, Вьетнам, Индонези зэрэг арав гаруй орон оршино. Манай улсын хилийн нийт урт нь 8216 км, үүний 3543 км нь Оросын Холбоот улстай, 4673 км нь Хятад улстай залгана.

Манай орон бол эх газрын орон бөгөөд далайд гарцгүй дэлхийн 38 улсын нэг, далайд хамгийн ойр цэг нь Номхон далайгаас 1000 орчим км зайтай оршино. Манай орон Дэлхийн цагийн 6, 7, 8 дугаар бүсэнд /баруун таван аймаг зургаа, төвийн аймгууд 7, зүүн 2 аймаг 8-р бүсэнд/ оршино.

**Газрын гадарга.** Манай улс нь өндөр уул, өргөн тал, уудам хөндий хосолсон гадаргын олон хэв шинж бүхий нутагтай. Нутгийн баруун ба хойд хэсэгт **Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн** уулс орших бөгөөд **Алтайн** уулсад **Таванбогд** зэрэг мөнх цаст оргил 20 гаруй бий. Хангайд Отгонтэнгэр /4021 м/, Хөвсгөлд **Мөнхсарьдаг** /3461 м/ уулууд мөнх цастай Хэнтийн Асралтхайрхан /2800м/ зарим жилд цастай өнждөг. **Монгол Алтайн** нуруу нь манай улсын баруун захаас зүүн урагшаа 900 гаруй км үргэлжилж улмаар 3500- 4374 м өндөр. Хангай нуруу нь 3000-4021 м өндөр бөгөөд нутгийн баруун хэсгээс мөн зүүн урагшаа чиглэлтэйгээр төвийн нутгаар 800 орчим км үргэлжилнэ. Хэнтийн нуруу нь 2000-2800 м өндөр бөгөөд нутгийн зүүн хойд хэсгээс баруун урагшаа чиглэлтэйгээр 300 гаруй км үргэлжилж төгсгөл нь Хангайн нурууны зүүн захтай нийлнэ.

Ингэж манай орны нутгийн хойд хэсэгт уулсын нумарсан тохой үүсдэг юм. Өнөөгийн манай нутагт эрт цагт далай байсан бөгөөд нутгийн ихэнх хэсэг нь эртний төрмөлийн эриний пермийн галавт болсон герцины хөдөлгөөнөөр уснаас чөлөөлөгджээ. Манай орны **Алтай, Хангай, Хэнтий Хөвсгөлийн** уулс шинэ төрмөлийн эриний сүүлчээр болсон Альпийн уул тогтох хөдөлгөөнөөр сэргэн өнөөгийн хэлбэрийн олсон боловч одоо ч энэ уулсын гадаргын хэлбэр бүрэн тогтож чадаагүй байгааг үе үе болдог газар хөдлөлтүүд гэрчилнэ.

Манай нутгийн дундаж өндөр нь д.т.д 1580 м бөгөөд энэ нь дэлхийн хуурай газрын дундаж өндөрөөс 700 м-ээр их гэсэн үг. Нутгийн 80 гаруй хувь нь 1000 м-ээс илүү өргөгджээ. Зүүн ба зүүн өмнөд хэсэгт уудам тал оршино. Тэнд үнэмлэхүй өндөр нь 560-1000 м байна.

**Манай орон ашигт малтмалаар нэн баялаг.** Манай орны олборлоход бэлтгэгдсэн зөвхөн 13 төрлийн эрдэсийн баялгийн үнэ 60 гаруй тэрбум америк доллар болох ажээ. Үүнд: **төмөр, зэс, анзан, (молибден), нүүрс, цайр, алт, хар тугалга, гянт, мөнгө, цагаан тугалга, газрын ховор**

---



**элемент, уран** орж байна. Нүүрс гэхэд л 152 тэрбум т. нөөцтэй. Манай нутгаас алмаз олдсоноос гадна онгонит, армоострангит зэрэг шинэ эрдэсүүд олджээ. Фосфоритын нөөц бас их. Одоо нефть олборлохоор эрэл хайгуул хийж Дорнод аймгийн Тосон уул, Дорноговь аймгийн Зүүнбаянд газрын тосны орд олдож байна. Өмнөговийн Оюу толгойд зэс, алтны баялаг орд нээгдэж байна. Манай бараг бүх аймгийн нутагт нүүрс бий. Манай орны геологи, ашигт малтмалын судалгаа хийсэн голлох мэргэжилтэн нь "шүлтлэг боржинд хоорондоо төсөөтэй ховор махбод харилцан ямарч хуримтлагдах үзэгдэл" гэдэг шинжлэх ухааны шинэ нээлтийг ОХУ-ын эрдэмтэдтэй хамтарч хийсэн академич Б.Лувсанданзан гуай болон түүний шавь нар юм.

**Уур амьсгал.** Манай орны том их газрын төв хэсэгт, их өндөрлөгт, далайгаас алслагдан оршдог учраас эх газрын эрс тэс уур амьсгалтай болжээ. Өвөлдөө I сард  $-50^{\circ}\text{C}$  градусаас давж хүйтрэх, зун VII сард  $+40^{\circ}\text{C}$  өөс хэтэрч халах явдал гардагаас гадна 1 хоногийн температурын зөрөө 30 градус хүрэх явдал ч бий. Жилийн дундаж температур нь нутгийн хойд хэсэгт "-", өмнөд хэсэгт "+" тэмдэгтэй байна. Манай эхийн голд  $44.8^{\circ}\text{C}$  хүрч халсан, увсын зүүнговь суманд  $-56.6^{\circ}\text{C}$  хүрч хүйтэрсэн нь манай улсын үнэмлэхүй их, бага температур болсон юм. Энэ тухай Баянхонгор, Увс аймгийн замаас үзээрэй.

Улаанбаатар хотод тогтвортой хүйтэн намар X сарын аравдаар эхэлж, хавар IV сарын аравдаар зогсож 180 орчим хоног үргэлжилнэ. Агаарын даралт нутгийн зүүн хагаст арай бага (844 гПа-аас бага) бөгөөд баруун хэсэгт их байдаг. (Монголын онцлог газрыг үз) Манай улс дэлхийн хамгийн (жилдээ 250 хоног) цэлмэг тэнгэртэй орны нэг бөгөөд мөн нар гийгүүлэх хугацаа (2600-3300 цаг) ихтэй орны нэг. Бүрхэг өдөр цөөнтэй нарлаг орон. Хур тунадас багатай, жилдээ хойд хэсэгт 300-400 мм, өмнөд хэсэгт 200 мм-ээс бага тунадас унана. Өвөл цас багавтар орно. Агаар ерөнхийдөө хуурайвтар, харьцангуй чийг багавтар, өмнөд хэсэгтээ ялангуяа хавар салхи ихтэй.

Ш.Шагдар.

Монгол орноор жуулчлах зуун зам

Салхитай өдөр олон бөгөөд салхины хурд өмнө зүгийн нутагт хаврын цагт дундажаар 3 м/с орчим байх бөгөөд 40 м/с хүрэх явдал ч бий.

**Гадаргын ус.** Манай улсын нутаг гадаргын ба газрын дорхи усаар тийм бага биш. Нийтдээ 67 мян. км урттай гол горхи, 4 мянгаад булаг шанд бий. Нутгийн хойд хэсэг нь гадаргын ус гол мөрөн нуураар өмнөд хэсгээсээ илүү. Гол мөрдийг Хойд Мөсөн далайн, Номхон далайн болон Төв Азийн гадагш урсгалгүй гэж 3 ай савд хуваана.

Том гол мөрд гэвэл: Хойд Мөсөн далайн савын Сэлэнгэ мөрөн (992 км), Номхон далайн савын Хэрлэн, Онон, Төв Азийн гадагш урсгалгүй савын Завхан, Ховд зэрэг юм. Манай гол мөрд усны эрчим хүчний нөөц ихтэй, цэвэр цэнгэг устай бөгөөд зуны борооны үед үерлэдэг. Манайд 100 ам км-ээс илүү талбайтай нуур 16 байгаагийн хамгийн том нь Увс нуур /3350 ам км/ юм. Гол мөрд нуурууд нь загасаар баялаг, Гол мөрд нуурын ус нь зун VII-VIII сард +15°C-+23°C градус хүртэл халдаг.

Манай өмнөд хэсгийн хээр, говь нутаг жижиг нуур ихтэй бөгөөд говь цөлд баянбүрд элбэг, говь хээрийн бүсэнд газар доорх усны нөөц их бий. Өмнөд хэсэгт хүн малын ундаанд газар доорх усыг хэрэглэдэг. Манай оронд халуун хүйтэн рашаан 400 орчим байгаагийн дотроос **Хужирт, Жанчивлин, Улаанбаатар, Отгонтэнгэр, Онон, Естий, Шаргалжуут, Халзан уул, Аварга-Тосон, Могойт, Цэнхэрийн, Утаатминчүүр, Ерөө, Гурваннуур** зэрэг их нэрд гарсан юм.

**Хөрсөн бүрхэвч.** Манай орон уудам их нутагтай учраас хөрсний олон хэв шинж бий болжээ. Нутгийн хойд хэсэгт хар шороон маягийн хөрс тархсан бол төв хэсгээр нь хүрэн хөрс, өмнө хэсгээр нь говийн саарал хөрс тархжээ. Нутгийн (төвийн зүүн хэсгийн тал, хээрийн) 50 гаруй хувьд хүрэн хөрс тархсан юм. Хойд хэсгийн хар шороон маягийн хөрстэй нутагт газар тариалан хөгжүүлсэн, тариаланд тохиромжтой хөрс нийтдээ 1, 6 сая гаруй гектар талбайтай.



Манай орны хойд хэсгийн уулархаг нутгаар ой тайга, ойт-хээр, төвийн ба зүүн хэсгээр хээрийн, өмнө хэсгийн нутгаар говийн, хамгийн урд захаар цөлийн байгалийн бүс оршиж байна. Өндөр уулуудад ойн дээд хилээс дээш тагийн бүс, түүнээс дээш мөнх цастай.

**Ургамалжил.** Манай орон нийтдээ 4000 орчим зүйлийн ургамалтай. Монголын **унаган** ургамал олон бий. Манай орны хойд хэсэгт ой хөвч тархсан. Энд шинэс, нарс зэрэг мод, өмнөд хэсгийн говь нутагт заг мод ургана. Нийтдээ нутгийн 11, 4 хувь буюу 18 сая шахам гектар талбайд ой тархжээ. Ой модны 72 хувь нь шинэс юм. Том гол мөрдийн хөндийд шугуй ихтэй. Нууруудын эргээр зэгс, шагшуурга элбэг ургана. Улсын нутгийн 1.22 сая ам км талбайг малын бэлчээрийн, 20 мян ам км талбайг хадланд ашигладаг. Үйлдвэрийн түүхий эд, эмийн ургамал нэн элбэг. Жишээлбэл: Дэлхийд ховордсон эмийн ургамал **лидэр, чихэр өвс, хунчир, чацаргана** элбэг ургана. Дэлхийн чацарганы бутны 80 хувь нь манайд ургадаг гэсэн тооцоо бий.

Манай улс ховордож байгаа ургамал амьтнаа бичсэн Улаан номыг 1987, 1997 онд гаргасан бөгөөд УИХ-аас 1995 онд баталсан "Байгалийн ургамлын тухай" хуулинд 133 зүйлийн ургамлыг **нэн ховор** гэсэн ангилалд оруулан хамгаалж байна.

**Амьтны аймаг.** Манай орон амьтны аймгаар баялаг, 15 мян. зүйлийн шавьж, 300 орчим зүйлийн хоёр нутагтан, мөлхөгчид, 80-аад зүйлийн загас, 415 зүйлийн шувуу, 140 гаруй зүйлийн хөхтөн амьтантай. Эдгээрийн дотроос цагаан зээр /2 сая орчим/ хамгийн элбэг тохиолдох бөгөөд тарвага, үнэг, чоно, ой хөвчид баавгай, бор гөрөөс зэрэг амьтад элбэг тохиолдоно.

Зөвхөн ойн буга гэхэд л 139 мян бий гэсэн тооцоо бий. Эдгээрээс дэлхийд нэн ховордсон учир Байгаль түүний нөөц баялагийг хамгаалах Олон Улсын Холбооны улаан номонд нэр нь орсон амьтан олон бий. Манай орны гол мөрд загасаар элбэг. Гол мөрдийн тайлбарт үз.

Ш.Шагдар.

Монгол орноор жуулчлах зуун зам

УИХ-аас 1995 онд баталсан ан агнуурын хууль ёсоор дараахь амьтадыг "нэн ховор" гэсэн ангилалд оруулж агнах явдлыг хориглосон байна. Үүнд **тахь, цаа буга, хар мөрний хандгай, мазаалай, хавтгай, цөөвөр чоно, хүдэр, бөхөн, ирвэс, минж, халиу, хилим загас гангар хун, жороо тоодог, цэн тогоруу, хар тогоруу, цагаан тогоруу гургуул** зэрэг 18 зүйл амьтан, жигүүртэн шувууд болно.

Мөн олон амьтныг агнах хугацааг тогтоосон байна. Ер нь Монгол оронд XIII зууны үед ой ангийн хууль дүрэмтэй байсан бөгөөд 1940 онд халиу, булгыг хулгайгаар агнахыг, 1720 онд Их хүрээний хавьд мод огтлох, ан гөрөө хийхийг хуулиар хориглон хамгаалж байсан сайхан уламжлалтай юм. Энэ тухай II бүлэгт дурдана.

## Монголын онцлог газрууд

Монгол нутгийн Дэлхийн онцлог газрууд. Аливаа улс орон өөрийн нутгаа бусад улс орныхоос юугаараа онцлогоор нь бахархан үздэг. Монгол орон Дэлхийд онцлог газар нутаг олонтой. Үүнийг дурдая.

1. Өвлийн цагт манай нутагт Дэлхийн бөмбөрцгийн хойд хагасын агаарын урсгалыг хамарсан энэ нутгийг Увс, хяргас нуурын хотгорыг хамарсан энэ нутгийг **газарзүйн ухаанд агаарын их даралтын төв тогтмол үүсдэг.** гэж нэрлэдэг. Энэ төвийн төв Улаангом хотод 1 сард агаарын даралт 1055 гПа хүрнэ. Тогтмол үүсдэг ийм төв Дэлхийн бөмбөрцөг дээр өөр байхгүй. Увс аймгийн тухай хэсгээс үз.

2. Дэлхийн бөмбөрцгийн **хамгийн хойшоо түрж орсон хамгийн их талбайтай манхт** элс бол манай Увс аймгийн Зүүнговь сумын нутаг дахь Бөөрөгийн элс юм. Энэ элсний хойд зах нь х. ө 50 градус 18 минутад хүрсэн бөгөөд энэ нь Канадын өмнөд хэсэгтэй (Хойд Мөсөн далайн Гудзоны булангийн өмнөд эрэгтэй бараг) зэрэгцэж байгаа юм. Увс аймгийн 63-р чиглэлээс үз.

3. Дэлхийн бөмбөрцгийн хойд хагасын урагшаа түрж орсон **ул хөрсний үргэлжилсэн цэвдгийн хамгийн урд зах** нь Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын нутагт х. ө 46 градус 17 минут, з.у. 107° 10' минутын солбицолд Модон салаа ууланд хүрчээ. Энэ нь Газрын Дундад Тэнгисийн хойд эрэгтэй зэрэгцэж байгаа гэсэн үг. Баянхонгор аймгийн 38-р чиглэлээс очно.

4. Бөөргийн манхт элс, цэвдгийн урд зах хоёр нь хоорондоо 700 орчим км зайтай бөгөөд харьцангуй ийм бага зайнд говь цөл нь хойшоо, цэвдэгт хөрс нь урагшаа түрж зөрчихсөн газар байхгүй. Дэлхийд Монголоос өөр газар

5. Хэнтийн нурууны төгсгөл болох **Цогтчандмань** уул нь Дэлхийн усны гурван ай савын хагалбар болдог. Улаанбаатараас зүүн урагш 80 орчим км-т орших 1845 м өндөр энэ уул Хойд Мөсөн далай, Номхон далай, Ази тивийн гадагш урсгалгүй савуудын усны хагалбар болдог.

6. Хөвсгөл аймгийн нутаг дахь Сангийн Далай нуурын орчмоос (51-р, 59-р чиглэл) баруун тийш Увс аймгийн нутаг дахь /63-р чиглэл/ Ханхөхийн нурууны Хангилцагийн голын эх хүртэл 400 шахам км үргэлжилсэн хагархай нь **газар хөдлөлөөр үүссэн Дэлхийн хамгийн урт бөгөөд хамгийн шулуун хагархайн** нэг юм. Энэ хагархай ан цав 1905 оны газар хөдлөлөөр анх үүсэх үедээ зарим газартаа 60-аад метр гүн, 10 гаруй метр өргөн байжээ. Одоо мэдэгдэх боловч их эдгэрчээ. Энд тэнд нуур тогтсон бий. Одоо өндөр нь 10 метр хүрэх эрэгтэй газар ч бий.

7. Дэлхийн экватор, хойд туйл хоёрын газрын дунд орших **х.ө 45 дугаар зэргэд**, (Ховд, Говь-алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговь, Дорноговь, Сүхбаатар аймгийн нутаг) мөн анхны ба 180 дугаар голдож хоёрын мөн газрын дунд **з.у 90 дугаар голдож** (Баян-Өлгий, Өлгий хотын дундуур) гэсэн хоёр чухал шугам манай улсын нутгаар өнгөрдөг.

8. Хүний аж ахуйн үйл ажиллагаанд бараг нэрвэгдээгүй **ой тайга, тал хээр, говь цөл** нутгийн аль аль нь Монгол оронд байдгийг дээр дурдсан. (II бүлгээс Ханхэнтий, Говийн их дархан газар, Дорнод талыг үз.)

### **Монголдоо онцлог газрууд**

9. Манай улсын нутгийн хүйс (Төв Цэг) нь Өвөрхангай аймгийн Бүрд сумын төвөөс урагш 14 км газарт х. ө 46 градус 52 минут, з. у 103 градус 50 минутын сол-д Өвөрхөшөөтийн булгийн эхэнд оршдог юм. Улаанбаатарын үүсэл болсон ордын суурийг 1639 онд тавьсан Ширээтцагаан нуур нь манай улсын нутгийн өнөөгийн Хүйсээс хойш 40-аад км-т байна. Бас Ширээтцагаан нуурын эрэгт орших Монгол уулыг Монгол улсын нутгийн хүйс гэж нэрлэж байсан аж.

---

Монголын нутгийн Хүйс гэж нэрлэгдэж байсан Батхаан уул өнөөгийн хүйсээс зүүн хойш 50-аад км-т, мөн Зүүнхайрхан уул өнөөгийн хүйснээс баруун урагш мөн 30-аад хан км-т, бас Халхын нутгийн төв гэж нэрлэгдэж байсан Номгон, Цагаанхайрхан уул, /Архангай аймгийн Хашаат сумын нутаг/ өнөөгийн хүйсээс баруун хойш 50 орчим км-т, мөн хүйс гэгдэж байсан Сартолгой, хүйсээс баруун тийш 30 орчим км-т, оршиж байна.

МЭӨ II зуунаас хойших эртний монголчуудын /Их Юан улсын үеийнхнээс бусад/ нийслэл, хааны орд нь өнөөгийн манай нутгийн Хүйсэд ойрхон Орхоны хөндийд байсан байна. Орхоны хөндий нь монголчуудын гений сан бүрэлдэн тогтсон голомт мөн гэдгийг доктор Ж.Батсуурь баталсан юм. Энэ бүгдийг холбож үзвэл сонин дүгнэлт гарч болно. Өөрөөр хэлбэл Орхоны хөндий Хархорин орчмын нутаг нь түүхийн, биологийн, газарзүйн үүднээс монголын нутгийн хүйс байжээ гэж хэлж болох нь.

Энэ бүгд бол манай өвөг дээдсээс нийслэл хотоо байгуулах газраа сонгоход хичнээн их мэдлэг ухаан зарж байсны гэрч юм. Улсын нутгийн өнөөгийн Хүйсийг энэ мөрийг зохиогч миний бие 1979 онд тодорхойлж 1989 онд газар дээр нь чулуун овоо босгосон юм. Улсын нутгийн Хүйсэд /Төв Цэгт/ зориулсан хүндэтгэлийн суваргыг нутгийнхан миний босгосон чулуун овоон дээр 1993 онд байгуулсан байна. Улсын нутгийн Хүйсийн ойролцоо монголчуудын эртний өвөг Хүннүгийн булш оршдогийг түүхч эрдэмтэн Г.Сүхбаатар олжээ.

Өвөрхангай аймгийн 16-р чиглэлээс очно.

10. Манай улсын хамгийн өндөр уул бол Алтай Таванбогд уулын оргил /Баян-Өлгийн 68-р чиглэл/ Хүйтэн уул 4374 м өндөр юм. Хамгийн нам дор газар бол Дорнод аймгийн Эрээнцав сумын нутаг дахь Хөх нуур 560 м өндөрт оршино. /32-р чиглэл/

11. Хамгийн өндөрт оршдог аймгийн төвд нь д.т.д. 2181 м өндөрт орших Говь-алтай аймгийн төв Алтай хот /41-р чиглэл/ юм. 2181 гэдэг нь Улаанбаатарын дэргэдэх Богдхан уулын бараг орой гэсэн үг юм. Хамгийн нам дор

газар оршдог аймгийн төв нь д.т.д. 626 м өндөрт оршдог Сэлэнгэ аймгийн төв Сүхбаатар хот юм. /48-р чиглэл/


12. Хамгийн өндөрт оршдог сумын төв бол д.т.д. 2400 м өндөрт оршдог Ховд аймгийн Дуут сум / 61-р чиглэл / юм. Хамгийн намд оршдог сумын төв нь д.т.д. 600 м өндөрт оршдог Дорнод аймгийн Эрээнцав сумын төв юм. /32-р чиглэл/

## **Эдийн засаг, улс төр**

### **Эдийн засаг аж ахуй**

Манай орон төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжиж байна. Манай орны эдийн засагт хөдөө аж ахуй түүний дотор мал аж ахуй, газар тариалан голлоно.

**Мал аж ахуй.** Манай орон бол мал аж ахуйн орон 2001 оны байдлаар 26 сая гаруй малтай, түүний дотор хонь 12 сая шахам, ямаа 9.6 сая гаруй, адуу 2.2 сая гаруй, үхэр 2 сая гаруй, тэмээ 285.2 мян гаруй байв. Манай орон нэг хүнд ногдох малын тоо /13/ гаар Дэлхийд дээгүүр ордог. Мал сүргийн 97 % орчим нь ардын аж ахуйтны мэдэлд байна. Улсын хэмжээнд хамгийн олон малтай аймаг нь Хөвсгөл (1.9 сая толгой малтай), 2000 онд хамгийн олон малтай сум нь Өвөрхангай аймгийн Богд сум 242 мянган





толгой малтай/, хамгийн олон малтай малчин нь 2000 онд Төв аймгийн Сэргэлэн сумын малчин Хэнмэдэх /3000 гаруй толгой малтай/ байв.

Манай оронд тахиа, гахай, зөгийн аж ахуй бага зэрэг хөгжиж байна.

**Газар тариалан.** Нутгийн хойд хэсэгт газар тариалан хөгжүүлж байна. Нийт эргэлтийн талбай 1.3 сая гаруй гектар юм. 1998 онд 837.9 мян. гектарт тариалж нэг гектараас үр тариа 13 цн-ийг буюу нийт 687 мян.тн-ыг хурааж байв. Төмс хүнсний ногоо нилээд тариалдаг. Харин жимс нарийн ногооны аж ахуй сайн хөгжөөгүй.

**Аж үйлдвэр.** Манай орны хөгжлийн шилжилтийн энэ үе манай аж үйлдвэрт их хүчтэй мэдрэгдэж байна. Аж үйлдвэрийн үйлдвэрлэл 1989 оныхоос их буурлаа. Манай улсад хөнгөн ба хүнсний үйлдвэр голдуу мал, хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах үйлдвэр хөгжсөн. Мөн газрын баялаг олборлох үйлдвэр нилээд байна. Эдгээрээс хайлуур жонш, зэс молибден, нүүрсний үйлдвэр голлох байр эзэлнэ. 2001 онд хайлуур жонш 209 мян, тонн, нүүрс 5,2 сая гаруй тонн, зэсийн баяжмал 381.4 мян.тонн, молибдены баяжмал 3028 тонныг олборлож, 3017.0 сая кВт. ц эрчим хүч боловсруулжээ. 2001 онд 13.7 орчим тонн алт олборлож цемент 68 мян.тонныг үйлдвэрлэжээ. Металл боловсруулах анхны үйлдвэр 1993 оноос ажиллаж эхэллээ. Машины үйлдвэрийн суурь тавигдаж барилгын материалын үйлдвэр үлэмж хөгжиж байна. 2001 онд хөнгөн ба хүнсний үйлдвэрт хивс 1800 мян.ам метр, нэхий дээл 180.2 мян, ширхэгийг, малын мах 240 мян. тонн, сүү 1.2 сая литр үйлдвэрлэжээ.

**Зам тээвэр.** Өргөн уудам нутагтай манай орон зам тээвэр чухал үүрэгтэй. Манай тээвэр, төмөр зам, агаарын тээвэр, хөгжиж байна. Усан замын тээвэр бага, орон нутагт ердийн хөсгийн тээвэр бий. Авто тээвэрт хатуу хучилттай зам бага учраас байгалийн засаагүй замыг их ашигладаг.

Ш.Шагдар.

Монгол орноор жуулчлах зуун зам

Манай орны зам тээвэрт чухал үүрэг гүйцэтгэх Мянганы замын чиглэлийг УИХ 2001 оны 1-р сарын 25-нд баталсан чиглэлийг авч үзье.

**Баруун чиглэл.** Улаанбаатар-Лүн-Дашчилэн-Өгийн доод гүүр-Батцэнгэл-Хануйн гүүр-Тариат-Цахир-Загастай зүүн эхний даваа-Идэр-Яруу-Эрдэнэхайрхан-Завхан-Тээлийн билчэр-Дөргөн-Мянгад-Өлгий-Цагаан нуур-Улаанбайшинт

**Зүүн чиглэл.** Улаанбаатар-Налайх-Баяндаваа-Эрдэнэ-Багануур-Өндөрхаан-Хэрлэнгийн гүүр-Нарансаран-Хургалж ухаа-Адаг дулаан-Сүмбэр гэж өнгөрнө.

Замын энэ чиглэлийг Төв, Булган, Архангай, Завхан, Ховд, Баян-Өлгийн замд, Хэнтий, Сүхбаатар, Дорнодын замд дурдах болно.

**Холбоо.** Харилцаа холбоо хөгжиж ихэнхи сумд аймгийн төвтэй ба Улаанбаатартай утсан харилцаатай болжээ. Ихэнх аймаг үүрэн телефонтой, гадаад улстай харилцах боломжтой болж орчин үеийн харилцаа холбоо хөгжиж байна.



## Г. Хүн ам, засаг захиргааны хуваарь

**Хүн ам.** Манай орон 2003 оны байдлаар 2.5 сая шахам хүн амтай боллоо. Хүн амын цэвэр өсөлт 1000 хүн ам дутамд 24, 1 байв. 2002 онд манай улсад 560 гаруй мян, гэр бүл (Нэг гэр бүл дундажаар 4, 4 хүнтэй) байлаа. Хүн амын ихэнх нь буддийн шашин шүтдэг **халх монгол үндэстэн** бөгөөд лалын шашин шүтдэг **казах үндэстэн** бий. Хүн амын дотор 2000 оны байдлаар **Казах** 103 мян, **Дөрвөд** 67 мян, **Баяд** 51 мян, **Буриад** 41 мян, **Дарьганга** 32 мян, **Захчин** 30 мян, **Урианхай** 25 мян, **Дархад** 19 мян, **Өөлд** 15 мян, **Хотон** 9 мян, **Торгууд** 13 мян, **Хотгойд** 7 мян, **Мянгад** 6 мян, **Тува** 5 мян байна. Манайд сургуулийн насны хүүхдийг бага болон бүрэн бус дунд боловсролтой болгох ажил 1990 ээд оны эх гэхэд үндсэндээ хэрэгжсэн юм. 2002 оны намраас бүх шатны сургуульд 700 гаруй мян хүн түүний дотор ерөнхий боловсролын сургуульд 515 мян сурагч суралцаж байгаа нь улсын хүн амын бараг 22 хувийг эзэлж байна. Одоо сум бүхэн бүрэн бус дунд сургуультай, Улаанбаатар хот, зарим аймгийн төв хотуудад их дээд сургууль, коллеж эрдэм шинжилгээний байгууллагууд ажиллаж байна. Үүнд: 181 их дээд сургууль коллежид 93400 оюутан, 32 мэргэжлийн төвд 20500 хүүхэд, 665 цэцэрлэгт 86000 гаруй багачууд хүмүүжиж байна. Мөн сум бүгдэд их эмчийн салбар, номын сан, соёлын байгууллагууд ажилладаг

**Засаг захиргааны хуваарь.** Манай улс 22 аймаг хотод хуваагдах бөгөөд нэг аймаг дундажаар 74,5 мян ам км нутагтай, 90 мян хүн амтай юм. Хамгийн их нутагтай аймаг нь Өмнөговь /165, 4 мян ам км нутагтай/ хамгийн олон хүнтэй аймаг нь Хөвсгөл /117,0 мян хүн амтай/ юм. Аймаг хотууд нь сум дүүрэг, хороодод хуваагдах бөгөөд манай улсад 320 гаруй сум хороо байна. Нэг сум дунджаар 4,9 мян орчим ам км нутагтай. 2,7 мян хүн амтай юм. Хамгийн их нутагтай сум нь Өмнөговь аймгийн Гурвантэс /28 мян шахам ам км нутагтай/ хамгийн олон

хүн амтай сум нь Увс аймгийн Тэс сум /9,1 мян гаруй хүн амтай/ юм. Улаанбаатараас хамгийн хол орших аймгийн төв нь Баян-Өлгий аймгийн төв Өлгий хот /1636 км/, сум нь Баян-Өлгий аймгийн Булган сум /1930 км/ аймгийн төвөөсөө хамгийн хол орших сум нь Дорнод аймгийн Халх гол сум /338 км зайтай / юм.

**Нийслэл Улаанбаатар хот.** Манай нийслэл Улаанбаатар хотын эх суурь анх 1639 онд өнөөгийн Өвөрхангай аймгийн нутаг дахь Монгол элсний Ширээтцагаан нуурт тавигдсанаас хойш 30 орчим удаа нүүсээр 1778 онд өнөөгийн байгаа газарт ирж суурьшжээ. Улаанбаатар хот нь х. ө 47 градус 55 минут, з. у 106 градус 55 минутын солбицолд д.т.д. Талбайд төв цэг багана 1300 м өндөрт х.ө.  $47^{\circ} 55' 03''$ , з.у.  $106^{\circ} 55' 04''$ , дэлхийн экватороос хойш 5311 км, анхны голджоос зүүн тийш 7987 км зайтай газарт 4704 ам.км талбай эзлэн оршино. Улаанбаатар хотод (Буянт, Ухаад) агаарын жилийн дундаж температур нь  $-3.0^{\circ}\text{C}$ , I сарынх  $-26, 1^{\circ}\text{C}$ , VII сарынх  $17^{\circ}\text{C}$ , агаарын даралт нэг сард 1037, 7 гПа, VII сард арай бага. Жилд 233 мм тунадус унадаг. Салхины жилийн дундаж хурд 2, 2 м/с хамгийн их салхитай 5 сард 3, 7 м/с байдаг. Манай улсын засаг захиргаа, улс төр, эдийн засаг, соёл шинжлэл ухааны төв нийслэл Улаанбаатар хотод 2000 оны байдлаар 770 мян хүн ам амьдарч байна. Мөн 233 мян малтай. Улаанбаатар хотод байгаа **Богдын ногоон ордон, Гандантэгчэнлин хийд, Гачууртын амны зосон зурагтай хад, Гэр хэлбэрт модон дуганууд, Гэсэр сүм, Дамбадаржаа хийд, Дарь-Эхийн сүмийн 0.07 га 2 чулуун багана, Ихтэнгэрийн амын Сүг зураг, бичээстэй хад, Мэгжид-Жанрайсаг дугана, Сонгинохайрхан уулын олон булш, Чинван Ханддоржийн байшин, Чойжин ламын сүм** гэж түүх соёлын бүгд 12 дурсгалыг 1944-1988 онд улсын хамгаалалтанд авчээ.

Улаанбаатар хотын орчимд "Чингис хааны хүрээ", "Форестленд", "Бумбат" зэрэг жуулчны олон бааз ажилладаг.

Улаанбаатар хотын нүүж суурьшиж байсан газруудыг олж тогтохоор Улаанбаатар хотын соёлын газрын (Г.Нямсамбуу) санаачлага, хотын засаг даргын тамгын газрын дэмжлэгээр “Хүрээ нүүдэл” аяллыг 1999 он, 2002 оны намар зохион байгуулан ажилуулахад хориод хүнтэй багийн бүрэлдэхүүнд нь энэ мөрийг зохиогч миний бие оролцсон юм. Бид энэ аяллаар Хутагтын өргөө, Их хүрээ суурьшиж байсан 16 газарт багана босгосон. Тэр газруудад дараа дурсгалын самбар, хөшөө босно. Энэ талаар Төв аймгийн 2, 9, 10, 12, 49, 50, Архангай аймгийн 18, Сэлэнгэ аймгийн 49, 50, Өвөрхангай аймгийн 13, 16-р чиглэлүүд болон “Сувдан сондор-6”-д үз.

**Улс төрийн тогтолцоо.** Монгол улсад өөрчлөн байгуулалт нийгмийн нийт хүрээг хамрах болсноор нийгмийн амьдралыг хөдөлгөөнд оруулж ардчилал, ил тод байдал, шударга ёсыг хөгжүүлж, өв соёл, шашин шүтлэг сэргэж, манай нийгмийн улс төрийн хуучин тогтолцоо шинэчлэгдэв. Төрт ёсны олон зуун жилийн түүх уламжлалтай Монгол улс орчин үеийн хууль цаазат төрийн тогтолцоог бүрдүүлж, шинэ Үндсэн хуулиа 1992 онд батлан гаргалаа. “Үндсэн хууль”-нд манай улсын улс төрийн тогтолцоог **“Монгол улс бол тусгаар тогтносон бүрэн эрхт, Бүгд найрамдах улс мөн”** гэж тодорхойлсон бөгөөд мөн “Монгол улсын төрийн эрх барих Дээд байгууллага нь Улсын Их Хурал юм. Улсын Их Хурал нэг танхимтай 76 гишүүнтэй. “Монгол улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн” гэж заасан юм. Манайд нэг намын захиран удирдах ёс халагдаж олон намын систем тогтож МАХН, МАН, МАШСН, ИЗ-БН зэрэг 20 орчим улс төрийн нам ажиллаж байна.

### **Түүхийн хуудаснаас**

Монгол орон бол Төв Азид хүн үүссэнээс хойших бүхий л үеийн түүхийн ховор нандин дурсгалуудтай эртний өвөрмөц соёлтой орон. Монгол нутагт сая шахам жилийн тэртээгээс хүн оршин амьдарч байсныг сүүлийн



үеийн олборууд гэрчилж байна. Балар эртний хүний үйл ажиллагааны хамгийн эртний үл мөр ашель-мустьегийн үе-хуучин чулуун зэвсгийн дорд үед хамаардаг. Энэ үеийн нэн эртний хүний бууц, суурин, хөддөлмөрийн анхны багаж зэвсгийн зүйл: чоппер, чоппинг, ялтас, залтас, хусуур, зоруул мэт хуучны судлалын олбор,

хадны сүг зураг, шавар сав суулга, соёлын дурсгалт зүйлсийг Баянхонгор, Дундговь, Сүхбаатар, Дорноговь, Өмнөговь, Өвөрхангай, Ховд, Говь-алтай, Хэнтий, Дорнод зэрэг олон аймгийн нутгаас олсон юм. Монгол орны янз бүрийн нутгаас олдсон дурсгалууд Төв Азийн энэ хэсэгт эртнээс нааш хүн оршин суурьшсан соёл иргэншлийн нэг голомт болон хөгжиж байсныг гэрчилнэ. Нүүдэлчин ард түмний түүхэн Төв Азийн өргөн уудам нутагт оршин суугч ард түмнүүдийн нийгэм эдийн засаг, улс төрийн болон соёлын хөгжлийн бие даасан өвөрмөц зам юм. Анхны хүй нэгдлийн байгуулал задарсны үр дүнд Төв Азид үүссэн бий болсон ангит нийгэм ба төр улсын үүслийн эхийг МЭӨ III зуунд Хүннү нар тавьжээ. Монгол нутагт монгол хэлтэй овог аймгуудын дунд үүсэн бий болсон Нирун аймаг (МЭ V), Түрэг (VI-VIII) улсын үед феодалжих үйл явц улам урагшлан хөгжсөн байна. Уйгар, улс МЭ-VIII-IX зууны үед Орхоны хөндийд тогтож Ордубалык буюу Балыклык хот улс төрийн төв нь болж байжээ. Хятан улс X-XII зуунд оршин хот суурин, суварга, орд харш байгуулж байсан нь тус улсын нутгаас илрүүлэн олоод байгаа Хэрлэнбарс хот, Хадаасангийн Чин толгой, Харбухын балгас зэрэг хот суурины үлдэгдлээс мэдэгддэг. Хятан гүрний эдийн засаг-нийгмийн хөгжил нь түүний харьяанд байсан олон нүүдэлчин аймгуудад зохих нөлөө үзүүлсэн бөгөөд улмаар монголын феодалын улс бүрдэн тогтнохын өмнө үе болсон юм.



XIII зууны эхнээс Монголын нэгдсэн төр улс байгуулагдсан нь монгол угсаатанг бүрдүүлж феодалын харилцааг бэхжүүлжээ. XVII зууны үеэс 200 гаруй жил үргэлжилсэн Манжийн талхидлын үед Монгол улс төрийн тусгаар тогтнолоо алдаж, Манж гүрний дарлагдсан хоцрогдмол хязгаар болсон байна. 1911 онд Манжийн дарлалыг түлхэн унагаасны дараа Монголын засгийн газар өөрийн орны тусгаар тогтнолыг тунхаглан, улс төр эдийн засаг, соёлын амьдралд зарим өөрчлөлтийг гаргажээ.

Гэвч ард түмэн урьдын адил улс төрийн эрхгүй, анги-нийгмийн хувьд дарлагдсан хэвээр байв. 1921 онд үндэсний ардчилсан хувьсгалын үр дүнд нийгмийн амьдралыг ардчилах, нийгмийн гишүүдийн улс төрийн тэгш эрхийн баталгааг хангахад чиглэгдсэн гүнзгий өөрчлөлт хийв. 1924 онд хуралдсан Улсын анхдугаар Их Хурал Монгол улсын анхны “Үндсэн хуулийг” батлан туурга тусгаар төр улсаа байгуулсныг Дэлхий дахинд тунхаглан зарласан юм. Үндэсний ардчилсан хувьсгалаас хойших ная гаруй жилд шинэ эдийн засаг, аж ахуйн байгуулалтыг цогцлон бүрдүүлэв. Монгол улсын гадаад нөхцөл байдал өөрчлөгдөж, манай улс төр, нийгэм эдийн засгийн байгуулалын өөрчлөлт шинэчлэлт улс үндэснийхээ ашиг сонирхлыг дээдэлсэн, бодит байдалд тулгуурласан гадаад бодлого явуулах боллоо. Одоо манай улс дэлхийн 140 гаруй улстай дипломат харилцаатай, 60-аад улстай худалдаа-эдийн засгийн, 30 гаруй улстай соёлын харилцаа хөгжүүлж байна.

[Монгол орон түүх соёлын дурсгал арвин ихтэйг дээр дурьдсан билээ. Манай улс энэ түүх соёлын дурсгалыг бас хамгаалж ирсэн уламжлалтай. 1944 онд Амарбаясгалант хийдийг улсын хамгаалалтад авснаас хойш, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1961 оны 10-р сарын 9-ны өдрийн 524-р тогтоолоор Хархорин зэрэг 12 дурсгалыг, мөн Сайд нарын Зөвлөлийн 1971 оны тогтоолоор Хэрлэнбарс



Ш.Шагдар.

Монгол орноор жуулчлах зуун зам


хот зэрэг 9 газрыг түрүүчийн газар дээр нэмж улсын хамгаалалтад авч Засгийн газрын 1998 оны 12-р сарын 23-ны 235 дугаар тогтоолоор дээрх 21 газар дээр нэмж Өвөрхангай аймгийн Бат-Өлзийт сумын нутаг дахь Төвхөн хийд зэрэг 98 газрыг нэмж одоо хамгаалалтад аваад байгаа энэ 119 түүх соёлын дурсгалуудыг зохих зохих замд нь дурдан тайлбарлав.

ЮНЕСКО манай Орхон мөрний сав дахь Эрдэнэзуу хийд, Хархорин ба Харбалгас хотын туурь, Төвхөн хийд, Культегин, Билгэ хааны хөшөө, Амарбаясгалант хийд, Цагаан салаагийн хадны зураг, Хойд Цэнхэрийн агуйн хадны сүг зураг зэрэг нэн эртнээс XVIII зуун хүртэл үеийн дурсгалыг **"Дэлхийн гайхамшигт үнэт зүйл"** зэрэг зэрэглэлээр дэлхийн соёлын өвд бүртгэн авах санал гаргажээ. Энэ нь манай эдгээр дурсгал дэлхийн дансанд орно гэсэн үг билээ.



Ш.Шагдар.

Монгол орноор жуулчлах зуун зам



## II. БҮЛЭГ

### БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ


#### Ерөнхий мэдэгдэхүүн

Монголчууд байгаль орчноо хамгаалдаг өнө эртний түүхтэй ард түмэн. Байгаль орчноо хамгаална гэдэг нь агаар, ус, хөрс, ургамал, мал, амьтан, газрын гадаргыг хамгаална гэсэн үг билээ. Монголчуудын эртний өвөг Хүннү нар МЭӨ II зууны үед хөх тэнгэр, хөрст дэлхийн онгон хайрхдад тахилга үйлдэж байснаас нааш манай монголчууд уул овоо, нутаг усаа тахин шүтэж дээдлэн хүндлэх замаар хамгаалсаар иржээ. Тэмүүжин Бурханхалдун уулыг ихэд шүтэж тахиж байсан билээ. Монголчуудын байгалиа хамгаалах нэгэн чухал арга зам нь ийнхүү эртнээс нааш уул овоо, нуур рашаан, ус, булгийн тахилга юм. Энэ ажил цагийн байдлаас болж 1930 аад оны эцсээс 1990—ээд он хүртэл хориотой байснаа одоо дахин сэргэн өрнөж байна. Өнөөдөр манай сум бүр өөр өөрсдийн тахилгатай уул, овоо, нуур, ус рашаан /800 орчим/ болжээ. Эдгээр нь **нутгийн тахилгатай уул ус** юм. Тахилгатай уул, усыг хамгаална гэдэг нь монголд бичигдээгүй хууль байсан бөгөөд одоо бол тахилгатай уул ус нь уг нутагтаа ийнхүү дархан цаазтай газар болдог юм. Түүнээс гадна

Ш.Шагдар.

Монгол орноор жуулчлах зуун зам

нэг хошуу нутгийг төдийгүй өргөн олныг хамруулан их тахилга хийх уул, усыг төрөөс нэр цохон гаргаж байсан нь ард олны сүсэг бишрэлийг дээдлэн хүндэтгэх, байгаль орчноо хамгаалах нэн чухал ажил болж байсан бөгөөд энэ ажил одоо сэргэн хийгдэж байна. Тахилгатай уул усыг **их тахилгатай, цэргийн тахилгатай, нутгийн тахилагатай** гэж 3 ангилж үзэж болно. Монголд ийм их тахилгатай уул гэвэл: 1778 оноос тахиж болсон **Богдхан уул**, 1818 оноос тахиж болсон Хэнтийхан уул, 1891 оноос тахиж болсон **Отгонтэнгэр уул**, XVIII зуунаас тахиж байсан 1913 оноос их тахилга хийх болсон **Дарьгангын Алтан-Овоо, Архангайн Суваргахайрхан уулууд** байна. Эдгээр нь мөн л дархан цаазтай газар гэдэг нь тодорхой билээ. Өнөөдөр манайд **цэргийн тахилгатай** 3 уул байгааг дурдвал: Улаанбаатарын **Баянзүрх хайрхан**, Төв аймгийн Баянжаргалан сумын **Баян-эрхэт**, Сүхбаатар аймгийн Наран сумын **Баяндулаан** уулууд байна. Эдгээрийг дурдсан аймгуудад үз. Монголчуудын байгалиа хамгаалах өөр **нэг /хоёрдох/** түгээмэл арга зам нь ёс заншил зан үйлийн чанартай энгийн арга хэмжээ юм. Монголчууд бид хийморио сэргээх, аян замд явах, бэлчээрлэн буй мал сүргээ буюу ан амьтныг харах, газар нутаг, агаар тэнгэрийн байдлыг ажиглах гэж уулан дээр гарахдаа бэлээс нь чулуу авч явж уулын овоон дээр өргөн нэмэрлэдэг заншилтай. Ингэхдээ



“Ачаа нь хүнд  
Аян нь зөөлөн байтугай”, гэх буюу  
“Сүрийн их нь Танд  
Сүлдний их нь надад” гэх буюу  
“Овоо овоо  
Олон болоорой  
Олны юмыг  
Олон болгоорой” гэх буюу  
“Овооны том нь Танд  
Олзны их нь надад”  
Өлийн их нь Танд  
Өлзийн их нь манд гэж залбиран



овоогоо нар зөв гурав эргэн ёслол үйлдэж лхаржийлоо /тэнгэр олтугай/ гээд чулуу нэмнэ. Мөн булаг рашаан усны эхэнд овоо босгож мод хатган бүс даавуу хадаг яндар зүүж уснаас нь амсан, тэргүүндээ хүргэж булаг усаа хүндэтгэдэг сайхан заншилтай. Энэ бүгд нь уул овоогоо бүрэн бүтэн, сүрлэг сайхан, булаг усаа ариун тунгалаг, арвин баян байлган хамгаалах, нөгөө талаар байгалиасаа буян хишиг хутаг гуйж байгаа гүн утга учир бүхий ажил юм. Тахилгатай уул, ус, энгийн овоог ч буснуулан сүйтгэвэл лусын хорлол болж гай барцад тохиолдоно гэж үздэг бөгөөд тэгдэг ч. Манай ард түмэн уулаас жирийн билүү авахдаа оронд нь юм тавих, газар ухахын өмнө газраа гөрөөс, ороонгын эврээр хөндөх гэхчлэн нарийн ёс горим бий. Манай байгаль хамгаалах **гурав дахь арга зам** болох байгалийн хам бүрдэлийн хэсгүүдийг хамгаалах хуулийг төрөөс XIII зууны үеэс эртнээс гаргаж байсныг дээр дурьдсан. XVII зууны "Халх журам" хууль болон 1926 оноос ан амьтныг хамгаалах хууль гаргасан байна. Одоо манайд байгаль орчныг хамгаалахад холбогдол бүхий багц /15/ хуулиуд /газар эдэлбэрийн, газрын хэвлийн, хөрс, ургамал, сй хамгаалах ан агнуурын зэрэг/-ийг шинээр боловсруулж батлан гаргалаа. Монголчуудын байгаль орчноо хамгаалдаг **дөрөв дөх** арга нь тодорхой газар нутгийг төрийн шийдвэрээр зориуд дархлан улсын тусгай хамгаалалтад авах явдал юм. (Хойно үз) Манай орны төдийгүй дэлхийн хийгээд бүс нутгийн экологийн тэнцлийг хангахад чухал нөлөө бүхий байгаль, түүх, соёл шинжлэх ухааны онцгой ач холбогдолтой тусгай хамгаалалттай газруудыг олон улсын хүн ба шим мандлын нөөц газар болон дэлхийн байгаль соёлын өвийн жагсаалтад хамруулах, тэдгээрийн хамгаалалтыг сайжруулах ажлыг эхлээд байна.


### **Олон улсын байгаль хамгааллын ажил**

Дэлхийн хэмжээнд харьцангуй онгоноороо байгаа манай байгалийг хамгаалах ажил Олон улсын анхаарлыг татдаг юм. Ингэж анхаарагдаж одоогоор олон улсын хамгаалалтад аваад байгаа газруудыг дурдая.

Ш.Шагдар.

Монгол орноор жуулчлах зуун зам

Дэлхийн хэмжээнд зайлшгүй хамгаалах шаардлагатай 200 бүс нутагт  
Монгол орны нутаг дэвсгэрээс хамрагдсан байдал



Масштаб: 1 см-т 172 км

Дэлхийн хэмжээнд зайлшгүй хамгаалах шаардлагатай 200 бүс нутагт манай улсын **Дагуурын хээр тал** /Дорнод аймгийн нутгийн ихэнх Буйр нуур орчим ороод хойд хэсэг, Хэнтий аймгийн нутгийн зүүн хойд хэсэг, Сүхбаатар аймгийн нутгийн хойд хэсэг/, **Алтай-Соёны** уул нурууд /Увс, Баян-Өлгий аймгийн нутаг бүхлээрээ, Ховд аймгийн нутгийн ихэнх хойд хэсэг, Говь-Алтай аймгийн нутгийн баруун хойд хэсэг, Завхан аймгийн нутгийн баруун ба хойд хэсэг, Хөвсгөл аймгийн нутгийн ихэнх хойд хэсэг орсон байна.

ЮНЕСКО “Дэлхийн гайхамшигт үнэт зүйл болох нь” зэрэглэлээр дараах газруудыг “Дэлхийн өвд” бүртгэн авчээ.

**а. Байгалийн дурсгалын хувьд:**

- Увс нуурын ай сав (II бүлгийн 9)
- Говийн их цөл (Говийн их дархан газар II 3)
- Говь-Гурвансайхан уул (II 15)
- Хөвсгөл нуур ба бөө мөргөлтэй цаатангуудын нутаг (II 13)
- Богдхан уул (II. 1)
- Бурханхалдун (II. 4)
- Отгонтэнгэр (II. 8)

**Б. Түүх соёлын дурсгалын хувьд:**

- Хархорум хотын туурь -13-р чиглэл
- Эрдэнэзуу -13-р чиглэл
- Төвхөн хийд -16-р чиглэл
- Харбалгас - 13-р чиглэл
- Культегин, Билгэ хааны хөшөө -13-р чиглэл
- Цагаансалаагийн хадны зураг - 68-р чиглэл
- Хойд цэнхэрийн агуйн хадны зураг - 61-р чиглэл
- Амарбаясгалант хийд - 49-р чиглэл

“Олон улсын ач холбогдол бүхий ус намгархаг газар ялангуяа усны шувуу олноор амьдардаг орчны тухай” Рамсарын конвенцийн хавсралт жагсаалтад Монгол Дагуурын дархан цаазат газарыг 1997 онд бүртгэн авчээ. (II. 5)

Тэрхийн цагаан нуур, (II. 16) Өгий нуур, (18-р чиглэл) Говийн нууруудын хөндий (Орог нуур, Таацын цагаан нуур, Бөөнцагаан нуур, Адгийн цагаан нуур) 1998 онд, Хар-Ус, Айраг нуурыг 1999 онд тус тус бүртгэжээ. 38-р чиглэл, II. 24-ыг үз.

Зүүн хойд Азийн тогоруу хамгаалах олон улсын сүлжээнд Монгол дагуурын Дархан цаазат газарыг 1997 онд бүртгэн авчээ. (II-ын 5-ыг үз.)

Зүүн хойд Азийн галуу, нугасны овгийн шувуудыг хамгаалах олон улсын сүлжээнд Тэрхийн цагаан нуур, Өгий нуурууд 1999 онд бүртгэгдээд байна. (II-ын 16, ба 18-р чиглэлд үз.)

### **Улсын тусгай хамгаалалттай газрууд**

Манай улсад улсын тусгай хамгаалалттай газар нутгийг 1994 он хүртэл ганцхан дархан цаазат газар гэдэг зэрглэлээр тогтоож байв.

Харин Улсын Их Хурлаас 1994 оны 11 дүгээр сард баталсан "Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай" хууль ёсоор манай улсад улсын хамгаалалтад авах газар нутгийг олон улсын жишигт нийцүүлэн дараах дөрвөн дэсэд хуваах болсныг дурдвал.

**Дархан цаазат газар**

**Байгалийн цогцолборт газар**

**Байгалийн нөөц газар**

**Дурсгалт газар эдгээр болно.**

Манай улс 2002 оны эцсийн байдлаар 207 орчим мян. ам км талбай буюу улсын нутгийн 13.2 гаруй хувийг эзлэх 50 газар нутгийг улсын тусгай хамгаалалтад аваад байна. Цаашид улсын тусгай хамгаалалтад авахаар төлөвлөж байгаа газар нутаг олон байна. Улсын хамгаалалтад авсан газар нутгаар аялахдаа "Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай" хуулийг мөрдөнө.

## **Дархан цаазат газар**

“Байгалийн бүс, бүслүүрийн онцлог, хэв шинжийг төлөөлж чадах, унаган төрхөө хадгалсан байдал, шинжлэх ухааны ач холбогдолыг нь харгалзан байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг дархан цаазат газар гэнэ” гэж хуулинд заажээ.

### **Дархан цаазат газар**

**1. Богдхан уул.** Улаанбаатар хотын чимэг болон орших Богдхан уул нь 1778 оноос онголон дархлагдаж ирсэн Дэлхийн анхны дархан газрын нэг юм.

Хэнтийн нурууны баруун урд захад орших Богдхан уул нь герцины атираатлаар тогтсон, энд дунд төрмөлийн эриний боржиндуу чулуулаг зонхилно. Оргил нь д.т.д. 2256м өргөгдсөн Цэцээ гүн юм. Богдхан уул нь шинэс голлосон ой хөвчтэй бөгөөд хуш, гацуур, хус, улиас, хайлас зэрэг модод, нохой хошуу зэрэг бут болон дигд, сөд, алирс гэх зэрэг эмийн болон өвслөг 220 гаруй зүйлийн ургамал ургана. Ойн буга, хүдэр, бор гөрөөс, янгир, зэрлэг гахай гэхчлэн олон зүйл ан амьтан, араатан, сар, тоншуул, өрөвтас зэрэг жигүүртэн амьдарна. Богдхан уулын олон ам хөндийд 3000 жилийн түүхийг хадгалсан түүхийн дурсгалт зүйлс хадны сүг зураг их байдаг, энэ уулыг бараг хормойгоор нь буюу 417 ам км талбайг хамруулан дархлан хамгаалж байна. Сибирийн их тайга Богдхан уулын ойгоор төгсөнө гэж оросын жуулчид бичсэн байдаг, Богдхан уул нь Монголын их тахилгатай уулын нэг билээ. Богдхан уулыг Монголын их тахилгатай уулынх нь хувьд ЮНЕСКО “Дэлхийн гайхамшигт үнэт зүйл болох нь” зэрэглэлээр үнэлэн дэлхийн байгалийн өв гэж “Дэлхийн хүн ба шим мандлын нөөц газрын сүлжээ”-нд 1996 онд бүртгэн авчээ. (Төв аймгийн зургийг үз)

**2. Хөхсэрхийн нуруу.** Ховд, Баян-Өлгий аймгийн нутгийн зааг дээр Монгол Алтайн нурууны хойд салбар уул болох Гурван цаст уулаас зүүн урагшаа 50 гаруй км

үргэлжилэн тогтсон том нуруу юм. Оргил нь мөнхцаст Тахилтын уул 4019 м өндөр. Энд янгир элбэг байдаг учраас түүнийг нас гүйцсэн эр ямааны нэрээр Хөхсэрхийн нуруу гэж нэрлэжээ. Цавчим ам хөндийтэй, шовх оргилтой уулын таг царам учраас хүн бараг нутагладаггүй болохоор энд нэн ховор, ховор **ирвэс, аргаль, янгир, суусар, шилүүс, хойлог** зэрэг амьтад, жигүүртэн шувууд элбэг юм.

Энэ уулын дээд биеийн 50 орчим км урт, 20 орчим км өргөн, 659 ам км талбайг хамарсан нутгийг 1977 оноос дархлан хамгаалж байна. Ховд аймгийн төвөөс баруун тийш 70 км зайтай оршино. Баян-Өлгийн 67-р, Ховдын 62-р чиглэлээс очиж болно. Ховд, Баян-Өлгий аймгийн зургийг үз.

**3. Говийн их дархан газар.** Говийн их дархан газар нь "А", "Б" гэсэн хоёр хэсэгтэй, "А" хэсэг нь Баянхонгор, Говь-Алтай аймгийн хамгийн урд захын улсын хилээс нааш 100 орчим км өргөн газрыг хамрах бөгөөд энд Эдрэнгийн нуруу, Атас, Чингис, Сэгс Цагаанбогд, Арсланхайрхан, Шивээт-Улаан, Ланзат, Цувилуур Харын нуруу, Хуцын шанд зэрэг говь цөлийн бүсийн уулууд, Номин, Цэнхэр зэрэг нүд алдам уудам говь хөндийг багтаасан 45149 ам км талбайтай нутаг юм. "Б" хэсэг нь Ховд, Говь-Алтай аймгийн нутгийн заагийн урд захын улсын хилээс нааш 80 аад км өргөн газрыг хамрах бөгөөд энд Алтайн Өвөр говь, Зүүнгарын говь, Баруунхуурай, Борцонжийн говийн өмнөд хэсэг, Хонин Усны говийг багтаасан 7968 ам км талбайтай нутаг юм.

Говийн их дархан газар нь нийтдээ 53117,3 ам км буюу дэлхийн хамгийн их талбайтай дархан газрын нэг 1975 оноос дархлан хамгаалж байна. Дархан газрын нутагт манхт элсэн толгод бараг байхгүй, ихэнх нутаг нь хуурай цөлийн бүсэнд багтах боловч Эхийн гол, Цагаанбургасны, Шархулсны, Талын мэлтэсийн зэрэг баянбүрд олонтой юм. Зундаа их халдаг, өвөлдөө тийм их хүйтэрдэггүй. Энд орших эхийн голд 44.8° хүрч халж байсан нь манай орны





үргэлжилэн тогтсон том нуруу юм. Оргил нь мөнхцаст Тахилтын уул 4019 м өндөр. Энд янгир элбэг байдаг учраас түүнийг нас гүйцсэн эр ямааны нэрээр Хөхсэрхийн нуруу гэж нэрлэжээ. Цавчим ам хөндийтэй, шовх оргилтой уулын таг царам учраас хүн бараг нутагладаггүй болохоор энд нэн ховор, ховор **ирвэс, аргаль, янгир, суусар, шилүүс, хойлог** зэрэг амьтад, жигүүртэн шувууд элбэг юм.

Энэ уулын дээд биеийн 50 орчим км урт, 20 орчим км өргөн, 659 ам км талбайг хамарсан нутгийг 1977 оноос дархлан хамгаалж байна. Ховд аймгийн төвөөс баруун тийш 70 км зайтай оршино. Баян-Өлгийн 67-р, Ховдын 62-р чиглэлээс очиж болно. Ховд, Баян-Өлгий аймгийн зургийг үз.

**3. Говийн их дархан газар.** Говийн их дархан газар нь "А", "Б" гэсэн хоёр хэсэгтэй, "А" хэсэг нь Баянхонгор, Говь-Алтай аймгийн хамгийн урд захын улсын хилээс нааш 100 орчим км өргөн газрыг хамрах бөгөөд энд Эдрэнгийн нуруу, Атас, Чингис, Сэгс Цагаанбогд, Арсланхайрхан, Шивээт-Улаан, Ланзат, Цувилуур Харын нуруу, Хуцын шанд зэрэг говь цөлийн бүсийн уулууд, Номин, Цэнхэр зэрэг нүд алдам уудам говь хөндийг багтаасан 45149 ам км талбайтай нутаг юм. "Б" хэсэг нь Ховд, Говь-Алтай аймгийн нутгийн заагийн урд захын улсын хилээс нааш 80 аад км өргөн газрыг хамрах бөгөөд энд Алтайн Өвөр говь, Зүүнгарын говь, Баруунхуурай, Борцонжийн говийн өмнөд хэсэг, Хонин Усны говийг багтаасан 7968 ам км талбайтай нутаг юм.

Говийн их дархан газар нь нийтдээ 53117,3 ам км буюу дэлхийн хамгийн их талбайтай дархан газрын нэг 1975 оноос дархлан хамгаалж байна. Дархан газрын нутагт манхт элсэн толгод бараг байхгүй, ихэнх нутаг нь хуурай цөлийн бүсэнд багтах боловч Эхийн гол, Цагаанбургасны, Шархулсны, Талын мэлтэсийн зэрэг баянбүрд олонтой юм. Зундаа их халдаг, өвөлдөө тийм их хүйтэрдэггүй. Энд орших эхийн голд 44.8° хүрч халж байсан нь манай орны





Дэлхийн зайлшгүй хамгаалах ёстой 200 бүс нутгийн нэг юм. Чойбалсан хотоос 270 км, Эрээнцав сумын төвд ойрхон оршино. Манай энэ дархан газрын цаана ОХУ-ын Чита мужид Дагуурын дархан газар, БНХАУ-ын ӨМӨЗО-ны нутагт Далай нуурын дархан газар байдаг. Энэ бүс нутагт олон улсын дархан газар байгуулах асуудлыг Монгол, Орос, Хятад улс 1994 онд хэлэлцэн тохирчээ. Дорнод аймгийн 32-р чиглэлээс очно. Дорнод аймгийн зургийг үз.

**6. Нөмрөг гол.** Нөмрөг голын сав нь манай улсын нутгийн зүүн захаар орших Иххянганы уулсын баруун хойд захын хэсгийн уулын ойт хээр, хээрийн газарзүйн биеэ даасан муж болох үлэмж онцлог нутаг юм. Чойбалсан хотоос зүүн урагш 420 км, Халх гол сумын төвөөс 80 км зайтай оршино. 1992 оноос дархалсан Халх голын цутгал, Нөмрөг голуудын савд орших энэ дархан газар 3112 ам км талбай эзлэнэ. Энд нэн ховор **цээнэ, сибирийн агдаргана, уссури яшил**, нягт сонгино, **дагуур сараана** болон тэсхэй тэсмэг зэрэг олон зүйлийн ховор ургамал ургаж тоодог, **цэн тогоруу, гургуул** зэрэг жигүүртэн **хар мөрний хандгай, халиу** зэрэг нэн ховор амьтад амьдарна. Халх, Нөмрөг голуудын савд МНТ-нд Далан Нэмүргэ, Хянганы даваа, Абжиа, Хүдгэр, Тэмээн Хяр гэж гардаг газрууд бий. /1. 26/ Дорнод аймгийн 31-р чиглэлээс очно. Дорнод аймгийн зургийг үз.

**7. Монголын Дорнодын тал.** Энэ нутаг нь Дэлхийн хэмжээнд хүний аж ахуйн үйл ажиллагаанд өртөөгүй хуурай хээрийн байгалийн унаган төрх байдлаа хадгалж үлдсэн бэлчээрийн арвин их нөөц бүхий цөөн тал газрын нэг юм. 1992 оноос хамгаалагдсан энэ дархан газар нь 5704 ам. км талбайтай бөгөөд Мэнэнгийн тал Лагийн хоолойг хамран Дорнод, Сүхбаатар аймгийн нутгийн заагт оршино. Энэ их талд нэн ховор **цэн тогоруу, цагаан тогоруу, гургуул, жороо тоодог** зэрэг олон зүйлийн шувууд бий. МУН-д орсон бүх ургамлын арав орчим хувь нь энд ургадаг бөгөөд Төв Азийн цагаан зээрийн дал гаруй хувь нь амьдардаг хуурай хээр, Чойбалсан хотоос

урагш 240 орчим км зайтай оршино. Дорнод аймгийн 31-р чиглэлээс, Сүхбаатар аймгийн 33-р чиглэлээс очно. Дорнод, Сүхбаатар аймгийн зургийг үз.

**8. Отгонтэнгэр уул.** Хангайн нурууны ноён оргил Отгонтэнгэрийг, түүний орчны уулсыг оролцуулан 955 ам км талбайг хамруулан 1992 оноос дархлан хамгаалж байна. Отгонтэнгэр уулын ноён оргил 4021 м өндөр өргөгдсөн бөгөөд түүний 3752 м-ээс дээш өндөрт мөнх цастай юм. Мөнх цасны хилээс доошхно уулын энгэрт дархан газрын бүсэнд Бадархундага гэдэг үзэсгэлэнт нуур бий. Энэ уул нь эртнээс онголон тахисаар ирсэн Монголын их тахилгатай уулын нэг энэ уулыг монголын тахилгатай уулынх нь хувьд болон, эртнээс хамгаалагдаж ирсэн уулынх нь хувьд ЮНЕСКО "Дэлхийн гайхамшигт үнэт зүйл болох нь" зэрэглэлээр дэлхийн байгалийн өв гэж бүртгэн авах санал гаргажээ. Отгонтэнгэр ууланд нэн ховор **вансэмбэрүү** болон монгол алтан хундага, хунчир зэрэг ховор ургамал ургадгаас гадна Отгонтэнгэрийн арц гэж Монгол даяар алдаршсан арц ургадаг. Мөн энд **хүдэр, ирвэс, аргаль, буга, янгир** зэрэг нэн ховор, ховор амьтад амьдардаг. Отгонтэнгэр нь Улиастай хотоос зүүн тийш 100 км, амралтын газраас урагш 20 гаруй км зайтай оршино. Завхан аймгийн 56-р чиглэлээс очно. Завхан аймгийн зургийг үз.

**9. Увс нуурын ай савын дархан газар.** Энэ дархан газарт Увс нуур, Хархираа уул, Түргэний уул, Торхлог гол, Тэсийн голын адаг, Цагааншувуут уул, Алтан элсийг хамарсан 7125 ам. км талбайтай нутаг багтана. Энэ багахан нутагт манхт элст говь нутгаас хээр тал, уулын хээр, ой мод, тагийн бүс, мөнх цаст оргил зэрэг байгалийн 5 бүсийн төрх байдлыг нэг зэрэг үзэж болох сонин нутаг юм. Ууландаа аргаль, янгир, монгол тарвага зэрэг амьтад, нуур усандаа борцгор хотон, халбаган хошуут, хээр талдаа нэн ховор **жороо тоодог** зэрэг амьтан жигүүртэн, хонхот харгана, чацаргана зэрэг ургамалтай байгалийн сонин сайхан төрх байдлаа алдаагүй үзэсгэлэнт нутаг юм. 1993 оноос дархлан хамгаалж байна. Увс нуурын сав газар

## Байгалийн цогцолборт газар

"Байгалийн унаган төрхөө харьцангуй хадгалсан түүх, соёл, шинжлэх ухааны болон танин мэдэхүй, экологийн хүмүүжилд ач холбогдол бүхий улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг байгалийн цогцолборт газар гэнэ" гэж дээр дурдсан хуулинд заажээ. Ийм газарт дараах газруудыг оруулсан байна.

**13. Хөвсгөл орчмын нутаг.** Үүнд: Хөвсгөл нуур, түүний сав газар, Эгийн голын эх, Үүр голын сав газар, Зүүнсоёны усны хагабарын хэсэг зэрэг нийтдээ 8381 ам км талбайтай нутаг багтах бөгөөд энэ нутгийг 1992 оноос улсын хамгаалалтад аваад байна. Энд 30-40 өрх цаатан ард түмэн бугын аж ахуй эрхлэн өндөр уулын ой тайгаар нүүдэллэн амьдардаг. Энэ хавийн нутгийг Хөвсгөл нуур ба бөө мөргөлтэй цаатангуудын амьдардаг газар нутгийг оролцуулан "Дэлхийн гайхамшигт үнэт зүйл болох нь" гэж ЮНЕСКО үнэлэн 1996 онд дэлхийн соёлын өвд бүртгэн авах санал гаргажээ. Хөвсгөлийн байгалийн цогцолборт газрыг ОХУ-ын хил дагуух тусгай хамгаалалттай газруудтай нь хамт Монгол-Оросын хамтарсан дархан цаазат газар байгуулах асуудлыг ярилцаж байна.

Эндэх их ой тайгад ямаан сэрдэг, вансэмбрүү зэрэг нэн ховор ургамал ургаж **хүдэр, умардын халиу, ирвэс** зэрэг нэн ховор амьтад, сибирийн хандгай ойн цаа буга, алтайн аргаль, янгир, буга, бор гөрөөс гахай зэрэг ховор амьтад, хар өрөвтас, явлаг сар, хурган тутгалжин зэрэг жигүүртэн шувууд амьдарна.

**Хөвсгөл нуур.** Монгол орны нутгийн хойд хэсэгт Хорьдол Сарьдаг уулын шовх оргилт салбаруудаар хүрээлэгдэн д.т.д. 1624 мт өндөрт 2620 ам км талбайг эзлэн Мөрөн хотоос 102 км зайтай оршино. Хөвсгөл нуур хойш урагшаа 134 км, өргөөшөө 39 км бөгөөд энэ нуурт 5300 ам км талбайгаас усжих 46 гол горхи цутгаж ганцхан Эгийн гол эх авч урсана. Хөвсгөл нуур нь Төв Азийн хамгийн гүн /262м/ нуур бөгөөд түүний усны нөөц нь 380 шоо км юм. Усны нөөцөөрөө Азид 2,

**16. Хорго. Тэрхийн цагаан нуур.** Хорго бол Архангай аймгийн Тариат сумын төвийн дэргэд Тэрхийн Цагаан нуурын зүүн, Суман голын хойд биеэр орших хэдхэн мянган жилийн өмнө /эрдэмтэд 8 орчим мян. жилийн өмнө гэж үздэг. / оргилж байгаад унтарсан галт уулын хүрмэн чулуун гадаргат нутаг. Хорго гэж нэрлэгдэх энэ нутгийн хойд захад орших 2240 метр өндөр Хоргын Тогоо уул, Тэрхийн Цагаан нуурыг оролцуулан бүгд 773 ам. км талбайтай нутгийг 1965 оноос дархлан хамгаалж байна. Тогоо уул нь 200 орчим м өргөн, 100 гаруй м гүнзгий бөгөөд давхар амсартай тогоотой.

Араар нь ба амсараар нь шинэс мод ургасан. Ер нь хоргот самрын хуш зэрэг шилмүүст ойн мод өвс ургамал элбэг. Хоргын урд хэсгээр халуун лаавын царцах үеийн хийн хөөсний хальсанцараас үүссэн хүрмэн чулуун "гэрүүд" бий. Зарим чулуун гэр нь "үүд", тооно"-той, өндөр нь 1, 7 м хүрдэг. Мөн Хоргод агуй хонгил олон бий. Хоргоос урагш холгүй хэд хэдэн унтарсан галт уул орших бөгөөд эндээс эрдэнийн чулуу олдсон байна. Хоргын хавь нутагт буга, бор гөрөөс, аргаль, гахай зэрэг ховор амьтад, ангир, нугас зэрэг шувууд бий. Тэрхийн цагаан нуурын Толгойд гогой зуны цагт олноороо цугларч өндөглөдөг. Рамсарын конвенцийн жагсаалтад болон Зүүнхөйд Азийн галуу, нугасны овгийн шувуудыг хамгаалах олон улсын сүлжээнд 1999 бүртгэгджээ. Архангайн 18-р чиглэлээс очно. Архангай аймгийн зургийг үз. Олон улсын байгаль хамгаалал гарчигийг үз.

**17. Алтай Таванбогд.** Монгол Алтайн нуруу нь Монголын баруун захаас Говь-Алтай аймгийн нутгийг өнгөртөл 900 гаруй км үргэлжилдэг юм. Хамгийн өндөр цэг нь улсын хил дээр орших Хүйтэн оргил 4374 м өндөр. Алтай Таванбогдын хамгийн баруун захын мөнх цаст уулууд, уулын нуга, хээрт Ёлт, Өвчүү уулууд Хотон, Хоргон нууруудыг оролцуулан 1996 оноос 6362 ам км талбайгаар улсын тусгай хамгаалалтад авчээ. Баян-Өлгий 67-р чиглэлээс очно. Баян-Өлгий аймгийн зургийг үз.



**18. Хангайн нуруу.** Монгол орны нутгийн төв хэсгээр Завхан аймгийн нутгаас Төв аймгийн нутаг хүртэл 800 орчим км үргэлжилсэн том нуруу, Дэлхий усны хагалбар болдог. Хамгийн өндөр оргил нь 4021 м өндөр Отгонтэнгэр. Ой хөвч, ус гол, мөрөн амьтан, жигүүртэн, рашаан, ус ихтэй монголын үзэсгэлэнт сайхан нутгийн нэг. Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймгийн нутгийн заагаар орших гол нурууны уулын нуга, уулын хээр, ойт-хээрт 8885 ам км талбайг хамруулан 1996 оноос улсын тусгай хамгаалалтад авчээ. Хамгаалалтын энэ бүсэд Орхон голын эх, Улаанцутгалангийн хүрхрээ, Хархорин хүртлэх Орхон голын хөндий хамрагдана. Баянхонгорын 38, 39-р, Архангайн 18-р, Өвөрхангайн 13-р, 17-р чиглэлээс очно. Архангай, Өвөрхангай, Баянхонгорын зургийг үз.

**19. Хар-ус нуур.** Монголын том нууруудын нэг 1153 ам. км талбайтай 72 км урт, 26 км өргөн, дундаа аралтай урд захаараа хулс, шагшуурга ихтэй нуур. Рамсарын Конвенцийн хавсралтын жагсаалтад орсон. ОУ-ын байгаль хамгааллын ажилыг үз. Алтайн шар загас, монгол хадран зэрэг загас элбэг бий. Зэгсний гахай зэрэг ховор амьтадтай цөлжүү хээр, заримдаг цөлийг Хар-Ус, Хар, Дөргөн нууруудыг оролцуулан 1997 оноос 8503 ам км талбайгаар улсын тусгай хамгаалалтад авсан байна. Ховдын 60, Говь-Алтайн 44, Завханы 58-р чиглэлээс очно. Ховд, Говь-Алтай, Завханы зургийг үз.

**20. Ноёнхангай уул.** Архангай аймгийн Хангай сумын нутагт орших Хангайн нурууны салбар энэ уулыг Хатанхангай уулыг оролцуулан 1998 онсоос 591 ам км газраар улсын тусгай хамгаалалтад авсан байна. Архангайн 18-р чиглэлээс очно. Архангай аймгийн зургийг үз.

**21. Хустайн нуруу.** Төв аймгийн Алтанбулаг сумын нутагт Улаанбаатараас баруун тийш 90 орчим км-т Лүн сум орох замын урд харагдах 1842 м өндөр уул. Хэнтий ой тайгаас хол оршдог боловч хус голлосон их ойтой сайхан уул. Энд 1992 оноос тахь нутагшуулах Монгол, Голландын хамтарсан "Тахь" төслийг хэрэгжүүлж 506 ам



км талбайг 1993 оноос улсын тусгай хамгаалалтад авсан. 1998 оноос Байгалийн цогцолборт газар болгов. Хустайн нуруунаас баруун хойш холгүй орших Молцог элсийг 2, 5 км голчтой тойргоор улсын хамгаалалтад бас авсан. Төв аймгийн 12-р чиглэлээс очно. Төв аймгийн зургийг үз.

**22. Тарвагатайн нуруу.** Архангай, Завхан аймгийн нутгийн заагаар орших 5254 ам км талбайгаар 2000 онд УТХ-д авчээ. Манай орны хамгийн том мөрөн болох Сэлэнгийн урсгалын эх ус хагалбарын нуруу, үзэсгэлэнт байгальтай түүх соёлын дурсгалтай нутаг, Архангайн 18-р, Завханы 59-р чиглэлээс очиж болно. Архангай, Завханы зургийг үз.

**23. Сийлхэмийн нуруу.** Баян-өлгий аймгийн нутгийн баруун хойд захаар орших нуруу, уулын алтайн аргалийн байршил нөөцийг хамгаалах зорилгоор 2000 онд 1401 ам. км талбайгаар УТХ-д авчээ. Баян-Өлгийн 69-р чиглэлээс очно. Баян-Өлгий аймгийн зургийг үз.

**24. Ханхөхий-Хяргас нуур.** Ханхөхийн нурууг 2205 ам км талбайгаар, Хяргас нуур орчмыг 3320 ам км бүгд 5525 ам км талбайгаар 2000 онд УТХ-д авчээ. Ханхөхий нуруу нь цөлийн хээрийн бүс нэмэгдэх үйл явцыг хязгаарладаг экологийн тэнцлийн чухал ач холбогдолтой газар юм. Хяргас-Айраг нуур нь олон улсын Гео-биосферийн судалгааны бүсэнд багтдаг нутаг. ОУ-ын байгаль хамгаалал гарчигийг үз.

**Ханхөхий уул.** Хангайн нурууны баруун хойд залгаа болж оршино. Оргил нь Алтан Дуулга уул д.т.д. 2928 м өндөр. Мөн Буштаг, Алтанбургас зэрэг сайхан уулууд бий. Ханхөхий уул нь ой мод, ус, гол хэлбэртэй том уул юм. Энэ ууланд оршдог Хяргас сум нь манай алдарт бөх дархан аварга, хөдөлмөрийн баатар Х.Баянмөнхийн төрсөн нутаг юм. Ханхөхийд Увсын 63-р чиглэлээс очно.

**Хяргас нуур.** Манай том нууруудын нэг д.т.д. 1028 м өндөрт оршино. 1406 ам км талбайтай. 75 км урт 31 км өргөн, гүн нь 80 м хүрнэ. Айраг нууртай хоолойгоор

холбогдсон бөгөөд Айраг нуурт алтайн шар загас, монгол хадран бий. Хяргас нь гадагшаа урсгалгүй, хүхэр хүчлийн натри голлосон давстай нуур. Усны шувууд их цуглардаг, Рамсарын конвекцийн жагсаалтад орсон нуур. Хяргас нууранд Увсын 64, Завханы 59-р чиглэлээс очно. Увс аймгийн зургийг үз. ОУ-ын байгаль хамгаалал гарчигийг үз.

**25. Цамбагарав уул.** Ховд, Баян-өлгий аймгийн нутгийн заагаар орших энэ уулыг 2000 онд 1109 ам км талбайгаар УТХ-д авсны учир нь энэ уул мөс судлалын ач холбогдолтой ирвэсний өсөлтийг хангах явдал юм. Ховдын 60-р чиглэл. Баян-Өлгийн 70-р чиглэлээс очно. Ховд, Баян-Өлгий аймгийн зургийг үз.

**26. Онон-Балжийн сав.** Хэнтий аймгийн нутгийн зүүн хойд зах, Дорнод аймгийн нутгийн баруун хойд захыг хамрах энэ нутгийг 2000 онд 4158 ам км талбайгаар 2 хэсэг газраар УТХ-д авчээ. Монгол орны умарт этгээдээс Сибирийн ой тайга уулсыг дагаж өмнө зүг рүү, өмнөдөөс Төв Азийн хуурай цөл хээр хөндий хотосыг дамжин умард руу гүн нэвтэрч газарзүйн орчныг маш өвөрмөц буюу завсарын шинжтэй болгодог. Хэнтийн 30-р, Дорнодын 32-р чиглэлээс очиж болно. Хэнтий, Дорнод аймгийн зургийг үз.

**27. Тужийн нарс.** Сэлэнгэ аймгийн Шаамар, Алтанбулаг сумын нутагт оршдог, монголд цор ганц тохиолддог тал газрын элсэн хөрсний нарсан ой. 2002 онд 800 ам км талбайгаар УТХ-д аваад байна. Сэлэнгийн 48-р чиглэлээс очно. Сэлэнгэ аймгийн зургийг үз.

**28. Мянган угалзат уулууд.** Монгол Алтайн гол нурууны хэсэг том нуруу. Ховд аймгийн нутагт Цэцэг нуурын хотгорын урдуур оршино. Ховор амьтан аргаль, янгир амьдардаг. 2002 онд 600 ам км талбайгаар УТХ-д аваад байна. Ховдын 61-р чиглэлээс очно. Ховд аймгийн зургийг үз.

## Байгалийн нөөц газар

“Байгалийн тодорхой хэв шинж, аль нэгэн нөөц баялагийг хамгаалах, хадгалах, нөхөн сэргээх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор улсын хамгаалалтад авсан газар нутгийг **байгалийн нөөц газар** гэнэ гэж дээр дурьдсан хуулинд дурьджээ. Энэ хуулинд байгалийн нөөц газрыг дараах 4 төрөлд хуваажээ.

- Байгалийн унаган төрх, хэв шинжийг хадгалах зорилго бүхий **байгалийн иж бүрдлийн нөөц газар**.
- Ховор, ховордсон ургамал, амьтныг хамгаалах тэдгээрийн нөхөн үржих нөхцөлийг бүрдүүлэх зорилго бүхий **биологийн нөөц газар**.
- Эртний амьтан ургамлын ховор олборыг байгалийн байдлаар нь хадгалах зорилго бүхий **байгалийн түүхэн олдворын нөөц газар**.
- Газрын өвөрмөц тогтоц илэрц, тэдгээрийн бүтцийг байгалийн байдлаар нь хадгалах зорилго бүхий **геологийн нөөц газар** болно.

Байгалийн нөөц газарт дараах газруудыг оруулсан байна.

**29. Улаан тайга уул.** Хөвсгөлийн мужийн баруун захад Хөг, Бүсийн голын сав дагуухь өндөр уулс багтана. 2003 онд 1080 ам км талбайгаар улсын тусгай хамгаалалтад авчээ. Эндэхийн ян сарьдаг бүхий уул нуруудад эртний тэгшрэлийн гадарга мөстлөгийн моренна, мөстлийн гаралтай нуур элбэгтэй. Энд жинхэнэ уулын тайгын бүслүүр тархснаараа онцлог, бас шинэ төрмөлийн эриний галт уулын хурдас их тархсан.

**30. Намнан уул.** Хөвсгөл аймгийн Тариалан, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутгийн заагт оршино. 2003 онд 296 ам км талбайгаар Улсын тусгай хамгаалалтад авчээ. Шинэс голлосон хуш бүхий ойтой, ховор амьтан ургамалтай.

**31. Ханжаргалант уул.** Булган аймгийн Бүрэнгийн нурууны баруун хэсэгт Уул, Чачиртай голын хооронд

Ш.Шагдар.

Монгол орноор жуулчлах зуун зам

Бугат сумын нутагт оршино. Эндэхийн байгалийн төрхийн өвөрмөц тогтоц, биологийн төрөл зүйлийг хамгаалах зорилгоор 2003 онд 600 ам км талбайгаар Улсын тусгай хамгаалалтад авчээ. Шинэс голлосон хус, улиас бүхий их ойтой, ой тайгын амьтанаар баялаг.

**32. Их газрын чулуу.** Дундговь аймгийн Говь-Угтаал зэрэг сумын нутаг, Монголын их боржингийн бүсэнд багтах боржин чулуун цохиот уул орчмын байгалийн төрхийн үзэсгэлэнт байдлыг хамгаалах зорилгоор 2003 онд 250 ам км талбайгаар Улсын тусгай хамгаалалтад авчээ. Тоонот, Агуйт зэрэг 40 гаруй агуйтай. Хээрийн өвслөг ургамал билчээр арвинтай.

**33. Даригангын байгалийн цогцолборт газар.** Ганга нуурын дурсгалт газрын Алтан-Овоо уул, Молцог элсийн оролцуулан 2004 онд 629 ам км талбайгаар Дарьгангын байгалийн цогцолборт газар болгожээ. Ганга, Холбоо, Эрдэнэ, Дуут нууруудад намартаа нэн ховор Гангар хунгийн чуулга болдог.

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутагт сумын төвөөс зүүн урагш 11 км-т Молцог элсний зүүн хойд захад түрж орж орших 4 ам км талбайтай нуур. Одоо томорч байгаа энэ нууранд намартаа хун шувуудын чуулга болох нь үнэхээр гайхамшигтай. Ганга нуур болон Молцог элс түүний захаар орших Холбоо, Сүмт нуурууд орчмын 329 ам км талбайтай нутгийг байгалийн дурсгалт газар болгон 1993 оноос улсын тусгай хамгаалалтад авсны учир бол энэ нууруудад нэн ховор Цэн тогоруу, гангар хун, хурган тутгалжин зэрэг ховор зүйл жигүүртэн шувууд ихээр цуглардаг явдал юм. Энэ нуурын тухай "Ганган байгалийг тольдсон Ганга нуур. . ." гэдэг дууг монголд хааяагүй дуулдаг нь ийм учиртай юм. Сүхбаатар аймгийн 35-р чиглэлээс очно. Молцог элсний захад орших Алтан-Овоо уулыг Ерөнхийлөгчийн 2004 оны зарлигаар Улсын их тахилгатай уул болгосон билээ.

Сүхбаатар аймгийн зургийг үз.

**34. Хөгнө-Тарнын байгалийн цогцолборт газар.**

Булган аймгийн Гурван булаг, Рашаант сумын нутаг. Энд тарнын яргай гэдэг ховор ургамал бий бөгөөд Тайгын болон хээрийн ургамал нэг дор ургадаг. Юу гэвэл энд Хангай Хэнтийн хушин ойгоос 200 гаруй км оршдог боловч Хөгнөхаан уулын ар хормойгоор шинэс, хусан холимог ойтой, оройгоор нь хушин ойтойгоороо онцлог юм. Ийм учраас 1997 онд Байгалийн нөөц (470 км<sup>2</sup>) газар болгосныг 2003 онхд 844 ам км талбайгаар байгалийн цогцолборт газар болгон өөрчилжээ.

Батхаан уулаас баруун хойш холгүй орших эртний төрмөлийн эриний боржин зэрэг магмын чулуулагаас тогтсон уул, МНТ-д Ханхархан гэдэг нэрээр гардаг гэдэг бөгөөд эндээс хойш, зүүн хойш МНТ-ны Наху гүн, Сайр хээр гэдэг газрууд оршдог. Хөгнөхааны урд аманд хоёр хийдийн туурийн хамгаалалтын бүсийг 42.9 га байхаар тогтжээ. Энэ нь XVII дугаар зуунд Монголчуудын барьсан хийдийн нэг. 1688 онд Галданбошигтын цэрэг эвдэж лам нарыг хөгнөсөн учир Хөгнөхаан гэж нэршжээ. Энэ хавьд "Мандухай хатан" киноны зураг авсан байна. Буга, бор гөрөөс бүхий үзэсгэлэнт тогтоцтой ойт хээрт Хөгнөхаан уулыг 1997 оноос 470 ам км талбайгаар улсын тусгай хамгаалалтад авчээ. Өвөрхангай 16-р, Булганы 45-р чиглэлээс очиж болно.

Булган аймгийн зургийг үз.

**35. Угтам уул.** Дорнод аймгийн Баяндун сумын төвөөс зүүн тийш 30-аад км зайтай орших д.т.д 1025 м өндөр уул. МУН-д орсон бөгөөд Монгол Дагуурын дархан газарт тархсан нэн ховор амьтан ургамалтай хээр талд орших боловч ой модтой энэ уулыг 462 ам км талбайг хамруулан 1993 оноос утх-д аваад байна. Дорнодын 32-р чиглэлээс очно.

Дорнод аймгийн зургийг үз.

**36. Шарга-Манханы тал.**

**А/ Шаргын говь.** Говь-Алтай аймгийн Тонхил, Дарви, Төгрөг, Халиун, Шарга сумдын нутагт орших том хонхор.

46с, Дово



Ш.Шагдар.

Монгол орноор жуулчлах зуун зам

Монголын дуу, шүлэг, домог ярианд орсон жинхэнэ говь нутаг, д.т.д. 984-1200 м өндөрт Алтай хотоос баруун тийш 90 км зайтай оршино. Урт нь 120 орчим км, өргөн нь 90 орчим юм. Говь-Алтайн 41-р чиглэлээс очно. Шаргын говийн төвд Шаргын Цагаан нуур оршино. Энэ нуур руу хүрээлж байгаа уулсаас эх авч урсах хэд хэдэн гол ирдэг. Зарим нь замдаа ширгэдэг. Энд зулзаган заган ойгоор аялана. Говь-Алтай аймгийн зургийг үз.

**Б/ Манханы тал.** Ховд хотоос зүүн урагш 70-аад км-т оршино. Шарга-Манханы талд ОУУН ба МУН-д орсон зөвхөн монголд л үлдсэн монгол бөхөн, соргог бөхөн зэрэг нэн ховор амьтан ургамал байдаг учраас нийт 3901 ам км талбайтай нутгийг 1993 оноос улсын тусгай хамгаалалтад авчээ. Ховдын 61-р чиглэлээс очно.



Ховд аймгийн зургийг үз.

**37. Нагалхаан уул.** Төв аймгийн нутагт Улаанбаатараас зүүн урагш 80 орчим км зайтай, Жанчивлангийн рашаан амралтын газрын зүүн өмнө оршдог уул юм. Хэнтийн нурууны өмнө захын төгсгөлийн хэсэг. Нагалхаан уул нь Богдхан уулын нэг адил герцины атираат уул бөгөөд энд эртний төрмөлийн эриний боржиндуу чулуулаг зонхилно. Д.т.д. 1970 м өндөр энэ уулын төв хэсгийн 500 орчим гектар талбай эзлэх шинэсэн ой нь Хэнтийн нурууны



хамгийн урд төгсгөлийн ой юм. Иймд энэ хавийн 31 ам км талбайтай нутгийг 1957 оноос дархлан хамгаалж байна. Энэ цагаан тугалганы үлэмж нөөцтэй орд бий. Төв аймгийн 7-р чиглэлээс очно.

Төв аймгийн зургийг үз.

**38. Батхаан уул.** Төв, Өвөрхангай аймгийн нутгийн заагаар 30 орчим км үргэлжилдэг нуруу. Оргил нь Батхаан уул д.т.д 2178 м өндөр. Улаанбаатараас баруун урагш 250 км, Эрдэнэсант сумын төвөөс 33 км зайтай орших Батхаан уулын төв хэсэг нь өвс ургамал ус намагтай, уулын хар шороон хөрстэй жинхэнэ ойт хээрийн байгалийн төрхтэй үзэсгэлэнтэй сайхан нутаг ажээ. Эндээс арваад гол горхи эх авч хойшоо урагшаа урсана. Батхаан уул нь ойт-хээрээс их тасархай урагш хээрийн бүсийн дотор орших бөгөөд тэр ч байтугай энэ уулын урд дор. Ар, Өвөр хоёр Жаргалант голын эхэнд Монгол элс гэж алдаршсан их элсний зах хүрч ирсэн байна. Аржаргалант голын манхт элсний захаас хайласны төгөлийг дамжин өгсөж хойшоо хяр даван Тольтын амны эх рүү ороход энэ чинь юу билээ гэхээр их ой руу орж явчихна. Хайлас бүхий манхт их элс, их ой хоёр ийм ойрхон орших нь Дэлхийд ховор. Байгалийн ийм ховор нандин тохиолт 219 ам км талбайтай Батхаан уулыг 1957 оноос дархлан хамгаалж байна. Батхаан уулын ойд хус, шинэс голлоно. Улиас, хусан торлог, бургас бий. Батхаан уул ан амьтан, жигүүртэн шувуудаар нэн баялаг ажээ. Буга тавь жараар сүрэглэж явна. Халхын нутгийн хүйс гэж нэрлэгдэж байсан. Энд хувирмал элсэн чулуу, боржин, гантиг, мөн бялхмал чулуулаг тархжээ. Батхаан ууланд ерхөг, хиаг болон сөд, бамбай, алтан гагнуур, ганга гэх зэрэг билчээрийн ба эмийн ургамал элбэг бий. Төв аймгийн 11-р, Өвөрхангайн 16-р чиглэлээс очно.

Төв, Өвөрхангай аймгийн зургийг үз.

**39. Лхачинвандад уул.** Манай улсын нутгийн зүүн өмнө захад Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын төвөөс зүүн урагш 70 гаруй км зайтай оршино. Энэ уулыг Баруун Зүүн Араат уулуудыг оролцуулан дунджаар

Ш.Шагдар.

Монгол орноор жуулчлах зуун зам

зүүнээс баруунаа 50 км урт, 20 км өргөн буюу 588 ам км талбайтай буга иддээшин нутагшиж буй газраар нь 1965 оноос дархлан хамгаалж байна. Аглаг их ой хөвчийн бугыг нүд алдам задгай талын том биш ууланд сүргээр нь харна гэдэг үнэхээр сонин юм. Бугын тоо 200 хүрнэ. Энд бас цагаан зээр, дорго, элбэнх зэрэг ховор амьтан бий.

1886 онд Өвөр Монголын нэг ноён Егүзэр хутагтад бугын хоёр ил бэлэглэсэн нь өсөж үржээд 1915 оны үед 100 орчим болж хашаандаа багтахгүй болохоор нь гаргаж тавьснаар энэ ууланд буга нутагших болжээ. Лхачинвандад д.т.д 1233 м өндөр бөгөөд баруун урагшаа зүүн хойшоо хушуурсан хавтгай, хадархаг оройтой 2-3 км орчим үргэлжилсэн дүнэгэр сайхан уул юм. Энэ хавь нутаг нь эртний төрмөлийн эриний ордовикийн болон триасын галавын янз бүрийн боржин, хадан цагаан, хувирмал занар зэрэг чулуулагтай, бэлчээрийн арвин их нөөцтэй. Зарим жил ам хөндийд нь яваа зээр харагдахтай үгүйтэй болохоор өвс тийм их өндөр ургадгаас гадна бургас, хайлас ч бага биш бий.

Дашрамд дурдахад Эрдэнэцагаан сумын нутгийн зүүн урд хэсгийн энэ хавь нутаг зундаа бороо хур элбэгтэй байдгийг Номхон далайн зуны улирлын (муссон) салхины нөлөө гэж үзэж болох юм. Сүхбаатар аймгийн 35-р чиглэлээс очно.

Сүхбаатар аймгийн зургийг үз.

**40. Булган гол.** Алтайн уулаас эх авч урагшаа Баян-Өлгий, Ховд аймгийн нутгаар 200 орчим км урсаад хил гарч Өлөнгөр нуурт цутгадаг гол. Булган голын азийн минж амьдардаг хэсэг буюу улсын хилээс нааш 25 км урт, голын 2 эргээс 2 тийшээ 1, 5 км өргөн газраар зааглагдсан 77 ам км талбайтай газрыг 1965 оноос дархлан хамгаалж байна. Булган голын хамгаалалттай газрын хил нь Ховд аймгийн Булган сумын төвөөс 20-иод км доороос эхэлнэ. Энд минж орших таатай нөхцөл болсон өндөр зөөлөн эрэг, их өвс ургамал, бургас, улиас, чацарганын шугуй бий. Минж үүрээ барих гэж улиасыг үүдэн шүдээрээ

мэрж тайрсан нь цүүцдсэн мэт байдаг. Минж нь голыг мод мөчрөөр боож усыг нь ихэсгэн бүдүүн модыг сал болгон урсгаж овоохойдоо ойртуулж авдаг учраас минжний овоохойд том том улиас ч байна. Энэ хавь нутагт хар сүүлтий, зэгсний гахай, аргаль, янгир зэрэг ховор амьтад цахлай, өрөвтас, галуу, гогой зэрэг жигүүртэн бий. Минжийг хамгаалах өсгөж үржүүлэх зорилгоор Ховд голд тавьсан нь өсөж үржиж байна. Булган сумын төв нь Ховд хотоос 314 км зайтай. Ховд аймгийн 61-р чиглэлээс очно.



Ховд аймгийн зургийг үз.

**41. Алагхайрхан уул.** Говь-Алтай аймгийн нутагт Монгол Алтайн гол нуруунаас урагшаа салбарлан орших д.т.д 3789 м өндөр том уул, ховор амьтан аргаль, янгир, шилүүс болон өндөр уулын ургамалтай уулын хээр учраас 1996 оноос 364 ам км талбайтайгаар улсын тусгай хамгаалалтад авчээ. Говь-Алтай аймгийн 41-р чиглэлээс очно.

Говь-Алтай аймгийн зургийг үз.

**42. Бурханбуудай уул.** Говь-Алтай аймгийн нутагт Бигэрийн хонхорын баруун урдуур Монгол Алтайн гол нуруунд орших д.т.д 3765 м өндөр том нуруу ховор, амьтан аргаль, янгир, шилүүс бүхий уулын хээрийн ургамалтай учраас 1996 оноос 521 ам км талбайтайгаар улсын хамгаалалтад авчээ. Говь-алтайн 41-р чиглэлээс очно.

Говь-Алтай аймгийн зургийг үз.

**43. Эргэлийн зоо.** Дорноговь аймгийн Хатанбулаг сумын төвөөс баруун хойш 30 орчим км-т орших намхан нуруу, арлуугаа эгц хажуутай. Эргэлийн зоо нь эртний амьтдын шим үлдэгдэл ихтэйгээр алдаршсан нутаг. Энд 40 гаруй сая жилийн тэртээ их намаг балчигийн хярс зэрэг амьтад элбэг амьдарч байжээ. Эндээс олдсон шинэ шим үлдэгдэл олборыг Ард гэдэг нэрээс гаралтай "Ардиномис", "Эргэлия" гэж нэрлэжээ. Эргэлийн зоогоос хойш холгүй Оцон хад гэдэг сонин хад бас хиргисүүр бий. Эргэлийн зоог 1996 оноос 609 ам км талбайтайгаар улсын тусгай хамгаалалтад авчээ. Дорноговийн 36-р чиглэлээс очно.

Дорноговийн зургийг үз.

**44. Их нартын уул.** Монголын их боржингийн бүсэнд багтах боржин чулуу хад цохионоостогтсон уул. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг. Ихборжингийн бүсийн тухай 34-р замаас үз. Говьд оршдог энэ ууланд бургас, хайластай үзэсгэлэнт олон ам бий нь сонин. Энд рашаан бий. Энд аргаль, янгир үзэж болно. Тэдгээр амны нэг нь их бургастай хадан хавцалт Бургасан ам юм. Нартын уулыг 1996 оноос 437 ам км талбайтайгаар улсын тусгай хамгаалалтад авчээ. Дорноговийн 37, Дундговийн 22-р чиглэлээс очно.

Дорноговь аймгийн зургийг үз.

**45. Загийн ус.** Дундговь, Дорноговь, Өмнөговь аймгийн нутгийн заагаар манай төвийн нутгаар хамгийн хойшоо орших загийн ой бүхий говь нутаг. Энэ нутгийг Модон овооны говийг оролцуулан 1996 оны 2736 ам км талбайтайгаар улсын тусгай хамгаалалтад авчээ. Дорноговийн 36-р, Дундговийн 21-р, Өмнөговийн 24-р чиглэлээс очно.

Дундговь, Дорноговь, Өмнөговь аймгийн зургийг үз.

**46. Хар Ямаат уул.** Түмэн цогт уул. Сүхбаатар, Хэнтий аймгийн нутгийн зааг дээр оршдог д.т.д 1358 м өндөр уул. Энэ уул хээр талд орших уулын хуурай хээр өвөрмөц тогтоцтой, ой модтой болж байгаа, буга зэрэг ховор

амьтадтай сайхан уул. Энд ацан цахилдаг, нэн ховор монгол бүрэлзгэнэ зэрэг ховор ургамал ургадаг. Энэ уулыг 1998 оноос 506 ам км талбайтайгаар улсын тусгай хамгаалалтад авчээ. Сүхбаатар аймгийн 34-р, Хэнтий аймгийн 29-р чиглэлээс очно.

Сүхбаатар, Хэнтий аймгийн зургийг үз.

**47. Тосон-Хулстай.** Дорнод, Хэнтий аймгийн нутгийн заагаар Хэрлэн голын хөндийд орших нуур намагт, зэгст нутаг. Энэ нутгийг 1998 оноос 4700 ам км талбайтайгаар улсын хамгаалалтад авчээ. Хэнтийн 30р, Дорнодын 32-р чиглэлээс очно.

Хэнтий, Дорнод аймгийн зургийг үз.

**48. Яхь нуур.** Чойбалсан хотоос хойш орших нуур, МНТ-д "Ураг цөл" гэж газрыг мөн гэж үздэг. /1. 14/ энэ нутгийг 1998 оноос 2514 ам км талбайтайгаар улсын тусгай хамгаалалтад авчээ. Цагаан зээрийн тархалтын хойд зах 28-р чиглэлд Чингисийн даланг үз. Дорнод аймгийн 32-р чиглэлээс очно.

Дорнод аймгийн зургийг үз.

**49. Дэвэл арал.** Баян-өлгий, Увс аймгийн нутгийн заагт Ачит нуураас гарсан Усан хоолойн гол, Ховд голын Дэвэл арал орчмын 103 ам км талбайг 2000 онд УТХ-д авчээ. Монголд ховордож байгаа гургуул, зэгсний гахай, минжний байршил нутаг төдийгүй чацарганы гол тархац нутаг, Баян-өлгийн 70-р чиглэлээс очно.

Баян-өлгий аймгийн зургийг үз.



## Дурсгалт газар

“Байгалийн өвөрмөц тогтоц, түүх, соёлын ул мөрийг уламжлагдан хадгалагдсан байгалийн байдлаар нь өвлөн үлдээх зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг **“Дурсгалт газар гэнэ”** гэж дээр дурьдсан хуулинд заажээ. Мөн энэ хуулинд дурсгалт газрыг байгалын түүх, соёлын дурсгалт газар гэж ялгасан бөгөөд **“Байгалийн дурсгалт газарт** өвөрмөц тогтоц, илэрц бүхий газар, хүрхрээ, хясаа хавцал, агуй, хад цохио, явар цонж, төгөл мод, рашаан булаг, элсэн манхан, солир, солирын цар, өрх, галт уулын тогоо зэргийг хамруулж болно.

**Түүх соёлын дурсгалт газарт** эртний хүний оромж отог бууц, агуй, сүг зураг, хадны бичээс, буган ба хүн чулуун хөшөө, булш, бунхан, эртний хот суурины үлдэгдэл, балгас, хэрэм цайз, суваг шуудуу, далан, эртний зэр зэвсэг хийж байсан орд, уламжлалт зан үйлтэй холбоотой уул овоо, тахилга бүхий болон түүхэн үйл явдал болсон газар зэргийг хамруулж болно” гэж заажээ.

Дурсгалт газарт дараах газруудыг оруулжээ.

**50/ Найман нуур.** Өвөрхангай аймгийн төв Арвайхээрээс 116 км, Уянга сумын төвөөс баруун хойш 50 км зайтай, Хангайн гол нурууны хэсэг Ивийн уул, Ширээтийн давааны араар Орхон голын эхэнд д.т.д 2200 орчим м өндөрт орших хоорондоо холбоотой ширээт /Хамгийн том/ Бугат, Халиут, Шанаа, Хаяа, Дөрөө, Хүйс, Шанага, Бага гэдэг есөн нуур. Шанага нуур нь жижиг учраас **Найман нуур** гэж нэршжээ. Найман нуур нь Хангайн гол нурууны Гятруун, Ивийн, Жаргалантын ба Намхайн нурууны шинэсэн их тайгат өндөр сүрлэг уулсын ам хөндий, хаяа хажуу руу түрэн шахаж ороод уулынхаа их ойг усандаа уруу харуулан буулгаж хараад ханашгүй үзэсгэлэнг бий болгожээ. Хүрээлэн байгаа уулс нь нуурын мандлаас 300-400 орчим м өндрөөсөө дээш ой модгүй таг болж нүцгэрэн байгалийн босоо бүслүүрийг үүсгэсэн нь орчны төрх байдлыг улам сүртэй болгоно. Ширээтийн даваан дээр зуны өдөр хүн хийсгэм хүчтэй салхитай, цас

---



бударч үүл сэмэрч байх нь ховор биш. Найман нуурын хавьд унтарсан галт уулын тогоонууд бий. Найман нуурын савын 115 ам км талбайтай нутгийг 1992 оноос улсын тусгай хамгаалалтад аваад байна. Энэ хавь нутагт хүдэр, буга, бор гөрөөс, аргаль, гахай, янгир, зэрэг ховор амьтад нугас, хойлог зэрэг жигдхртэн шувууд бий. Өвөрхангайн 17-р чиглэлээс очно.

Өвөрхангай аймгийн зургийг үз.

**51. Ээжхайрхан уул.** Уулын хажууд тогтсон тогооны



ус хальж доод талын тогоо руу урсана. Уулын оройн намгаас буусан ус ингэж нүцгэн боржин чулуун уулынхаа хажуу дээр шатлан тогтсон есөн тогоог дамжин болор тунгалаг боргио үүсгэн жирэлзэж урсана. Цөл нутгийн их нар салхи энэ уулын хажуу хормойн хад чулууг элдэв дүрстэй болгон элээж, нүх сүв гарган хонхойлгон ухсан нь уран хүн ухаан сийлж хийж гэлтэй.

Энэ бүгд бол их говийн алдарт д.т.д 2275 м өндөр Ээжхайрхан уулын үнэн төрх байдал юм. Тогоонууд нь дундажаар 2-3 м өргөн дугуй хэлбэртэй, гүн нь барагцаалбал 2-4 м, тогоо хоорондын зай нь 2-7 м хүрнэ. Энэ уулын есөн тогоо нь байгалийн гайхамшигт бүтээл юм. Ээжхайрхан уул Говьалтай аймгийн Цогт сумын нутагт Захуйн Баянбүрдийн баруун захад Алтай хотоос урагш 260 км Цээл сумын төвөөс 90 км, Цогт сумын төвөөс 70 км зайтай оршино. Ээжхайрханд заг, хөх ногоон зээргэнэ зэрэг говийн ургамал ургадаг. Ховор амьтад бий. Ээжхайрхан уулыг 225 ам км талбайг эзлэх хавь нутгийн хамт 1992 оноос улсын тусгай хамгаалалтад авчээ. Говьалтайн 41-р чиглэлээс очно.

Говьалтай аймгийн зургийг үз.

**52. Уран уул.** Уран уул нь Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутагт Булган хотоос баруун хойш 80 орчим км зайтай Булган хотоос Мөрөн орон авто их замын дэргэд баруухан талд нь орших унтарсан галт уул, Үнэмлэхүй өндөр нь 1686 м. Орой дээрээ тогоотой. Тогооны амсар нь 500-600 м өргөн гүн нь 50-60 м бөгөөд тогоондоо 20 орчим голчтой дугуй хэлбэртэй нууртай бас тогоон дотроо ой модтой сонин сайхан уул юм. Энд буга, аргаль, бор гөрөөс, гахай, янгир зэрэг амьтад, ангир, нугас зэрэг жигүүртэн шувууд бий. Энэ уул Улаанбаатар-Мөрөнгийн замд онгоцноос маш сайхан харагддаг. Тулга, Тогоо, Жалавч. Уулууд нь Уран уулаас урагш 12 км, Булган хотоос 70 км зайтай Урангийн хөндийн урд захад орших унтарсан галт уул. 1965 оноос дархлагдсан талбай нь Уран уулын хамт 58 ам км. Тулга уулын амсар нь сэтэрч Тулгын гурван чулуу шиг харагддаг учир Тулга гэж нэрлэгдсэн ажээ. Араараа шинэсэн ойтой Булганы 46-р чиглэлээс очно.

Булган аймгийн зургийг үз.

**53. Булган уул.** Архангай аймгийн төв Цэцэрлэг хотыг хойд талаас нь нөмрөлөн орших сүрлэг сайхан уулыг Булган уул гэдэг. Булган уулыг хааш хааш нь 6-8 км газраар зааглан 18 ам км талбайгаар 1965 оноос дархлан хамгаалж байна. Эгц цавчим энэ уулын 40 орчим хувийг таг, царам асга, цохио эзлэх бөгөөд ар, баруун, зүүн сугаар нь шинэс голлосон ой ургана. Энгэр өвөр нь хүн авирч болшгүй эгц нүцгэн хадан халил юм. Д.т.д. 1980 м өндөр. Энд туулайн тагнай, бугын зогдор зэрэг ховор ургамал ургах бөгөөд буга нэн ховор хүдэр, гахай гээд амьтан бий. Хур, сойр, ятуу, алаг шаазгай гээд олон зүйлийн шувууд амьдардаг үнэхээр баян тансаг, үзэсгэлэн төгөлдөр уул. Булган уулын баруун сугаар манай орны нэртэй том давааны нэг **Цагаан даваа** их ойн дотуур, уулын араар тахирлан мурилзан яаж өнгөрөх нь сонин сайхан. Архангай аймгийн 18-р чиглэлээс очно.

Архангай аймгийн зургийг үз.

**54. Сүйхэнтийн чулуужсан "ой".** Дорноговь аймгийн Мандах сумын нутагт Эргэлийн зоогоос баруун хойш 60 км орчимд Өлгий хийдийн тууриас баруун тийш 12 км зайтай орших Сүйхэнтийн "ой" нь мезозоин эриний юрийн галавын үеийн нуурын тунамал ургаагаараа дарагдаж чулуужсан мод юм.

Чулуужсан мод нь баруунаас зүүн тийш нийтдээ 500 м урт, 80 м өргөн талбайд тархжээ. Энд хагарч бутарсан хожуул, дархи унанги их тааралдах бөгөөд 20 м өндөртэй бүтэн мод ёзоороороо булгарч унасан байна. Чулуужсан модны голч нь 0, 5-1, 5 м хүрнэ. Моднуудын жилийн цагираг ч тод харагдана. Орчмын газар нь доош сууж ойн мод тэр үеийн нуурын усан дор орж аажмаар шаварлаг хурдасаар хучигдсаар модод нь ургаараа үлдэж хатуурсан нь энэ аж. Энэ бол дэлхийд ховор тохиолдох геологийн үнэт олборын нэг юм.

Сүйхэнтээс хойш 40 орчим км-т Цагаанцавд мөн чулуужсан ой бий. Цагаанцаваас хойш хар сүүлтийн сүрэг үзэж болох бөгөөд аймгийн хэмжээнд дархалсан газраар явна. Сүйхэнтийн ойролцоо цагаансуваргын зэсийн баялаг орд бий. Мандах сум орох замд Номтын хөшөөг үзэж болно. Сүйхэнтийг 1996 оноос 48 ам км талбайтайгаар улсын тусгай хамгаалалтад авчээ. Дорноговийн 36-р чиглэлээс очно.

Дорноговь аймгийн зургийг үз.

**55. Шилийн богд, Хөргийн хөндий.** Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутаг, Дарьгангын тэгш өндөрлөг мужид 222 унтарсан галт уул бий. Түүний хамгийн өндөр нь 1778 м өндөр Шилийн Богд уул юм. Тунадас харьцангуй их 200-250 мм унана. Ургамал-газарзүйн мужлалаар бол Дорнод Монголын хээрийн тойрогт багтах хадлан бэлчээрийн маш их өвстэй. Ургамалжилт нь ойт-хээр, хээр, говийн бүсийн төлөөлөл болох ховор ургамалтай.


Улсын фондод жилдээ 1000 шахам тонн өвс бэлтгэдэг.


Ш.Шагдар.

Монгол орноор жуулчлах зуун зам

Хөрөгийн хөндий нь хар хүрэн, цайвар-хүрэн хөрстэй. Шилийн богдоос баруун хойш 7 хүн чулуу бүхий хөндий юм. Дарьгангынхан хүн чулууг хөрөг гэж нэрлэдэг. Энэ хөргүүд нь голдуу хүрмэн чулуугаар хийсэн тул бараг бүдүүн хийцтэй байна. Байгалийн болон түүхийн энэ чухал дурсгалтай газрыг 2004 онд Байгалийн дурсгалт газрын зэрэглэлээр 232 ам км талбайгаар Улсын тусгай хамгаалалтад авчээ.

Ингэснээр манай улсын тусгай хамгаалалттай нутгийн хэмжээ 209 мян ам км талбайтай болж монгол орны нутаг дэвсгэрийн 13.4 хувийг эзлэх юм.






### III бүлэг

## ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛИЙН ЗАМ

### Төв аймаг

**Төв аймаг.** 74 мян ам км нутагтай. 100 мян хүн амтай,



Аймгийн төв Зуунмод хот нь Богдхан уулын өвөрт д.т.д. 1529 м өндөрт Улаанбаатараас 43 м зайтай оршино. Аймгийн ихэнх нутаг Монголын төв хэсэгт Хэнтий нуруу ба түүний захын

намхан уул талыг эзлэн оршино. Хэнтийн нурууны оргил Асралтхайрхан 2800 м өндөр, Богдхан 2256 м Хийдийн Сарьдаг, Алтан-Өлгий зэрэг том уулууд бий. Зуунмод хотын агаарын жилийн дундаж температур нь  $-1, 7^{\circ}\text{C}$ , 1 сарынх нь  $-20, 5^{\circ}\text{C}$ , 7-р сарынх  $15, 4^{\circ}\text{C}$  жилд 282.5 мм тунадас унадаг, агаарын даралт I ба VII-р сард адилавар 842 орчим гПа байдаг. Салхины жилийн дундаж хурд 2, 5 м/сек бөгөөд хамгийн их салхитай 5 сард дунджаар 3.7 м/с байдаг. Аймгийн нутгаар Туул, Хараа зэрэг том голууд том жижиг нуурууд бий. Аймгийн нутагт Хэнтийн нуруунд ой тайга ихтэй бөгөөд олон зүйл ургамалтай, ой, тал хээрийн амьтад ихтэй.


Төв аймаг 1.6 сая малтай, малын дотор хонь ямаа олон бөгөөд адууны тоогоор /193 мян/, хонины тоогоор (900 мян) улсад тэргүүн байрын нэгийг эзэлнэ.

Ш.Шагдар.

Монгол орноор жуулчлах зуун зам

Хөрөгийн хөндий нь хар хүрэн, цайвар-хүрэн хөрстэй. Шилийн богдоос баруун хойш 7 хүн чулуу бүхий хөндий юм. Дарьгангынхан хүн чулууг хөрөг гэж нэрлэдэг. Энэ хөргүүд нь голдуу хүрмэн чулуугаар хийсэн тул бараг бүдүүн хийцтэй байна. Байгалийн болон түүхийн энэ чухал дурсгалтай газрыг 2004 онд Байгалийн дурсгалт газрын зэрэглэлээр 232 ам км талбайгаар Улсын тусгай хамгаалалтад авчээ.


Ингэснээр манай улсын тусгай хамгаалалттай нутгийн хэмжээ 209 мян ам км талбайтай болж монгол орны нутаг дэвсгэрийн 13.4 хувийг эзлэх юм.





Ш.Шагдар.

Монгол орноор жуулчлах зуун зам




### III бүлэг

## ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛИЙН ЗАМ

### Төв аймаг

**Төв аймаг.** 74 мян ам км нутагтай. 100 мян хүн амтай, Аймгийн төв Зуунмод хот нь Богдхан уулын өвөрт д.т.д. 1529 м өндөрт Улаанбаатараас 43 м зайтай оршино. Аймгийн ихэнх нутаг Монголын төв хэсэгт Хэнтий нуруу ба түүний захын



намхан уул талыг эзлэн оршино. Хэнтийн нурууны оргил Асралтхайрхан 2800 м өндөр, Богдхан 2256 м Хийдийн Сарьдаг, Алтан-Өлгий зэрэг том уулууд бий. Зуунмод хотын агаарын жилийн дундаж температур нь  $-1, 7^{\circ}\text{C}$ , 1 сарынх нь  $-20, 5^{\circ}\text{C}$ , 7-р сарынх  $15, 4^{\circ}\text{C}$  жилд 282.5 мм тунадас унадаг, агаарын даралт I ба VII-р сард адилавар 842 орчим гПа байдаг. Салхины жилийн дундаж хурд 2, 5 м/сек бөгөөд хамгийн их салхитай 5 сард дунджаар 3.7 м/с байдаг. Аймгийн нутгаар Туул, Хараа зэрэг том голууд том жижиг нуурууд бий. Аймгийн нутагт Хэнтийн нуруунд ой тайга ихтэй бөгөөд олон зүйл ургамалтай, ой, тал хээрийн амьтад ихтэй.

Төв аймаг 1.6 сая малтай, малын дотор хонь ямаа олон бөгөөд адууны тоогоор /193 мян/, хонины тоогоор (900 мян) улсад тэргүүн байрын нэгийг эзэлнэ.



Хойд хэсгийн сумдын нутгаар газар тариалан хөгжүүлсэн, манай улсын тарианы гол талбай бүхий аймаг. Төв аймгийн нутагт нийт 20 шахам жуулчны бааз ажилладагийг зохих газарт нь дурьдана.

**Мянганы зам.** Төв аймгийн нутгаар Улаанбаатар-Налайх-Баяндаваа-Эрдэнэ-Багануур-Хэрлэн гэж явж өнгөрнө. Баруун талдаа Улаанбаатар-Лүн-Хангайн даваа гэж өнгөрнө.

### 1 дүгээр чиглэл

#### Улаанбаатар-Зуунмод-Алтанбулаг-Улаанбаатар

#### Зорих гол үзмэр. Богдхан уул, Байгалийн музей

**Аялах зам.** Улаанбаатар-Зуунмод 43 км-Манзушир хийд 8 км- Зуунмод 8 км-Алтанбулаг 48 км-Улаанбаатар 52 км.

Замын урт 151 км хугацаа 1-2 өдөр.

#### Үзэх гол зүйлийн товч тайлбар.

**1. Улаанбаатар хот.** I-р бүлгийн Г-д-үз.

**2. Богдхан уул.** Улаанбаатар хотыг хүрээлж байгаа тахилгат 4 уулын нэг. Богдхан уулын тухай II бүлгийн 1-ийг үз. Богдхан уулын Жаргалантын аманд "Чингэс хааны хүрээ", Шажин хурахын аманд "Форест Лэнд", Бумбатын аманд "Бумбат" зэрэг жуулчны баазууд ажилладаг.

**3. Баянзүрх хайрханы** тухай 2-р чиглэлийн замд үз.

**4. Сонгинохайрхан уул.** Улаанбаатар хотын баруун захад Туул голын баруун гарт орших д.т.д 1653 м өндөр уул. Энэ уулын өврөөр МНТ-ны "Хар шугуй" оршдог гэж үздэг. Ар, Өвөрлүүгээ эгц цавчим хажуутай, ой модгүй, хадархаг энэ ууланд орших эртний дурсгалт булшуудыг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. Эндэх Дадарт уулны нэг булшнаас манай анхны археологич нэрт эрдэмтэн Д.Наваан алтан бүс олсноо Жамухын бүс мөн байх гэж үзжээ. /6. 145/

5. Манай улсын авто замын сүлжээний эхлэл 0.00

цэгт зориулсан 2 тэмдэг Улаанбаатар хотын Сүхбаатарын талбайд Төв шуудангийн дэргэд бий.

**6. Туул гол.** Хэнтийханаас эх авч Улаанбаатарын дэргэдүүр урсаад /819 км/ Орхонд цутгадаг. Нэн ховор Хилим болон алгана, тул, цагаан загас, цулбуурт, гутаар, хадран, цурхай, булуу цаган, зэвэг зэрэг загастай. Туулын савд өрөвтас, халбаган хушуут, галуу зэрэг ховор шувууд тааралддаг. Туул гол бол Монголчуудын эртнээс нутаглаж ирсэн манай алдарт гурван голын нэг билээ.

7. Улаанбаатар хотын **Буянт-Ухаа, Наадмын талбай**, морины уралдааны замыг үзэхээс гадна Туулын сав, **Сонгинохайрхан уул**, Зайсан толгой, Гачуурт, Их тэнгэрийн ам зэрэг газарт хуучин чулуун зэвсгийн дээд буюу 40000-12000 жилийн өмнөх үеийн дурсгалын зүйлүүдийг үзэж болно. **Их тэнгэрийн амны гачууртын хадны** сүг зургийг 1998 онд улсын тусгай хамгаалалтад авсан.

**8. Зуунмод** Төв аймгийн төв

**9. Манзуширын хийд**, уулын байгалийн музей

**Манзуширын хийд** нь Зуунмод хотоос зүүн хойш Богдхан уулын өврийн шинэсэн ойд д.т.д. 1800 орчим м өндөрт үзэсгэлэнт газар оршдог. Энэ хийдийн дэргэд уулын энгэрийн хадан дээр сийлбэрлэсэн том бурхадын зураг нь түүх, соёлын ховор нандин бүтээл юм. Энэ хийд туурь, сийлсэн хөргүүдтэй хадыг 1998 оноос 15.6 га талбайгаар улсын хамгаалалтад авчээ. /6, 260/ Энд буга зэрэг ховор амьтныг үзэж болно. 1733 онд байгуулсан энэ хийдийг нураасныг одоо сэргээж байна. Энд 1726 онд цутгаж хийсэн хүрэл тогоо байдаг. Энэ тогооны амсар нь 215 см диаметртэй, гүн нь 140 см, багтаамж нь 1800 л, хүнд нь 2 тонн ажээ. Энэ тогоонд 2 үхрийн буюу 10 хонины махыг чанахад 4 тэрэг түлээ түлдэг байжээ. Нэг удаад 1000 хүний хоол бэлтгэж болдог байсан гэнэ. Энд "Манзушир" жуулчны бааз ажилладаг.

10. Зуунмод хотын ойролцоо "**Өндөр дов**" гэдэг жуулчны бааз ажилладаг.

---

11. Алтанбулаг сумаар орж болно. Алтанбулаг сум орчмын талаар 11-р чиглэлд үз. Энэ суманд “Жагар жуулчны баз ажилладаг.

#### **Өөр замд шилжих**

Төв аймгийн нутгаар аялах аль ч замыг Зуунмод, Улаанбаатар хотоос эхэлж болно.

#### **2 дугаар чиглэл**

#### **Улаанбаатар-Тэрэлж- Улаанбаатар**

**Зорих гол үзмэр.** Хэнтийн хөвч, Тэрэлж, Горхи уул, гол горхи ховор амьтан ургамал

**Аялах зам.** Улаанбаатар-Налайх 35 км-Тэрэлж-35 км-Гүнжийн сүм 30 км-Тэрэлж 30 км-Тонъюукукийн хөшөө 50 км-Налайхаар дамжин Улаанбаатар 50 км замын урт 230 км хугацаа нь 1-2 өдөр


#### **Үзэх гол зүйлийн товч тайлбар.**

**1. Туул гол, Богдхан уулын тайлбарыг 1-р чиглэлийн замаас үз.**

**2. Баянзүрххайрхан уул.** Улаанбаатарын тахилгат дөрвөн уулын нэг цэргийн тахилгат “Чидом” хэмээх нохой шүтээнтэй д.т.д 1846 м өндөр уул. Хууччуулын өгүүлснээр монголын дайсан эртнээс нааш зүүн урд зүгээс орж ирж байсан тул түүний омгийг дарах гэж улс орноо хамгаалах цэргийн сүлд тугийг Баянзүрх уулнаа залж тахин түүний орчимд цэргээ байрлуулсаар ирсэн гэлцдэг аж. Одоо ч архан талд нь Хужирбуланд цэргийн анги бий. Манай улсад цэргийн тахилгатай уул 3 бий бөгөөд нөгөө хоёрыг нь 27, 33-р чиглэлээс үз.

**3. Налайхын уурхай.** 1910 аад оны үеэс ашиглаж эхэлсэн Дунд төрмөлийн эриний цэрдийн галавын настай нүүрсний уурхай. Жилдээ 600 мян тн нүүрс гаргадаг байв. Монгол орны нүүрсний 150 гаруй орд газрын нэг. Одоо Налайхад газрын тос боловсруулах үйлдвэр барьж байгаа.

Төв аймгийн нутгийн зураг



Масштаб: 1 см-т 37.3 км





**4. Тоньюкукийн бичигт хөшөө** Тайлбарыг 27-р чиглэлээс үз.

**5. Зуунмодны төгөл.** Налайхаас зүүн тийш 20 орчим км-т Элстийн голын баруун гарт Тэрэлж голын адгийн харалдаа Туул голын урд талд орших нарсны төгөл урьд их төгөл байсан гэдэг. 1696 онд Манжийн Энх-Амгалан хааны 1 бум гаруй цэрэгтэй Ойрод Монголын хаан Галданбошигтын цэрэг байлдсан Тэрэлжийн Зуунмод гэж түүхэнд тэмдэглэсэн нутаг.

**6. Горхи-Тэрэлжийн сав газар.** II-р бүлгийн 14-ийг үз.

**7. Тэрэлж гол.** Хэнтийн Асралтхайрхан уулын баруун урд хэсгийн Янгийн Сарьдагаас эх авч 70 гаруй км урсаад Туул голд цутгадаг уулын хурдан урсгалт тунгалаг уст том гол, Тэрэлжийн үзэсгэлэнт хөндийд “Тэрэлж” жуулчны бааз оршдог. Тэрэлжийн орчинд “Мираж” горхит, “Тэмүүжингийн отог”, “Ханхэнтий”, “Чингэс уулын өртөө”, “Гандан уул”, “Жалман” зэрэг жуулчны бааз ажилладаг.

**8. Гүнжийн сүм.** Тэрэлжийн баазаас зүүн хойш 30 км-т үзэсгэлэнт Баруунбаян голын эрэг, Эрдэнэ сумын нутагт орших Буддийн сүм. Халхын Түшээт хан Чахундорж, Манжийн Энх-Амгалан /Кансий/ хааны дэргэд амьдрах ахуйд нь ач хүү Дондовдоржийг эфу ноён гэж өргөмжлөн 6-р гүнжээ хатан болгон өгч ураг барилджээ.

Хатан болгож өгөхдөө Кансий хаан гүнждээ хичээнгүй Амарлингуй цол олгож 5 кг шижир алтан дэвтэрт сийлсэн “Алтан навчит өргөмжлөл” өгчээ. Гүнжийг нас барахад Эфу Дондовдорж шарилын сүм, цагаан гантиг гэрэлт хөшөөг 1740 онд босгосон байна.

Хичээнгүй Амирлангуй гүнж монголд элэгтэй болсны учир манжийн туршуулын гарт амь үрэгдсэн гэдэг. Эфи гэдэг нь Манжийн хааны хүргэн гэсэн үг. Гүнжийн сүмийг 1961 оноос улсын хамгаалалтад авчээ. /6. 253/

**9. Тэрэлжийн** жуулчны базаас урагш 10 орчим км-т Тэрэлж голын зүүн гарт Тэрэлж-Туулын бэлчэрт Их хүрээ 1733 онд өвөлжиж байжээ.

---

**Өөр замд шилжих.**

1. Улаанбаатараас зүүн урагшаа Хэнтий, Дорнот, Сүхбаатар, Дорноговь аймгийн чиглэлд аялах аль ч замд Налайхаас шилжиж болно.

**III дугаар чиглэл**

**Улаанбаатар-Хагийн Хар нуур-Естий-Улаанбаатар**

**Зорих гол үзмэр.** Хэнтийн их ой хөвч, гол горхи, ховор амьтад, мөстлөгийн морена, хунх

**Аялах зам А. Хагийн Хар нуур.** Дунд Баянголын адгаас цааш явган явж очно. Явган очих ирэх зам 90 орчим км. Ус, намаг, уул, хад чулуу, ой мод, ширэнг ихтэй төвөгтэй замтай. Гол үертэй цагт бол явах аргагүй. Хугацаа 7 хоног.

**Үзэх гол зүйлийн товч тайлбар.**

**1. Хавиргын даваа.** Хэнтийн нурууны том хэсэг болох Алтан-Өлгий уулыг давах даваа. Энд мөстлөгийн хунх зэргийг үзэж Алтан-Өлгий уулын оройгоос орчныг ажиглаж болно.

**2. Хагийн Хар нуур.** Багахэнтийн нурууны өвөрт Хийдийн Сарьдаг, Хүнхэр уул, Асгатын Сарьдаг уулсын шилмүүст ойн дунд д.т.д 1800 орчим м өндөрт 4 орчим ам км талбайг эзлэн орших ариг цэнгэг сайхан нуур. Гүн нь 25-30 м ажээ. Хэнтийн нуруунаас буусан дөрөвдөгчийн их мөстлөгийн морена /20-80 м өндөр 5 орчим км урт, 600 орчим м өргөн/ уулсын ам хөндийг таглан хаахад уулсын ус нь уг хонхорт хуримтлагдан энэ нуур үүсжээ.

Хагийн Хар нуураас гарах Хөлийн гол нь тэр мореныг зүсэж 20 орчим м өндөр хавцал үүсгэн урсан гарч Хонгорын голд нийлнэ. Хагийн Хар нуурт Хийдийн Сарьдагаас эх авсан жижиг Хагийн гол ирж цутгана.

**3. Хагийн голын** эхэнд Хийдийн Сарьдагийн өвөрт боржин чулуун хийдийн туурь оршино. Монголчуудын XVII зууны үед барьсан чулуун хийдийн нэг юм. Өндөр гэгээн Занабазар бариулсан /б. 262/ Энд Их хүрээ 1654-1687 онд суурьшиж байв.

зүүн хормойгоор Шаргаморьтын амны адгаар Сэлбэ голыг өгсөн явж Хандгайт 32 км, Хандгайтаас өгсөж Хоног толгойгоор дамжин Сэлбэ, Улиастай голын эх рүү орж ирж болно. Хандгайтаас Санзайн амны адгаар явж Сэлбийн эхээр давж Хараа голын хөндий рүү орж болно. Зам намаг ус ихтэй.

Хандгайтаас Сэлбийн эх рүү ороход Шаргаморьтын эхний уулын оройн урд хэсгээр давж орно. Хойд хэсгээр нь давбал Улиастайн голын эх руу орно. Сэлбийн эхэнд амралтын газар бий. Тэндээс Улаанбаатар хот 25 км, Чингэлтэй хайрхан уул Улаанбаатарын тахилгат 4 уулын нэг д.т.д 1950 м өндөр зүүн сугаар нь Чингэлтэй, Салхит, Ар Согоот (Орсгойт), Шадивлан, Яргайт, Жигжид, Гүнт, баруун сугаар нь Баянгол зэрэг олон сайхан ам хөндийнүүдэд нь Улаанбаатарынхны зуслан оршдог.

### **6 дугаар чиглэл**

#### **Улаанбаатар-Мөнгөнморьт-Улаанбаатар.**

**Аялах зам.** Улаанбаатар-Налайх, Баян даваагаар давж Төв аймгийн Эрдэнэ сум 80 км-Баяндэлгэр 27 км-Бага нуур 34 км- Бүрги эрэг 20 км-Мөнгөнморьт сум 26 км-буцаад замаараа Улаанбаатар 180 км.(Улаанбаатараас Мянганы замаар Багануур хүрнэ)

Эрдэнэ сумын нутагт “Элстэй” гэдэг жуулчны баз бий.

Бүгд 380 км, хугацаа 3-4 хоног

#### **Үзэх гол зүйлийн товч тайлбар.**

##### **1. Налайхын уурхай 2-р чиглэлийн замаас үз.**

**2. Баян даваа.** Хэнтийн нурууны салбарыг давах 1747 м өндөрт орших даваа. Зүүн зүгийн гол замд тохиолдох хамгийн урд захын ойн модот уул. Японы тусламжаар сайн засагдсан засмал замтай, даваа.

##### **3. Багануур 27-р чиглэлийн замаас үз.**

##### **4. Бүрги эрэг, мөн замаас үз.**

5. Энэ замд тохиолдох Байдлагийн голын рашаан, /20. 249/ Байдлагийн балгасын тухай мөн замаас үз.

6. Мөнгөнморьт сумын нутагт орших Бүрхийн дөрвөлжин, Тэрэлжийн дөрвөлжин булшуудыг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /6. 178/ , /6. 186/

7. Мөнгөнморьт суманд буриад ястан амьдардаг.

#### **Өөр замд шилжих**

Улаанбаатараас-Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Дорноговь аймаг орох замд Багануур, Эрдэнэ сум, Налайхын алинаас нь шилжиж болно.

#### **7 дугаар чиглэл**

#### **Төв аймгийн зүүн урд чиглэл**

**Аяллын зам.** Улаанбаатар-Налайх 35 км-Тоньюкукийн хөшөө 15 км-Аржанживлан 3 км-Баян даваа 30 км-Эрдэнэ сум 10 км –Архуст 27 км-Бөөрөлжүүт 20 км-Баянжаргалан сум 32 км-Өвөржанчивлин 91 км-Улаанбаатар 71 км

Бүгд 340 км, хугацаа 3-4 хоног

#### **-Үзэх гол зүйлийн товч тайлбар.**

**1. Налайхыг** 2-р Тоньюу кукийн хөшөөг 27-р чиглэлээс үз.

**2. Аржанчивлангийн рашаан.** Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт Налайхаас зүүн урагш 18 орчим км зайтай, Тоньюу кукийн хөшөөний зүүн дор оршино. Гидрокарбонат–натрий–кальцийн найрлагатай рашаан. Ходоод гэдэсний өвчнийг ууж эмчилнэ. Ар жанчивлан, Өвөржанчивлан хоёр нь Хөндлөнгийн давааны ар өвөрт ойрхон байгаа ойролцоо найрлагатай 2 рашаан юм. /20.241/

Манай мэргэжилтнүүдээс рашааныг дагнан судалсан хүнийг газарзүйч О.Намнандорж гуай юм. Тэрээр энд дурьдсан "Монголын рашаан" (20) гэдэг номын зохиогчийн нэг юм.

Эндээс Дэлхийн усны гурван ай савын хагалбар

Цогтчандманы уулы харна. I-р бүлэг Б. 5

**3. Нагалхаан уул.** II-р бүлгийн 37-г үз.

**4. Бөөрөлжүүт.** 27-р чиглэлээс үз. /20. 269/

**5. Баянжаргалан** сумын нутагт Хэрлэн голын баруун эрэгт Цагаан аралд Гуа довд эртний Хүннүгийн хотын туурь бий. Үүнийг 27-р чиглэлд дурьдана. /6. 178/

**6. Баянжаргалан** сумын нутагт цэргийн тахилгат Баян-Эрхэт уул бий. Энэ уул болон Өвөржанчивлангийн тухай 27-р чиглэлээс үз.

#### **Өөр замд шилжих**

-Баянжаргалангаас—Баян сум 58 км, Баян сумаас төмөр замаар Улаанбаатар юмуу, Чойрт очиж болно.

-Баянжаргалангаас Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Дорноговь аймгийн замд орж болно.

#### **8 дугаар чиглэл**

##### **Улаанбаатар–Бурханхалдун–Улаанбаатар**

**Аялах зам.** Улаанбаатараас 6-р чиглэлийн замаар гарч Мөнгөнморьт сум 180 км, Хэрлэн гол 40 км-Босготэнгэрийн даваа 33 км-Бурханхалдун уул 20 км –буцаад замаараа Улаанбаатар хот 290 км Мөнгөнморьтоос цааших зам намаг, ус ихтэй, бороотой үед бол явах аргагүй.

#### **Үзэх гол зүйлийн товч тайлбар.**

**1. Хэрлэн гол** 27-р чиглэлээс үз.

**2. Босготэнгэрийн даваа.** Хэрлэнгийн баруун гарт хойноосоо орж ирсэн Богдын голын адгаас доош холгүй, Хэрлэн голын хөндий рүү зүүн гараас нь түрж орсон Хонины Гозгор уулын зүүн шил дээгүүр давах д.т.д 1600 орчим м өндөр даваа. Ар өвөртөө намаг шавар ихтэй. Энэ даваанаас эмэгтэй хүн нэвтэрдэггүй, цааш явдаггүй заншилтай юм.

**3. Бурханхалдун уул.** /Хэнтийхан/ Хэрлэнгийн баруун гарын цутгал Богдын гол, Илүүр гол, Ононгийн



нэг эх Дээд Тарсын голын эхэнд орших манай улсын Их тахилгат уулын нэг, д.т.д 2332 м өндөр уул.

Бурханхалдун уулыг эзэн Чингис:

Өмөг болсон

Өндөр дээд

Бурханхалдун чамайг

Өглөө бүр мялааж

Өдөр бүр тахиж

Үе дутам

Үргэлж шүтэе. /МНТ 103/ гэж андгайлан гэрээслэсэн билээ. Ийм учраас тэр үеэс энэ уулыг тахин шүтэж ирсэн ажээ. Тахилгыг сэргээж анхлан 1995 онд тахьсан бөгөөд цаашид 3 жил дутамд 1 удаа тахиж байхаар тогтсон ёсоор 1998 оны 6-р сарын 11 нд тахихад энэ мөрийг зохиогч миний бие оролцох завшаан олдсон юм. Энэ уулын бэлд тахилчийн /бэлийн/ овоо, түүнээс дээш ой дотор 1 км орчимд д.т.д 1900 м орчим м өндөрт Дунд овоо оршино. Энэ овоог 1680-иад онд Өндөр гэгээн Занабазар тахисан гэдэг. Энэ овооны орчимд өндөр өндөр шинэс голлосон ойтой. Эндээс өгсөх дутам шинэс нь цөөрч хуш олширсоор байх агаад дээшлэхэд модод нь намссаар тагт нь гарахад оройд нь гар хүрэхээр бүр намхан заггар болно. Ой нь 2000 орчим м өндөрт ургах бөгөөд ойн дээд хил орчмын буюу уулын оройн хавтгай тагт таруу ургасан намхан хуш модод нь баруун хойноос үлээх салхины нөлөөгөөр мөчрүүд нь зөвхөн зүүн урагшаа дарцаг мэт хандан ургасан байх нь нэн сонин. Энэ уул орой дээрээ тус бүр нь хэд хэдэн ам км талбай бүхий, 30-50 орчим м өндөр шаталсан 4-5 тэгш тавцантай. Ойн захаас дээд овоо хүртэл 4 орчим км зайтай. Оройн овоо нь 400-гаад м урт 100 м өргөн тэгш тавцан дээр оршино. Энэ тавцан дээрээс Илүүр, Богдын гол, Онон голуудын эхэнд цүүцээр ухаад авч уу? гэлтэй тэвшин хөндий харагдах нь эртний Мөстлийн зузаан мөс уулын уруу гулгахад газрын хөрсөө сийлэн ухан үлдээсэн хунх юм.

Ханхэнтий уулын тухай II бүлгийн 4-ийг үз.

**4. Хэнтийн нуур.** Бурханхалдун уулын оройн овооны чанх урд дор овооноос 3 км зайтай, д.т.д 1900 орчим м өндөрт мөстлөгийн хунх дотор орших 1 км орчим ам км талбайтай уулын цэнгэг уст нуур. Хунхны хажуу нь маш эгц учраас энэ нуур руу зөвхөн Богдын гол руу зүүн урагшаа гарсан урсгалын хөндийгөөр нь очиж болно.

**Өөр замд шилжих.**

-Багануураас-Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Дорноговийн замд шилжиж болно.

**9 дүгээр чиглэл**

**Төв аймгийн урд сумдаар**

**Аялах зам.** Улаанбаатар-Зуунмод 43 км-Сэргэлэн сум 12 км-Ээж хад 50 км –Баян сум 50 км-Баянцагаан сум 80 км-Өлзийт нуур 30 км–Хундаганы рашаан 50 км–Баян-Өнжүүл сум 60 км-Дэлгэрхаан сум 115 км-Дуутын хад 20 км–Бүрэн сум 61 км Улаанбаатар 201 км.

Бүгд 835 км хугацаа 6-7 хоног

**Үзэх гол зүйлийн товч тайлбар**

**1. Ээж хад.** Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг Авдар уулын зүүн хэсэгт жижиг горхины гулдралд орших сууж байгаа хүн дүрстэй 17 м өндөр боржин чулуун цохио. Нутгийн ардууд эртнээс тахин шүтсээр хашаа хайс байшинтай болгон ардын хамгаалалтад авчээ.

**2. Баян сум.** Төмөр замын буудал. Баян сумын нутагт сумын төвөөс урагш 30 гаруй км-т орших Өгөөмөрт Их хүрээ 1688-1689 он ба 1743-1747 онд суурьшиж байжээ.

**3. Өлзийт нуур.** Баянцагаан сумын нутагт орших энэ нуурыг рашаан гэж нутгийн ардууд ус шаварт нь орж биеэ эмчилдэг.

**4. Хундаганы рашаан.** Шавартай жижиг /200 орчим м урт өргөн/ нуур. Гидрокарбонат-кальц натрийн найрлагатай рашаан арьсны болон үе мөчний өвчнийг шаварт нь орж эмчилдэг. /20. 270/

---

**5. Баянцагаан сумын нутагт Гашуунбалтастайд** Түрэгийн бичигт боржин чулуун 1 м гаруй өндөр хөшөө бий. Үүнийг болон мөн энэ сумын нутаг Хүүхэнхонгор гэдэг газар орших 2 ширхэг чулуун хөшөөг 1998 онд улсын хамгаалалтад авчээ.

**6. Зорголхайрхан уул.** Дуутын бичигт. Бичигт хадыг 20-р чиглэлийн замаас үз. /6. 240/

**7. Кулчурийн хөшөө.** Дэлгэрхаан сумын төвөөс хойш 30 орчим км-т Их хөшөөт гэдэг газарт Кулчурийн гэж "Цэцэн Кулчур, Тардуш түмнийг захиран сууваа" гэхчилэн олон мөр бичигтэй Түрэг хөшөө бий. Үүнийг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. Эндээс хойшоо 20 орчим км явж Эрдэнэсант сумын нутаг Дэвсэн булагийн рашаан хүрч цаашаа 13-р чиглэлд нийлж үргэлжлэн аялж болно. /6. 213/

**8. Багатөхөм.** Дэлгэрхаан сумын төвөөс хойш 15 км-т орших давстай нуур рашаан.

**9. Ихтөхөм нуур.** Бүрэн сумын төвийн дэргэд орших 16 ам км талбайтай, хлорт натрийн найрлагатай нуур рашаан. Хамуу зэрэг арьс өнгөний өвчнийг орж эмчилдэг рашаан. /20, 275/

**Өөр замд шилжих**

**1. Зуунмод хотоос** Төв аймгийн аль ч замд шилжиж болно.

**2. Дорноговийн замд.**

Баянцагаанаас Чойр 105 км,

Баянгаас Чойр 120 км.

**3. Дундговийн замд.**

Баянцагаанаас Говь-Угтаал 90 гаруй км мөн Цагаандэлэгэр 70 орчим км, Дэрэн 80 гаруй км.

**4. Бүрэнгээс** Дэлгэрхаан сум 51 км

5.Өвөрхангайн замд

Дэлгэрхаанаас Баян-Өндөр сум 45 км

## 10 дугаар чиглэл

### “Сувдан сондор-1” Аяллын зам

“Монгол сувдан сондор-1” Аяллын замд байгаль газар зүй, түүхийн сонирхолтой бөгөөд олон замын дээжээс сонгосон соёл эрдэм шинжилгээний аяллын энэ шинэ замыг Монголын соёлын сан, Монголын аялал жуулчлалын холбоо, ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс хамтран тогтоосон юм. “Сувдан сондор” аялал нь 6 удаа яваад байгаа бөгөөд бид энд Улаанбаатар орчимд, Төв, Дундговь, Өвөрхангай, Булган аймгийн нутгаар 1995 онд аяласан анхны аяллын замыг авч ярилцана. “Сувдан сондор” 2, 3, 4, 5, 6, -ын замыг Өвөрхангай, Хэнтий, Сүхбаатар, Өмнөговь аймгийн замд дараалан ярих болно. Манай улсын ба гадаад орны соёл, урлаг, шинжлэх ухааны нарийн мэрэгжлийн хүмүүс оролцон явдаг энэ аялалын замыг энэ мөрийг зохиолч миний бие 1995 оноос хойш жил дараалан зохиолцож аянд өөрөө биечлэн оролцож, газар нутгийн тайлбарыг бичиж сурталчлан явж байгааг энд дурдая. Зургаан удаа явсан энэ аянд **Төрийн шагналтнууд:** Ардын зохиолч С.Эрдэнэ академич Д.Цэрэнсодном, уран барилгач Г.Лувсандорж, уран зураач Н.Цүлтэм, **эрдэмтэд:** Г.Сүхбаатар, Л.Жамсран, Х.Лхагвасүрэн, Д.Наваан, С.Ичинноров, лам Ш.Сонинбаяр, Ж.Энэбиш, Батчулуун, Н.Жамсансүрэн, О.Сүхбаатар, Ж.Саруулбуян, Соёлын гавъяат зүтгэлтэн Г.Мэнд-оёо орчуулагчид: Б.Энэбиш, Ц.Хасбаатар, Г.Амар, Даваадулам, лам Батсайхан, Халиммандах, Алтантэтим, зохиолч сэтгүүлчид: Д.Шагдарсүрэн, Г.Ловор. Ц.Батзориг, Т.Мандир, Г.Жаргалсайхан, Ц.Түмэнбаяр, зураачид: Л.Ганбаатар, С.Бадрал, ажилтан С.Алтанчимэг болон Япон улсын гэрэл зурагчин Сугияама ОХУ-ын эрдэмтэн Л.Скородумова болон аймаг орон нутгийн төлөөлөгчид зэрэг олон хүмүүс цаг цагт оролцон ажиллаж байв. Монголын шинжлэх ухаан, соёл урлаг, утга зохиолын сор болсон эдгээр нэрт хүмүүстэй нэг баг болон аялан тэдний ухаант үг яриаг сонсож явах ховор аз надад олдсонд баяртай байдаг.

---

### Сувдан сондор-1-ийн аяллын зам

Улаанбаатар-Тэрэлж 70 км-Гүнжийн сүм 30 км-Тэрэлжээр дамжин Тоньюкукийн хөшөө 80 км-Налайх 20 км-Зуунмод 34 км. Энд налайхаас урагш орших Цогтчандмань уулыг харна. Манзуширийн ирэх очих хийд 16 км-Зуунмод-баруун урагшаа Зорголхайрхан 125 км – Дуутын бичигт хад 90 км-Дэлгэрхан 20 км- Монголын нутгийн Хүйс /төв цэг/ Өвөрхөшөөт 70 км-Бүрд сум 14 км-Баянговь жуулчны бааз 40 км-Элсэнтасархайгаар дамжин Хөгнөхан уул 20 км-Дашинчилэн сум 50 км-Харбухын балгас 13 км-Цогтын цагаан байшин 55 км-Лүн сум 70 км-Баянхангай 36 км-Баянцогт 34 км-Баянчандмань 40 км- Борнуур сум 35 км-Ноён уул 50 км- Борнуур сум 50 км-Батсүмбэр 44 км-Улаанбаатар 77км Бүгд 1370 км, хугацаа 7-8 хоног

#### Үзэх гол зүйлийн товч тайлбар.

1. **Тэрэлж, Гүнжийн сүм**, 2-р чиглэлийн замаас үз.
2. **Тоньюкукийн хөшөө** 27-р чиглэлийн замаас үз.
3. **Цогтчандмань уул**. МОГ-ын 5-аас үз.
4. **Манзуширийн хийд**. 1-р чиглэлийн замаас үз.
5. **Зорголхайрхан, Сүм-Хөхбүрд, Дуутын бичигт хад**-20-р чиглэлийн замаас үз.
6. **Өвөрхөшөөт**. I бүлгийн 6-гийн 9-ийг үз.
7. **Элсэнтасархай**. 13-р чиглэлийн замаас үз.
8. **Хөгнөхаан**. II-р бүлгийн 33-ийг үз.
9. **Харбухын балгас, Цогтын цагаан байшин** 13-р чиглэлийн замаас үз.
10. **Борнуур** сумын нутагт орших **хүннүгийн үеийн** Бороогийн сууринг 1998 оноос улсын хамгаалалтад авчээ.
11. **Ноён уул**. Бороо голоос Баянголыг өгсөж 25 км явж очно. Түнхэлээс баруун тийш холгүй орших д.т.д 1722

цэгт зориулсан 2 тэмдэг Улаанбаатар хотын Сүхбаатарын талбайд Төв шуудангийн дэргэд бий.

**6. Туул гол.** Хэнтийханаас эх авч Улаанбаатарын дэргэдүүр урсаад /819 км/ Орхонд цутгадаг. Нэн ховор Хилим болон алгана, тул, цагаан загас, цулбуурт, гутаар, хадран, цурхай, булуу цаган, зэвэг зэрэг загастай. Туулын савд өрөвтас, халбаган хушуут, галуу зэрэг ховор шувууд тааралддаг. Туул гол бол Монголчуудын эртнээс нутаглаж ирсэн манай алдарт гурван голын нэг билээ.

7. Улаанбаатар хотын **Буянт-Ухаа, Наадмын талбай**, морины уралдааны замыг үзэхээс гадна Туулын сав, **Сонгинохайрхан уул**, Зайсан толгой, Гачуурт, Их тэнгэрийн ам зэрэг газарт хуучин чулуун зэвсгийн дээд буюу 40000-12000 жилийн өмнөх үеийн дурсгалын зүйлүүдийг үзэж болно. **Их тэнгэрийн амны гачууртын хадны** сүг зургийг 1998 онд улсын тусгай хамгаалалтад авсан.

**8. Зуунмод** Төв аймгийн төв

**9. Манзуширын хийд**, уулын байгалийн музей

**Манзуширын хийд** нь Зуунмод хотоос зүүн хойш Богдхан уулын өврийн шинэсэн ойд д.т.д. 1800 орчим м өндөрт үзэсгэлэнт газар оршдог. Энэ хийдийн дэргэд уулын энгэрийн хадан дээр сийлбэрлэсэн том бурхадын зураг нь түүх, соёлын ховор нандин бүтээл юм. Энэ хийд туурь, сийлсэн хөргүүдтэй хадыг 1998 оноос 15.6 га талбайгаар улсын хамгаалалтад авчээ. /6, 260/ Энд буга зэрэг ховор амьтныг үзэж болно. 1733 онд байгуулсан энэ хийдийг нураасныг одоо сэргээж байна. Энд 1726 онд цутгаж хийсэн хүрэл тогоо байдаг. Энэ тогооны амсар нь 215 см диаметртэй, гүн нь 140 см, багтаамж нь 1800 л, хүнд нь 2 тонн ажээ. Энэ тогоонд 2 үхрийн буюу 10 хонины махыг чанахад 4 тэрэг түлээ түлдэг байжээ. Нэг удаад 1000 хүний хоол бэлтгэж болдог байсан гэнэ. Энд "Манзушир" жуулчны бааз ажилладаг.

10. Зуунмод хотын ойролцоо **"Өндөр дов"** гэдэг жуулчны бааз ажилладаг.

---



11. Алтанбулаг сумаар орж болно. Алтанбулаг сум орчмын талаар 11-р чиглэлд үз. Энэ суманд “Жагар жуулчны баз ажилладаг.

#### **Өөр замд шилжих**

Төв аймгийн нутгаар аялах аль ч замыг Зуунмод, Улаанбаатар хотоос эхэлж болно.

#### **2 дугаар чиглэл**

#### **Улаанбаатар-Тэрэлж- Улаанбаатар**

**Зорих гол үзмэр.** Хэнтийн хөвч, Тэрэлж, Горхи уул, гол горхи ховор амьтан ургамал

**Аялах зам.** Улаанбаатар-Налайх 35 км-Тэрэлж-35 км-Гүнжийн сүм 30 км-Тэрэлж 30 км-Тоньюукукийн хөшөө 50 км-Налайхаар дамжин Улаанбаатар 50 км замын урт 230 км хугацаа нь 1-2 өдөр


#### **Үзэх гол зүйлийн товч тайлбар.**

**1. Туул гол, Богдхан уулын тайлбарыг 1-р чиглэлийн замаас үз.**

**2. Баянзүрххайрхан уул.** Улаанбаатарын тахилгат дөрвөн уулын нэг цэргийн тахилгат “Чидом” хэмээх нохой шүтээнтэй д.т.д 1846 м өндөр уул. Хууччуулын өгүүлснээр монголын дайсан эртнээс нааш зүүн урд зүгээс орж ирж байсан тул түүний омгийг дарах гэж улс орноо хамгаалах цэргийн сүлд тугийг Баянзүрх уулнаа залж тахин түүний орчимд цэргээ байрлуулсаар ирсэн гэлцдэг аж. Одоо ч архан талд нь Хужирбуланд цэргийн анги бий. Манай улсад цэргийн тахилгатай уул 3 бий бөгөөд нөгөө хоёрыг нь 27, 33-р чиглэлээс үз.

**3. Налайхын уурхай.** 1910 аад оны үеэс ашиглаж эхэлсэн Дунд төрмөлийн эриний цэрдийн галавын настай нүүрсний уурхай. Жилдээ 600 мян тн нүүрс гаргадаг байв. Монгол орны нүүрсний 150 гаруй орд газрын нэг. Одоо Налайхад газрын тос боловсруулах үйлдвэр барьж байгаа.

Төв аймгийн нутгийн зураг



Масштаб: 1 см-т 37.3 км



**4. Тоньюкукийн бичигт хөшөө** Тайлбарыг 27-р чиглэлээс үз.

**5. Зуунмодны төгөл.** Налайхаас зүүн тийш 20 орчим км-т Элстийн голын баруун гарт Тэрэлж голын адгийн харалдаа Туул голын урд талд орших нарсны төгөл урьд их төгөл байсан гэдэг. 1696 онд Манжийн Энх-Амгалан хааны 1 бум гаруй цэрэгтэй Ойрод Монголын хаан Галданбошигтын цэрэг байлдсан Тэрэлжийн Зуунмод гэж түүхэнд тэмдэглэсэн нутаг.

**6. Горхи-Тэрэлжийн сав газар.** II-р бүлгийн 14-ийг үз.

**7. Тэрэлж гол.** Хэнтийн Асралтхайрхан уулын баруун урд хэсгийн Янгийн Сарьдагаас эх авч 70 гаруй км урсаад Туул голд цутгадаг уулын хурдан урсгалт тунгалаг уст том гол, Тэрэлжийн үзэсгэлэнт хөндийд “Тэрэлж” жуулчны бааз оршдог. Тэрэлжийн орчинд “Мираж” горхит, “Тэмүүжингийн отог”, “Ханхэнтий”, “Чингэс уулын өртөө”, “Гандан уул”, “Жалман” зэрэг жуулчны бааз ажилладаг.

**8. Гүнжийн сүм.** Тэрэлжийн баазаас зүүн хойш 30 км-т үзэсгэлэнт Баруунбаян голын эрэг, Эрдэнэ сумын нутагт орших Буддийн сүм. Халхын Түшээт хан Чахундорж, Манжийн Энх-Амгалан /Кансий/ хааны дэргэд амьдрах ахуйд нь ач хүү Дондовдоржийг эфу ноён гэж өргөмжлөн 6-р гүнжээ хатан болгон өгч ураг барилджээ.

Хатан болгож өгөхдөө Кансий хаан гүнждээ хичээнгүй Амарлингуй цол олгож 5 кг шижир алтан дэвтэрт сийлсэн “Алтан навчит өргөмжлөл” өгчээ. Гүнжийг нас барахад Эфу Дондовдорж шарилын сүм, цагаан гантиг гэрэлт хөшөөг 1740 онд босгосон байна.

Хичээнгүй Амирлангуй гүнж монголд элэгтэй болсны учир манжийн туршуулын гарт амь үрэгдсэн гэдэг. Эфи гэдэг нь Манжийн хааны хүргэн гэсэн үг. Гүнжийн сүмийг 1961 оноос улсын хамгаалалтад авчээ. /6. 253/

**9. Тэрэлжийн жуулчны базаас урагш 10 орчим км-т Тэрэлж голын зүүн гарт Тэрэлж-Туулын бэлчэрт Их хүрээ** 1733 онд өвөлжиж байжээ.

**Өөр замд шилжих.**

1. Улаанбаатараас зүүн урагшаа Хэнтий, Дорнот, Сүхбаатар, Дорноговь аймгийн чиглэлд аялах аль ч замд Налайхаас шилжиж болно.

**III дугаар чиглэл**

**Улаанбаатар-Хагийн Хар нуур-Естий-Улаанбаатар**

**Зорих гол үзмэр.** Хэнтийн их ой хөвч, гол горхи, ховор амьтад, мөстлөгийн морена, хунх

**Аялах зам А. Хагийн Хар нуур.** Дунд Баянголын адгаас цааш явган явж очно. Явган очих ирэх зам 90 орчим км. Ус, намаг, уул, хад чулуу, ой мод, ширэнг ихтэй төвөгтэй замтай. Гол үертэй цагт бол явах аргагүй. Хугацаа 7 хоног.

**Үзэх гол зүйлийн товч тайлбар.**

**1. Хавиргын даваа.** Хэнтийн нурууны том хэсэг болох Алтан-Өлгий уулыг давах даваа. Энд мөстлөгийн хунх зэргийг үзэж Алтан-Өлгий уулын оройгоос орчныг ажиглаж болно.

**2. Хагийн Хар нуур.** Багахэнтийн нурууны өвөрт Хийдийн Сарьдаг, Хүнхэр уул, Асгатын Сарьдаг уулсын шилмүүст ойн дунд д.т.д 1800 орчим м өндөрт 4 орчим ам км талбайг эзлэн орших ариг цэнгэг сайхан нуур. Гүн нь 25-30 м ажээ. Хэнтийн нуруунаас буусан дөрөвдөгчийн их мөстлөгийн морена /20-80 м өндөр 5 орчим км урт, 600 орчим м өргөн/ уулсын ам хөндийг таглан хаахад уулсын ус нь уг хонхорт хуримтлагдан энэ нуур үүсжээ.

Хагийн Хар нуураас гарах Хөлийн гол нь тэр мореныг зүсэж 20 орчим м өндөр хавцал үүсгэн урсан гарч Хонгорын голд нийлнэ. Хагийн Хар нуурт Хийдийн Сарьдагаас эх авсан жижиг Хагийн гол ирж цутгана.

**3. Хагийн голын** эхэнд Хийдийн Сарьдагийн өвөрт боржин чулуун хийдийн туурь оршино. Монголчуудын XVII зууны үед барьсан чулуун хийдийн нэг юм. Өндөр гэгээн Занабазар бариулсан /б. 262/ Энд Их хүрээ 1654-1687 онд суурьшиж байв.

зүүн хормойгоор Шаргаморьтын амны адгаар Сэлбэ голыг өгсөн явж Хандгайт 32 км, Хандгайтаас өгсөж Хоног толгойгоор дамжин Сэлбэ, Улиастай голын эх рүү орж ирж болно. Хандгайтаас Санзайн амны адгаар явж Сэлбийн эхээр давж Хараа голын хөндий рүү орж болно. Зам намаг ус ихтэй.

Хандгайтаас Сэлбийн эх рүү ороход Шаргаморьтын эхний уулын оройн урд хэсгээр давж орно. Хойд хэсгээр нь давбал Улиастайн голын эх руу орно. Сэлбийн эхэнд амралтын газар бий. Тэндээс Улаанбаатар хот 25 км, Чингэлтэй хайрхан уул Улаанбаатарын тахилгат 4 уулын нэг д.т.д 1950 м өндөр зүүн сугаар нь Чингэлтэй, Салхит, Ар Согоот (Орсгойт), Шадивлан, Яргайт, Жигжид, Гүнт, баруун сугаар нь Баянгол зэрэг олон сайхан ам хөндийнүүдэд нь Улаанбаатарынхны зуслан оршдог.

### **6 дугаар чиглэл**

#### **Улаанбаатар-Мөнгөнморьт-Улаанбаатар.**

**Аялах зам.** Улаанбаатар-Налайх, Баян даваагаар давж Төв аймгийн Эрдэнэ сум 80 км-Баяндэлгэр 27 км-Бага нуур 34 км- Бүрги эрэг 20 км-Мөнгөнморьт сум 26 км-буцаад замаараа Улаанбаатар 180 км.(Улаанбаатараас Мянганы замаар Багануур хүрнэ)

Эрдэнэ сумын нутагт “Элстэй” гэдэг жуулчны баз бий.

Бүгд 380 км, хугацаа 3-4 хоног

#### **Үзэх гол зүйлийн товч тайлбар.**

##### **1. Налайхын уурхай 2-р чиглэлийн замаас үз.**

**2. Баян даваа.** Хэнтийн нурууны салбарыг давах 1747 м өндөрт орших даваа. Зүүн зүгийн гол замд тохиолдох хамгийн урд захын ойн модот уул. Японы тусламжаар сайн засагдсан засмал замтай, даваа.

##### **3. Багануур 27-р чиглэлийн замаас үз.**

##### **4. Бүрги эрэг, мөн замаас үз.**



5. Энэ замд тохиолдох Байдлагийн голын рашаан, /20. 249/ Байдлагийн балгасын тухай мөн замаас үз.

6. Мөнгөнморьт сумын нутагт орших Бүрхийн дөрвөлжин, Тэрэлжийн дөрвөлжин булшуудыг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /6. 178/ , /6. 186/

7. Мөнгөнморьт суманд буриад ястан амьдардаг.

#### **Өөр замд шилжих**

Улаанбаатараас-Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Дорноговь аймаг орох замд Багануур, Эрдэнэ сум, Налайхын алинаас нь шилжиж болно.

#### **7 дугаар чиглэл**

#### **Төв аймгийн зүүн урд чиглэл**

**Аяллын зам.** Улаанбаатар-Налайх 35 км-Тоньюкукийн хөшөө 15 км-Аржанживлан 3 км-Баян даваа 30 км-Эрдэнэ сум 10 км –Архуст 27 км-Бөөрөлжүүт 20 км-Баянжаргалан сум 32 км-Өвөржанчивлин 91 км-Улаанбаатар 71 км

Бүгд 340 км, хугацаа 3-4 хоног

#### **-Үзэх гол зүйлийн товч тайлбар.**

**1. Налайхыг** 2-р Тоньюу кукийн хөшөөг 27-р чиглэлээс үз.

**2. Аржанчивлангийн рашаан.** Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт Налайхаас зүүн урагш 18 орчим км зайтай, Тоньюу кукийн хөшөөний зүүн дор оршино. Гидрокарбонат–натрий–кальцийн найрлагатай рашаан. Ходоод гэдэсний өвчнийг ууж эмчилнэ. Ар жанчивлан, Өвөржанчивлан хоёр нь Хөндлөнгийн давааны ар өвөрт ойрхон байгаа ойролцоо найрлагатай 2 рашаан юм. /20.241/

Манай мэргэжилтнүүдээс рашааныг дагнан судалсан хүнийг газарзүйч О.Намнандорж гуай юм. Тэрээр энд дурьдсан "Монголын рашаан" (20) гэдэг номын зохиогчийн нэг юм.

Эндээс Дэлхийн усны гурван ай савын хагалбар

Цогтчандманы уулы харна. I-р бүлэг Б. 5

**3. Нагалхаан уул.** II-р бүлгийн 37-г үз.

**4. Бөөрөлжүүт.** 27-р чиглэлээс үз. /20. 269/

**5. Баянжаргалан** сумын нутагт Хэрлэн голын баруун эрэгт Цагаан аралд Гуа довд эртний Хүннүгийн хотын туурь бий. Үүнийг 27-р чиглэлд дурьдана. /6. 178/

**6. Баянжаргалан** сумын нутагт цэргийн тахилгат Баян-Эрхэт уул бий. Энэ уул болон Өвөржанчивлангийн тухай 27-р чиглэлээс үз.

#### **Өөр замд шилжих**

-Баянжаргалангаас—Баян сум 58 км, Баян сумаас төмөр замаар Улаанбаатар юмуу, Чойрт очиж болно.

-Баянжаргалангаас Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Дорноговь аймгийн замд орж болно.

#### **8 дугаар чиглэл**

##### **Улаанбаатар–Бурханхалдун–Улаанбаатар**

**Аялах зам.** Улаанбаатараас 6-р чиглэлийн замаар гарч Мөнгөнморьт сум 180 км, Хэрлэн гол 40 км-Босготэнгэрийн даваа 33 км-Бурханхалдун уул 20 км –буцаад замаараа Улаанбаатар хот 290 км Мөнгөнморьтоос цааших зам намаг, ус ихтэй, бороотой үед бол явах аргагүй.

#### **Үзэх гол зүйлийн товч тайлбар.**

**1. Хэрлэн гол** 27-р чиглэлээс үз.

**2. Босготэнгэрийн даваа.** Хэрлэнгийн баруун гарт хойноосоо орж ирсэн Богдын голын адгаас доош холгүй, Хэрлэн голын хөндий рүү зүүн гараас нь түрж орсон Хонины Гозгор уулын зүүн шил дээгүүр давах д.т.д 1600 орчим м өндөр даваа. Ар өвөртөө намаг шавар ихтэй. Энэ даваанаас эмэгтэй хүн нэвтэрдэггүй, цааш явдаггүй заншилтай юм.

**3. Бурханхалдун уул.** /Хэнтийхан/ Хэрлэнгийн баруун гарын цутгал Богдын гол, Илүүр гол, Ононгийн

нэг эх Дээд Тарсын голын эхэнд орших манай улсын Их тахилгат уулын нэг, д.т.д 2332 м өндөр уул.

Бурханхалдун уулыг эзэн Чингис:

Өмөг болсон

Өндөр дээд

Бурханхалдун чамайг

Өглөө бүр мялааж

Өдөр бүр тахиж

Үе дутам

Үргэлж шүтэе. /МНТ 103/ гэж андгайлан гэрээслэсэн билээ. Ийм учраас тэр үеэс энэ уулыг тахин шүтэж ирсэн ажээ. Тахилгыг сэргээж анхлан 1995 онд тахьсан бөгөөд цаашид 3 жил дутамд 1 удаа тахиж байхаар тогтсон ёсоор 1998 оны 6-р сарын 11 нд тахихад энэ мөрийг зохиогч миний бие оролцох завшаан олдсон юм. Энэ уулын бэлд тахилчийн /бэлийн/ овоо, түүнээс дээш ой дотор 1 км орчимд д.т.д 1900 м орчим м өндөрт Дунд овоо оршино. Энэ овоог 1680-иад онд Өндөр гэгээн Занабазар тахисан гэдэг. Энэ овооны орчимд өндөр өндөр шинэс голлосон ойтой. Эндээс өгсөх дутам шинэс нь цөөрч хуш олширсоор байх агаад дээшлэхэд модод нь намссаар тагт нь гарахад оройд нь гар хүрэхээр бүр намхан заггар болно. Ой нь 2000 орчим м өндөрт ургах бөгөөд ойн дээд хил орчмын буюу уулын оройн хавтгай тагт таруу ургасан намхан хуш модод нь баруун хойноос үлээх салхины нөлөөгөөр мөчрүүд нь зөвхөн зүүн урагшаа дарцаг мэт хандан ургасан байх нь нэн сонин. Энэ уул орой дээрээ тус бүр нь хэд хэдэн ам км талбай бүхий, 30-50 орчим м өндөр шаталсан 4-5 тэгш тавцантай. Ойн захаас дээд овоо хүртэл 4 орчим км зайтай. Оройн овоо нь 400-гаад м урт 100 м өргөн тэгш тавцан дээр оршино. Энэ тавцан дээрээс Илүүр, Богдын гол, Онон голуудын эхэнд цүүцээр ухаад авч уу? гэлтэй тэвшин хөндий харагдах нь эртний Мөстлийн зузаан мөс уулын уруу гулгахад газрын хөрсөө сийлэн ухан үлдээсэн хунх юм.

Ханхэнтий уулын тухай II бүлгийн 4-ийг үз.

**4. Хэнтийн нуур.** Бурханхалдун уулын оройн овооны чанх урд дор овооноос 3 км зайтай, д.т.д 1900 орчим м өндөрт мөстлөгийн хунх дотор орших 1 км орчим ам км талбайтай уулын цэнгэг уст нуур. Хунхны хажуу нь маш эгц учраас энэ нуур руу зөвхөн Богдын гол руу зүүн урагшаа гарсан урсгалын хөндийгөөр нь очиж болно.

**Өөр замд шилжих.**

-Багануураас-Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Дорноговийн замд шилжиж болно.

**9 дүгээр чиглэл**

**Төв аймгийн урд сумдаар**

**Аялах зам.** Улаанбаатар-Зуунмод 43 км-Сэргэлэн сум 12 км-Ээж хад 50 км –Баян сум 50 км-Баянцагаан сум 80 км-Өлзийт нуур 30 км–Хундаганы рашаан 50 км–Баян-Өнжүүл сум 60 км-Дэлгэрхаан сум 115 км-Дуутын хад 20 км–Бүрэн сум 61 км Улаанбаатар 201 км.

Бүгд 835 км хугацаа 6-7 хоног

**Үзэх гол зүйлийн товч тайлбар**

**1. Ээж хад.** Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг Авдар уулын зүүн хэсэгт жижиг горхины гулдралд орших сууж байгаа хүн дүрстэй 17 м өндөр боржин чулуун цохио. Нутгийн ардууд эртнээс тахин шүтсээр хашаа хайс байшинтай болгон ардын хамгаалалтад авчээ.

**2. Баян сум.** Төмөр замын буудал. Баян сумын нутагт сумын төвөөс урагш 30 гаруй км-т орших Өгөөмөрт Их хүрээ 1688-1689 он ба 1743-1747 онд суурьшиж байжээ.

**3. Өлзийт нуур.** Баянцагаан сумын нутагт орших энэ нуурыг рашаан гэж нутгийн ардууд ус шаварт нь орж биеэ эмчилдэг.

**4. Хундаганы рашаан.** Шавартай жижиг /200 орчим м урт өргөн/ нуур. Гидрокарбонат-кальц натрийн найрлагатай рашаан арьсны болон үе мөчний өвчнийг шаварт нь орж эмчилдэг. /20. 270/

---

**5. Баянцагаан сумын нутагт Гашуунбалтастайд** Түрэгийн бичигт боржин чулуун 1 м гаруй өндөр хөшөө бий. Үүнийг болон мөн энэ сумын нутаг Хүүхэнхонгор гэдэг газар орших 2 ширхэг чулуун хөшөөг 1998 онд улсын хамгаалалтад авчээ.

**6. Зорголхайрхан уул.** Дуутын бичигт. Бичигт хадыг 20-р чиглэлийн замаас үз. /6. 240/

**7. Кулчурийн хөшөө.** Дэлгэрхаан сумын төвөөс хойш 30 орчим км-т Их хөшөөт гэдэг газарт Кулчурийн гэж "Цэцэн Кулчур, Тардуш түмнийг захиран сууваа" гэхчилэн олон мөр бичигтэй Түрэг хөшөө бий. Үүнийг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. Эндээс хойшоо 20 орчим км явж Эрдэнэсант сумын нутаг Дэвсэн булагийн рашаан хүрч цаашаа 13-р чиглэлд нийлж үргэлжлэн аялж болно. /6. 213/

**8. Багатөхөм.** Дэлгэрхаан сумын төвөөс хойш 15 км-т орших давстай нуур рашаан.

**9. Ихтөхөм нуур.** Бүрэн сумын төвийн дэргэд орших 16 ам км талбайтай, хлорт натрийн найрлагатай нуур рашаан. Хамуу зэрэг арьс өнгөний өвчнийг орж эмчилдэг рашаан. /20, 275/

**Өөр замд шилжих**

**1. Зуунмод хотоос** Төв аймгийн аль ч замд шилжиж болно.

**2. Дорноговийн замд.**

Баянцагаанаас Чойр 105 км,

Баянгаас Чойр 120 км.

**3. Дундговийн замд.**

Баянцагаанаас Говь-Угтаал 90 гаруй км мөн Цагаандэлэгэр 70 орчим км, Дэрэн 80 гаруй км.

**4. Бүрэнгээс** Дэлгэрхаан сум 51 км

5.Өвөрхангайн замд

Дэлгэрхаанаас Баян-Өндөр сум 45 км

## 10 дугаар чиглэл

### "Сувдан сондор-1" Аяллын зам

"Монгол сувдан сондор-1" Аяллын замд байгаль газар зүй, түүхийн сонирхолтой бөгөөд олон замын дээжээс сонгосон соёл эрдэм шинжилгээний аяллын энэ шинэ замыг Монголын соёлын сан, Монголын аялал жуулчлалын холбоо, ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс хамтран тогтоосон юм. "Сувдан сондор" аялал нь 6 удаа яваад байгаа бөгөөд бид энд Улаанбаатар орчимд, Төв, Дундговь, Өвөрхангай, Булган аймгийн нутгаар 1995 онд аяласан анхны аяллын замыг авч ярилцана. "Сувдан сондор" 2, 3, 4, 5, 6, -ын замыг Өвөрхангай, Хэнтий, Сүхбаатар, Өмнөговь аймгийн замд дараалан ярих болно. Манай улсын ба гадаад орны соёл, урлаг, шинжлэх ухааны нарийн мэрэгжлийн хүмүүс оролцон явдаг энэ аялалын замыг энэ мөрийг зохиолч миний бие 1995 оноос хойш жил дараалан зохиолцож аянд өөрөө биечлэн оролцож, газар нутгийн тайлбарыг бичиж сурталчлан явж байгааг энд дурдая. Зургаан удаа явсан энэ аянд **Төрийн шагналтнууд:** Ардын зохиолч С.Эрдэнэ академич Д.Цэрэнсодном, уран барилгач Г.Лувсандорж, уран зураач Н.Цүлтэм, **эрдэмтэд:** Г.Сүхбаатар, Л.Жамсран, Х.Лхагвасүрэн, Д.Наваан, С.Ичинноров, лам Ш.Сонинбаяр, Ж.Энэбиш, Батчулуун, Н.Жамсансүрэн, О.Сүхбаатар, Ж.Саруулбуян, Соёлын гавъяат зүтгэлтэн Г.Мэнд-оёо орчуулагчид: Б.Энэбиш, Ц.Хасбаатар, Г.Амар, Даваадулам, лам Батсайхан, Халиммандах, Алтантэтим, зохиолч сэтгүүлчид: Д.Шагдарсүрэн, Г.Ловор. Ц.Батзориг, Т.Мандир, Г.Жаргалсайхан, Ц.Түмэнбаяр, зураачид: Л.Ганбаатар, С.Бадрал, ажилтан С.Алтанчимэг болон Япон улсын гэрэл зурагчин Сугияама ОХУ-ын эрдэмтэн Л.Скородумова болон аймаг орон нутгийн төлөөлөгчид зэрэг олон хүмүүс цаг цагт оролцон ажиллаж байв. Монголын шинжлэх ухаан, соёл урлаг, утга зохиолын сор болсон эдгээр нэрт хүмүүстэй нэг баг болон аялан тэдний ухаант үг яриаг сонсож явах ховор аз надад олдсонд баяртай байдаг.

---



### Сувдан сондор-1-ийн аяллын зам

Улаанбаатар-Тэрэлж 70 км-Гүнжийн сүм 30 км-Тэрэлжээр дамжин Тоньюкукийн хөшөө 80 км-Налайх 20 км-Зуунмод 34 км. Энд налайхаас урагш орших Цогтчандмань уулыг харна. Манзуширийн ирэх очих хийд 16 км-Зуунмод-баруун урагшаа Зорголхайрхан 125 км – Дуутын бичигт хад 90 км-Дэлгэрхан 20 км- Монголын нутгийн Хүйс /төв цэг/ Өвөрхөшөөт 70 км-Бүрд сум 14 км-Баянговь жуулчны бааз 40 км-Элсэнтасархайгаар дамжин Хөгнөхан уул 20 км-Дашинчилэн сум 50 км-Харбухын балгас 13 км-Цогтын цагаан байшин 55 км-Лүн сум 70 км-Баянхангай 36 км-Баянцогт 34 км-Баянчандмань 40 км- Борнуур сум 35 км-Ноён уул 50 км- Борнуур сум 50 км-Батсүмбэр 44 км-Улаанбаатар 77км Бүгд 1370 км, хугацаа 7-8 хоног

#### Үзэх гол зүйлийн товч тайлбар.

1. **Тэрэлж, Гүнжийн сүм**, 2-р чиглэлийн замаас үз.
2. **Тоньюкукийн хөшөө** 27-р чиглэлийн замаас үз.
3. **Цогтчандмань уул**. МОГ-ын 5-аас үз.
4. **Манзуширийн хийд**. 1-р чиглэлийн замаас үз.
5. **Зорголхайрхан, Сүм-Хөхбүрд, Дуутын бичигт хад**-20-р чиглэлийн замаас үз.
6. **Өвөрхөшөөт**. I бүлгийн 6-гийн 9-ийг үз.
7. **Элсэнтасархай**. 13-р чиглэлийн замаас үз.
8. **Хөгнөхаан**. II-р бүлгийн 33-ийг үз.
9. **Харбухын балгас, Цогтын цагаан байшин** 13-р чиглэлийн замаас үз.
10. **Борнуур** сумын нутагт орших **хүннүгийн үеийн** Бороогийн сууринг 1998 оноос улсын хамгаалалтад авчээ.
11. **Ноён уул**. Бороо голоос Баянголыг өгсөж 25 км явж очно. Түнхэлээс баруун тийш холгүй орших д.т.д 1722

м өндөр уул, энэ уулын Зурамт, Сүжигтийн амнаас 1924 онд Орсын эрдэмтэн П.К.Козлов эртний /МЭӨ I-р зууны/ Хүннүгийн дээдсийн 6 булш малтаж их олбор олсон юм. Батсүмбэр сумын нутагт орших Хараагийн Ноён уулын Хүннүгийн үеийн энэ булшийг 1961 оноос улсын хамгаалалтад авчээ. /б. 152/

12. Энэ замд Батсүмбэр сумын нутагт Их хүрээ нүүдэллэн суурьшиж байсан газрууд бий. Үүнд:

**Сөгнөгөрийн голд** 1730-32 онд, **Бургалтайн голд** 1732-онд, **Хүйн нууранд** голд 1736-1740 онд, **Үдлэгийн голд** 1742 онд, **Хунцалын голд** 1740-1742 онд суурьшиж байжээ. Эдгээрт зориулсан дурсгалын баганыг дурьдсан газруудад босгосон байна. Хунцалын гол, Бургалтайн голын савд Борнуур сумаас очиж болно.

#### **Өөр замд шилжих**

##### **1. Дундговийн замд**

- Дуутын бичигт хаднаас Эрдэнэдалай 60 км

##### **2. Налайхаас зүүн урд зүгийн замд,**

##### **3. Өвөрхангай аймгийн замд,**

- Дэлгэрхаан сумаас-Баян-Өндөр сум 45 км

##### **4. Архангайн замд,**

- Элсэн тасархайгаас - Хашаат 60км

##### **5. Булганы замд,**

- Хөгнөхаанаас

##### **6. Сэлэнгийн замд**

- Борнуураас-Баянжаргалан сум 70 км

#### **11 дүгээр чиглэл**

#### **Төв аймгийн баруун урд зам**

**Аялах зам А.** Улаанбаатар-Алтанбулаг 52 км-Баян-Өнжүүл 90 км-Бүрэн сум 85 км-Эрдэнэсант 75 км-Өндөрширээт 36 км-Лүн сум 56 км-Улаанбаатар 132 км

Бүгд 530 км, хугацаа 3-4 хоног.

**Аялах зам Б.** Улаанбаатар-Алтанбулаг 52 км-хойшоо Туул голыг гүүрээр гарч 15 орчим км явж “Нью шилэн интернейшнил” жуулчны баазаар дамжин Өнгөт уулын цогцолбор 40 орчим км –Хустайн нурууны улсын тусгай хамгаалалттай газар 30 км Эндээс Лүн сум 70 км орж болно. Бас Туул–Овоотын гүүр 65 км гээд Өндөрширээт сум 15 км орж болно.

**Үзэх гол зүйлийн товч тайлбар:**

**1. Алтанбулаг сум.** Улсын наадмын уралдааны морины гарааг сумын төв орчимд үзэж болно.

**2. Өнгөт уулын цогцолбор дурсгал.** Хустайн нуруунаас урагш орших Өнгөт уулын урдуур үргэлжлэх хөндийд Туул голоос 5 км зайтай уужуу тавиу газарт Өнгөтийн цогцолборт дурсгал гэж нэрлэгддэг дурсгал оршино. Энд босоо байгаа нэгэн хүн чулууг хөшөө гэж нэрлэх бөгөөд энд олон хэлбэр төрхийн иж бүрэн цогцолборт дурсгал байна. Үүнийг Нирун улсын дурсгал гэж үздэг, энэ цогцолборыг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /б, 114/

**3.** Мөн Алтанбулаг сумын нутагт **Моринтолгой** гэдэг газар орших олон үеийн булшийг 1998 онд улсын хамгаалалтад авчээ.

**4. Зорголхайрхан уул.** Моринхадыг 2-р чиглэлийн замаас үз.

**5.** Бүрэн сумын **Ихтөхөм** нуурыг 9-р, Эрдэнэсант сум орох замын Өвөржаргалант голыг 13-р чиглэлийн Б замаас, Сайжрах, Дэвсэнбулагийн рашааныг 13-р чиглэлээс үз.

**6. Батхаан уул.** II бүлгийн 38-ыг үз.

**7.** Өндөрширээт сумын нутагт **Уянгын үзүүр** гэдэг газарт сүг зурагтай хаднууд бий. Үүнийг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /б. 38 , 47/

**8.** Өндөрширээт сумын нутаг **Хэрмийн дэнжид** эртний хотын туурь, булшууд бий.

9. Өндөрширээт сумын нутагт “Ривер сайд” “Караван тур” гэдэг жуулчны баазууд ажилладаг.

**10. Туул гол.** Тайлбарыг 1 дүгээр чиглэлээс үз.

**11. Сайжрах уул.** Эрдэнэсант сумын төвөөс баруун урагш оршино.

Цэрдийн галавын үеийн үлэг гүрвэлийн мөр байдаг.



Үлэг гүрвэлийн гишгэн явсан нойтон элс тэр хэвээрээ хатаад гуранз болжээ. Гуранзан дээр үлдсэн энэ мөр Дэлхийн ховор нандин олборын нэг юм. Зураг дээр мөрний дэргэд түүнийг олсон хүн О.Намнандорж гуай сууж байна. Манай оронд үлэг гүрвэлийн судалгаа хийгдсэн голлох мэргэжилтнүүд нв академич Р.Барсболд, Д.Дашзэвэг, Н.Пэрлээ, О.Намнандорж нарын зэрэг хүмүүс юм.

Эрдэнэсант сум бол манай алдарт бөх дархан аварга, хөдөлмөрийн баатар Ж.Мөнхбатын төрсөн нутаг.

**12. Дэвсэнбулагийн рашаан.** Сайжрах уулын дэргэд оршдог гидрокарбонат, кали, магнитай рашаан, хүхрийн найрлагатай үе мөч, бөөр нуруу, арьсны өвчнийг орж эмчилдэг. /20, 259/

**13. Батхаан уул.** II-р бүлгийн 30-рыг үз.

**Өөр замд шилжих**

**1.Дунговийн замд**

Баян-Өнжүүлээс-Адаацаг 80 км

**2. Өвөрхангайн замд**

Дэвсэнбулгийн рашаанаас Бүрд сум 70 км

3. Эрдэнэсантаас Рашаант 40 км гээд Булганы ба **Өвөрхангайн** замд орж болно.

---

## **12 дугаар чиглэл**

### **Улаанбаатар-Лүн-Жаргалант-Улаанбаатар**

**Зорих гол үзмэр.** Хээр тал нутаг, манхт элс, ой хөвч, тариалангийн талбай.

**Аялах зам.** Улаанбаатараас Лүнгийн замаар Баянхангай сум 106 км-Авдрантын замаар урагш салж Энхийн элс /Молцог/ 30 км-Тавангийн элс 20 км-Лүн сум 30 км-Баянхангай сум 36 км-Угтаалцайдам сум 46 км-Заамар сум 53 км-Цээл сум 70 км-Жаргалант сум 60 км-Улаанбаатар 135 км.

Замын урт 600 км, хугацаа 3-4.

Мянганы зам. Улаанбаатараас Лүн-Хангайн даваагаар өнгөрнө.

#### **Үзэх гол үйлийн товч тайлбар:**

**1. Хустайн нуруу.** II-р бүлгийн 21-үз. Хустайд жуулчны баз бий.

**2. Молцог, Энхийн ба Тавангийн элс** нь Улаанбаатарт хамгийн ойр байгаа Манхт элс, уулын ам хөндий, ар хажууд тогтсон. Энд "Молцог элс" жуулчны бааз ажилладаг. II-р бүлгээс 21-Хустайн нурууг үз.

**3. Авдар уул.** Лүн сумын нутагт Энхийн элснээс баруун урагш холгүй орших боржин чулуун уул. Энэ уулнаас олборлож Улаанбаатарын зам талбайд хэрэглэж байгаа ногоон өнгийн амазонит боржин нь хатуу чанараараа дэлхийд ховор үнэтэй чулуу юм.

**4. Жаргалант.** Цээл сум хавь нутаг нь манай орны тарианы талбай нутаг учраас энд тариалан үзнэ. Энд орших Угтаалцайдам сум бол манай алдарт бөх Д.Хадбаатарын уугуул нутаг.

**Их хүрээ** Жаргалант сумын нутагт Угтаалжаргалантад 1724 онд, Буурал уулын өвөрт 1723 онд өвөлжиж байжээ.

**5. Хүүлэнханы хөшөө булш,** хүн чулуунуудыг үзнэ.

**6. Дугана хадны амралтад амарч болно.**

7. Баянчандмань суманд **"Баянхангай"** жуулчны баз ажилладаг.

**Өөр замд шилжих.**

**1.Булганы замд**

Заамраас Орхон сум 131 км

**2. Сэлэнгийн замд**

Жаргалантаас Баянгол сум 45 км, Хөтөл 90 км, Орхон сум 100 км.

**Өвөрхангай аймаг**

**Өвөрхангай аймаг.** 62.9 мян ам км нутагтай. 114.0 мян хүн амтай. Аймгийн төв Арвайхээр хот нь Хангай нурууны өвөрт д.т.д. 1913 м өндөрт Улаанбаатараас 430 км зайтай байрлана. Өвөрхангай аймаг нь Хангай нурууны



өврийн уулархаг, тэгш өндөрлөгт оршино. Өмнөд хэсэг нь говирхог хөндий, тал нутаг, Арвайхээр хотын агаарын жилийн дундаж температур нь  $0.8^{\circ}\text{C}$ , 1 сарынх нь  $-15.4^{\circ}\text{C}$ , VII сарынх  $15.3^{\circ}\text{C}$ , жилд 247.2 мм тунадас унана. Агаарын даралт мөн саруудад 811 орчим г Па байдаг. Салхины жилийн дундаж хурд 3.8 м/с бөгөөд хамгийн их салхитай IV-р сард дундаж нь 5.0 м/с байдаг. Аймгийн нутгаар Орхон, Онги, Түй, Таац голууд урсах бөгөөд Таацын, Найман зэрэг том жижиг нуурууд рашаан олон бий. Аймгийн нутгийн хойд хэсэг нь ойт хээрийн, дунд хэсэгтээ хээрийн, өмнөд хэсэг нь говийн амьтан ургамалтай.

Өвөрхангай аймаг нь 1.6 сая буюу манай орны хамгийн олон малтай аймгийн нэг. Малын дотор хонь ямаа олон. Нутгийн хойд хэсэгт тариалан хөгжүүлсэн. Өвөрхангай аймаг нь байгалийн ба түүхийн дурсгалт газрууд олонтой аймаг юм. Арвайхээр орчимд "Чандмань", "Алтан дөл", "Амар", "Хубилай", "Мөнгөн мод" зэрэг жуулчны баз ажилладаг.



Бүрд сумын нутгаар аялах замыг 20-р чиглэлийн замаас үз.

### **Арвайхээрт очих зам**

1. Улаанбаатар-Элсэнтасархай 300 км-Арвайхээр 140 км

Бүгд 440 км

2. **Улаанбаатар-Хужирт** 420 км-Арвайхээр 84 км

Бүгд 504 км

3. **Улаанбаатар-Төв аймгийн Дэлгэрхаан** сум 263 км  
Өвөрхангайн Баян-Өндөр сум 40 км, Арвайхээр 122 км

Бүгд 425 км.

### **13 дугаар чиглэл**


#### **Улаанбаатар-Хужирт-Улаанбаатар**

**Зорих гол үзмэр.** Монголын хангай, тал, хээр, нутгийн байгаль, гол мөрөн, элс манх, түүхийн дурсгалт газрууд, ховор амьтан ургамал,

Улаанбаатараас машинаар аялаж очих олон зам байж болно. Энд дөрвөн зам дурдая.

**Аялах зам А.** Улаанбаатар-Төв аймгийн Лүн сум 132 км Туул голыг гарч баруун урагшаа Эрдэнэсант сум 87 км, -урагшаа Дэвсэн булгийн рашаан 25 км баруун хойшоо Батхаан уул 30 км хойшоо-Цүүгэлийн гол 20 км, -Баруун тийшээ Булган аймгийн Рашаант сум 20 км –Хөгнөхаан уул 20 км-Элсэн тасархай 15 км-Тарны гол, Архангай аймгийн нутаг Хөөвөр голыг гарч, Өвөрхангай аймгийн нутаг Хөгшин Орхон гол 60 км-Хархорин 11км-урагшаа Хөгшин Орхон нолыг өгсөж Шанхын хийд 22км-Хужирт сум 34 км-баруун тийшээ Орхоны хөндий Үүртийн тохой 35 км-Бат-Өлзийт сум 17 км-Улаанцутгалангийн хүрхрээ 28 км, буцаад Хужирт сум 80 км-Хархорин 54 км-хойшоо Орхоны Харбалгас 40 км буцаад хархорин-Улаанбаатар 405 км—зүүн тийшээ Орхоныг гарвал Архангай аймгийн Хашаат сумын нутаг Хөшөөцайдам 25 км-Хашаат сумаар

### Өвөрхангай аймгийн нутгийн зураг



Масштаб: 1 см-т 33.5 км



дайрч зүүн хойшоо Булган аймгийн нутаг Харбухын гол / хийд/ 87км- Дашинчилэн сум 13км- Чинтолгойгоор дайрч Цогтын цагаан байшин 50 км- Хангайн даваа 54 км-Лүн сум 10 км- Улаанбаатар 132 км.

Энэ замд Хангайн даваа, Долоон даваа, Баяннуур, Дашинчилэн сумаар **Мянганы зам** өнгөрнө.

Замын урт 1100 км, хугацаа 6-7 хоног.

### **Үзэх гол зүйлийн товч тайлбар:**

1. Улаанбаатараас Лүн орох замын хойд талд Хайртхан уул, урд талд Хустайн нурууг /II бүлгийн 21-г үз/ харна. Лүнгийн зүүнээ Молцог Энхийн элс, Лүнгээс урагш Тавангийн элсийг харна.

2. Улаанбаатараас 60-аад км яваад **Жирмийн** хөндийгөөр гарч Жирмийн цагаан нуурыг харна. Энэ нь:

“”Жин жингээр дундарсан  
Жирмийн цагаан нуур  
Жилээс жилд жижгэрсэн  
Жаахан буурал эжий минь”

гэдэг сайхан дууны нуур юм.

Энэ замд тохиолдох зүйлүүдийг 12-р чиглэлийн замаас үз.

**8. Хөгнөхаан уул.** II бүлгийн 34-г үз.

✓ **9. Элсэнтасархай.** Батхаан уулын баруун урд хажуугаас эхлэн баруун хойшоо Хөгнөхаан уулын баруугаар гээд 80-аад км үргэлжилсэн манхт элсийг огтлон гарах зам. Энэ элс нь Монгол элс, Хөгнө-Тарнын элс гэж нэрд гарсан бөгөөд бургас, яргай зэрэг бутлаг ургамалтай. Энд “Баянговь” гэдэг жуулчны бааз ажилладаг.

Баянговиос Ширээтцагаан нуур 30 км- Бүрд сум 30 км- Хүйс Өвөрхөшөөт 14 км- Есөнзүйл сум 40 км- Арвайхээр 100 км гэсэн сонирхолтой зам байж болно.

Мөн энд Рашаант сумын төвөөс баруун тийш 13 км- т их замаас урагш ойрхон **“Хоёр загал”** жуулчны бааз бий. Хөгнөхаан орчимд жуулчны олон бааз бий.

---

Элсэнтасархайгаас /гүүрнээс/ Арвайхээр 140 км.

✓ **10. Эрдэнэзуу.** Улаанбаатараас онгоцоор 1цаг ниснэ. 1585 онд Монголын Автай сайн хааны санаачилгаар эртний монголын нийслэл Хархорум хотын туурийн дэргэд байгуулагдсан үндэс суурь нь эрт тавигдсан Монголын шарын шашны анхны хийд юм. 1944 онд улсын хамгаалалтад авчээ. Эрдэнэзуу нь хааш хаашаа 400 км тэг дөрвөлжин хэрэмтэй. Хэрэмний дөрвөн зүгт хаалгатай. Хэрэмний тал бүрд 25, дөрвөн өнцөгт нь тус бүр 2, бүгд 108 суваргатай. 1658 онд Эрдэнэзуугийн хэрмийн голд чуулганд зориулж барьсан 20 м голчтой Бат -Өлзий гэдэг гэрийн шал бий. Энэ шалны урьдахь хонхорт Орхон голоос нарийн сувгаар ус татаж нуур тогтоож байсан. Гурванзуугийн сүмийн гадаа үүдэнд жинхэнэ монгол уран барилгын загвараар барьсан хоёр бунхан бий. Түүний нэгийг Абтай сайн ханд, нөгөөг түүний хүү Түшээт хан Гомбодоржийн шарилд зориулжээ.

Эрдэнэзууд XVI-XVIII зууны монгол уран дархчуулын урлан бүтээсэн цутгамал бурхан хөрөг, хүрэл сав, сангийн бойпор, хонх, цамын хувцас, хөгжим, бүрээ зэрэг урлаг түүхийн олон ховор нандин үзмэрийг хадгалж байдаг том музей ажилладаг. (6.273)

Орхон голын хөндий, Эрдэнэзуу хавийн нутаг нь одоогийн ба эртний монголчуудын нутгийн төв билээ гэдгийг дээр МОГ-д дурдсан.

✓ **11. Хархорум** хот нь Монголын эзэнт улсын нийслэл байв. Хар хорин хотыг эртний Уйгар улсын үед IX зуунд байгуулагдсан гэж бас үздэг. Хархорин хотод 1220 оноос хойш Чингис хаан, Өгэдэй хаан, Гүюг, Мөнх нар сууж төр барьж байсан. XIV зууны үед Мин улсын цэрэг довтолгон сүйтгэсэн байна. "Хархүрэм" гэх нь зөв мэт санагддаг "Ү" үсэг байхгүй орос, Европын хэлний хүмүүс Каракорум болгосон нь сунжраад Хархорум, улмаар Хархорин болсон байх. Манай улс Хархорум хотын туурийг 1961 оноос улсын хамгаалалтанд авчээ.

Эрдэнэзуу хийд, Хархорум хотын туурийг ЮНЕСКО "Дэлхийн гайхамшигт үнэт зүйл болох нь" гэдэг зэрэглэлээр 1996 онд дэлхийн соёлын өвд бүртгэн авчээ. (6.189)

Хархорины орчимд "Хархорум", "Ханбаян", "Чандмань", "Өгөөдэй", "Хархорин", "Номин" зэрэг олон жуулчны бааз ажилладаг. Хархорин сум нь алдарт бөх, Дэлхийн 2 удаагийн аварга, хөдөлмөрийн баатар З.Ойдовын төрсөн сум. Сумын төвд түүний хөшөөг босгожээ.

✍ **12. Мойлтын ам.** Хархорумын баруун хойд захад Мойлтын рашааны ам Орхоны баруун эрэгт оршино. Хуучин чулуун зэвсэгийн үеийн чулууны дарханы буйр бий.

✍ **13. Шанхын хийд.** 1650-аад онд байгуулагдсан Монголын эртний хийдийн нэг, саяхан сэргээн засварласан Баруун хүрээ гэдэг энэ хийдийн зүүгээр Сарын гол /Хөгшин Орхон/ хойшоо урсдаг бөгөөд энд Өндөр гэгээн Занабазар багадаа тоглож өссөн. Шанхын ойролцоо "Сарын голын" хөндийд Чингисийн хар цагаан тугны өргөө цогцолбор байгуулагдана.

✍ **14. Хужиртын рашаан сувилал.** Өвөрхангай аймгийн Хужирт сумын төв дээр Хужирт голын эрэг дээр д.т.д. 1660 өндөрт оршдог рашаа. Гидрокарбонат-сульфат, натри, хүхэрт-устөрөгч, цайрын хүчил, фторын найрлагатай. Бөөр нуруу, үе мөч, хулуу шар ус, элдэв бэртэнгэ гэмтэл, тахир дутуу, зүрх мэдрэлийн зэрэг олон өвчнийг анагаахад орж ашигладаг. +55ос хүртэл халуун устай /20. 361/ рашаан сувилалын газар, жуулчны бааз ажилладаг. Энд дөрвөлжин булш олон байдаг. Хужиртыг аялал жуулчлалын Орхон голын бүсийн төв болгон хөгжүүлж байна.

✍ **15. Орхон гол.** Хангайн гол нуруунаас эх авч 1124 км урсаад Сүхбаатар хотын дэргэд Сэлэнгэд нийлэх том гол. Хангай, Хэнтийн уулсаас эх авах Туул, Ерөө зэрэг олон том голуудыг нийлүүлж авдаг. Орхон гол дээр Хархорины



дэргэд жижиг усан цахилгаан станц бий. Доод хэсэгт хөндийд нь тариалан эрхэлдэг. Орхонд зэвэг, цуурхай, булуу цагаан, хилим, тул, цагаан загас, алгана, сибирь хадран, балиус, улаан нүдэн, сибирь сугас, бух заарам, мөнгөлөг хэлтэг, цулбуурт, гутар зэрэг загастай. Орхоны хөндий нь Төв Азийн хойд хэсэг ялангуяа Монголын хот байгуулалтын гарал үүсэл хөгжлийг харуулж байгаа археологийн болон түүх соёлын дурсгалаар баян нутаг, энд XIII-XVI зууны үеийн монголын эзэнт гүрний өргөн уудам нутгийн маш чухал суурин газар байв. Орхоны хөндий дэх Эрдэнэзуу, Төвхөн хийд, Хар балгас, Хархорум хотын туурь, Культегин, Билгэ хааны хөшөө зэргийн түүх соёлын чухал дурсгалыг ЮНЕСКО "Дэлхийн гайхамшигт үнэт зүйл" гэдэг зэрэглэлээр дэлхийн соёлын өвд 1996 онд бүртгэн авчээ. Орхоны хөндийд эртнээс нааш монголын хаадын өргөө, улсын нийслэл оршиж байсан бөгөөд монголын газар нутгийн өнөөгийн хүйс/төв цэг / нь Орхоны хөндийн чухам энэ хэсгээс зүүн урагш холгүй /90- ээдхэн км/ оршиж байгаа нь тохиолдлын хэрэг биш. /Энэ тухай МОГ-д дурьдсан/

✓ **16. Үүртийн тохой.** Орхоны эгц цавчим хүрмэн чулуун хавчилд оршдог нүүрсхүчлийн хийтэй, эсэглэн хүйтэн рашаан, ууж эмчилгээнд хэрэглэдэг. Үүртийн тохой хүрэх замд Хурган хүрмийн үзүүрт жижиг хэрэм бий. Үүртийн тохойгоос баруун тийш Бага хүрхрээ, түүнээс дээш Тэмээн чулуу гэдэг газар хүрлийн үеийн дөрвөлжин булш бий.

✓ **17. Улаан цутгалангийн хүрхрээ.** Орхон голын баруун газарт цутгах Улаан голд үүссэн 20 гаруй м өндрөөс буух 10 орчим м өргөн хүрхрээ юм. Энэ хавьдаа Орхон гол нь 20 гаруй метр өндөр ханан эгц хүрмэн чулуун хавцал дундуур урсах бөгөөд энэ хавцал руу Гятрууны нуруунаас эх авсан Улаан гол буухдаа энэ хүрхрээг үүсгэжээ. Улаан голын ус цагийн удаанд хүрмэн чулуун тавцанг идэн ухраасаар одоо хүрхрээ нь Орхон голоосоо 100 орчим м холджээ. Орхон гол нь Гятрууны нуруунаас Хархорин сум хүртлэх 130 км хүртлэх газарт галт уулын хүрмэн чулуун дундуур урсдаг юм. Дөрөвдөгч галавын үед Хангайн

гол нуруунаас эх авах Цагаан Азарга голын эхэнд галт уул дэлбэрэн оргилж түүний халуун хайлмал бодис нь Орхоны хөндийг уруудан урсаж хэдэн арван км зузаан хүрмэн чулуун хучлага үүсгэсэн нь энэ юм. Тэр хүрмэн чулуун хучлагыг Орхон гол хөрөөдөж урссаар таслан өнөөгийн энэ хавцлыг үүсгэсэн ажээ. Хүрхрээний дэргэд “Мөнгөн хүрхрээ” гэдэг жуулчны бааз ажилладаг.

✎ **18. Өөлдийн улаан хад.** Хүрхрээнээс зүүн тийш 30 орчим км зайтай Орхон гол дээр Бат-Өлзийт сумын төвөөс хойш чигт Улаан хадны Онгоцтын гүүр оршино. Энэ гүүрний хойд хажууд гол руугаа түрж орсон улаан хошуунд Галданбошигтын цэрэг буудалцаж байсан учраас Өөлдийн улаан хад гэдэг болсон.

Энэ гүүрний дэргэдээс урагшаа, баруун урагшаа харахад Хангайн нурууны арын битүү ой мод, оройн таг, Цэгээний хуниас, Манангийн тархи, Манангийн гурван ховог, Зэст, Улаан зэрэг мөстлөгийн хунхт, нүцгэн асга хадат тагийн бүст уулууд маш сайхан харагдана. Энэ гүүрээр гарч /одоохондоо эвдэрсэн/ Орхон голын хойд эргээр 35 орчим км явж Нарийн голыг өгсөн Төвхөн хийдэд очиж болно. Төвхөн хийдийн тухай 16-р чиглэлээс үз.


✎ **19. Бат-Өлзийт** сумын төвөөс баруун урагш 12 км-т Могойтын голын хөндийд машинаар очиход намаг ус ихтэй бэрх газарт /Яг рашаан дээр машин очиж чадахгүй 2-3 км л ойртоно/ Могойтын рашаан оршино. Энэ рашаан гидрокарбонат найрлагатай, 45°C-70°C-ын халуун рашаан юм.

✎ **20. Хангайн Цагаан чулуу.** Могойтын рашааны зүүн урд ар дээр ойрхон орших үзэсгэлэнт цагаан гантиг шохойн чулуун цохио бий. Үүний өндөр нь 10 гаруй метр, эргэн тойрон нь 100 метр энэ цохионы гэрэл зургийг хальсанд буулгаж болдоггүй гэж нутгийнхан ярьж тахин шүтдэг.

Хангайн нурууны тухай II бүлгийн 18-ыг үз.

---

21. **Орхоны Хар балгас.** Хархорумаас баруун хойш 40 орчим км Архангай, Хотонт сумын төвөөс зүүн хойш 15 орчим км-т Орхон голын зүүн гар талд оршино. 751 онд байгуулагдсан IX-р зууны үеийн Уйгар улсын нийслэл байсан. Ордубалык буюу Балыклык хотын туурь. Хар балгас нь Төв Азиар дайрч өнгөрч байсан торгоны замын салааны төв газруудын нэг, бэхэлгээтэй цайз, худалдааны төв болж байсан. Хар балгас, Хархорум хот нь энэ торгоны замын хойд /Монголын нутгаар өнгөрөх/ салааг 400 жил хянаж байсан газар гэж үздэг. /Энэ тухай 25, 41, 61-р чиглэлүүдэд үз/ Хааны хэрэмт орд харш, гар үйлдвэр, цайз, агтны хашаа, цэргийн ба худалдааны агуулах, захиргааны барилгын хэрэмт туурь бий. Энэ дурсгалыг ЮНЕСКО "Дэлхийн гайхамшигт үнэт зүйл болох нь" гэдэг зэрэглэлээр дэлхийн соёлын өвд 1996 онд бүртгэн авсан бөгөөд манай улс 1971 онд улсын хамгаалалтад авсан, хамгаалалтын талбайг 2002 онд 39.8 ам км болгож ихэсгэжээ. /Энэ хэсгийн 11, 15-ыг үз. / мөн Хотонт сумын нутагт Хар балгасаас хойш холгүй орших Дойтын толгойн туурийг 1998 онд улсын хамгаалалтад авсан байна. /6. 187/



22. **Хөшөө цайдам.** Хархориноос хойш 40 орчим км-т Хар балгасаас зүүн тийш 20 гаруй км-орших VI-VIII-р зууны үед мандаж байсан Түрэг улсын Билгэ хаан, түүний ах Культегин жанжин нарт зориулан 732 онд Культегины ач хүү Йолуг тегины бичсэн бичигт хөшөө, шинжлэх ухаанд "Орхоны бичээс" гэж алдаршсан бичигт ховор нандин энэ чулуун хөшөө 3, 3 м өндөр 1, 3 м өргөн. Энд 68 мөр бичээс бий. Энд бүхэл бүтэн цогцолбор байсан бөгөөд одоо энэ Гэрэлт хөшөө л үлджээ. Монгол оронд Түрэг бичээстэй хөшөө 40 гаруй байдгийн 10 гаруй нь Орхоны хөндий, сав газарт байдаг юм. Культегин, Билгэ хаан нарын хөшөөг ЮНЕСКО "Дэлхийн гайхамшигт үнэт зүйл болох нь" гэдэг зэрэглэлээр 1996 онд дэлхийн соёлын өвд бүртгэн авсан байна. /б. 165/ Манай улс 1961 оноос улсын хамгаалалтад авсан бөгөөд хамгаалалтын талбайг 2002 онд 20.8 ам км-ээр тогтоожээ. Хөшөө цайдамын энэ хөндийн Улаанхудагт Хутагтын өргөө буюу Шар бүст өргөө Ширээтцагаан нуураас нүүж ирээд энд 14 жил нутагласан ажээ.

23. **Харбухын балгас.** Булган аймгийн Дашинчилэн сумын нутагт Хар бухын голын гүүрний дэргэд харагдана. Хун тайжийн балгас ч гэж нэрлэдэг. Энд галт уулын хүрмэн чулуу, билүү занар чулууг үелүүлэн алаглуулж өрж барьсан 2 давхар ордны маш үзэсгэлэнтэй хана суварга үлджээ. Х- зууны үеийн Хятан улсын том хотын хэрэмний турь дотор монголчууд энэ чулуун хийдийг XVII зууны үед барьжээ. Хадаасангийн балгас ч гэж нэрлэдэг энэ дурсгалыг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /б. 188/ Энэ балгас орчмоос нэрт эрдэмтэн Х.Пэрлээ гуай XV, XVI зууны үед холбогдох үйсэн дээр бичсэн монгол хуулийн эмхэтгэлийг олж нээлт хийжээ.

24. **Цогт тайжийн цагаан байшин.** Чин толгойн хэрэмнээс зүүн хойш /20 гаруй км/ Дашинчилэн сумын Халдунзүрх ууланд Туулын хөндийд оршино. Энэ нь Цогт Хун тайжийн ээж Мадай Тайгал хатны өргөө номын сургууль байсан цагаан ордны суурь юм. Одоо байшингийн хана, 5 м орчим өндөр чулуун тавцан бичигт

хөшөө байна. Цогт тайж бол XVII зууны үеийн монголын эх орон ч хүн билээ. 1601 оноос барьж эхэлсэн энэ дурсгалыг байгуулсан түүхийг Монгол, Төвд бичгээр бичсэн бичиг бүхий чулуун хөшөө нь энэ харшнаас баруун тийш холгүй бий. Энэ орд харш, дурсгалыг 1971 онд улсын хамгаалалтад авчээ. /б. 197/ Туулын голын хөндий Бор Булан гэдэг энэ хавь нь ямар ч зун гандаж хуурайшдаггүй нутаг, эндээс зүүн хойш 20-иод км-т харагдах Заамар уул нь ямар ч өвөл зутардаггүй нутаг юм. Иймд энэ хавь нутгийг

Ган болдоггүй **Бор булан**

Зуд болдоггүй **Тосон Заамар** гэж нэрлэдэг юм.


**Өөр замд шилжих**

**1. Булганы замд:**

- Лүнгээс Баяннуур сум 65км,
- Эрдэнэсантаас-Рашаант 40км.

**2. Архангайн замд:**

- Элсэнтасархайгаас Хашаат 60км
- Хархориноос Хотонт 37км
- Төвхөн уулаас Түвшрүүлэх 85км



**Хүрхрэнээс Найманнуур орох зам**

Хүрхрэнээс баруун урагшаа Улаан гол, Цагаан Азаргын голыг өгсөж Дээдхүрд намаг чулуутай замаар 28 км явж сайн машинаар очиж болно. Цаашаа голоо өгсөн Найман нуурын хойд захын том нуур болох Хүйс нуур хүртэл Хөх голыг өгсөж Хөх голын даваагаар давж 25км орчим явган явж очно. Хүйс нуураас хамгийн урд захын бөгөөд хамгийн том нуур болох Ширээт нуур хүртэл Бугат, Дөрөө зэрэг нууруудыг дамжин 10 орчим км явна.

**Б. Хужиртаад Улаанбаатараас машинаар аялах зам.**

**А. Замаар** гарч Эрдэнэсант-Дэвсэнбулагийн рашаан 245км, Өвөржаргалант голыг өгсөж Жаргалантын хөтөлийг давж Аржаргалант голын эх /Дуут манхан/ 39км- Ширээтцагаан нуур 50км- Өвөрхангай аймгийн Бүрд сум 30км-Өвөрхөшөөт /хүйс/ 14км-Бүрд сум 14км-



Хархорин 100км /Бүрд сум-Хужирт 90км/ бүгд 500км

**Үзэх гол зүйлийн товч тайлбар:**

**1. Туул гол.** Дэвсэнбулагийн рашаан, Сайжрах уулын тайлбарыг 11-р чиглэлийн замаас үзнэ.

**2. Өвөржаргалант гол.** Батхаан уулын урд салбараас эх авч зүүн тийшээ 50-аад км урсаад Дэвсэнгийн хөндийн нуур хүрнэ.

**3. Аржаргалант гол.** Батхаан уулын урд салбараас эх авч баруун тийш урсан Олон гол, Шарлингийн голтой нийлэн Тарнын гол, улмаар Харбухын гол болж Туул голд цутгана. Өвөр, Аржаргалант голууд эрт цагт нэг гол байгаад хожим нь газрын өргөгдлөөс болж хоёр тийшээ урсах болсон гэж зарим эрдэмтэд бичсэн.

**4. Дуут манхан.** Аржаргалант голын эхэнд орших өвс ургамалгүй үзэсгэлэнт гөлөөн манх. Алсаас улайрч шаргалтан сайхан харагдана.

**5. Ширээтцагаан нуур** 16-р чиглэлээс үз.

**6. Өвөрхөшөөт** 1 бүлгийн б-ын 9-ийг үз.

**Өөр замд шилжих**

**1. Дундговийн замд**

- Төв аймгийн Бүрэн, Дэлгэрхаан сумаар дамжин орж болно.

**2. Архангайн замд**

- Хархориноос Хотонт 37 км.

**В. Хужиртаад Улаанбаатараас машинаар аялах зам.**

**А. Замаар** гарч Эрдэнэсант сум 220 км-Булганы Рашаант сум-40 км гээд А замдаа нийлэх зам байж болно. Ингэж явбал Улаанбаатар-Хужирт-425 км, Улаанбаатар-Хархорин 380 км байх болно. Одоо энэ замаар аялах нь их болсон.

**В. Замд үзэх зүйлийн тайлбарыг А замаас үз.**

**Г. Хужиртаад Улаанбаатараас машинаар аялах**



**зам. А** замаар гарч Лүн 132 км-Булганы Баяннуур 65 км-Чинтолгойг дайраад Дашинчилэн сум 40 км-(Чинтолгойг дайрахгүйгээр Дашинчилэн сум 30)-Харбухын балгас 13 км-Номын булгийн рашаан 5 км-Гурванбулаг сум 50 км-Архангайн Хөшөөцайдам 55 км-Хархорин 40 км-Хужирт 56 км. **Бүгд 490 км**, гэсэн зам байж болно. Улаанбаатараас Дашинчилэн 226 км зам нь Мянганы замын хэсэг билээ. Хуучин гол зам, ойрд засагдаагүй учир дэржигнүүртэй гэдэг, гэхдээ шавар ус, даваа гүвээ бараг байхгүй сайн зам.

**Д. Зам.** Улаанбаатар-Төв аймгийн Бүрэн сум 172 км-Дэвсэнбулгийн рашаан 70 км-Жаргалантын хөтлөөр, Өвөрхөшөөт 70 км-Бүрд сум 14 км-Ширээтцагаан нуур 30 км-Хужирт сум 130 км (буюу Хархорин 100 км) гэсэн зам бий.

#### **Г. Замд үзэх гол зүйлийн товч тайлбар.**

**1. Долоон даваа.** Лүнээс баруун тийш Хангайн даваагаар давсны дараа замд тохиолдох даваанууд. Энэ бол Мянганы замын хэсэг.

**2. Борогчингийн манх.** Булган аймгийн Баяннуур сумын төвөөс баруун урагш замын урд харагдах өвс ургамлаар бэхлэгдсэн манхт элс.

**3. Их цагаан нуур.** Их замын хойд талаар тулгуу орших их намаг, зэгст нуур, шувууд их цугларна.

**4. Чинтолгой, Харбухын балгас, Хөшөөцайдамын** тайлбарыг энэ чиглэлийн А замаас үз.

**5. Номын булгийн рашаан.** Харбухын голын гүүрнээс /балгасаас баруун тийш 5 км орчимд замын дэргэд хойд талд нь оршино. Ходоодны өвчнийг анагаахад уудаг булаг. /20. 296/

#### **Өөр замд шилжих**

**1. Булганы замд** Баяннуураас,

**2. Архангайн замд** Хөшөөцайдамаас, бас Харбухын балгасаас Өгий нуур 90 км

## **14 дүгээр чиглэл**

### **Хужирт орчмын зам**

Хужиртаад онгоцоор очно. Хужиртаас олон зам байж болно.

**А.Зам.** Хужирт-Үүртийн тохой-35, Бат-өлзийт сум 17 км, Улаанцутгалан 28 км-Төвхөн хийд 65 км-Хужирт 40 км

Бүгд 185 км хугацаа 2 хоног

### **Үзэх гол зүйлийн товч тайлбар**

**1. Бат-өлзийт** сумын хавьд Могойт, Гятрууны рашаанууд бий. /20. 367, 370/

**2. Төвхөн** хийдийг 16-р чиглэлээс, бусад зүйлийг 13-р чиглэлээс үз.

**Б. Зам.** Хужирт-Хархорин 56 км-Хөшөө цайдам 40 км-буцаад Хужирт 100 км

Бүгд 200 км хугацаа 1-2 өдөр.

### **Үзэх зүйлийн товч тайлбарыг 13-р чиглэлээс үз.**

**В. Зам.** Хужирт –Хархорин 56 км-Архангайн Хотонт сум 37 км гээд Архангайн замд орж болно.

### **Үзэх гол зүйлийн товч тайлбар.**

**1. Орхоны Харбалгасыг** 13-р чиглэлийн А замаас, Өгийнуурыг 18-р чиглэлээс үз.

**2. Чилин хийд.** Өгий нуураас баруун тийш 5 орчим км зайтай, Хөгшин Орхон, Орхон, Өгий нуурын хоолойн хооронд усан хүрээлэлд оршино. Очиход төвөгтэй, 1км орчим газраас харна. XVII зууны үед монголчуудын барьсан чулуун хийдийн туурь, том хэрэм, цамхаг харагдана.

**Г. Зам.** В замаар аялж Хужирт- Өгийнуур сум 133 км Өгий нуур 156 км- Дашинчилэн 106 км- Баяннуур 30 км- Лүн 65 км- Улаанбаатар 132 км. Бүгд 510 км.

---

**Д. Зам.** Хужирт- Арвайхээр 84км- Хужирт 84км,  
Бүгд 170 км, хугацаа 2 хоног.

**Үзэх зүйлийн тайлбарыг В замаас үз.**

**Өөр замд шилжих**

**1. Архангайн замд**

Төвхөн хийдээс зүүн урдуур Нарийн голын ба хужиртын  
давааг давж:

-Түвшрүүлэх сум 85км

-Хотонт сум 70км

**15 дугаар чиглэл**

**Хархорин орчмын зам**

Хархоринд онгоцоор очвол тэндээс олон зам байж  
болно.

**А. Зам.** Хархорин- Хужирт 56 км- Улаанцутгалан 80  
км-Төвхөн хийд 65 км- Орхоныг усаар гаталж Хужирт 40  
км- Хархорин 56 км.

Бүгд 310 км, хугацаа 2-3 хоног.

Б. Зам. Хархорин-Хужирт-Улаанцутгалан Төвхөн хийд  
200 км Орхоныг усаар гаталж Хархорин 70 км,

Бүгд 270 км, хугацаа 2 хоног.

**Энэ хоёр замаар аялахад анхаарах зүйл:**

**1. Орхоны** усаар гатлах амаргүй, үертэй бол ерөөсөө  
явахгүй.

**2. Бат-Өлзийт** сумын Улаанхадны Онгоцтын гүүр  
засвартай бол аль ч замаар явж болохгүй.

**В. Зам.** Хархорин- Архангайн Хотонт 37км гээд  
Архангайн замд орж болно. Энэ замд Архангайн Хашаат  
сумын нутагт "Бүрд" гэдэг жуулчны баз бий.

**Г. Зам.** Хархорин-Хотонт 37 км- Харбалгас 16 км-Өгийнуур  
сум 40 км Чилин хийд 20 км-Өгий нуур 5 км-Нуураа зүүгээр нь  
тойроод Хөшөөцайдам 60 км-Хархорин 40 км.

Бүгд 220 км, хугацаа 2 хоног. Өгий нуурт жуулчны бааз бий.

**Д. Зам.** Хархорин-Хөшөөцайдам-Хархорин 80 км.

**Е. Зам.** Хөшөөцайдам гээд Улаанбаатар Хужиртын Г замд орж болно.

#### **Өөр ззамд шилжих**

##### **1. Өвөрхангайн чиглэлд**

- Арвайхээр, Хужиртаар дамжин 140 км

-Өвөрхөшөөт /хүйс/-100 км.

##### **16 дугаар чиглэл**

##### **"Сувдан сондор-2"**

"Өндөр гэгээн Занабазарын төрөлх нутгаар гэдэг "Сувдан сондор-2" аян 1996 онд Өвөрхангай аймгийн нутгаар явсан юм.

**Аяласан зам нь.** Улаанбаатараас 13-р чиглэлийн замаар гарч Эрдэнэсант 220 км-Булганы Рашаант сум 40 сум-Хөгнөхаан 20 км-Баянговь жуулчны бааз 20 км-Ширээтцагаан нуур 50 км- Бүрд сум 30 км- Өвөрхөшөөт 14 км- Навчитын рашаан 20 км- Буурлын хөшөө 30 км- Өвгөнсуварга 15 км- Арвайхээр 120 км- Хужирт 84 км- Төвхөн хийд 40 км- Хашаат сум 40км- Элсэнтасархай 50 км- Рашаат сум 25 км- Эрдэнэсант 40 км –Лүн 87 км- Улаанбаатар 132 км.

Бүгд 1240км, хугацаа 10 хоног.

#### **Үзэх гол зүйлийн товч тайлбар.**

Энд бичээгүй зарим зүйлийн тайлбарыг Өвөрхангайн замуудаас үзээрэй. Бусад нь:

**1. Баянговь.** Монгол элсний хойд захад Элсэнтасархайд Шилүүтэй уулын баруун бэлд Шилүүтэйн голын хөвөөнд орших жуулчны бааз.

**2. Хөгнөхаан уул.** II бүлгийн 34-ийг үз. Хөгнөхааны орчимд "Монгол элс", "Хоёр загал", "Жи эм ти", "Хөгнөговь", "Батхаан" зэрэг жуулчны баазууд бий.

**3. Ширээтцагаан нуур.** Монгол элсэнд Ихмонгол уулын зүүн урд бэлд орших гурван жижиг нуур. Цагаан нуур гэдэг энэ нуурын эрэг дээр 1639 онд Өндөр гэгээн Занабазарыг 5 настай байхад нь түүнийг монголын шарын шашны тэргүүн анхдугаар Богдод өргөмжлөн ширээнд суулгаж /Ширээт гэдэг нэр эндээс гарсан/ Шар бүст өргөөг барьснаар өнөөгийн нийслэлийн /Улаанбаатарын/ суурь тавигдсан. Ширээтцагаан нуур нь өөрөө манхт элсэн хүрээлэлд орших бөгөөд энд гүрвэл давхиж явах нь говийн байгалийн төрх байдал, Нуур орчмын шинэсний төгөл бургас, хус, хайласны шугуйд буга 20-30- аараа идэшлэж явах, хөхөө донгодох зэрэг нь ой модтой хангай газрын төрх байдал, Монгол элс Ихмонгол ууланд арц ургах нь өндөр уулын тагийн бүсийн төрх байдал билээ. Монгол элс нь өөрөө хээрийн бүсийн хүрээлэлд оршино. Энүүхэн бага нутагт Говь, хээр, ой тайга, уулын тагийн бүс гээд монголын байгалийн үндсэн бүсийн төрх байдлыг нэг дор хадгалсан нь үнэхээр сонин бөгөөд чухам ийм онцлог газрыг олж нийслэлийнхээ суурийг тавьсан бидний өвөг дээдэс яасан их ухаантай, мэдлэгтэй, яасан их гярхай хүмүүс байж вэ? гэж гайхмаар, бахархмаар. Ихмонгол уулын арцыг өндөр гэгээн Занабазар өөрөө аравнайлсан. Ууландаа аравнайлагдсан арц монголд үүнээс өөр байхгүй гэдэг. Ширээтцагаан нуураас Ширээтийн гол баруун урагшаа урсан гарч Жаргалант голд нийлнэ. Эндээс Батхаан ууланд очиж болно. II бүлгийн 32. (Ард бий "Сувдан сондор" 6-г үз.)

**4. Өвөрхөшөөт.** I бүлгийн 6-ын 9-ийг үз.

**5. Навчитын рашаан.** Баян-Өндөр сумын нутагт Зүүнхайрхан уулын зүүн хажууд орших хүйтэн рашаан, элэгний өвчнийг анагаахад уудаг гэдэг.

**6. Буурлын хөшөө.** Нэгэн омгийн удирдагчид зориулсан хөшөө гэдэг. Баян-Өндөр сумын төвөөс баруун тийш их замын дэргэд оршино.

**7. Өвгөнсуварга.** Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын нутгийн урд захад оршино. Энд өндөр гэгээн Занабазар 1634 онд мэндэлсэн.

8. Өлзийт сумын нутаг **Баруунхайрхан** ууланд Яргайтын сүм бий. Энэ сүмийн дэргэд Хайлангийн булаг гэж рашаан бий. Ходоод дотрын өвчнийг ууж анагаадаг. Нарийн судлагдаагүй рашаан, нутгийн ардууд зундаа их цуглардаг.

### **9. Төвхөн хийд.**

Архангай, Өвөрхангай аймгийн нутгийн заагт Хужирт сумын төвөөс баруун хойш 40 орчим км зайтай д.т.д 2312 м өндөр Өндөр-Овоот /Шивээт/ уулын оройд Өвөр агуйтад оршино. Хужиртаас Орхон голыг усаар гатлан гарч Төвхөний зүүн сугаар урсах Нарийн гол гэдэг горхийг өгсөн уулын бэлд хүрнэ. Бэлээс нь уулын орой хүртэл 5 км орчим явган явж очно. Ойн замаар өгсөж чадах машин очно. Төвхөн хийд нь 20-оод метр өндөр том эгц хадан цохионы өвөрт засаж тэгшилсэн талбайд орших 1654 онд баригдсан 14 сүм дугантай байсан жижиг хийд. Буйд газар орших энэ хийд нь өндөр гэгээн Занабазарын бүтээлийн хийд бөгөөд чухам энд 1680 онд алдарт соёмбо үсгээ бүтээсэн аж. (6.263) Энэ бүтээлийн сүмийг 1998 онд улсын хамгаалалтанд авсан бөгөөд 2002 оноос 4.5 ам км талбайгаар хамгаалах болов. Бас ЮНЕСКО"Дэлхийн гайхамшигт үнэт зүйл болох нь" гэдэг зэрэглэлээр 1996 онд дэлхийн соёлын өвд бүртгэн авчээ. Энд очих замуудыг 14-ын А, 15-р чиглэлүүдэд дурьдсан. Бас Архангайн Хотонт, Түявшрүүлэх сумаас ус гатлахгүй, Хужиртын ба Нарийны давааг даваад энэ сүмд очиж болно.

### **10. Хөшөөцайдам. 13-р чиглэлийн замаас үз.**

#### **Өөр замд шилжих**

#### **1. Өвөрхангайн замд**

- Элсэнтасархайгаас Арвайхээр 140 км
- Элсэнтасархайгаас Хужирт 120 км
- Элсэнтасархайгаас Хархорин 70 км

#### **2. Архангайн замд**

- Төвхөн хийдээс Нарийн голын давааг давж Түвшрүүлэх км
-



- Төвхөн хийдээс Хотонт 70 км

### **3. Дундговь аймгийн замд**

- Баян-Өндөрөөс Эрдэнэдалай сум 90 км

### **4. Төв аймгийн замд.**

- Баян-Өндөрөөс Дэлгэрхаан сум 60 км.

### **"Сувдан сондор-6" аяны зам**

"Сувдан сондор-6" аян 1999 оны 9-р сард Улаанбаатар хот байгуулагдсаны 360 жилийн ойд зориулан Улаанбаатарын суурь тавигдсан газар, нүүж суурьшиж байсан зарим газрыг олж хөшөө босгох цэгийг сонгох ажлаар Өвөрхангай, Архангай, Булган, Төв аймгийн нутгаар аялав. Энэ аялалд түүхч О.Пүрэв, С.Ичинноров, С.Идшинноров, Ц.Байды, Ц.Болдсайхан, Г.Нямсамбуу бид нарын хориод хүн оролцов.

### **Аялахаар төлөвлөсөн зам нь:**

Улаанбаатар-Лүн сум 132 км-Эрдэнэсант 87 км-Давсэнбулгийн рашаан 30 км-Өвөржаргалант голоор өгсөж Аржаргалант голоор уруудаж Дуут манхыг дайрч-Өвөрхөшөөт 90 км-Бүрд сум 14 км-Ширээтцагаан нуур 30 км –Баянговь жуулчны бааз, Элсэнтасархайгаар дамжин Хархорин 130 км-Харбалгас 40 км-Хотонт, Түвшрүүлэх сумаар дамжин Хотонт сумын нутаг дахь Эрдэнэтолгой-Цэнхэр сум 100 км-Өгийнуур 71 км-Улаанхудаг 30 км-Хөшөөцайдам 20 км-Хашаат сум 40 км-Элсэнтасархай 50 км-Хөгнөхаан уул 30 км-Дашинчилэн сум 60 км Харбухын балгас 13 км-Дашинчилэн сум 13 км-Чинтогой 18 км-Цогтын цагаан байшин 50 км-Хангайн даваа 54 км-Лүн сум 10 км-Авдрант уул 60 км-Улаанбаатар 80 км.

Замын нийт урт 1400 км-хугацаа 7 хоног.

Цаг уурын бэрхшээлээс болоод аялах зам хугацаагаа өөрчилсөн юм. Тухайлбал: Улаанбаатар-Эрдэнэсант / Батхаан ууланд цас орж байсан учир урдуур замаар явахаа больж/ -Хөгнөхаан уул 60 км-Баянговь жуулчны бааз 20 км /хоноглов/. Бүрд сум 40 км-Өвөрхөшөөт 14 км-Бүрд сум 14 км Ширээтцагаан нуур 30 км /хоноглов/. -Шанх

сум 100 км-Хархорин 22 км-Ханбаян /С.Н/ жуулчны бааз (7 км) хоноглов. Хархорин Архангайд их цас орсны улмаас цааш явж болохгүй болж Хархорин-Улаанбаатар 370 км явж ирэв.

**Үзэх гол зүйлийн товч тайлбар:**

**1. Туул гол,** 1-р чигэлээс, Хустайн нуруу 2-р бүлгийн 21-ыг үз

**2. Дэвсэнбулгийн рашаан** 11-р чиглэлээс үз

**3. Аржаргалант, Өвөржаргалант** гол 13-р чигэлийн Б замаас үз

**4. Өвөрхөшөөт.** Монголын онцлог газруудын 9-ийг үз.

**5. Ширээтцагаан нуурыг** 16-р чиглэлээс үз. Энд Гэрэлт хөшөө босгох газрыг бид 1999 оны намар сонгосон юм.

**6. Элсэнтасархай, Хархорин, Эрдэнэзуу, Мойлтын ам, Орхон гол, Харбалгас, Хөшөөцайдам, Харбухын балгас, Чинтолгой, Цогтын цагаан байшингийн** тухай 13-р чиглэлээс үз.

**7. Эрдэнэтолгой,** Хутагтын өргөө /Улаанбаатарын эх суурь/ 1700-1719 онд энд суурьшиж байсан. Цэнхэр сумын Эрдэнэтолгой багийн нутаг түвшрүүлэх (сумын төвөөс урагш 16 км)

**8. Өгий нуур.** 18-р чиглэлээс үз.

**9. Улаанхудаг.** Өгий нуураас урагш чигээрээ 20 орчим км-т оршино.

Хутагтын өргөө /Улаанбаатарын эх суурь/ 1640 оноос 14 жил суурьшин байсан газар.

**10. Хөгнөхаан уулын** тухай II бүлгийн 33-д үз.

**17 дугаар чиглэл**

**Өвөрхангай аймаг дотор**

**Зорих гол үзмэр.** Монгол орны их ой хөвч, хээр тал, говь хосолсон нутаг, гол горхи, нуур, уулын тагийн бүс, амьтан ургамал.

---

**Улаанбаатараас** Арвайхээрт онгоцоор/1 цаг 30 мин/ эсвэл Хужиртаас 84 км машинаар очиж болно.

**Арвайхээрээс аялах зам.** Арвайхээр-баруун хойшоо Тарагт сум 35 км-Уянга сум 26 км/Эндээс Онгийн ба Шурангын голыг өгсөж Найман нуур 50 км/-баруун урагшаа Нохойн Усны даваа давж Муруйн голыг уруудан Хайрхандулаан сум 90 км-урагшаа Өшгөхийн нурууг давж Баруунбаян Улаан сум 100 км-зүүн урагшаа Багабогд уул 60 км-Богд сум 60 км-хойшоо Гучин-Ус сум 93 км-Арвайхээр 104 км

Замын урт 700 км, хугацаа 4-5 хоног

#### **Үзэх гол зүйлийн товч тайлбар:**

**1. Хүрэмтийн рашаан.** Эртнээс ашиглаж ирсэн халуун рашаан. Энэ рашаан нь Хужирттай адил гидрокарбонат сульфат натрит рашаан юм. Халуун нь +58.8оc хүрнэ. Энд 10 гаруй булаг бий. Үе мөч, мэдрэлийн өвчин сувилахад ордог. /20. 374/

2. Уянга сумын төвд ойролцоо **Увшхайн хөшөө**, YI-YIII зуунд босгосон Түрэг улсын Эльтарс хааны хөшөөг үзэж болно.

Ноён, хатан, жанжин, сөнч, хонины ууц зэргээс бүтсэн 9 хөшөө бий. Эдгээрийг тойроод 9 хонхор бий. Үүнийг нийтэд нь Увшхай/сахилтан/ гэж нэрлэдэг гэж эрдэмтэд үздэг. Онгийн голын цогцолбор гэж нэрлэдэг энэ дурсгалыг 1971 онд улсын хамгаалалтад авчаа. /6. 220/, /6. 122/

**3. Шурангын цохио.** Уянга сумын төвөөс баруун тийш 30 –аад км-т Найман нуур орох замд Шурангын голын хөвөөнд орших тэмээ хэлбэрт тунамал чулуун том цохио.

**4. Ширээтийн даваа.** Шурангын голыг өгсөж Найман нуур орох замын д.т.д. 2500 гаруй м-т орших, Хангайн гол нурууг давах нэг даваа. Найман нуурыг үз.

**5. Найман нуур.** II бүлгийн 50-г үз. Хангайн нурууны тухай. II бүлгийн 18-г үз.

**6. Нохойн Усны даваа.** Уянгаас Хайрхандулаан сум ороход давах том даваа д.т.д. 2300 гаруй м өндөрт оршино.

**7. Ханхөгшин уул.** Хангайн гол нуруунаас урагш ганцаар сондгой орших тахилгатай том уул. Өндөр нь д.т.д 2978 м. Энэ уулын урд хажуу нь модгүй бөгөөд ар хажууд нь ой мод тэхий дундаас нь доош ургажээ. Нохой усны даваанаас энэ уул тийм өндөр биш харагдах боловч энэ уулын ойн дээд хил нь даваатай бараг зэрэгцэн оршиж байгааг харахад энэ даваа, энэ уул аль аль нь өндөр болох нь мэдэгдэнэ.

**8. Сүрийг бадруулагч хотын турь.** Ханхөгшин / Хөгшин тээл/ уулын зүүн урд хормойд Тээлийн голын баруун эрэгт XIII зууны үед Хубилай хааны санаачлагаар байгуулагдсан цэргийн цайз төв том хот байжээ. Энэ хотыг байгуулсан тухай дурсгалын бичигт хөшөө Улсын төв музейд бий. Үүнийг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /б. 193/

9. Хайрхандулаан сумын төвөөс зүүн урагш орших эртний олон хөшөө булшийг **Говийн гурван эрэлчин** гэж нэлэдэг юм.

10. Хайрхандулаан сумын төвөөс баруун урагш **Мандухай** хатны дурсгалт газар бий. Хайрхандулаан сумаас Нарийнтээл сумаар орж болно. Нарийнтээл сум бол манай алдарт бөх дархан аварга Д.Цэрэнтогтохын төрсөн нутаг юм.

11. Хайрхандулаанаас гарч **Өшгөхийн** нуруугаар явахдаа эртний амьтдын үлдэгдэл олддог Заг Хашаат, Андайн сайраар орж болох юм.

**12. Шаргын тасархай.** Нарийнтээл нутаг их хадат үзэсгэлэнт уул. Халуун +20ос рашаантай. Рашаан нь Нарийнтээл сумын төвөөс урагш 20 км-т орших бөгөөд

үе мөч, мэдрэл, арьсны өвчнийг орж эмчилдэг рашаан. Энэ хавьд Хүрэнбухт, Цагаан нуруу, Дүгнэн Гурван өндөр зэрэг монголын их боржингийн бүсэнд багтах хадархаг уулууд бий. Их боржингийн бүс нь Сүхбаатар аймгийн Төрөнгийн чулуунаас эхэлдгийг 34-р замд дурьдана.

**13. Таацын Цагаан нуур.** Багабогд уулын ард их элсний захад орших говийн нуур. 10 ам. км талбайтай. Сүүлийн үед талбай нь ихсэж байгаа нуур. Энэ нуурын орчмоор үзэсгэлэнт Нугын элсээр явж болно. Рамсарын конвенцийн жагсаалтад орсон. ОУ-ын байгаль хамгаалал гарчигт үз.

**14. Багабогд уул.** Говь-Алтайн Гурванбогдын нэг. Говийн том уул, д.т.д 3590 м өндөр, энэ ууланд аргаль, янгир зэрэг ховор амьтан, ургамал бий.

**15. Хүрэнхадны рашаан.** Багабогд уулын зүүн хойд сугад оршино. Гидрокарбонат-сульфат кальци, магнит рашаан. /20. 383/

**16. Арцбогд уул.** Говь-Алтайн нурууны хэсэг том уул. Энэ уулын ард Богд сумаас зүүн урагш 40 км-т Мухарбулаг гэдэг газарт шинэ чулуун зэвсгийн үеийн дархны газар байсан ул мөр бий. Энэ дархны газрын талбай нь 8x12 км ажээ. (6.9)

**17. Тэвш** уулнаас эртний хүмүүсийн гоёлын алтан эдлэл олдсон. Арцбогд уулаас хойш орших энэ ууланд хадны сүг зураг, буга, хүн морины зураг бий. 8 морь хөллөсөн тэрэгний зургийг Түрэгийн үеийн дурсгал гэдэг. /6. 51/

**18. Арцбогд** хавьд Алтан элс гэж үзэсгэлэнтэй газар бий. Арцбогдоос зүүн хойш Өөш уулын баруун урд хэсэгт Өөш шахлага гэж эртний амьтны үлдэгдэлтэй, үзэсгэлэнт хясаа бий.

**19. Нуруудын хөндий.** Энэ нь Хангайн өвөр, Говь-Алтайн араар зүүн урагшаа нэвт орших том хөндий. Энд говийн таван нуур гэж нэрлэгдэх Бөөнцагаан, Орог,

Адгийн Цагаан, Таацын Цагаан, Хаяа нуур оршдог. Богд сумаас Гучин-Ус су орох замд тохиолдох энэ хөндий бол Монголын жинхэнэ говь нутгийн төрхийг харуулна.

**Өөр замд шилжих.**

**1. Төв,** Булган, Архангайн замд шилжихийг 13 дугаар чиглэлээс үз.

**2. Баянхонгорын замд.**

- Баруунбаян-Улаанаас Богд сум 55 км,
- Нарийнтээлээс Өлзийт сум 48 км,
- Богд сумаас Баянлиг сум 127 км

**3. Өмнөговийн замд.**


- Богд сумаас Булган сум 160 км
- Богд сумаас Хонгорын гол урагшаа 140 орчим км.

**4. Дундговийн замд.**

- Гучин-Ус сумаас Төгрөг 49 км,
- Сайхан-Овоо сум 75 км.

**Архангай аймаг**

**Архангай аймаг.** 55.3 мян. ам. км нутагтай, 98.3 мян хүн амтай. Аймгийн төв Цэцэрлэг хот нь улсын тусгай хамгаалалттай Булган уулын өвөрт д.т.д. 1691 м өндөрт Улаанбаатараас 463 км зайтай оршино. Аймгийн нутаг нь



Хангайн нурууны ар хажуугийн уулсыг эзлэнэ.

Хангайн нурууны Унтаа Ямаат, Ангархай, Суваргахайрхан зэрэг /3000 гаруй м өндөр/ том уул нуруудтай. Цэцэрлэг хотын агаарын жилийн температур нь  $-0.1^{\circ}\text{C}$ , I сарынх нь  $-15.6^{\circ}\text{C}$ , VII сарынх  $+14.7^{\circ}\text{C}$  байдаг. Цэцэрлэг нь манай аймгийн төвүүдийн дотор хамгийн их тунадас унадаг хот бөгөөд жилд 350.5 мм тунадас унана. Агаарын даралт I ба VII сард 827 орчим гПа байдаг, салхины жилийн дундаж хурд 2.5 м/с бөгөөд хамгийн их салхитай IV сарынх 3.5 м/с байдаг. Тэрхийн цагаан зэрэг олон нуур, Тамир, Чулуут, Суман, Хануй зэрэг олон гол



мөрөнтэй. Аймгийн нутагт ой хөвч ихтэй бөгөөд ховор ургамал амьтан элбэгтэй.

Архангай аймаг 1.7 сая малтай, малын дотор хонь, үхэр олон. Зүүн сумдад газар тариалан хөгжүүлдэг. Хамгийн олон буюу 216 мян адуутай, 277 мян үхэртэй аймгийн нэг.

Булган уул. II бүлгийн 53-д үз.

Улаанбаатараас Цэцэрлэг хотод очих гурван зам байж болно.

**1. Хархориноор** /370 км/ -Хотонт 37 км-Түвшрүүлэх 52 км-Цэнхэр сум 15 км Цэцэрлэг хот 29 км.

Бүгд 500 км. Энэ замаар Цэцэрлэг-Хархорин 133 км гээд буцаж болно.

Замд тохиолдох зүйлийн тайлбарыг 13-р чиглэлээс үз.

**2. Улаанбаатараас** 13-р чиглэлийн Г замаар гарч Дашинчилэн 226 км-Өгийнуур 106 км,

Тохиолдох зүйлийн тайлбарыг мөн 13-р чиглэлээс үз.

3. 13-р чиглэлийн В замаар гарч Улаанбаатар-Элсэнтасархай 300 км гээд 2 зам байж болно. Элсэнтасархайгаас:

**А. -Хашаат сум** 50 км-Хөшөөцайдам 40 км-Хархорин 40 км-Цэцэрлэг хот 133 км

Бүгд 560 км

**Б. -Хашаат сум** 50 км-Хөшөөцайдам 40 км-Өгийнуур 50 км-Цэцэрлэг хот 121 км

Бүгд 561 км. Энэ 2 замд тохиолдох зүйлийн тайлбарыг 13-р чиглэлээс үз.





## 18 дугаар чиглэл

### Архангай аймаг дотор аялах

**Зорих гол үзмэр.** Монголын хангай нутаг, Хангайн их нуруу, ой хөвч, гол горхи, унтарсан галт уулт үзэсгэлэнт Хорго нутаг, түүхийн дурсгалт зүйлс, ховор амьтан ургамал.

**Аялах зам.** Цэцэрлэг хотод онгоцоор очиж /1 цаг/ болно. Машинаар очих замыг дурдая.

Улаанбаатараас 13 дугаар чиглэлийн замаар гарч Лүн сум хүрнэ. Лүнгээс баруун тийш Дашинчилэн 100 км /Харбухын балгасыг дайрч 13 дугаар чиглэлээс үз/ -Өгий нуур 106 км-Орхон гол 10 км-Өгийнуур сум 11 км-Батцэнгэл сум 61 км-Цэнхэр сум 50 км-Цэцэрлэг хот 29 км.

Замын урт 500 км, хугацаа 2-3 өдөр.

**Мянганы зам** Архангайн нутгаар Өгий нуур-Орхоны доод нуур -Батцэнгэл сум-Хануйн гүүр , Тариат-Цахир сум, Загастай зүүн эхний даваагаар дамжин өнгөрнө.

### Цэцэрлэг хотоос машинаар баруун хойшоо аялах зам

**А. Ихтамир сум** 27 км-Хужиртын даваа 16 км-Хануй гол 25 км Донгойн даваа 26 км-Тээлийн гол 24 км-Чулуут голын гүүр 24 км

/Цэцэрлэг хотоос 142 км/

**Б. Чулуут сумаар** орё гэвэл Ихтамир сум-Хануй гол 55 км Хүрмийн гол 25 км, Чулуут сум 20 км-Чулуут голыг уруудаж Чулуут голын гүүр 70 км, /Цэцэрлэг хотоос 210 км/

**Чулуут голын гүүрээс** цааш /баруун хойш/ явах зам. Гучин хоёр салаа мод 5 км-Гичгэнэ голыг гарч Тариат сум 35 км-баруун хойшоо Суман голыг гаталж Хорго уул 10 км-Тэрхийн Цагаан нуур/Өвгөн хад/ 10 км-эргээд Тариат сум 20 км-зүүн тийшээ Суман голыг уруудан Чойдогийн боргио 55 км-Буцаад Чулуут голын гүүр 40 км. /Чулуут

голын гүүрнээс яваад эргээд эндээ ирэхэд 175 км/. Тэрхийн цагаан нуураас Ихтамир сумаар дамжаад шууд Цэцэрлэг хот хүртэлх буцах замын урт 200 км, хугацаа 3-4 хоног.

В. Буцахдаа **Ихтамир сумаас** Тамир голыг уруудаж Батцэнгэл сум 86 км-Улаанбаатар 393 км гэсэн замаар явж болно. Ингэвэл Улаанбаатараас явсан бүх замын урт 1350 км болно.

Г. **Ихтамир сумаас** Цэцэрлэг хотоор дамжин ирсэн замаараа /480 км/ Улаанбаатар орж болно.

Д. **Цэцэрлэг** хотоос Булган сум 30 км-Цэцэрлэг хот 30 км, Бүгд 60 км, хугацаа 1 өдөр гэсэн зам байж болно.

#### Үзэх гол зүйлийн товч тайлбар:

1. **Өгий нуур.** Архангай аймгийн Өгийнуур сумын нутагт д.т.д. 1337 м өндөрт орших 25 ам км талбайтай нуур. Энд алгана, цурхай, зэрэг Орхоны савд байдаг загас элбэг. Жилд 50 тонн загас агнах нөөцтэй. Хошуу галуу, халбаган хошуут, борцгор хотон зэрэг ховор шувууд байдаг учраас Зүүн хойд Азийн галуу, нугасны овгийн шувуудыг хамгаалах олон улсын сүлжээнд 1999 онд бүртгэгджээ. Нутгийн тахилгатай нуур. Рамсарын конвенцийн жагсаалтад орсон. ОУ-ын байгаль хамгаалал гарчигийг үз. Өгий нуураас урагш 20 орчим км-т орших **Улаанхудагт** Хутагтын өргөө 1640-1654 онд сууршиж байв. Энэ тухай дээр дурьдсан.

2. **Чилин хийдийн туурь.** 14-р чиглэлээс үз!

3. **Батцэнгэл** сумын төвөөс урагш Тамирын голын урдуур орших Тоглохын талд дөрвөлжин булш, тамга бүхий хөшөө, зэл чудуу бүхий цогцолбор бий. Үүнийг Жужааны үеийн дурсгал гэж үздэг. Батцэнгэл сумын Цацын дэнж гэдэг газар орших 6 ширхэг буган хөшөө, булш, хиргисүүрүүд, мөн сумын нутаг Худгийн толгой гэдэг газар орших хүннүгийн үеийн булшнууд гэсэн 2 дурсгалыг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. Батцэнгэл суманд алдарт бөх Вандан аварга төрсөн юм. Сумын төвд

түүний хөшөө бий. Батцэнгэл сумын өнөөгийн төв нь 1846 онд байгуулагдсан Сайн ноён хан аймгийн Түшээ гүн Лувсанхайдавын /Лу гүний/ хүрээний суурь дээр оршино. Энд хийдийн уран барилгын дурсгал хадгалагдан үлдсэн. Үүнийг аймгийн хамгаалалтад авчээ.

**4. Цэнхэр сумын** нутагт хуучин чулуун зэвсгийн дээд буюу 40-12000 жилийн өмнөх үеийн дурсгалын зүйл бий.

Түвшрүүлэх сумын нутагт сумын төвөөс урагш 16 км-т Цэцэрлэг голын савд одоогийн Хөх сүмийн голын савд **Эрдэнэтолгой** гэдэг газарт **Их хүрээ**, /Улаанбаатар/ 1700-гаад оноос даруй 17 жил суурьшиж Их хүрээ нэрийг авсан бөгөөд энд Батцагаан гэдэг Цогчин дуган баригджээ.

Энэ сумын нутагт Цэнхэрийн халуун ус гэдэг рашаан бий. Энд “Цэнхэр жигүүр” гэдэг жуулчны баз бий.

**5. Хөх сүмийн рашаан:** Түвшрүүлэх сумын төвөөс урагш 18 км-т д.т.д 2000 м өндөрт уулын ойд орших хүйтэн гидрокарбонат-сульфат-натрит найрлагатай олон булаг рашаан, зуны байшинтай.

Хотонт сумын нутагт Цагаан сүмийн халуун рашаанд жуулчны баз бий.

**6. Булган уул** II бүлгийн 53-ыг үз.

**Цэцэрлэг хот** нь 1616 онд байгуулагдсан Зая бандид хутагтын хүрээний суурин дээр байгуулагдсан бөгөөд энэ хийдийн цогцолборыг 1998 онд улсын хамгаалалтад авчээ.

**7. Цагаан давааны арын** Арцатын аманд буган чулуун хөшөөнүүдэд амьтдын зураг бий. II бүлгийн 49. Булган уулыг үз.

**8. Тайхар чулуу.** Тамирын голын хөвөөнд орших герцины бүдүүн ширхэгт боржингоос тогтсон 10 гаруй метр өндөр цохио. /6. 224/

Энд эртний хадны зосон бичээс бий. 1998 онд улсын хамгаалалтад авчээ. Тайхар чулууны дэргэд жуулчны бааз ажилладаг.

---



**9. Ихтамир** сумын нутаг Алтансандал уулын шилд орших дөрвөлжин булшинд адууны зурагтай буган хөшөө бий. Хүрэл зэвсгийн үед холбогдоно. Мөн Батцэнгэл сумын нутаг Шивэртийн аманд хүрэл, төмрийн үе хамаарагдах дөрвөлжин булш байдаг. /б. 91/

Мөн Шивэртэд уул, ус ой модтой үзэсгэлэнтэй газарт гидрокарбонат, сульфат натрийн найрлагатай халуун рашаан бий. /20. 341/

**10. Тамир гол.** Хангайн нуруунаас эх авч урсаад Орхоны зүүн гарт нийлдэг гол. Хойд, Урд, Дунд Тамир гээд Гурван Тамирын гол гэдэг. 280 км урт.

Тамир голд Их хүрээ 1722-23 онд суурьшиж байсан. Хангайн нурууг II бүлгийн 18-д үз.

**11. Хануй гол.** Хангайн нуруунаас эх авч зүүн хойшоо 421 км урсаад Сэлэнгэ мөрөнд нийлдэг юм.

**12. Чулуут гол.** түүний хавцал. Чулуут гол нь Хангайн нурууны Эгийн даваанаас эх авч хойшоо 415 км урсаад Идэр, Дэлгэр мөрөнтэй нийлж Сэлэнгэ мөрөн болдог. Чулуут гол Тээлийн голын адгаас Ацатын гол хүртэл 100 км-т эгц гүнзгий /20-иод м/ хүрмэн чулуун хавцал дундуур урсах нь нэн сонин.

Энэ хүрмэн чулуун нь Хорго ба түүний хавийн галт уулаас бялхан гарсан магма юм.

Чулуут голд Сэлэнгийн савд байдаг загас элбэг Чулуут голын савд Чулуут гидрокарбонат, сульфат натрийн найрлагатай сайн рашаан бий.

**13. Чулуут, Тариат, Жаргалант, Цэцэрлэг сумдын** нутгаар орших Чулуут голын хадны сүг зургийг 1998 онд улсын хамгаалалтад авчээ.

**14. Хоргоос** урагш холгүй /20-иод км/ орших Шаварын царам уулнаас геологчид анар зэрэг эрдэнийн чулуу олжээ. Шаварын Царам хүрэхэд зам хэцүү. Хорго бол Тариат сумын нутаг. Тариат сум бол манай алдарт бөх аварга "буур" Жамьянгийн төрсөн нутаг. Энд "Хорго" гэдэг жуулчны бааз ажилладаг.

**3. Эрдэнэмандал сумын** Баруунцүүр гэдэг газар / сумын төвийн баруун талд ойрхон/ орших буган хөшөөг 1998 онд улсын хамгаалалтад авчээ.

**4. Хайрхан сумын** нутагт Уйгарын Трояны хааны /IX зуун/ гэрэлт хөшөө бий. Хайрхан сум бол манай аварга бөх Ц.Чимид-Очирын төрсөн нутаг.

**5. Хайрхан сумын** төвөөс баруун урагш холгүй Гол мод гэдэг газарт хүннүгийн язгууртны булш олон чулуун хөшөө бий. Энэ дурсгалыг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /б. 143/

#### Өөр замд шилжих

##### 1. Булганы замд

- Хайрхан сумаас Сайхан сум 64 км


##### 2. Хөвсгөлийн замд

- Жаргалант сумаас Галт сум 100 км /зам хэцүү/

- Цэцэрлэг сумаас Рашаант сум 47 км

#### Дундговь аймаг

**Дундговь аймаг.** 74.7 мян. ам км нутагтай, 51.3 мян. хүн амтай. Аймгийн төв Мандалговь хот их талд д.т.д. 1393 м өндөрт Улаанбаатараас 260 км зайтай оршино. Аймгийн нутаг нь манай орны төв хэсгийн их талархаг.



Дундаж өндөр нь 1500 орчим бөгөөд хамгийн өндөр уул нь 1926 м өндөр Дэлгэрхангай уул юм. Аймгийн нутагт чулуун нүүрс, уран зэргийн нөөц бий. Мандалговь хотын агаарын жилийн дундаж температур нь 1.0°C, 1 сарынх -18°C, VII сарынх 19°C, жилд 159.7 мм тунадас унадаг. Агаарын даралт нь мөн саруудад 850 орчим гПа байна. Салхины жилийн дундаж хурд нь 4.4 м/с, хамгийн их салхитай V сард 5.8 м/с Мандалговь нь манай орны хамгийн их салхитай газрын нэг юм. Аймгийн нутгийн баруун захаар Онгийн гол урсах бөгөөд жижиг нуурууд, рашаан олон бий. Аймгийн нутаг нь тал хээрийн бүсэнд

орших учраас хээрийн ургамал, амьтад оршино. Өмнөд хэсгээрээ говь нутагтай.

Дундговь аймаг 1.5 сая гаруй малтай, малын дотор хонь, ямаа олон.

### **Мандалговьд очих зам.**

1. Улаанбаатар-Дэлгэрцогт 216 км-Мандалговь 44 км, Бүгд 260 км гэж очиж болно.

**2. Улаанбаатар**-Баян-Өнжүүлээр дамжин Адаацаг 211 км-Мандалговь 104 км,

Бүгд 315 км гэсэн зам байж болно.

Энэ замд тохиолдох зүйлийн тайлбарыг 20, 21 дүгээр чиглэлээс үз.

**3. Улаанбаатар**-Зуунмод 43 км-Баянцагаан сум 113 км-Дэрэн сум 80 км –Мандалговь 66 км,

Бүгд 310 км гэсэн зам байж болно.

### **20 дугаар чиглэл**

#### **Улаанбаатар-Бүрд сум-Сүм Хөхбүрд-Улаанбаатар**

**Зорих гол үзмэр.** Хангай, тал хээрийн байгаль, Дуутын хадны бичиг, талын баянбүрд. Зорголхайрхан уул.

**Аялах зам.** Улаанбаатараас 16 дугаар чиглэлийн замаар явж Тарнын гол 290 км /Баянговийн жуулчны бааз/-Монгол элс Ширээтцагаан нуур 50 км-урагшаа Өвөрхангай аймгийн Бүрд сум 30 км-Нутгийн хүйс-Өвөрхөшөөт 14 км-урагшаа Олон нуурын голыг гарч Батхаан баг 35 км-Төв аймгийн Дэлгэрхаан сум 35 км-урагшаа Дуутын хад 20 км-Дундговь аймгийн Эрдэнэдалай сум 60 км-зүүн хойшоо Сүм Хөхбүрд 70 км-хойшоо Адаацаг сум 22 км-Төв аймгийн нутаг Даацын хөндийгөөр дамжин Зорголхайрхан уул 70 км-Ихгангын даваа 80 км-Улаанбаатар 74 км

Замын нийт урт 920 км, хугацаа 6-7 хоног.

Энэ замд Эрдэнэдалай суманд “Дундговь” гэдэг жуулчны бааз, Сүм Хөхбүрдэд амралтын газар ажилладаг.


### **Үзэх гол зүйлийн товч тайлбар.**

16 дугаар чиглэлийн замд Элсэнтасархай хүртэл тохиолдох зүйлийг үзнэ. Энэ замаас цааш үзэх зүйл:

1. Бүрд сумын төвөөс хойш 30 гаруй км-т Монгол элсэнд Их Монгол уулын зүүн урд хөндийд 1639 онд Өндөргэгээн Занабазарыг Монголын шарын шашны тэргүүний гэж ширээнд залж, өнөөгийн Улаанбаатарын суурийг Хутагтын Шар бүст өргөө нэртэйгээр тавьсан Ширээтцагаан нуур оршдог. 16 дугаар чиглэлд үз.

2. Монгол улсын **нутгийн хүйс** /Төв цэг Өвөрхөшөөтийн булаг/ бүлгийн МОГ-д үз.

**3. Дуутын бичигт хад.** Төв аймгийн Дэлгэрхаан сумын төвөөс урагш 20-иод км зайтай оршино. Дуутын хад гэж нэрлэгддэг “Цогт тайжийн хадны бичиг” нь Монголын эх оронч, яруу найрагч Цогт тайжийн /1581-1639/ 1626 онд сийлүүлсэн шүлэгтэй хад юм. Шүлэг сийлсэн хад нь газрын гүний маш бөх чулуу бөгөөд юмаар цохиход ширмэн тогоо мэт жингэнэн дуугардаг тул дуутын хад гэсэн аж. 380 шахам жилийн өмнө бичсэн тэр бичиг өчигдөр бичсэн юм шиг тод хадгалагдаж байгаа нь уг хадны бөх батаас болж байна. Хадан дээрх шүлэг нь





**Дундговь аймгийн сум хоорондын зай (км)**

																				Улаанбаатар															
																				Мандалговь Сайнцагаан	260														
																				Эрдэнэдалай	114	275													
																				Сайхан-Овоо	117	220	392												
																				Дэрэн	286	180	66	210											
																				Говь-Угтаал	75	321	215	101	240										
																				Баянжаргалан	57	132	357	262	148	286									
																				Гурвансайхан	85	90	90	294	185	74	300								
																				Өндөршил	111	70	127	201	402	296	182	356							
																				Дэлгэрцогт	226	118	192	110	35	264	158	44	216						
																				Луус	94	232	129	198	151	115	169	95	55	310					
																				Хулд	36	127	225	120	231	184	149	145	110	83	343				
																				Дэлгэрхангай	63	87	182	328	183	286	231	204	82	100	138	357			
																				Өлзийт	143	80	116	142	165	104	189	194	164	225	190	100	358		
																				Адаацаг	204	192	200	187	60	286	175	252	205	95	207	92	104	211	
																				Цагаандэлгэр	177	236	278	231	198	117	158	132	88	42	82	368	262	148	198





**Өөр аймгийн замд шилжих.**

**1. Өвөрхангай аймгийн замд шилжих замыг 16 дугаар чиглэлүүдээс үзээрэй.**

**2. Дундговь ймгийн замд**

- шилжих замыг 17-р чиглэлээс үз.

**21 дүгээр чиглэл**

**Дундговь аймаг дотор**

**Зорих гол үзмэр.** Манай хээр тал, говь нутаг Их, Багагазрын чулууны уул.

**Аялах зам.** Мандалговьд онгоцоор очиж болно. /1 цаг/ машинаар Улаанбаатараас баруун урагш 20 дугаар чиглэлээс ирсэн замаар гарч Сүм Хөхбүрд 246 км-зүүн тийшээ Багагазрын Чулуу 20 км, Дэлгэрийн Чойр 10 км-Мандалговь 45 км урагшаа Өлзийт сум 98 км-баруун урагшаа Дэл уул 70 км /Дэл уулаас урагш 30 орчим км-т Хөнжилийн уул оршино. Энд Далайн гурван хийдийн туурь бий/ баруун хойшоо Цагаансуварга 50 км-баруун хойшоо Дэлгэрхангай сум 110 км-баруун тийшээ Онгийн хийд 70 км-Сайхан-Овоо сум 18 км-Эрдэнэдалай сум 117 км-Цагаан-Овоогийн уурхай 37 км-Хэрэ Үнстийн хийд 7 км-Мандалговь 70 км.

Бүгд 1000 км, хугацаа 6-7 хоног

**Үзэх гол зүйлийн товч тайлбар**

**1. Зорголхайрхан уул, Сүм Хөхбүрд** 20-р чиглэлээс үз.

**2. Багагазрын чулуу.** Монголын боржингийн их бүсэнд орших д.т.д 1751 м өндөр уул, хөндийдөө булаг ус олонтой талын үзэсгэлэнтэй сайхан уул Халхын 3 оргилын нэг байх. Энд хүүхдийн амралтын газар бий. Энд Сөртийн ам гэдэг улиас шугуйтай бачуу хавцал бий.

**3. Дэлгэрийн Чойр.** Багагазрын Чулуу уулын зүүн урд хэсэгт Ихдэлгэр уулын зүүн урд хажууд орших хийд. Их эрдэмтэн Зава Дамдины номын ордон байсан. Одоо хийд ажилладаг.

---

**4. Тэвшийн нүүрсний уурхай.** Мандалговь хотоос баруун хойш 30 км-т, Дэлгэрийн Чойроос баруун урагш орших хүрэн нүүрсний уурхай, Ил аргаар ашиглах энэ уурхайн нүүрсний давхарааны зузаан нь төв хэсэгтээ 200 м хүрдэг нь манайд хамгийн зузаан давхраастай орд болох аж. Нөөц ихтэй уурхай.

**5. Мандалговь аймгийн музей** үзнэ.

**6. Өөш манхан.** Өлзийт сумын Буянт багийн төвийн араар х. ө. 45 дугаар зэргэдийн дагуу үүссэн зөрөгт ангалын урагшаа хандсан эгц ирмэг, эндээ элсэн манхтай сонин газар. Эндээс зүүн урагшаа 50 км-т **Загийн усны хоолой** гэж Улсын тусгай хамгаалалттай газар бий. II бүлгийн 40

45 дугаар зэргэд гэдэг нь дэлхийн экватор, хойд туйл хоёрын газрын дундах шугам/зэргэд/ билээ.

7. Өөш манханаас баруун урагш Талын жасын туурь орчимд **Сайр-Усны** өртөөний буурь бий. Энэ өртөө нь XVII-XX зууны эх хүртэл Манжийн дарангуйлалын үед Хүрээнээс /одоогийн Улаанбаатар/ Бээжин орох өртөө замын гол зангилаа болж байжээ. Бээжингээс Улиастай орох өртөө эндээс сална. Бээжин-Хаалган-Сайр Ус 20 өртөө-Улиастай Сайр Ус 29 өртөө, Сайр Ус -Хүрээ 14 өртөө байжээ.

8. Өлзийт сумын нутаг **Баруунбилүүт** ууланд сүг зураг, шаантиг бичиг бүхий хад бий, үүнийг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. Үүнийг төмөр, хүрлийн үеийнх гэж үздэг. (6.38) Өлзийт сумын нутагт Хэвтээ босоогийн агуй бий. 100 гаруй м урт. Ард дурдах Дэл уулын баруун Билүүт уул юм.

**9. Дэл уул.** Өлзийт сумын нутгийн урд хэсэгт орших занараас тогтсон, баруун хойшоо зүүн урагшаа сунан үргэлжилсэн намхан нуруу. Өөр хоорондоо арваад метр зайтайгаар дэллэн, зэллэн 25 орчим км үргэлжлэн тогтсон олон дэлтэй учраас Дэл уул гэж нэрлэгджээ. Дэл хаднуудад нь морь, хүн, янгир, зэв тамга, тэмдэг зурсан эртний сүг зураг маш элбэгтэй. /6. 38/

зам, бас Гурвансайхан-Баянжаргалан 85 км гэсэн зам байж болно/ -Ихгазрын чулуу уул 45 км-Хараат уул 40 км-Говь-Угтаал сум 25 км-Цагаандэлгэр сум 42 км-Дэрэн сум 82 км-Дэлгэрцогт сум 40 км-Мандалговь 44 км

Бүгд 390 км, хугацаа 3-4 хоног. Баянжаргалан суманд“Хүрэн дух” гэдэг жуулчны бааз ажилладаг.

### **Үзэх гол зүйлийн товч тайлбар:**

**1. Ярх уул.** Гурвансайхан сумын төвөөс зүүн урагш 50 орчим км-т оршдог жижиг толгой. Энд одоогоос 300 мян. жилийн өмнө хүн амьдарч байсан ор мөр олджээ. Доод чулуун зэвсгийн үеийн чулуун зэвсэг бэлтгэдэг дархны томоохон газар байжээ. Түүхийн ном зохиолд Ярхын соёл гэж нэрлэгдсэн, энэ газрыг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /б. 23/ Гурвансайхан сумын нутагт Тооонотын агуй бий. Урт нь 27 м.

**2. Ихгазрын Чулуу уул.** Монголын их боржингийн бүсэнд багтах нүцгэн боржин чулуун уул Халхын гурван оргилын нэг байх. Энэ уулыг 2003 онд УТХ-д авах санал бий. Оргил нь Ерлөг уул д.т.д 1706 м өндөр. Энд буудаллах байр бий.

II бүлгийн 32-ыг үз.

**3. Хараат уул.** Талд оршдог уул. Нутгийн олон сумын ардууд билгийн тооллын намрын дунд сарын 15–ны шөнө энэ уулан дээр цугларч тэр шөнийн байдлыг ажиглаж ойр орчны нутагт ирэх өвөл ямар болохыг шинждэг газар юм. Ардуудын урьдчилан хэлсэн таамаглал нь бараг үнэн болдог гэж ярьдаг. Хараат уулаас урагш Арагийн Чулуу гэдэг үзэсгэлэнт уул бий.

**4. Цагаандэлгэр, Дэрэн, Дэлгэрцогт** сумдын нутгаар Монголын Их Талын төрх байдал, боржигин овогтны ажил амьдралтай танилцаж, айраг ууж болно. Манай нэртэй дуучдыг төрүүлсэн нутаг.

**5. Өндөршил** сумын нутагт Шарханангийн агуй бий. 170 гаруй м урт.

---

**Өөр замд шилжих****1. Дорноговийн замд.**

- Баянжаргалангаас Даланжаргалан сум 80 км, Чойр 80 км


2. Аль ч сумаас Төв аймгийн замд орж болно

**3. Өмнөговийн замд**

- Гурвансайхан сумаас Өлзийтээр дайран орж болно.

**Өмнөговь аймаг**

**Өмнөговь аймаг.** 165, 4 мян ам км буюу манай орны хамгийн их нутагтай аймаг юм. 47.3 мян хүн амтай. Аймгийн төв Даланзадгад хот нь Зүүнсайхан уулын зүүн бэлд д.т.д. 1406 м өндөрт Улаанбаатараас 553 км зайтай оршино. Өмнөговь




аймаг нь манай орны нутгийн өмнө захад говь цөлийн бүсэнд оршдог аймаг. Говь-Гурвансайхан /2800/ гэж сүрлэг уулс бий. Антрацит нүүрсний болон зэс, алтны их нөөцтэй. Даланзадгад хотын агаарын жилийн дундаж температур нь 3.9°C, 1 сарынх-15,4°C, VII сарынх 21.2°C буюу манай орны хамгийн дулаан нутгийн нэг. Жилд 129.5 мм тунадас унана. Агаарын даралт нь I ба VII сард 850 орчим гПа байна. Салхины жилийн дундаж хурд нь 4 м/с, хамгийн их салхитай V сард 5. 6 м/с. Аймгийн нутагт гантай жил ширгэдэг үлэмж том Улаан нуур орших ба түүнд Онгийн гол ирж цутгана. Рашаан ус нэлээд бий. Аймгийн нутаг нь говь цөлийн бүсэнд орших учраас говь, цөлийн ургамал амьтад тархсан.

Өмнөговь аймаг 900 мян гаруй малтай. Малын дотор ямаа, хонь олонтой бөгөөд тэмээний тоогоор /82.3 мян/ улсад тэргүүн байр эзэлнэ. Усалгаатай газар тариалан хөгжүүлбэл дулааны хүрэлцээ хангалттай.

**Даланзадгадад очих зам**

**1. Улаанбаатар-Мандалговь** 260 км-Хулд 83 км-Цогт-Овоо 110 км-Даланзадгад 126 км,

### Өмнөговь аймгийн нутгийн зураг



Масштаб: 1 см-т 50 км





Бүгд 580 км

2. Улаанбаатар-Адаацаг 211 км-Эрдэнэдалай 92 км-Сайхан-Овоо 117 км-Мандал-Овоо 97 км-Даланзадгад 140 км,

Бүгд 660 км

Даланзадгад хотын ойролцоо “Жуулчин говь”, “Төвшин”, “Хавцгайт”, “Багахонгор”, “Жуулчин Ханбогд”, “Намуун говь 2”, “Гүег хаан” зэрэг жуулчны баазууд бий.

### **23 дугаар чиглэл**

#### **Улаанбаатар-Өмнөговь-Улаанбаатар**

**Зорих гол үзмэр.** Монгол орны их говийн уулс, тал, элсэн манх, Улсын тусгай хамгаалалттай Гурвансайхан уул, Ёлын ам эртний амьтны үлдэгдэлт Баянзаг, говийн ховор амьтан ургамал.

**Аялах зам.** 1. Даланзадгад/1 цаг 25 мин/ онгоцоор очоод цаашаа машинаар явна.

**Даланзадгад**-баруун хойшоо Жуулчны бааз 40 км-урагшаа Зүүнсайхан уул/Ёлын ам/ 40 км-баруун тийшээ Баяндалай сум 60 км-Ноён сум 132 км Гурвантэс сум 97 км-Сэврээ сум 125 км-Хонгорын гол/Хонгор элс/ 45 км-Төгрөгийн ширээ 100 км-Булган сум 32 км-Баянзаг 20 км-Жуулчны бааз 70 км-Даланзадгад 40 км.

Замын урт 900 км, хугацаа 6-7 хоног.

#### **Үзэх зүйлийн гол товч тайлбар:**

##### **1. Даланзадгад хот**

**2. Говь Гурвансайхан** уул II бүлгийн 15-ыг үз.

**3. Ёлын ам.** II бүлгийн 15-ыг үз

**4. Ноён уул.** Толь хад. Говь-Алтайн нурууны салбар унтарсан галт уул. д.т.д 2403 м өндөр. Энэ уулын ард Ноён сумын төвөөс баруун хойш 8 км-зайтай, баруун тийш явах замын урд ойрхон алдарт Толь хад бий. Толь

хад нь эрт цагийн уул тогтох хөдөлгөөнөөр царцдсын чулуу зөрж, гулгахдаа хүчтэй хавиран үрцэлдэснээс гөлгөр гадартай алсаас гялалзах толь мэт өнгөтэй болж зүүн хойшоо хандан тогтсон том цохио юм. 3 орчим метр өндөр тасархайтсан байдлаар 40 м урт.

**5. Гурвантэсийн хоолой.** Ноён Сэврээ хоёр уулын хооронд өргөрөгийн дагуу үргэлжлэх элстэй, тэсги, загтай урт уудам хоолой, Тэсгийн хоолой гэх нь зөв боловч сунжраад Тэсийн хоолой болжээ. Энэ хоолойн баруун хэсэгт Ноён сумаас баруун хойш 74 км зайтай хоолны давсны асар их нөөцтэй тойрмууд бий. Үүнийг Гурвантэсийн давсны уурхай гэж нэрлэдэг. Сүүлийн үед нуур тойрмууд нь элсэнд дарагдаж давс ашиглахад төвөгтэй болж байна. Гурвантэсийн хоолойн зүүн хэсгийг Жарангийн элс гэх бөгөөд энд бие биенээсээ алс сондгой орших том манхнууд байгаа нь сонин.

**6. Гурвантэсийн** хоолойн хойд биед орших Нэмэгт, Гилбэнт, Алтан уулаас эртний үлэг гүрвэлийн өндөг, яс олддог. Нэмэгтэд сайн рашаан бий. Говийн үлэг гүрвэлийн яс өндөгийг Монгол, Орос, Польийн мэргэжилтнүүд их судалжээ. Оросын эрдэмтэн И.А.Ефремов монголоос үлэг гүрвэлийн олбор 100 тонн-ыг аваачсан гэдэг. Москвагийн палеонтологийн музейн үзмэрийн ихэнх нь “монгол” гэсэн хаягтай байдаг.

**7. Хонгор элс.** Сэврээ, Зөөлөн уулын араар 180 орчим км үргэлжилсэн, 3-15 км өргөн, өвс ургамалгүй гөлөөн манхт сул элс юм. Сэврээ уулын зүүн суга дээрээс энэ элсийг харахад үтрэм дээр улаан буудай нуруулдчихаад байгаа мэт хөндлөн зурайсан урт нуруу улайран хонгортон харагдах нь нэн сонин. Манханы өндөр нь 100-300 м хүрнэ. Том манхан дээр гарах гэж дотор талаас нь өгсөхөд элстэйгээ буцаж нураад гутлаар нэг элс утгаад тун хэцүү, манхан дээр арай гэж гараад харахад хэдийгээр төдий л салхигүй боловч бүх манхны орой яльгүй манарч харагдах нь манхны нүүлт явагдаж буй хэрэг юм. Хонгор элс нь манай орны нутгийн 2.7 хувийг эзэлдэг элсний нэгээхэн хэсэг юм.

Энэ элсний хойд захаар Хонгорын гол гэдэг баянбүрд үүссэн нь нэн сонирхолтой. Хонгор элсний зүүн урд орших том уул Зөөлөнгийн нурууны араас буусан үерийн ус Хонгор элсний дундуур хойшоо зам гарган нэвт урсаж хөрсөнд шингэнэ. Энэ шингэсэн ус элсний хойд захад Сэрүүн булаг, Аргангын булаг нэртэйгээр газар дээр гарч баруун тийшээ элснийхээ хаяагаар 10 гаруй км урсаж Хонгорын гол болно. Энэ голын орчмоор бургас, шугуй, зүлэг цэцэг ногоо ургасан хангай газар гэлтэй үзэсгэлэнтэй сайхан. Энд "Дуут манхан" гэдэг жуулчны бааз ажилладаг.

**8. Төгрөгийн Ширээ** тайлбарыг 26-р чиглэлээс үз.

**9. Баянзаг.** Булган сумын төвөөс зүүн тийш ойрхон оршино. Энд хүн олон үе дамжин суурьшиж байсныг гэрчлэх түүхийн ховор нандин олбор болох шинэ чулуун зэвсгийн үеийн дурсгалын зүйл их олддоогоороо дэлхийд алдартай. /6.10/ Мөн эндэхийн Ширээ, Шавар зэрэг газраас цэрдийн галавын /70-80 сая жилийн өмнөх/ үеийн аварга гүрвэлийн чулуужсан яс, өндөг бүтнээрээ олон олдсон. Ийм олбор Бүгийн Цав /26-р чиглэлийн 12-ыг үз/ зэрэг газарт бий. Баянзагвас 1922 онд Дэлхийд анх удаа үлэг гүрвэлийн 10-15 см өндөг олсон юм. Монгол орон бол үлэг гүрвэлийн талаар их гүрэнд орно.

Энэ нь үлэг гүрвэл өндөг төрүүлдэг юм гэдгийг анх баталсан болов. АНУ-ын жуулчин Рой Эндрюс Монголын говиор хэдэн удаа аялаж олбороо 70 тэмээнд ачин буцсан байна. Рой Эндрюс Монголын говиор аялахдаа манай говийн толгодыг "асаж байгаа толгод" гэж нэрлэсэн нь хожим газарзүйн ухааны ном зохиолд нэр томъёо болон орсон гэдэг. Булган суманд "Намуун говь I", "Говийн гурван тэмээ" жуулчны баз бий. Баянзагаас урагшаа жуулчны баазад хүрнэ.

#### **Өөр замд шилжих**

1. Булган сумаас хойшоо Мандал-Овоо сум 75 км, цаашаа Онгийн хийд 85 км-Сайхан-Овоо сум 18 км гээд Дундговийн 26-р чиглэлд нийлнэ, бас зүүн хойшоо Эрдэнэдалай сум /120

км/ гээд Дундговийн замд нийлж болно.

2. Сайхан-Овоо сум 18 км-баруун хойшоо Онгийн голыг өгсөж Баянгол сум 80 км гээд Өвөрхангай аймгийн замд нийлж болно.

## **24 дүгээр чиглэл**

### **Даланзадгадад машинаар очих,**

### **Өмнөговийн зүүн хэсгээр аялах зам**

**Улаанбаатар**-урагшаа Дундговийн замаар гарч Айцын даваа 20 км-Түргэн, Бөхөгийн голыг гарч Зосын даваа 47 км-Дундговийн Дэлгэрцогт сум 150 км-Мандалговь хот 44 км-урагшаа 110 орчим км яваад х. ө 45 дугаар зэргэдийг огтлон гарч-Өмнөговийн Цогт-Овоо сум/Дугшихийн балгасыг үзнэ/-урагшаа Цогтцэций сум 70 км-зүүн тийшээ Манлай сум 133 км-урагшаа Ханбогд сум 118 км-баруун тийшээ Баян-Овоо сум 100 км-Даланзадгад 162 км

Замын урт 960 км, хугацаа 6-7 хоног

### **Үзэх гол зүйлийн товч тайлбар:**

**1. Улаанбаатараас** Түргэний голд Хэрэйд Ванханы үеийн балгасыг үзнэ. Төв аймгийн нутагт түүхийн хөшөө дурсгал, зурагтай, бичигтэй хад олон бий бөгөөд үүнээс бид зарим тааралдахыг нь зохих замд нь ярьж байна.

**2. Цогтцэций нүүрс.** Цогтцэций сумын төвөөс баруун урагш ойрхон оршдог антрацит нүүрсэнд хамаарах сайн чанартай, их нөөцтэй /7-10 тэрбум тонн гэсэн тооцоо бий/ орд юм. Одоо орон нутгийн хэмжээнд бага зэрэг ашигладаг.

**3. Галбын говь.** Ханбогд сумын нутагт орших их говь нутаг. Энэ говийн хойд захад Ханбогд сумын төвөөс баруун тийш ойрхон Галбын уул гэж боржин чулуун уул бий. Энэ ууланд ноён хутагт Данзанравжаагийн жүжгээ тоглуулж байсан Дэмчигийн, Эрээт, Цогзолын гэж Галбын гурван хийдийн турь бий. Энэ хийдүүд нь монголчуудын барьсан чулуун хийдийн нэг бололтой. Энэ хийдүүдийн туурийг 1998 онд улсын хамгаалалтад

авчээ. Энэ хийдийн тууриас урагш холгүй боржин чулууг хавтгайлан засдаг үйлдвэрийн газар байсны ор мөр одоо тод бий. Галбын уулын шүлтлэг эрдэст боржин чулуунаас Зөвлөлт, Монголын эрдэмтэд кальци, циркони, силикатын найрлагатай шинэ эрдэс олж түүнээ Америкийн сарнаа буугчийг хүндэтгэн "Армострангит" гэж нэрлэжээ.

Ханбогдоос Говийн бага дархан газарт очиж болно. (II-р бүлгийн 11)

**4. Ханбогд сумаас** баруун урагш 54 км Баян-Овоо сум орох замд жаахан урдуур мурийсхийж одоогоос 100 мянгаас урагш жилийн /хуучин чулуун зэвсгийн / үед хүн суурьшин амьдарч байсныг гэрчлэх дурсгалын зүйл их олддог Оцон Мааньтаар орж болно. /б. 16/ Ханбогд сумын нутагт 60 гаруй м урт Гурванзээрдийн агуй, 50-аад м урт Ловон Чомбын агуй бий. Ханбогд сумын нутагт Оюутаас зэс алтны баялаг орд олдож байна.

#### **5. Баян-Овоо-Даланзадгад.**

6. Энэ замаас Говийн бага дархан цаазат газарт/II бүлгийн 11/, бас Загийн усанд очиж болно. /II бүлгийн 40-ийг үз/

7. Эндээс **Гашуунсухайтын** түр боомтоор хятад улс руу гарч болно.

#### **Өөр замд шилжих:**

##### **1. Дорноговийн замд**

- Манлайгаас Мандах сум 122 км
- Ханбогдоос Хатанбулаг сум 160 км

##### **25 дугаар чиглэл**

##### **Өмнөговийн урд чиглэл**

**Аялах зам.** Даланзадгад-Ёлын ам 40 км-Баяндалай сум-60 км Хүрмэн сум 57 км-Номгон сум 109 км-Баян-Овоо сум 90 км-Даланзадгад 162 км,

Бүгд 500 км, хугацаа 2 хоног.

##### **Үзэх гол зүйлийн товч тайлбар:**

*Handwritten signature or initials.*

**1. Ёлын ам** II бүлгийн 15-ыг үз

**2. Номгон сумын** Шүүлэн, Долоон уулын өвөр бичигтэд сүг зурагтай хад бий. Үүнийг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /б. 37/

**3. Хятадын** өнөөгийн Миньшуй хотоос гарсан Говь-Алтай, Баянхонгор аймгийн нутгаар дамжиж Өмнөговийн нутгаар Тост Ноён уулын урдуур явж Ноён сум хүрсэн хуучин зам бий, бас Баяндалай сумаас урагшаа явж хил гарсан, мөн сумаас зүүн урагшаа гарч хил гарсан, мөн Ханбогд сум, Дорноговийн Сулинхээрээр дамжиж хил гарсан хуучин замууд бий. Эдгээр нь эртний замын, магадгүй Торгон замын салаа байсан байж болох юм.

4. Энэ замын урд захаар Чингисийн даланг үзэж болно.

**Өөр замд шилжих**

-Өмнөговийн баруун замд-Баяндалайгаас нийлнэ

-Өмнөговийн зүүн замд Баян-Овоогоос нийлнэ

**26 дугаар чиглэл**

**"Сувдан сондор-5" аяны зам**

**"Сувдан сондор-5"** аялал 1998 оны 10-р сард Төв, Дундговь, Өмнөговь аймгийн нутгаар явсан юм.

**Аялсан зам.** Улаанбаатар-Зуунмод 43 км-Ээж хад 60 км-Гашуун балтастай 30 км-Үйзэнгийн говь 30 км-Дундговь аймгийн Говь-Угтаал сум 100 км-Хараат уул 25 км-Ихгазрын Чулуу 40 км-Гурвансайхан сум 45 км-Өлзийт сум 104 км-Дэл уул 70 км-Цагаансуварга 50 км-Өмнөговь аймгийн Цогт-Овоо сум 45 км-Сэрвэн уул 50 км-Даланзадгад 130 км-Жуулчин бааз 40 км-Ёлын ам 40 км-Баяндалай сум 60 км-Ноён сум 132 км-Толь хад, Ноён уулаар дамжин Гурвантэс сум 97 км-Хэрмэнцав 120 км-Зулганай 50 шахам км-Наран даац 40 км-Давсны үйлдвэр 100 км-Сэврээ сум 72 км-Хонгорын гол 45 км-Төгрөгийн Ширээ 100 км-Булган сум 32 км-Баянзаг 20 км-Мандал-Овоо сум 75 км-Онгийн голын 3 хийд 85 км-



Эрдэнэдалай сум 130 км-Цагаан-Овоо/Үнстийн хийд/ 44 км-Мандалговь-84 км-Дэлгэрийн чойр 45 км-Багагазрын Чулуугаар дайрч Адаацаг сум 45 км-Зорголхайрханаар /Моринцохиогоор/ дайрч Ихгангын даваагаар давж Улаанбаатар 211 км

Бүгд 2600 км, 14 хоног аялна.

Энэ замд Гурвантэс сумын нутаг дахь Шивээхүрэнгийн хилийн боомт байнгын ажиллагаатай болжээ.

### **Үзэх гол зүйлийн товч тайлбар:**

**1. Ээж хад** 9 дүгээр чиглэлд үз

**2. Гашуунбалтастай.** Төв аймгийн Баянцагаан сумын нутаг Гашуунбалтастайн уудам хөндийн хойд дээр орших Түрэгийн үеийн дурсгал бичигтэй 2 боржин чулуун хөшөө. 1998 онд улсын хамгаалалтад авчээ. Энэ тухай 9-р чиглэлд дурьдсан.

**3. Үйзэнгийн говь.** х. ө 46 градус 50-ын орчимд орших энэ говь Улаанбаатар Мандалговийн энэ замд хамгийн хойно тохиолдох анхны говь.

**4. Хараат уул.** 22 дугаар чиглэлээс үз

**5. Ихгазрын Чулуу уул.** Мөн чиглэлээс үз.

**6. Дэл уул.** 21 дүгээр чиглэлээс үз

**7. Цагаан суварга.** 21-р чиглэлээс үз

**8. Сэрвэн уул** /Тээрэм толгой/

Сэрвэн уулын зүүн дор, Хуц уулаас зүүн урагш урагшаа хандсан сайрын зүүн эрэг дээр Тээрэм толгой оршино. Энэ жижиг толгой дээр хааш хаашаа 80 орчим метр дөрвөлжин орд байшингийн суурь маягтай байрлуулсан дөрвөлжлөн зассан 14 цайвар улаан боржин чулуу байна. 90x90 см-ын урт өргөнтэй. 30 см зузаан энэ боржин чулуу ямар ч гэсэн нэг ордны суурь болж байсан бололтой. Үүнийг Тогоонтөмөр хааны зуны ордны суурь гэж үздэг аж. Энэ толгойн ар дор 1 км орчим зайтай газарт 100x100

м урт өргөнтэй, усан хүрээлэлтэй байсан болуу гэмээр хэрэмний туурь байна.

**9. Ёлын ам.** II бүлгийн 15-ыг үз.

**10. Толь хад.** 23 дугаар чиглэлээс үз

**11. Ноён уул орчим.** Энэ орчимд говийн Ноёнбогд мөлгөр хөрзөн чулуу, занарын үеэс тогтсон Ханан Хэц зэрэг хадархаг, эгц хажуутай том уулуудын дундуур аялна.

**12. Хэрмэнцав.** Өмнөговь аймгийн нутгийн баруун захад Гурвантэс сумыг төвөөс баруун хойш оршино. Хэрмэнцав нь Тосонбумбын нурууны баруун хойд салбар болох Шариг, Шаригийн Сондог уулын баруун хойд бэлийн үзүүр болж д.т.д 1000 орчим метр өндөрт орших баруун хойшоо Ингэнэхөөвөрийн говь руу хандсан 10 гаруй км үргэлжилсэн том ганга. Ганга адагтаа 10-аад км өргөн, гүн нь 100-200 м хүрнэ. Дунд ба шинэ төрмөлийн эриний нуурын зузаан хурдас усны үйл ажиллагаанд угаагдан эвдэрсэн тал талаасаа орж ирсэн олон сархиа бүхий 250 ам км талбайтай энэ гангыг үүсгэжээ.

Эндээс Дэлхийд алдартай эртний амьтдын шинэ олбор олдох боломжтой гэж үздэг бөгөөд одоогоор сайн судлагдаагүй байна. Хэрмэнцаваас хойш 50 орчим км зайтай Бүгийн Цав оршино. Эндээс Дундад төрмөлийн эриний үлэг гүрвэлийн бүтэн араг яс олдсон нь одоо манай байгалийн түүхийн музейд бий.

**13. Зулганай.** Хэрмэнцаваас зүүн хойш тойруу замаар 40 гаруй км зайтай орших горхи баянбүрд. Дунд нь их элстэй учраас нэлээд зүүгээр тойрч очно. Алтан уулын баруун захын Нарийн уул болон зүүн талын өндөрлөгөөс буусан ус газарт шингээд дахин газар дээр гарч ирж Зулганай гол болон баруун тийшээ 20-иод км урт урсаж элсэнд шингэнэ.

Зулганайн гол нь зэгс, бургас зүлэг цэцэг ногоо хангай газар шиг шигүү ургасан үнэхээр сонин сайхан газар.

Энд зэгс гэхэд л тэмээ харагдахгүй 3 метр шахам өндөр ургана.

**14. Нарандаац.** Зулганайгаас зүүн тийш 40 орчим км-т орших Баянбүрд булаг. Эртний амьтдын үлдэгдэл олддог. Нэмэгт, Алтан уул, Хэрмэнцав зэрэг газруудад ойр учраас энд эрдэм шинжилгээний ангийнханы буудал байрладаг.

**15. Гурвантэсийн** давсны үйлдвэр 23 дугаар чиглэлээс үз.

16. Сэврээ сумын төвөөс зүүн урагш холгүй **Наранбулагийн цагаан чулуу** бий. 80 см босоо, 50 см өргөн энэ шохойн чулуу эртний бичиг, зурагтай энэ бичгийн шаантиг бичиг бололтой гэж эрдэмтэн Д.Наваан үзэж байна.

**17. Хонгорын гол.** 23 дугаар чиглэлээс үз.

**18. Төгрөгийн ширээ.** Булган сумын төвөөс баруун тийш орших урагшаа эрэглэсэн мөргөцөг, . Эргийн өндөр нь 30-аад метр энд мөргөцөгийн хананд эртний үлэг гүрвэлийн яс цухуйж байдаг. Мөн үлэг гүрвэлийн чулуужсан өндөг олддог. Энэ өндөгний дотор зулзаганы араг яс хадгалагдаж үлдсэнээрээ ховор олбор км.

**19. Булган сум.** Говийн бүсийн эрдэм шинжилгээний хүрээлэн ажилладаг. Энд зундаа дулаан байдаг учраас сумын төв ба Хад багийн нутагт халуун дулаан шаарддаг улаан лооль зэрэг таримлыг их тарьдаг.

Булган сумын төвөөс урагш ойрхон Хадатын рашаан оршино. Хлорид, гидрокарбинат магни кальцийн найрлагатай энэ рашаан магни их байгааг нарийвчлан судлаж үзүүштэй гэж О.Намнандорж гуай бичсэн. /20. 134/

**Баянзагийн** тухай 23-р чиглэлээс үз.

**20. Булган сумын** Цахиуртын хөндийд чулуун зэвсгийн үеийн дархны газар бий . Үүнийг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /6. 22/

**21. Онгийн хийд.** Эрдэнэдалай сум, Үнстийн хийд, Дэлгэрийн чойр, Багагазрын Чулууны тухай 21 дүгээр чиглэлийн замаас үз.

**22. Зорголхайрхан уулын** тухай 20 дугаар чиглэлийн замаас үз

**23. Ихгангын даваа.** Улаанбаатараас баруун урагш 74 км зайтай, Хэнтийн нурууны Улаанбаатарын урдуур баруун тийш дугуйрсан хэсэгт 1651 м өндөрт орших том даваа.

**Өөр замд шилжих.**

**1. Дорноговийн замд**

- Ээж хад-Баянцагаан гээд Чойр 110 км
- Дундговийн Говь-Угтаалаас Чойр 85 км
- Мөн Баянжаргалангаас Чойр 110 км
- Дундговийн Өлзийт-Буянт 75 км -Мандах сум 165 км

**2. Өмнөговийн замд**

- Дундговийн Өлзийтөөс-Манлай сум 120 км

**3. Өвөрхангайн замд**


- Өмнөговийн Хонгорын голоос Богд сум 140 км
- Мөн Булган сумаас Богд сум 160 км
- Дундговийн Сайхан-Овоо сумаас Төгрөг сум 70 км
- Мөн Сайхан-Овоо сумаас Баянгол сум 60 км
- Дундговийн Эрдэнэдалайгаас Сант сум 94 км

**4. Баянхонгорын замд**

- Хэрмэнцаваас Эхийн гол бүдэг замаар 80 км
- Зулганайгаас Бүгийн Цаваар дамжин Шинэжинст сум 130 км
- Хонгорын голоос Баянлиг сум 135 км

## Хэнтий аймаг

**Хэнтий аймаг.** 80.3 мян ам км нутагтай, 71мян



хүн амтай. Аймагийн төв Өндөрхаан хот нь Хэрлэн голын хөвөөнд д.т.д. 1027 м өндөрт Улаанбаатараас 331 км зайтай оршино. Хэнтий аймаг нь улсын нутгийн зүүн хэсэг

Хэнтийн уулс, түүний захын намхан уулс, тал нутгийг эзлэн оршино. Хамгийн өндөр уул нь Хэнтийхан 2362 м өндөр. Хэнтий аймаг нь монголын түүхийн дурсгалт газар түүний дотор эзэн Чингисийн түүхтэй холбоотой газар нутаг ихтэй аймаг. Хайлуур жонш, нүүрс, цагаан тугалганы баялагтай. Өндөрхаан хотын агаарын жилийн дундаж температур нь  $-0.8^{\circ}\text{C}$ , I сарынх  $-23.2^{\circ}\text{C}$ , VII сарынх  $18.8^{\circ}\text{C}$  дулаан, жилд 255.7 мм тунадас унана. Агаарын даралт нь I ба VII сард 890 гаруй гПа, салхины жилийн дундаж хурд 3.6 м/с, хамгийн их салхитай V сард дунджаар 4.8 м/с.

Хэнтий аймгийн нутагт Онон, Хэрлэн зэрэг том гол мөрд нуур, рашаан ус элбэг бөгөөд уул, тал хосолсон нутаг учраас ой, тал хээрийн амьтан, ургамал ихтэй.

Хэнтий аймаг 1.3 сая малтай, малын дотор хонь, ямаа олон, газар тариаланг хойд хэсгийн нутгаар хөгжүүлдэг.

### Өндөрхаанд очих зам.

**1. Улаанбаатар-Эрдэнэ сум** 80 км-Багануур 61 км-Жаргалтхаан 100 км-Өндөрхаан 90 км.

Бүгд 331 км, Энэ бол Мянганы зам юм.

Өндөрхаанаас-Сүхбаатар аймгийн нутагт Наран сарангийн уул хүрнэ.

**2. Улаанбаатар-Эрдэнэ сум** 80 км-Баянжаргалан 80 км-Хэрлэнгийн Хөмүүлтэйн гүүр 60 км-Дэлгэрхаан / Аварга-Тосон/ 35 км-Өндөрхаан 124 км.

Бүгд 380 км.

**3. Улаанбаатар-Багануур** 141 км-Хэрлэн буудал 20 км-Хэрлэнгийн зүүн гараар уруудаж Дэлгэрхаан/Аварга Тосон/ 100 км-Өндөрхаан 124 км, бүгд 365 км

### **27 дугаар чиглэл**

#### **Улаанбаатар-Хөдөө арал-Улаанбаатар**

**Зорих гол үзмэр.** Монгол орны хээр тал нутаг, гол мөрөн, нуур, рашаан, ховор амьтан ургамал, эзэн Чингисийн түүхийн дурсгалт газар.

**Аялах зам.** Улаанбаатар-зүүн урагшаа Налайх 35 км-Түрэгийн сайд Тоньюкукийн хөшөө 15 км-Өвөржанчивлан 25 км-Багахангай 30 км-Бөөрөлжүүтийн рашаан 23 км-Баянжаргалан сум 30 км-Хэрлэн гол Хөмүүлтэйн гүүр 60 км-Хөдөө арал 20 км-хойшоо Аварга Тосонгийн рашаан/Тосон нуур/ Дэлгэрхаан сум 2 км-Цэнхэрийн голыг өгсөж Цэнхэрмандал сум 70 км-хойшоо Хар зүрхний Хөх нуур 30 км-баруун тийшээ Багануур 85 км-зүүн хойшоо Бүрги эрэг 20 км-/Эндээс Мөнгөнморьт сум хүрч болно/. буцаад Баяндэлгэр сум 54 км-Баяндаваа 40 км-Элстэй гол 25 км-Налайх 10 км-Улаанбаатар 35 км.

Замын урт 620 км, хугацаа 3-4 хоног


#### **Үзэх гол зүйлийн товч тайлбар:**

##### **1. Налайх 2-р чиглэлийн замаас үз.**

**2. Тоньюкукийн хөшөө.** VI-VIII зууны үеийн Орхоны Түрэг улсын сайд, мэргэн Тоньюкукийн бунхан түрэг бичигт хөшөө. Энэ хөшөөний бичгээс дурьдвал "Би мэргэн Тоньюкук, Нангиадын эрх дор хүмүүжигдсэн ману. ... Би Түрэг улсын хагантай болох цагийг үзээсээ хэмээн санах бөлгөө. Түрэг улс Нангиадаас хагацаж хагантай болов. . . удалгүй эргэж Нангиадад дагаар орж Түрэг хүмүүн үхэж бууран мөхвэй" гэж бичжээ. Энэ хөшөөг 744 онд босгожээ. Энэ хөшөөг 1961 оноос улсын хамгаалалтад авчээ. /6. 226/ Хамгаалалтын талбайг 2002 онд 65.58 ам км болгов.



### Хэнтий аймгийн нутгийн зураг



Масштаб: 1 см-т 37.3 км



**3. Цогт-Чандмань уул.** /I бүлгийн МОГ-д үз/

**4. Жанчивлингийн рашаан сувилал.** Хэнтийн нурууны салбарын герцины атираатлаар тогтсон боржиндуу чулуулагт ууланд 1600 м өндөрт орших 60 орчим метр гүнээс гарах гидрокарбонат-натри-кальци, магни, нүүрсхүчлийн хийтэй эсэглэн рашаан. Ходоод, нарийн, бүдүүн гэдэс, элэг цөсний архаг үрэвсэлийг анагаах чанартай, сайн рашаан. /20. 243/

**5. Бөөрөлжүүтийн рашаан.** Төв аймгийн Баянжаргалан сумын нутагт Галуутын хөндийд д.т.д. 1340 м өндөрт орших гидрокарбонат хүхэрлэг, шавартай нуур, Хулуу шар ус, дүмбэ, үе мөч, хамуу зэрэг өвчнийг анагаахаар зуны сард хүмүүс их очно. /20. 269/

**6. Баян-Эрхэт уул.** Баянжаргалан сумын нутагт орших энэ уул байгалийн "битум" хэмээх өтгөн хар тостой юм. Түүний нөөцийг 1 сая тонн гэж тооцоолсон бөгөөд замын хатуу хучлага хийхэд хэрэглэж байна. Энэ уул нь цэргийн тахилгат сүлдэт гурван уулын нэг юм. Нөгөө хоёрыг Төв аймгийн 2, Сүхбаатар аймгийн 33-р чиглэлийн замаас үз.

**7. Баянжаргалан** сумын нутаг Гуа дов гэдэг газар орших эртний хотын турийг 1998 онд хамгаалалтад авчээ. 7-р чиглэлд үз.

**8. Хэрлэн гол.** Манай улсын том гол, алдарт гурван голын нэг, Хэнтийн уулаас эх авч 1264 км урсаад Хятадын нутагт орших Далай нуурт цутгана. Хэнтийн уулнаас гараад их талын өргөн хөндийгөөр урсдаг гол. Хэрлэнд цулбуурт, хадран, тул зэвэг, улаан живэрт, булуу цагаан, мөнгөлөг хэлтэг амарын сугас, цурхай, морин загас толбот морин загас, гутаар зэрэг загас элбэг, Галуу, нугас зэрэг усны шувуудтай.

**9. Хэрлэнтооно уул.** Хэрлэн голын зүүн гарт Хэрлэнбаян Улаан уулаас урагш орших 1578 м өндөр хадан уул. Энэ ууланд Манжийн Энх-Амгалан хаан Галданбошигттой байлдахаар явахдаа бичиж үлдээсэн бичигт хад бий, мөн энэ ууланд хүн чулуу булш хиргисүүр олон бийг аймгийн хамгаалалтад авчээ.

**10. Хөдөө арал.** Хэрлэнбаян Улаан уулаас урагш Хэрлэнтооно уулаас баруун тийш, Хэрлэнгийн тохойд орших 30 км урт 20-иод км өргөн тал газар д.т.д. 1300 гаруй м өндөртэй. Билчээрийн өвс ихтэй тал. Энэ талд Аварга голын хойд дээр эзэн Чингис хааны Их Аураг орд байсан юм. Энд МНТ-г бичиж дуусгасан учраас түүний 750 жилийн ойд зориулсан хүндэтгэлийн хөшөөг 1990 онд босгосон юм. Энд МНТ-д гардаг Долоон болдог, Шилхинцэг гэдэг газрууд бий. Аураг ордны энэ балгасыг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /6. 175/, /1. 24/, /1. 40, 42/ Хөдөө аралд Чингисийн онгон байгуулсан.

**11. Дэлгэрхаан** сумын нутаг Иххайлант, Шархад, Ханангийн энгэрт байгаа олон төрлийн булшнууд, чулуун зэвсгийн үеийн бууцыг 1998 онд улсын хамгаалатад авчээ.

**12. Аваргын гол,** Аваргын рашаан. Аваргын гол нь Хэрлэнбаян-Улаан уулаас эх авч урагшаа урсаад Хэрлэнд цутгах жижиг гол. Энэ голын хөндийд Хэрлэнтооно уулын баруун хойд хормойгоос гарах гидрокарбонат, нүүрсхүчлийн хийтэй, төмрийн найрлагатай эсэглэн рашаан. Эзэн Чингисийн Их Аураг оршиж байснаас энэ голыг Аураг /Аваргын/ гэж нэрлэсэн бололтой. Аураг ордны буурийг 1230 га газраар хамгаалалтанд авчээ.

**13. Тосон нуур.** Аваргын рашаанаас хойш 11 км-т д.т.д. 1300 м өндөрт их талд орших карбонат-натри, хлор, хүхрийн найрлага бүхий нуур. Нуурын эргээр шар хар өнгөтэй нарийн ширхэгт шавар бүхий өрхүүдтэй. Захын мэдрэлийн өвчин, арьс өнгөний өвчин анагаахад нууранд орж шавар тавьж эмчилдэг. Аварга Тосонд рашаан сувилал ажилладаг. Энд ойролцоо "Хөдөө арал" гэдэг жуулчны бааз бий.

**14. Хэрлэнбаян-Улаан уул.** Хэнтийхан уулаас урагш салбарласан Хэрлэн голын зүүн гараар урагшаа үргэлжилсэн том уул. Хамгийн өндөр цэг нь Дэлгэрхан уул д.т.д 2042 м өндөр. Энэ уулын Хэрлэн рүү хандсан баруун хажууд МНТ-д Тэлэт ам, Аргал хохь гэж гардаг

газрууд байдаг гэдэг. Ямарч жил ган, зуд болдоггүй өгөөмөр баян энэ ууланд мянган өвөлжөө бий гэдэг. Энд Хэнтий, Төв, Дорноговь, Дундговь аймгийн олон зуун айл өнтэй сайхан өвөлждөг.

**15. Цэнхэрийн гол.** Хэрлэнбаян-Улаан уулын зүүн хойд залгаанд орших Царамын Цагаан Гозгор уулын араас эх авч урагшаа 160 орчим км урсаад Хэрлэнд нийлдэг. МНТ-д Сэнгүр горхи гэж гардаг. Одоо Цэнхэр болжээ. Мөн сумын төвөөс хойш холгүй Бургастайн аманд эртний бичээстэй цохио бий. (Хар зүрхний Хөх нуур 30-р чиглэлээс үз)

**16. Багануурын уурхай.** Төв аймгийн Баяндэлгэр сумын нутагт орших нүүрсний ил уурхай. Дунд төрмөлийн эриний юрын настай нүүрстэй. Эндээс жилдээ 5 сая орчим тонн нүүрс олборлож Улаанбаатарт хүргэдэг. Их зохиолч Д.Нацагдоржийн төрсөн нутаг Гүн Галуутай нуур энд оршдог.

**17. Бүрги эрэг.** Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутагт Хэрлэн голд Баруунбайдлаг голын нийлэх адгаас доош ойрхон орших нурсан эгц эрэг. Дөрөвдөгч ба гуравдагч галавын хурдсыг Хэрлэн голын ус идэж элээснээс үүссэн энэ эргийг МНТ-д Бүрги эрэг гэж дурьдсан эргийг мөн гэж үздэг. Бүрги эрэг нь Байдлаг, Бүрх голын адаг хавьд байгаа учраас Бүрх гэдгийг Бүрги гэдэг ч байсан байж болох юм. /1. 14. 18/

Мөнгөнморьт суманд буриад ястан амьдардаг.

**18. Баруун ба Дундбайдлаг** голуудын хөндийд нүүрс хүчлийн хийтэй эсэглэн амттай, гүнээс гардаг гурван рашаан бий. Эдгээр рашааныг ходоод гэдэс доторын өвчин анагаахад уудаг. Эдгээр гурван рашаан хоорондоо ойрхон. /20. 249/

**19. Байдлагийн рашаан.** Бүрги эрэг хоёрын дунд, эртний Кидан улсын балгасны туурь бий. Мөн Байдлагт хүннүгийн үеийн түүхийн дурсгал бий.

---

### **Өөр чиглэлийн замд шилжих**

#### **1. Хэнтийн замд.**

- Дэлгэрхаан сумаас Өндөрхаан хот 124 км

#### **2. Дорноговийн замд**

- Дэлгэрхаан сумаас Чойр 145 км

#### **3. Дундговийн замд.**

- Чойроос Дундговийн Цагаандэлгэр сум 62 км

### **28 дугаар чиглэл**

#### **Хэнтий аймгийн дотор**

Улаанбаатараас Өндөрхаанд онгоцоор /1 цаг/ очиж болно. Мөн Хөдөө арлаар дамжин машинаар очиж болно.

**Аялах зам.** Өндөрхаан-Баруун хойшоо Өмнөдэлгэр сум 112 км /Хөдөө арлаас/ Дэлгэрхаанаас / Өмнөдэлгэр сум 110 км/ -зүүн хойшоо Гурванбаян 52 км-Хурх, Жаргалант, Барх, Эг голуудыг гарч Батширээт сум 94 км зүүн тийшээ Биндэр сум 76 км-Ононг уруудаж Хурх, Баян голуудыг гарч Баян-Адарга сум 47 км-Шуус, Онон голуудыг огтолж Дадал сум 129 км-зүүн урагшаа Норовлин сум /Улз гол/ 52 км-Баян-Овоо сум 111 км /Гүрмийн нуур/ баруун тийшээ Батноров сум 54 км-Бэрхийн уурхай 36 км -Өндөрхаан 69 км

Замын урт 820 км, хугацаа 4-5 хоног

Өмнөдэлгэр суманд Хангал нуурын амралтаас урагш "Баянгол" жуулчны бааз ажилладаг.

#### **Үзэх гол зүйлийн товч тайлбар:**

**1. Өндөрхаан хотод** Цэцэн хааны ордон музейг үзнэ. Өндөрхаан хотод "Гэлэн" хэмээх хүн чулуу бий. Үүнийг 1998 онд улсын хамгаалалтад авчээ.

**2. Хэнтий аймгийн** нутгийн хойд хэсэг нь МНТ-д гардаг олон үйл явдал өрнөж байсан түүхтэй нутаг юм. Зарим газрыг МНТ-д гардаг нэрээр нь дурдвал Өндөрхаанаас баруун тийш болон хойно нь Цайтын цагаан тал түүнээс хойш Жалман тал, Чахрайхан нилээд



хойшоо Утхияа, Хүйтэн гол жаахан баруугаар өнөөгийн Хурхын голын /МНТ-д Химурга горхи/ хөндий хавьд Хирхоног Жибурийн хөндий, Айл харгана, арай хойгуур Хорчухайн болдог, Бэдэр хошуу зэрэг газрууд байна. /21/, /1, 18, 22, 28, 30, /

Өмнөдэлгэр сум бол манай алдарт бөх дархан аварга, хөдөлмөрийн баатар Б.Бат-Эрдэнэнийн төрсөн нутаг.

**3. Батширээт сумын Норовлин, Ёлын байц, Барх** зэрэг газруудад цахиур, манаар үйлдсэн хусуур, хутганы ялтас, суулга, ир зэрэг эртний чулуун зэвсгийн үеийн дурсгалын зүйл их олддог.

**4. Биндэр сум.** Биндэр сумын төвөөс зүүн урагш холгүй орших д.т.д 1231 м өндөр “Ламын ухаа” толгойг манай зарим эрдэмтэд Чингис хааны төрсөн газар Дэлүүн Болдог мөн гэж үздэг.

**5. Биндэр сумын** нутаг Борбулаг гэдэг газар Хүннүгийн үеийн булшнууд оршдог. Түүнийг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /6. 143/

**6. Баян-Адарга** сум Онон голын урд хөвөөнд нарсан төгөлийн захад оршино. Энэ сумын төвийн Дуурлиг нарс гэдэг газарт Хүннүгийн үеийн язгууртны булш бий, үүнийг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /6, 147/

**7. Онон гол.** Хэнтийханы араас эх авч 808 км урсаад Орос улсын нутагт Шилка голд цутгана. Манай улсын нутаг дээр 445 км урсана. Манай улсын хамгийн их устай, хурдан урсгалтай гол. Монголчуудын уугуул нутаг алдарт гурван голын нэг. Ононд хилим, тул, зэвэг, улаан живэрт, морин загас, амарын цурхай, цагаан хадран, амарын сугас, цулбуурт, мөнгөлөг хэлтэг, булуу цагаан, гутаар зэрэг загас бий. Хөндийд нь нэн ховор цэн тогоруу болон хошуу галуу зэрэг ховор шувууд тааралддаг. Онон голд Хурх, Эг Шуус, Балж зэрэг олон голууд цутгана. Онон мөрний сав нутаг нь Эзэн Чингисийн дурсгалт гол газар нутаг билээ. Ононы эх болох Хэнтийхан уул нь Хэрлэн, Туул гол буюу гурван голын эх болох бөгөөд

---

МНТ-д Бурханхалдун уул нэрээр гардаг. Тэнд Тогоцог өндөр гэдэг уул, Ботохонбоорж зэрэг бий. Онон, Хурхын билчээрээс доош МНТ-д Хорхонгийн хөндий, Онон голд Зээрэн хавцал гэж гардаг газрууд бий.

**8. Гурваннуурын рашаан.** Дадал сумын төв дээр д.т.д. 800 м өндөрт нарсан их ойд оршино. Нүүрсхүчлийн хий, хүхэр, натри, калий, магнийн найрлага бүхий зэрэгцээ гурван нуур юм. Энэ рашааныг зүрх судас ходоод гэдэсний үрэвсэл, цусны даралт ихсэх, арьсны зарим өвчнийг анагаахад ашигладаг. Амралт сувиллын газартай. /20. 193/

Энд Чингис хааны дурсгалд зориулан 1962 онд босгосон манай анхны хөшөө бий.

Энд “Онон”, “Жуулчны өргөө” гэдэг жуулчны бааз бий.

Дадал сумын нутагт 70 гаруй м урт, босоо байрлалтай сонин агуй бий.

Дадал сумаас хилийн түр боомт Агацаар ОХУ-руу гарч болно.

**9. Балж гол.** Ононы зүүн гарын цутгал том гол. Энэ голын савд МНТ-д нэр нь гардаг газар олон бий. Тухайлбал Балжийн арал, Даланбалжууд, Хутухул нуга зэрэг. /1. 32/

**10. Чингисийн далан** гэдэг түүхийн дурсгалт газрыг Норовлин сумын дэргэд үзнэ. МНТ-д”. . . тэнгэр газрын заяагаар төрсөн гөрөөсийг бусад ах дүү нарын нутагт очих болуузаа гэж харамлаж шавар хэрэм бариулж ах дүү нараас гомдох үгийг сонсов. Энэ бас нэг буруу бий” гэж өөрийн дөрвөн буруу хэргийн нэгийг гэж Өгэдэй хааны дурьдсан“Хуруа Нурха” гэдэг тэр шавар хэрэмыг өнөө бид Чингисийн далан гэж нэрлэж ирсэн гэж зарим хүн үздэг. Энэ далан Баян-Адарга сумын нутгаас эхлэн Дорнод аймгийн нутгаар 270-аад км үргэлжилж зүүн тийшээ хил гараад /6, 199/ явж цаашаа Хятад улсын нутгаар явна. Нийтдээ 500-600 км үргэлжилдэг.

**11. Бэрхийн уурхай.** Энэ уурхай бол манай улсын хайлуур жонш олборлодог олон уурхайн нэг юм. Манай орны хайлуур жоншны уурхай бараг цөмөөрөө Хэнтий, Дорноговь аймгийн нутагт ойролцоо оршдог юм.

**12. Батширээт, Биндэр, Баян-Адарга, Дадал** сумд нь манай орны буриад ард түмэн амьдардаг сумд юм. Энд энэ ард түмний аж амьдрал, ахуй, зан заншилтай танилцаж болно. 2000 оны хүн амын тооллогоор бүх буриад ястан 41000 хүн байжээ.

#### **Өөр замд шилжих**

##### **1. Дорнод аймагт**

- Норовлин сумаас Баян-Уул сум 69 км
- Өндөрхаанаас Чойбалсан хот 315 км
- Баян-Овоогоос Чойбалсан хот 192 км
- Норовлиноос Цагаан-Овоо сум 118 км

##### **2. Сүхбаатар аймагт**

- Баян-Овоо сумаас Түмэнцогт сум 25 км
- Өндөрхаанаас Мөнххаан сум 126 км

#### **29 дүгээр чиглэл**

##### **Хэнтий аймгийн урд хэсгээр**

Урд чиглэлд орших Баянхутаг, Галшар, Дархан, Баянмөнх сумдаар аялаж тал хээр нутагтай танилцаж болно.

**Аялах зам:** Өндөрхаан-Баянхутаг 22 км-Галшир сумын Хужирт баг 55 км –Галшир сум 53 км-Дорноговийн Иххэт сум 60 км-Хажуу-Улаан 45 км-Бор-Өндөр 45 км-Дархан сум 49 км-Баянмөнх сум 41 км -Өндөрхаан 96 км,

Бүгд 460 км, 2-3 хоног

##### **Үзэх гол зүйлийн товч тайлбар.**

**1. Баянхутаг сумын** Баянцогт овоогоос эртний чулуун зэвсгийн үеийн дурсгал олддог сумын төвөөс зүүн тийш орших Баянхутаг уулыг МНТ-д Сэрвэн хад гэж гардаг уул мөн байх гэж үздэг. Энэ сумын нутагт Баянхутаг уулын

зүүн хэсэгт Сэрвэнхаалга гэдэг газар орших бичигт хадыг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /1. 24/

Эндээс Хар Ямаат ууланд очиж болно. (II бүлгийн 39)

2. Баянхутаг сумаас урагш Хужирт баг орох замд Хужирт багийн баруун урд орших 1597 м өндөр Галшар уулыг харна. Галшар уул нь Монголын Их боржингийн бүсэд багтах боржин чулуун уул.

Баянхутагаас Галшар сум орох замд зээрийн сүрэгтэй тааралдаж болно. Энэ хавь нутаг нь Галшарын унага гэж алдаршсан хурдан хүлэгтэйгээрээ нэрд гарсан юм.

3. Хажуу-Улаанд хаэлуур жоншны уурхай ажилладаг.

**4. Бор-Өндөр.** Манай орны хайлуур жонш олборлодог том уурхайнуудын нэг. Манай орон жилдээ хайлуур жонш 580 мян. орчим тонныг олборлодоогоороо нь Дэлхийд эхний тавд ордог юм.

**5. Дархан сум.** Д.т.д 1715 м өндөр Дархан уулын зүүн дор оршино. Энд төрийн шагналт яруу найрагч Р.Чойномын музей бий. Дархан сумын хавийн талыг МНТ-ны "Шар тал" мөн гэдэг. /1. 28/

**6. Баянмөнх сум** Хэрлэн голын урд эрэг дээр оршино.

**7. Мөнх дов, Баянмөнх сумаас** зүүн тийш 20 орчим км-т орших толгой. Чингисийн үеийн сүмийн ором бий гэдэг.

**8. Сумаас** зүүн тийш 25 км орчимд Хэрээхөхөл толгой оршино.

Хэрээхөхөлийн жонш, Хэрлэн голын шудаг гэж эмийн чухал ургамал байдгийг ардын ярианд толгой холбон оруулжээ.

#### **Өөр замд шилжих**

##### **1. Сүхбаатар аймагт**

- Баянхутгаас Бүрэнцогт 96 км

- Баянхутгаас Мөнххаан 100 км
- Хужирт багаас Түвшинширээ 90 км
- Хужирт багаас Мөнххаан 115 км
- Галшараас Түвшинширээ 80 км
- Өндөрхаанаас Мөнххаан сум 126 км

## **2. Дорноговь аймагт**

- Галшар сумаас Дэлгэрэх 80 км, Иххэт 60 км
- Бор-Өндөрөөс Далантүрүүгийн рашаан 7 км
- Дархан сумаас Сүмбэр 96 км
- Дэлгэрхаанаас Сүмбэр 145 км

## **3. Төв аймгийн замд**

- Дархан, Баянмөнх сумдаас Баянжаргалан сум 90 орчим км

## **30 дугаар чиглэл**

### **"Сувдан сондор-3"-ын зам**

"Эзэн Чингисийн Өлгий нутгаар" гэсэн "Сувдан сондор-3" аян 1996 онд Хэнтий аймгийн нутгаар явсан км.

**Аялсан зам.** Улаанбаатар Эрдэнэ сум 80-км Багануур 61км Хэрлэн гол 20 км-Харзүхний Хөх нуур75 км Цэнхэрмандал сум 40 км, Өмнөдэлгэр сум 108 км, Хангал нуур 80 км-Бэрээвэн хийд 30 км-Биндэр-Овоо 80 км-Өглөгчийн хэрэм 12 км-Биндэр-Овоо 20 км-Хурх голыг уруудаж Биндэр сум 50 км-Онон голыг усаар гаталж Манхдайн Баруун, Зүүн, Дунд голуудыг гаталж Ханхарын даваагаар давж Амгалант, Балж, Хөмөл, Талын, Жаргалант голуудыг гаталж Сэрүүн Галттай-90 км-Цагаанчулуут уул 40 км-нутгийнхны Бурханхалдун гэдэг уулын өвөрөөр гарч Балж голыг гаталж Гурваннуур /Дадал сум/ 80 км-Бодончор өвгийн отгийн буурь 8 км-Гурваннуур 8 км-Онон голыг гарч Улз голыг гатлан Чингисийн далангаар дайрч Норовлин сум 52 км-Батноров 97 км-Идэрмэг/Тунсаг толгой/ 54 км-Өндөрхаан 51 км-Мөрөн, Цэнхэр, Аварга голуудыг гаталж Аварга-Тосон 128 км-Аварга гол (рашаан) 11 км-Аварга Тосон 11 км-Хэрлэн гол /Хөмүүлтэй гүүр/ 35 км-Баянжаргалан сум 55 км-Баян сум 60 км-Улаанбаатар 82 км. Бүгд 1570 км. 12 хоног.

Энэ аянд “Сувдан сондор-1” (10-р чиглэл)-ийн багийн гишүүд бараг бүгдээрээ оролцсон юм.

### Үзсэн зарим газрууд

**1. Харзүрхний Хөх нуур.** МНТ-/122/-д” Тэмүүжин нар тэндээс нүүж Хүрэлх доторх Сэнгүр горхины Харзүрхний Хөх нуурт очиж буув”гэж дурьдсан энэ нуур өнөөгийн Цэнхэрмандал сумын төвөөс баруун хойш чигт Хэрлэн голоос зүүн тийш орших Багабуурал уулаас зүүн урагш Харзүрх уулын өвөрт Юдэг голын савд х.ө 48 градус, 01 минут з.у 108 градус 56 минутын солбицол хавьд оршдог том жижиг холбоотой хоёр нуур. Энэ нуур одоо Цэнхэрийн голын саваас Цагаан даваа гэдэг ой модтой намхан даваагаар тусгаарлагдан оршино. Энэ даваа нуураас 4 км зайтай юм. Харзүрх уул нь ардаа ой модтой, энгэртээ ойгүй зүрхэн шовх хэлбэртэй уул юм. Одоо баруун тийшээ 50 км урсаад Хэрлэн голын зүүн гарт цутгадаг Юдэг голын савд оршиж байгаа энэ нуурыг яагаад Сэнгүр /Цэнхэр/ горхины гэж нэрлэсэн юм бол гэдэг нь сонин юм.

Харзүрхний Хөх нуурын урд эрэг дээр 15 орчим метр диаметртэй гэрийн буурины чулуу байна. Энэ магад 1189 онд Чингисийг Хамаг Монголын хаан ширээнд өргөмжилсөн ордны буурь байх. Харзүрхний Хөх нуур орчмын газар нь шинэс, хус, улиасан ойтой, бургас бут намаг бөөрөг бүхий ус намаг ихтэй ой тайгын бүсийн төрх байдалтай нутаг. Дээр “Хүрэлх дотор” гэж гарч байна. Цэнхэрийн голын эх хавь, Харзүрхний Хөх нуур хавь орчмын аль аль нь уулсаар хүрээлэгдсэн уудам хөндий хотгор газар юм. Үүнийг Хүрэлхүү гэж нэрлэсэн байж болох юм. /1. 20/

**2. Хангал нуур.** Өмнөдэлгэр сумын нутагт Хурхын голын савд орших 1.5 ам км талбайтай тектоник гаралтай цэнгэг нуур. Энэ нуураас баруун тийш холгүй хүүхдийн зуслан, амралтын газар бий. Нуураас баруун урагш Баруунбаян голд “Баянгол”-ын жуулчны бааз оршдогийг дээр дурьдсан.



**3. Бэрээвэн хийд.** Балдан брайбунг гэдэг жинхэнэ нэр нь сунжраад Бэрээвэн хийд болжээ. Энэ хийд Хангал нуураас зүүн хойш шуудаараа бол /морин замаар / 10-аад км ойрхон, Иххалиугчин уулыг тойрч Жаргалант голыг өгсөж очиход 40 гаруй км явна. Дэлгэрхаан уулын өвөрт Жаргалантын голын савд Шар голын хөндийд оршино. /6. 250/

Хийдээс зүүн урагш замд ханан эгц улаан буурал боржин чулуун дээр ухаж товойлгон маш сайхан хийсэн 3 м орчим өндөр, 2 м орчим өргөн Манзушир бурхан бий.

Энэ хавийн уулыг 13 сансар уул гэх бөгөөд нарс, шинэс, даль бүхий ойтой нэлдээ боржин чулуун сайхан уул юм. Брайбунг хийдийг 1777 онд боржин чулуугаар барьж аравнайлсан аж. “Арван чулуун бурхантай, Арын цагаан утай гүмбэн” гэж нэрлэгдсэн 32 баганатай 3 давхар том ордон байсан боловч одоо нурж хана нь үлджээ. Харин энд жижиг хийд ажиллаж байна. Жаргалант голд буган хөшөө бий. /6, 75/

**4. Биндэр овоо.** Брайбунг хийдээс зүүн хойш 80 –аад км зайтай, Хурхын голын өргөн хөндий рүү зүүн гараас нь түрж орсон хадархаг намхан хамар дээр их замын дэргэд орших тэр хавийн олон сумдын ард түмний тахилгат овоо. Биндэр Батширээт, Өмнөдэлгэр сумдын нутгийн зааг.

**5. Рашаан хад.** Биндэр овооны зүүн дор дэргэд нь орших бүдүүн ширхэгт элсэн чулуу, хөр чулуу, боржин, хүрмэн, занар холилдсон хамрын зүүн дор орших бүдүүн ширхэгт элсэн чулуун 10 гаруй метр өндөр цохио. Зүүн тийшээ их хазайсан энэ Рашаант хадны орчим /МЭӨ 20000 жилийн өмнөх/ эртний булш бий бөгөөд мөн тэр орчмоос палеолит, неолитын чулуун зэвсэг, хүрэлийн ба Хүннү, Хятаны үеийн гээд олон үеийн дурсгал олбор олддог энэ хаданд Орхон-Енисей, Хятан, Араб, Перс, Монгол, Түвд зэрэг хорь орчим бичээс байгаа нь олны сонирхолыг ихэд татдаг юм.

---

Энэ бичээсүүдийг анх 1961 онд эрдэмтэн Х.Пэрлээ гуай мэдээлжээ. Түрэг бичээсийг С.Харажубай"Эцэг өвөгдийн шан хишиг", "Зоригтой ач /хүү/" гэж уншсан бөгөөд Хятад бичгийг доктор Л.Жамсран"Юнлин хаан явж өнгөрөв" гэж уншлаа. Монгол бичгийг нь академич төрийн шагналт Д.Цэрэнсодном, XIII-XIV зууны үеийн бичиг бололтой гэж үзэж байна. Энэ дурсгалыг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /б. 221 /

**6. Өглөгчийн хэрэм.** Хурхын голын зүүн гарын цутгал Өглөгчийн голын хөндийн зүүн гар талд хойд энгэрт нь урагшаа хандсан тавиу аманд Биндэр овооноос баруун тийш 12 км зайтай орших том улаан буурал боржин чулуугаар барьсан 2 м орчим өргөн, өндөртэй байсан болуу гэмээр 10 гаруй км урт үргэлжилсэн хэрэм. Хятаны үед барьсан гэж үздэг. Одоо нурсан боловч хэрэм гэдэг нь тод мэдэгдэнэ.

**7. Галттайн тохой.** Биндэр сумын төвөөс зүүн хойш 90 орчим км зайтай, хилийн наахна Балжийн голын зүүн гарын цутгал Галттайн голын уудам хөндий, Улиас бургас гол, намаг ус ихтэй нутаг. Төрийн шагналт ардын зохиолч Сэнгийн Эрдэнийн төрсөн нутаг -Тоонот учир бид түүнд зориулсан багана-сэрэг босгож бэсрэг наадам хийв. С.Эрдэнийн оролцоотойгоор хийсэн энэ ажил бидний аялалын нэг чухал зорилго байв.

**8. Баянхаан уул.** Галттайн тохойн баруун талд орших 1400 гаруй метр өндөр, нутгийн тахилгатай уул. Бид тахив.

**9. Цагаанчулуут уул.** Галттайн тохойноос зүүн тийш 40 орчим км зайтай Улсын хилийн наахна Цагаанчулуутын голын зүүн гар талд орших гантиг, шохойн чулуунаас тогтсон шүтлэгт уул. Нар салхины ажиллагаагаар хонгил, ангал, сэнж нүх үүссэн эмчилгээний чанартай уул.

**10. Дэлүүнболдог.** Гурваннуурын амралтаас хойш ойрхон нарсан ойд д.т.д 900 орчим метр өндөрт орших жижиг толгой. Эзэн Чингисийн төрсөн нутаг мөн гэж үздэг.

**11. Хажуубулаг.** Гурваннуурын рашаанаас баруун тийш, Дадал сумын төвийн баруун захад орших булаг, хойшоо урсаад Балж голд нийлнэ. Эзэн Чингисийн угаасан ус гэж үздэг. Эндээс Онон-Балжийн УТХ газарт очно. II бүлгийн 26-г үз.

**12. Бодончорын эмбүүлийн буурь.** Дадал сумын төвөөс баруун тийш 10 орчим км зайтай Балж голын урд эрэгт ойрхон, Тэнгэлэг горхины баруун эргээс холгүй оршино. Энд эзэн Чингисийн дээд өвөг Бодончорын эмбүүл байсан гэж газарзүйч О.Сүхбаатарын тодорхойлолтоор “Сувдан сондор-3” –ынхан бид тэмдэг /Сэрэг/ босгов.

**13. Тунсаг толгой.** Батноров сумаас баруун урагш 50 км зайтай, Хэрлэнгийн эрэг дээр орших тахилгатай хадтай жижиг толгой. Энэ толгойн орчим эртний булш, хаданд нь адууны тамганы дүрс зураг их байдаг учраас манай нэрт яруу найрагч, соёлын гавьяат зүтгэлтэн Г.Мэнд-Ооёо “Туурай тамгатай Тунсаг толгой” гэж сайхан шүлэг бичсэн. Нутгийн ардууд адуундаа тамга хийх болохоор Тунсаг толгойд ирж хамгийн түрүүнд ажиглагдсан тамгыг адууныхаа тамга болгож авдаг. Эндээс Баян-Овоо сумаар дамжиж Тосон-Хулстайн УТХ-газарт очно. II бүлгийн 42-д үз.

**14. Өндөрхаанд** үзэх зүйлийн тайлбарыг 28-р чиглэлээс үз.

**15. Хэрлэн, Аварга-Тосон, Хөдөө арал, Цэнхэрийн голын** тайлбарыг 27-р чиглэлийн замаас үз.

**16. Баянжаргалан** болон түүнээс хойш үзэх зүйлийн тайлбарыг 7, 10, 27-р чиглэлийн замаас үз.

#### **Өөр замд шилжих**

##### **1. Дорнод аймгийн замд**

- Норовлингоос Баян-Уул сум 69 км
- Идэрмэгээс-Баян-Овоо 70 км-Чойбалсан хот 192 км

##### **2. Сүхбаатар аймагт**

- Идэрмэгээс –Баян-Овоо 70 км- Түмэнцогт 25 км
-

- Өндөрхаанаас Мөнххаан сум 126 км

### 3. Төв аймгийн замд

- Дэлгэрхаанаас /Аварга-Тосонгоос/ Баянжаргалан сум 100 км

- Дэлгэрхаанаас Хэрлэнгийн зүүн гараар өгсөж Багануур 120 км

## Дорнод аймаг

**Дорнод аймаг.** 123, 6 мян ам км нутагтай 74.5 мян хүн амтай. Аймгийн төв Чойбалсан хот нь Хэрлэн мөрний хөвөөнд д.т.д. 747 м өндөрт Улаанбаатараас 655 км зайтай оршино. Дорнод аймаг бүхэлдээ монголын Дорнод



их талд оршдог юм. Энд алдарт Мэнэнгийн тал бий. Чойбалсан хотын агаарын жилийн дундаж температур нь  $0.5^{\circ}\text{C}$ , I сарынх  $-21.3^{\circ}\text{C}$ , VII сарынх  $19.9^{\circ}\text{C}$  байдаг, жилд 250.6 мм тунадас унадаг агаарын даралт I сард 932.5 гПа, VII сард 919.4 гПа байдаг. Салхины жилийн дундаж хурд нь 3.6 м/с, хамгийн их салхитай IV сард дунджаар 5.4 м/с. Аймгийн нутгаар манай орны том мөрний нэг Хэрлэн, Улз, Халх гол урсах бөгөөд Буйр, Хөх нуур зэрэг нуурууд, олон рашаан бий.

Аймгийн нутаг нь тал хээрийн бүсэнд орших учраас хадлан бэлчээрийн талбай ихтэй. Хээрийн ургамал амьтад ялангуяа цагаан зээр маш элбэгтэй. Дорнод аймаг нь улсын тусгай хамгаалалттай газар нутаг олонтойгоороо онцлог.

ОУ-ын байгаль хамгаалал гарчигийг үз.

Дорнод аймаг 800 мян малтай, малын дотор хонь, үхэр олон. Газар тариалан нэлээд хөгжүүлсэн. Чойбалсан хот нь хөнгөн ба хүнсний үйлдвэр хөгжүүлсэн манай улсын том хотын нэг. Чойбалсан-Эрээнцавын зам км нь Оросын Соловьёвскийн төмөр замтай нийлнэ. Чойбалсан хотоос Хавиргын түр боомтоор Хятад улс уруу гарч болно.

### Чойбалсан хотод очих зам

**1. Улаанбаатар –Өндөрхаан** 331 км-Баян-Овоо сум 132 км-Чойбалсан хот 192 км. Бүгд 655 км.

**2. Улаанбаатар–Өндөрхаан** 331 км-Бэрх 69 км-Батноров 36 км-норовлин 97 км-Баян-Уул 69 км-Чойбалсан хот 180 км.

Бүгд 782 км

**3. Улаанбаатар-Өндөрхаан** 331 км- Баруун урт 229 км-Чойбалсан хот 191 км Бүгд 751 км.

**4. Улаанбаатар-Өндөрхаан** 331 км-Баян-Овоо сум 132 км-Сүхбаатарын Түмэнцогт сум 25 км-Дорнодын Хөлөнбуйр 77 км-Булган сум 72 км-Чойбалсан 48 км.

Бүгд 685 км.

### **31 дүгээр чиглэл**

#### **Улаанбаатар –Дорнод-Улаанбаатар**

**Зорих гол үзмэр.** Монголын Дорнодын их тал, түүний байгаль, эзэн Чингисийн түүхийн дурсгалт газрууд, ховор амьтан ургамал, дархан газрууд- **Дорнодын тал, Нөмрөг, Монгол Дагуур, Угтам уул, Яхь нуур, Тосон-Хулстай.**

**Улаанбаатар-Чойбалсан** хотод онгоцоор /1 цаг 30 мин/ очно. Чойбалсан хотоос машинаар урагшаа аялна.

**Аялах зам урд чиглэл.** Чойбалсан хот-Буйр нуур 296 км-хуучин Халхгол сум 26 км-баруун урагшаа шинэ Халхгол- Сүмбэр сум 62 км-Дэгээ гол 80 км-баруун хойшоо Ихташгай нуур 80 км-Тамсагбулаг 90 км – Сангийн Далай нуур 60 км-Лаг нуур 75 км-Матад 95 км-хойшоо Чойбалсан 143 км.

Замын урт 1020 км, хугацаа 6-7 хоног.

**Мянганы зам** Халхгол сумаас баруун тийш шулуун явсаар Матад сумын төвийн хойгуур Адагдулаан-Хургант Ухаа овоогоор өнгөрч Сүхбаатар аймгийн нутагт орж ирнэ.

---

**Үзэх гол зүйлийн товч тайлбар:**

**1. Дорнод тал, Лаг нуур, Нөмрөгийн дархан газар,** II бүлгийн 6, 7-г үз. Дорнод аймгийн Халхын гол хоёр улсын усан хилээр Халхын голын төмөр бетон гүүр барих асуудал 1990-ээд оноос яригдж ирсэн бөгөөд уг гүүрийг барьж ашиглалтад оруулах нь бүс нутгийн эдийн засаг, худалдаа, аж үйлдвэр, аялал жуулчлал, хоёр талын хамтын ажиллагааны хөгжилд нэн чухал ач холбогдолтой гэж үзэж гүүр барих ажил эхлэх болж байна..

**2. Буйр нуур.** Монголын Дорнод хязгаарын талд д.т.д. 583 м өндөрт оршдог нуур. 615 ам км талбайтай. Өргөн нь 21 км, урт нь 40 км, Буйр нуурт Халхын гол цутгаж, Оршуун гол эх авч урсана. Буйр булуу цагаан, тул, улаан живэрт, зэвэг, амарын хадран, амарын цурхай, хадар, давх, цулбуурт, гутаар, өлгөр цагаан, мөнгөлөг хэлтэг зэрэг загастай. Энд загас олборлох үйлдвэр ажилладаг. Жилд 300 тонн загас агнах нөөцтэй гэсэн тооцоо бий. Агнуурын гол загас нь булуу цагаан юм. Буйр нуурын хавь газарт хар өрөвтас халбаган хушуут, хурган тутгалжин зэрэг ховор амьтад, ургамал их бий.

**3. Халх гол.** Иххянганы салбар уулсаас эх авч Монголын Дорнод хязгаараар 233 км урсаад Буйрт нуурт цутгадаг гол. Дэгээ Нөмрөг зэрэг олон голуудыг нийлүүлж авдаг. Халх голд Буйр нуурт байдаг загасууд бий. Халх голын ялангуяа Нөмрөгийн дархан газрын сав нутагт ховор амьтан, ургамал их бий. II бүлгийн 6. Мөн энэ хавь нутагт МНТ-ны түүхт газрууд олон бий. /1, 32, 26, 22/

**4. Хуучин Халх гол сумын** төвөөс урагш Халх голын зүүн гарт XIX зууны үед Халхын То-вангийн бүтээсэн Жигважиджав Жанрайсаг хэмээх Бурхантын цогцолбор гэдэг чулуун шигтгээт бурхны хөрөг бий.

Энэ цогцолборыг 2 га талбай эзэлсэн энэ асар том цогцолборыг 1864 онд Тогтохтөр /То-ван/ байгуулжээ. /6.259/







Урд нь өөр газар их бурхан бүтээх гэж байгаад үерийн усанд урсгаж газрыг нь эвдсэн учир хожим нь өөр газар босгосон нь энэ. Их бурханы маанийн 20 үсэг, язгуурын 7 бурхан, найман тахил, есөн эрдэнэ, 12 суварга, 2 хорол, 500 м урт хэрмэн хашааны гол том хаалга, дөрвөн махранзыг засч, гурван том хүрд гурван сангийн бойпор, зулын ба тахилын том цөгц бүхий аж. Энэ цогцолборыг 1997 онд сэргээн засварлаж 1998 онд улсын хамгаалалтад авчээ. Энэ бурхны орчмоос Киданы үеийн яст мэлхий олсон. Халх голын сав нутгаас хуучин чулуун зэвсгийн үеийн /40-12000 жилийн өмнөх / дурсгалын зүйл олддог. Бас Халх голын савд 1939 оны ялалтад зориулсан хориод хөшөө, дурсгал, цэргийн дурсгалын булш бий.

**5. Халхгол сумын** нутагт 1950 онд шилэн солир унасан нь ховор үзэгдэл юм. Хэрлэн гэж нэрлэгдсэн энэ солир 32, 7 кг жинтэй, 2 метр урт, 1 м гаруй өргөнтэй ажээ.

**6. Сүмбэр сумын** төвөөс урагш 7 км-т Шонхтаван толгойд хүн чулуу бий. Үүнийг 1998 онд улсын хамгаалалтад авчээ.

**7. Ихташгай нуур.** Халх гол сумын төвөөс баруун урагш 30-аад км-т орших жижиг нуурууд. Энэ нууранд зүүн урдаас нь Азаргын гол (Мухар, Шинэ гол гэж бас нэрлэдэг) цутгадаг. Ихташгай, Азаргын гол түүний цутгал Гүүгийн голд ОУН ба МУН-д орсон цэн тогоруу зэрэг ховор амьтанд ургамал их бий. Нөмрөгийн дархан газрын амьтад гүйгүүл маягаар орж ирдэг нутаг.

**8. Тамсагбулагаас** зүүн тийш 10 орчим км-т манай археологичид шинэ чулуун зэвсгийн үеийн /МЭӨ 5000-2000 жил / булш олсон нь нэн эртний булшны нэг болох ховор олбор ажээ. (6.18)

**9. Сангийн Далай нуур.** Мэнэнгийн талд Ихташгай нуураас баруун тийш орших хоолны давсны асар их баялагтай талын нуур 7.5 ам км талбайтай. Хоолны давсыг гар аргаар олборлодог. Энэ их талаар явахад хэдэн мянгаар сүрэглэн яваа зээр, дотроо чонотой зээрийн сүрэгтэй ч таарч болно. Дорнодын талын УТХ Газар. II бүлгийн 7-г үз.

---

**10. Матад сумын** төвөөс зүүн тийш холгүй орших Тосон уул орчмоос нефтийн орд олджээ. Тосон гэдэг нэртэй газраас газрын тос олдож байгаа нь манай ард түмэн газраа баялагаар нь онож нэрэлдгийн нэг жишээ.

**11. Матад сум** Ардын зохиолч, Академич, төрийн гурван удаагийн шагналт эрдэмтэн Ц.Дамдинсүрэнгийн төрсөн сум.

**12. Булган сумын** төвөөс баруун тийш ойрхон Хэрлэнгийн урд хөвөөнд орших Норовлин Овоо уулнаас олдсон монгол төрхийн хүний булшнаас чулуун онго, ясан зүүлт, зараа хэлбэрийн чимэг, зосон зургууд олджээ. Энэ бол сонин олборууд юм.

**Өөр замд шилжих:**

**1. Сүхбаатар аймгийн замд:**

- Матадаас Эрдэнэцагаан сум 124 км
- Матадаас Сүхбаатар сум 121 км
- Чойбалсан хотоос Баруун-Урт 191 км

**2. Хэнтий аймагт шилжих замыг** Хэнтийн 30 дугаар чиглэлээс үз.

**32 дугаар чиглэл**

**Дорнод аймаг дотор**

**Хойд чиглэл.** Чойбалсан хот-баруун тийшээ Хэрлэнбарс хот 75 км-хойшоо Галын голыг гаталж Сэргэлэн сум 100 км-Цагаан-Овоо сум 71 км-Чингисийн даланг огтолж Баян-Уул сум 83 км- Улз голыг гаталж Эрээн 24 км-буцаад Баян-Уул сум 24 км-зүүн тийшээ Улз голыг уруудан Баяндун сум 63 км-Угтам уулыг дайрч Дашбалбар сум 96 км-Зүүн хойшоо Хайчийн нуур 65 км-Эрээнцав 95 км-Хөх нуур 50 км Гурванзагал сум /Сүмийн нуур / 90 км-Чингисийн даланг огтолж Чойбалсан сум 65 км-Чойбалсан хот 55 км. Эрээнцав хилийн байнгын гарц, Баян-Уул сумаас хилийн түр боомт Ульханаар, Дашбалбар сумаас Ямалах боомтоор ОХУ-руу гарч болно. Замын урт 1000 км, хугацаа 5-6 хоног.

### **Үзэх зүйлийн гол товч тайлбар:**

**1. Хэрлэнбарс"хот", Чойбалсан хотоос** баруун тийш Цагаан-Овоо сумын нутагт Хэрлэн голоос хойш 5 км орчим зайтай орших гурван хотын туурь. Хятан улсын үед байгуулагдсан хотууд юм гэж эрдэмтэн Х.Пэрлээ бичсэн. Энэ хот Хятан улсын шашны төв байсан гэж үздэг. Хэрлэн барс I II III гэж ялгаж үздэг бөгөөд 1-ийн хэрэм нь 1600-1800 м урт, зузаан нь 4 м, өндөр нь одоо 2 м орчим байна. 3 хот нь нийтдээ 20-иод км цувсан зайтай, II хотын хэрэм нь арай бага, III хот нь мөн том шороон хэрэмтэй байжээ. Х.ө 48°04', з.у 113°25' орчимд оршдог.

Хэрлэнбарс хот Хятан улсын үед баригдсан боловч хожим нь Тогоонтөмөр хааны үед зарим хэсгийг бариулсан буюу засварласан гэж үздэг. /6.194/

Үүнийг 1971 оноос улсын хамгаалалтад авчээ.

### **2, Чингисийн далан** 28-р чиглэлд үз

Эндээс Баян-Уул сумаар дамжин Онон-Балжийн УТХГазарт очиж болно. II бүлгийн 26.

**3, Дорнод аймгийн** нутгийн баруун хойд хэсэгт МНТ-ны үйлявдал өрнөж байсан түүхт газрууд олон бий. Өнөөгийн Хэнтий, Дорнод аймгийн нутгийн заагт МНТ-ны Цэгцэрийн Шар тал, Дорнодын Цагаан-Овоо сумын нутагт Чихурху, Баян-Уул, Баяндун сумын нутагт Хусту Шитүэн, Нарату Шитүэн оршдог. /1, 24/

### **4. Угтам уул.** II бүлгийн 35-ыг үз.

**5. Улз гол.** Хэнтийн нуруунаас эх авч зүүн хойшоо 428 км урсаж Хөх, Тарь 2 нуурт очдог гол. Дөчийн гол зэрэг хэд хэдэн голыг нийлүүлж авдаг. Улзын сав олон нууртай бөгөөд тэнд жигүүртэн шувууд их цугладаг. Дашбалбар сумын нутагт гидрокарбонат, кальц-натрийн найрлагатай Цагаанхөндийн сайн /20.179/ рашаан, Улааны холимог төмөрлөгийн орд бий.

**6. Хайчийн Цагаан нуур** нь Улзын савд дахь олон нуурын нэг. Улз, Дөч голын бэлчэрээс дээш ойрхон оршино. Энэ хавийн олон нууруудад ОУУН болон МУН-д орсон нэн ховор цэн тогоруу, гангар хун болон хурган тутгалжин зэрэг ховор шувууд цуглардаг.

**7. Монгол дагуурын дархан газар** II бүлгийн 5-ыг үз.

**8. Хөх нуур.** Монгол орны хамгийн нам дор орших газар /1 бүлгийн МОГ 11-д үз/ 95 ам км талбайтай, нилээд гүнзгий нуур, Улзын голоос Тээлийн гол салж энд цутгана. Энд ховор амьтан, ургамал, жигүүртэн бий. Хөх нуур орчим олон нуур бий.

**9. Сүмийн нуур.** Гурванзагал сумын нутаг 23 ам км талбайтай энэ нуур орчим Монгол Дагуурын дархан газрын жигүүртэн шувууд их ирдэг.

**10. Чойбалсан сумын** нутагт Утаатминчүүр гэдэг хлор аммоний халуун ууртай рашаан бий. Газрын ан цаваар байнга халуун уур савсаж байдаг сонин газар. Газрыг нь ухаж хонхойл бол халуун нь нэмэгддэг. /20.185/

Мөн энэ сумын нутаг Баруун-Өлзийтээд шинэ чулууны зэвсгийн үеийн дурсгал бий. (6.9)

**11. Яхь нуур** II бүлгийн 48-ыг үз.

**12. Энэ замд Цагаан-Овоо, Баян-Уул, Баяндун, Дашбалбар сумдад** монголын буриад ард түмний ажил амьдралтай танилцана. Энэ хавь нутаг нь ардын зураач Г.Одон, ардын жүжигчин, дуучин Жаргалсайхан нарын зэрэг манай урлагийн нэрт олон зүтгэлтэн төрсөн нутаг юм. Хөлөнбуйр, Гурванзагал суманд барга, Сэргэлэн суманд үзэмчин ястан амьдардаг.

**13. Чойбалсан сум** бол Х.Чойбалсангийн төрсөн нутаг

**Өөр замд шилжих:**

Эндээс хилийн түр боомт Хавиргаар Хятад улс руу гарч болно.

**1. Хэнтий аймагт**

30 дугаар чиглэлээс үз

**2. Сүхбаатар аймагт**



- Чойбалсан хотоос Баруун урт 191 км
- Хөлөнбуйр сумаас Түмэнцогт 65 км
- Матад сумаас Эрдэнэцагаан сум 124 км, мөн сумаас Сүхбаатар сум 121 км,
- Лаг нуураас Эрдэнэцагаан сум 110 км

### Сүхбаатар аймаг

**Сүхбаатар аймаг.** 82, 3 мян ам км. Нутагтай 56.0 мян



хүн амтай. Аймгийн төв Баруун –Урт хот нь д.т.д. 981 м өндөрт Улаанбаатараас 560 км зайтай оршино. Аймгийн нутаг нь манай орны зүүн өмнө захын их тал юм. Хамгийн өндөр уул

нь нутгийн урд захад орших Шилийн Богд 1778 м өндөр. Энэ хавьд унтарсан галт уулууд бий. Аймгийн нутагт цайр холимог төмөрлөгийн баялаг нөөц бий. Баруун-Урт хотын агаарын жилийн дундаж температур нь 0.4°C, 1 сарынх-21.3°C, VII сарынх 19.9°C байдаг. Жилд 203.7 мм тунадас унадаг. Агаарын даралт 1 ба VII сард 900 орчим гПа байна. Салхины жилийн дундаж хурд нь 2.2 м/с бөгөөд хамгийн их салхитай IV сард 4, 9 м/с Зарим хавар 40 м/с хүртэл хурдтай шуурга болдог. Аймгийн нутгийн хойд захаар Хэрлэн гол урсана. Жижиг нуурууд олон бий. Малын бэлчээр, хадлангийн өвс ургамал ихтэй. Цагаан зээр элбэг бас ховор амьтад бий. Лхачинвандад , Ганга нуур зэрэг улсын хамгаалалттай газрууд бий.

Сүхбаатар аймаг 1.5 сая малтай, малын дотор хонь, ямаа олон. Нутгийн хойд хэсэгт тариалан бага зэрэг эрхэлдэг.

#### **Баруун –Уртад очих зам.**

1, Улаанбаатар-Өндөрхаан 331 км-Мөнххаан сум 126 км-Баруун-Урт 103 км,

Бүгд 560 км

---

**2. Улаанбаатар-Баянжаргалан сум** 138 км-Баянмөнх сум 80 км-Бүрэнцогт 180 км-Баруун-Урт 140 км, бүгд 538 км

**3. Мянганы зам** Хэнтийн Өндөрхаанаас Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Наран, Сарангийн уулаар явж Дорнод аймгийн нутгаар явна.

### **33 дугаар чиглэл**

#### **Улаанбаатар-Сүхбаатар аймаг-Улаанбаатар**

**Зорих гол үзмэр.** Дорнодын их тал, унтарсан галт уул, Дарьганга нутаг, Говийн баянбүрд, элс манх, түүхийн дурсгалт эртний хүн чулуунууд, ховор амьтан ургамал, улсын хамгаалалттай Лхачинвандад уул, Ганга нуур.

**Улаанбаатар хотоос** онгоцоор Баруун-Уртад /1 цаг 30 мин/ Эсвэл Дарьганга /1 цаг 50 мин/ суманд очно. Баруун-Уртаас хойд, урд 2 чиглэлд явж болно.

**Мянганы зам** зүүнээсээ орж ирж Түмэнцогт сумын нутаг Наран-Сарангийн уулаар дамжин баруун тийш чигээрээ явж Өндөрхаанд очно.

#### **Аялах зам**

**Урд чиглэл.** Баруун-Уртаас-баруун урагшаа Халзан сум 65 км-Баянбулаг 11 км-Баяндэлгэр сум 69 км-Шарбүрд /Онгон элс/ 50 км-урагшаа Онгон сум 45 км-зүүн тийшээ Дарьганга сум /Алтан-Овоо/ 64 км-урагшаа Наран сум 39 км-зүүн хойшоо Ганга нуур 50 км-зүүн тийшээ Эрээн толгой 30 км-Шилийн Богд 30 км-баруун хойшоо Талын агуй 14 км-зүүн хойшоо Харгилтайн голыг гатлаж Зотолхаан уул 50 км-Хонгорын голыг гатлаад Эрдэнэцагаан сум 50 км-зүүн урагш Лхачинвандад уул 75 км-буцаад Эрдэнэцэгээн сум 75 км-баруун хойшоо Сүхбаатар сум 180 км-Баруун-Урт 50 км .

Замын урт 950 км, хугацаа 6-7 хоног.





## Үзэх гол зүйлийн товч тайлбар:

**1. Төхөмийн тал.** Аймгийн төвийн урдуур өнгөрөх тал. Дорнод аймгийн нутгаас эхлэн баруун урагшаа Өмнөговь аймгийн нутаг хүрэх Дорнодын их хотгорын нэг хэсэг. Үнэмлэхүй өндөр нь 800-1000 м. Хээрийн их бэлчээртэй нутаг.

Энэ замд Халзан, Дарьганга, Онгон, Наран, Баяндэлгэр, Асгат болон Уулбаян, Түвшинширээ сумдын урд хэсгээр Дарьгангачууд амьдардаг. 2000 оны хүн амын тооллогоор Дарьганга ястан 32000 хүн байжээ.

**2. Хатавчийн хавцал.** Халзан сумын төвийн дэргэдүүр өргөрөгийн дагуу тасархайтан 3 км орчим үргэлжлэх хавцал. Хавцлыг үүсгэсэн чулуулаг нь эртний төрмөлийн эриний девоны галавын /одоогоос 350 орчим сая жилийн өмнөх/ үеийн далайн бэсрэг гүний усанд тунаж үүссэн нарийн ширхэгт элсэн чулуу юм. Далайн гүний энэ тунамал хурдас хожим нь дундад ба шинэ төрмөлийн эриний / мезокайнозойн/ зөрөгт хөдөлгөөнд нэрвэгдэж энэхүү хавцалыг үүсгэжээ. Хавцалын эгц ханан хадны өндөр 15-16м бөгөөд хавцалын өргөн нь 30-100м юм. Манай оронд ийм "шинээрээ" байгаа сүүлийн үеийн зөрөгт хавцал олон байхгүй. Хатавчаас /Халзан сумын төвөөс/ баруун урагш хөдлөөд Баянбулагт очно. Баянбулаг нь хээр талд орших цэвэр тунгалаг устай сайхан булаг юм. Булгийн эхний намагт улирлын бөөрөлж /намгийн хөрсөн доорхи мөс/ зун орой болтол хайлаагүй байдаг.

Баянбулагаас урагш Бор толгой гэж өнтэй өвөлжөөтэй толгой бий.

**3. Онгон элс** Шар бүрдний элс ч гэдэг Онгон сумын нутагт орших 127ам км талбайтай энэ элсэнд Нүүдэлчин ардын хүрээлэн, нүүдлийн хотхон байгуулж байна.

**4. Их булаг.** Онгон сумын төвийн дэргэд орших галт уулын уулын хүрмэн чулууны дороос ундрэн гарах тунгалаг уст булаг, нутгийнхан рашаан гэж үздэг. Онгон сумын нутгаас шинэ чулуун зэвсгийн үеийн зүйл олддог. 35-р чиглэлд үз.

**5. Молцог элс.** Онгон, Дарьганга сумын нутагт 248 ам км талбай эзлэн орших өвс ургамлаар бэхлэгдсэн манхтай элс. Энэ элсний захаар олон нуур бий. Энэ элсний захад Дарьганга сумын төвийн дэргэд орших Дагшин нуурын эрэг дээр амралтын газар бий.

**6. Алтан-Овоо.** Дарь-овоо гэж нэрлэх ч бий. Дарьгангын галт уулсын нэг д.т.д. 1354 м өндөр. Дарьганга сумын төвийн дэргэд оршдог энэ уул нь Сүхбаатар аймгийн урд хэсгийн 6 суманд амьдардаг Дарьгангачуудын шүтэн биширдэг уул. XVII зууны үеэс нутгийхан тахиж ирсэн бөгөөд 1913 оноос Богдын зарлигаар тахиж ирсэн. Монгол орны өргөн олныг хамарсан их тахилга хийдэг уулын нэг. 2004 онд их тахилгатай болгосон. Энэ тухай II бүлгийн 33-д үз.

Алтан-Овоон дээр эмэгтэй хүн гардаггүй бөгөөд харин эмэгтэйчүүд овооны баруун урд орших арай намхан дэвсэг дээр гарч болдог бас бэлээр нь тойрдог зам бий. Алтан-Овоо дээрээс зүүн урагшаа 60 гаруй км-т орших. Шилийн Богд уул харагддаг. Алтан-Овоо баруун хойшоо сэтэрч урссан тогоотой.

**7. Хаан, Хатан, Хүү, Бэр хөрөг.** Дарьганга сумын төвийн дэргэд Алтан-Овооны зүүн урд энгэрт байдаг хүн чулуу. Хүн чулуу нь тэрүүхэн тэндээ байхгүй гантиг чулуугаар хийгдсэн нь сонин. Энэ дурсгалыг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. (6.95) Сүхбаатар аймгийн нутагт янз бүрийн үеийн хүн чулуу 60 шахам бий бөгөөд үүний олонх нь Дарьганга Онгон сум, Молцог элсний элсний орчимд бий. Хүн чулууны тухай 35 дүгээр чиглэлийн замаас үз.

**8. Баяндулааны агуй.** Дарьганга Наран сумын нутгийн зааг дээр Молцог элснээс урагш х. ө 45 дугаар зэргэдээс хойшхно **Баяндулаан** гэдэг д.т.д 1752 м өндөр уул. Энэ уулыг цэрэг дайны үед тахидаг тахилгатай уул гэдэг. Өөр цагт тахидаггүй. Энэ унтарсан галт уулын баруун урд хажууд байх агуй нь галт уулын хажуугийн амсар ажээ. Энэ агуйн яг аман дээр нь очихоос нааш агуй

---



гэж мэдэхгүй. Агуй руу доошоо мөлхөн ороод цаашаа 20-иод м газарт босоогоороо явж болно. Энэ хэсгийн хана, шал, адар нь дан хүрмэн чулуу. Энд хэдэн арван хүн багтана. Агуй цаашаа 70-аад см диаметр бүхий зууван дугуй маягийн хоолойтой. Гаднаас ус, ургамал, амьтан нүхлэн орох аргагүй пааландсан мэт дан хүрмэн чулуун дотортой энэ хоолой уулынхаа оройг чиглэн гол төв рүү явсан ажээ. Мөлхөж нэлээд хэдэн метр яваад явж багтахгүй болно. Хайлмаг бодис нь бүр хатуурч амжаагүй байсан үед нь уулын гол хоолойгоос арай хатуу бодис хүчтэй шахалтын нөлөөгөөр гадагшаа цацагдан-бүлтрэн гарахдаа энэ хоолойг/агуйг/ үүсгэсэн байна. Энэ агуй 50 гаруй м урт юм.

**9. Наран сумын нутаг. Зүлэгт** гэдэг газар орших **Сөдөтийн Цагаан** гэдэг бичээстэй чулуу бий. Энэ чулуунд “Дайцингийн эзэн хаан Өөлдийн Галданг залхаан цээрлүүлэх их цэргийг удирдан үүгээр өнгөрөв. Эзэн хаан бийрээр бичсэнийг хаданд сийлэв. Тэнгэрийн дор байгаа бүхэн хаан миний балчир хүүхэд. Түвштгэн тогтоосон хязгаар нутаг харш хортонгүй цэвэршиж, уул ус ивээн тэтгэж ургац өвс амтат булаг дэлгэрүүлэв. Эзэн хаан үүгээр өнгөрөхдөө энэ чулууг сийлүүлэв.

Тэнэгэр говьд илдээ ирлэж  
Тэнгэр ууланд жадаа үзүүрлэж  
Эгнэгт Ху нарын тоосыг арилгаж  
Элс манхыг эгүүрд ариутгана”... .

Гэж 1696 оны 5-р сард бичүүлснийг доктор Хэрээд Л.Жамсран тайлан уншжээ. /6.230/


Энэ бичигт чулууг 1998 онд улсын хамгаалалтад авчээ.

**10. Ганга нуур.** II бүлгийн 47, Ганга нуурын эрэгт “Шилийн богд” жуулчны бааз бий. Энд ойролцоо Торойбандийн хөшөө бий.

---

**11. Эрээнтөлгойн рашаан.** Билчээр усжуулах зорилгоор өрөмдмөл худаг гаргахад гидрокарбонат-натри-магни, цахиурын хүчилтэй энэ рашаан гарсан. Ходоод гэдэсний өвчнийг анагаахад уудаг. Энэ хавь нутаг нь зунтай жил өвс нь зээрийн нуруу гүрвэлзэх төдий харагдах болтол /дөрөө зурам/ өндөр ургадаг үнэхээр сайхан нутаг юм.

**12. Шилийн Богд уул.** Дарьганга сумын төвөөс зүүн урагш 60 км-т. д.т.д. 1778 м өндөрт орших уул. Дарьгангын унтарсан галт уулын нэг. Их талын хамгийн өндөр уул, орчныхоо газраас 400 гаруй метр өндөр энэ уул тэгш тал дээр хаана, хаанаасаа жараад км холоос майхан шовгор юм хөхрөн харагдах нь нэн сонин. Энэ уулын тогоо нь баруун хойшоо сэтрэн урссан бөгөөд амсар нь 2 км орчим өргөн, 300 орчим м гүнзгий ажээ.



Энэ уулыг өглөө эрт баруун хойноос нь нарны зүг харахад төрх байдал нь тогоо нь дугараглан сүүдэртэж хүнхийж харлан оройг нь яг л зүсээд авчээ гэж хэлэхээр нэн гайхалтай сонин. Энэ уулан дээрээс дурандахад эргэн тойрон 180-аад унтарсан галт уулыг тоолж харж болно. Энэ хавийн уулууд нь авдар, дөш, сэнжит, ацаа гэхчлэн галт уулын шовгор дүрс хэлбэрээрээ нэрлэгдсэн нь их бий. Шилийн Богдын зүүн дор Агтны Хүрээ гэж дугуй тогоотой талын намхан уул бий. Шилийн Богд дээрээс тод харагдана. Шилийн Богд уулан дээрээс Зотолхаан Алтан-овоо уулууд сайхан харагдана.

II бүлгийн 55-ыг үз.

**13. Дарьгангын галт уулт өндөрлөг.** Сүхбаатар аймгийн урд хэсгийн сумдын нутгийг хамарч байгаа 10 мян ам км талбайг эзэлсэн 30 м хүртэл зузаантай галт уулын хүрмэн чулуун хучлагат өндөрлөг. Энд зүүн хойшоодуу чиглэлтэй 5-6 зэрэгцсэн шугаман дээр байрласан унтарсан галт уул 222 бий. Эдгээр галт уулууд 10-15 сая жилийн өмнө оргилж байжээ.

**14. Талын агуй.** Дарьганга сумын нутагт Шилийн Богд уулаас баруун хойш 14 км-т цагаан тал дээр оршино. Энэ агуй яг тал дээр орших учраас түүнийг олох амаргүй байсан одоо бол замтай болсон, түүнд ороход эгц доошоо орно. Галт уулын хүрмэн чулууны хийн зайд тогтсон энэ агуй 10000 орчим шоо метрээс илүү багтаамжтай, 200 гаруй метр урттай бөгөөд манай галт уулын хүрмэн чулууны хийн зайнд үүссэн агуйнуудын хамгийн том нь юм.) Агуй дотор хүрмэн чулуун асга, хад, мөсөн цацаг, цан хүүрэгтэй хүрмэн чулуу хөрөхдөө мушгиран унжин тогтсон сонин тогтоцтой нэн үзэмжтэй ажээ. Талын агуй бол Монгол оронд мэдэгдээд байгаа 200 гаруй агуйнуудаас хамгийн үзэсгэлэнтэй нь юм гэж манай агуй судлагчид бичсэн юм. Талын агуй нь Шилийн богд Хөргийн хөндийн УТХ газрын бүрэлдүүнд оржээ.

**15. Харгилтайн гол.** Зотолхаан уулын баруугаар хойшоо урсах гол. Энд дөрвөн, зургаан талтай дөрвөлжиндүү том том хүрмэн чулуу бий

**16. Зотолхаан уул.** Унтарсан галт уул, баруун хойшоо сэтэрч урссан тогоотой д.т.д. 1375 м өндөр уул. Бэлээсээ үлэмж өндөр зөв шовгор уул.

**17. Эрдэнэцагаан** сумын нутгаас зүүн тийш МНТ-д Улхуй шилүгэлжид гэдэг нэрээр гардаг газар бий. /1, 26/ Сумын төв нь 1921 оноос өмнө Егүзэр хутагтын хийд байсан, хожим нь 1950 –аад онд Чоно голын холимог төмөрлөгийн уурхай байсан газар. Чоно гол гэдэг жижиг горхины эрэгт оршдог. Эрдэнэцагаан суманд үзэмчин, хуучид зэрэг ястан амьдардаг.

**18. Лхачинвандад уул.** II бүлгийн 39-г үз. Энд хилийн гарц Бичигт оршдог.

**19. Дарханхаан уул.** Сүхбаатар төвийн зүүн талд ойрхон орших д.т.д. 1000 гаруй метр өндөр нутгийн тахилгатай уул. Энэ уул эртний төрмөлийн хөрзөн чулуу, элсэн чулуу, боржиндуу чулуулгаас тогтсон хавтгай оройтой уул юм.

**20, Сүхбаатар сум.** Д.Сүхбаатарын өвөг дээдсийн уугуул нутаг. Түүний музей бий. Энэ сумын нутагт Аймгийн төвд ойрхон Салхит, Төмөртөд цайрын хүдэр бий. Жилдээ 300 мян тонн хүдэр буюу 40 мян гаруй тонн цайр олборлох үйлдвэр барих гэж байна. Энэ суманд халхчууд амьдардаг.

**Өөр замд шилжих:**

**1. Дорнод аймагт:**

- Баруун-Уртаас Чойбалсан хот 191 км
- Сүхбаатар сумаас Чойбалсан хот 165 км
- Сүхбаатар сумаас Матад сум 121 км
- Эрдэнэцагаан сумаас Матад сум 121 км

**2. Дорноговь аймагт**

- Баяндэлгэрээс Сайншанд хот 223 км
- Онгон сумаас Сайншанд хот 260 км

**34 дүгээр зам**

**Сүхбаатар аймгийн дотор**

**Хойд чиглэл.** Баруун-Урт-Талбулаг 34 км-Түмэнцогт сум 105 км-баруун тийшээ Мөнххаан сум 81 км-Бүрэнцогт 40 км-Түвшинширээ 70 км-Уулбаян сум 56 км-Баруун-Урт 80 км. Замын урт нь 480 км, хугацаа 3-4 хоног

**Үзэх гол зүйлийн товч тайлбар:**

**1. Төмөртийн овоо** Баруун-Уртаас зүүн хойш ойрхон орших цайрын орд түшиглэн байгуулагдаж байгаа том үйлдвэр. 2004 онд ашиглалтад орно. Хятад, Монгол улс хамтран байгуулж байна.

Бүгд 2100 км, 12 хоног.

**Үзэх гол зүйлийн товч тайлбар:**

**1. Баяндаваа** 6 дугаар чиглэлийн замаас үз

**2. Бөөрөлжүүтийн рашаан** 27 дугаар чиглэлийн замаас үз

**3. Баян-Эрхэт уул** 27 дугаар чиглэлийн замаас үз

**4. Баянмөнх** сумын орчмын тайлбарыг 29 дүгээр чиглэлийн замаас үз

**5. Устай Бургастай.** Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын төвөөс зүүн урагш 10 орчим км-т их замын дагуу орших Баян-Уул гэдэг намхан толгодын ам хөндий, энгэрт шинэ чулуун зэвсгийн үеийн хүний бууц булшнууд. Энэ дурсгалыг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /6.19/

**6. Баруун-Уртад** аймгийн музей үзнэ

**7. Сүхбаатар сум** 33 дугаар чиглэлийн замаас үз

**8. Дugnaгарын хөшөө хаан, хатан, хүү** гэж боржин, занар хээрийн жоншоор бүтээсэн 3 хөшөө. Их замын баруун талд ойрхон бий.

**9. Алтайн даваа.** Дugnaгарын хөшөөнөөс зүүн урагш ойрхон талын Намхан ухааг их замаар давах даваа. 1000 орчим метр өндөр

**10. Хонгорын голд** хүн чулуу бий.

**11. Хөндлөнхайласт** нь хайлас модны их төгөлтэй, жижиг горхитой ам. Амралтын газар бий.

**12. Лхачинвандад уул.** II бүлгийн 39-ийг үз. Энд байгаа Бичилтийн хилийн боомт байнгын ажиллагаатай болсон юм.

**13. Далай Булгийн рашаан.** Эрдэнэцагаан сумын төвөөс урагш замаар 50 км зайтай 1050 м өндөрт Шархөвийн горхины хойд захад оршино. Сульфид-хлорид натрийн төрөлд багтах рашаан. Ходоод гэдэс доторын өвчнийг анагаахад уудаг. /20, 163/

**14. Жаргалант уул.** 1800 м өндөр уул. Зүүн хойшоо Эрдэнэцагаан сумын урдуур чигтэй үргэлжлэх нуруу. Энд оршдог хилийн застав хашаагаа дан гантигаар барьсан бий. Энэ нь энд ойролцоо гантиг чулууны орд байгаа гэсэн үг.

**15. Шилийн Богд, Талын агуйн** ба Дарьгангын галт уулсын тухай 33-р чиглэлийн замаас үз.



**16. Ламтын хөрөг.** Ламтын заставын дэргэд нарийн ширхэгт боржин чулуу, хээрийн жоншоор бүтээсэн 2 хүн чулуу байна. Нарийн ширхэгт боржин чулуун хүнийг инэвхийлж байгаа байдлаар таньдаг хүн бол тэр байна гэж хэлэхээр маш уран бүтээжээ. /6.107/

**17. Хөргийн Хөндий.** Хойшоо урагшаадуу намхан ухаад орших жижиг хөндий хотгор, Энд хүрмэн чулуун 6, боржин чулуун 1, хүн хөшөө чулуу бий. Хүн чулуунуудыг эр хүнийг нүцгэн байдлаар буюу эсвэл бэлэг эрхтэнийг нь унжуулан бүтээсэн байдаг энэ дурсгалыг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /6.126/

**18. Бичигтийн Хясаа.** Хүрмэн чулууны доорх хөндий зөрөгт хөдөлгөөнөөр цөмөрснөөс үүссэн хясаа 10 гаруй метр өндөр, 300-аад м урт хүрмэн хадан хясаа. Энэ хясааны чулуун дээр бичиг байдаг учраас бичигтийн хясаа гэдэг. Шуурганд уруудсан мал унаж үхэх нь их байдаг бөгөөд зээрийг энэ хясаа руу шахаж унаган агнадаг байсан гэдэг.

**19. Ганга нуур.** II бүлгийн 33-д үз

**20. Алтан-Овоо.** 33 дугаар чиглэлээс үз.

**21. Бударын чулуу.** Сүхбаатар аймгийн Онгон сумын нутгийн урд захад улсын хилийн дагуу з. у 112 градус 45 минут х.ө 45 градус орчмын солбицлоор төв хийсэн хааш хаашаа 15 орчим км үргэлжилсэн эртний төрмөлийн эриний улаан хүрэн боржин чулуун цохионуудын бөөгнөрөл. Цохионуудын өндөр 10 метр хүрэх бөгөөд олон зуун сая жилийн дотор нар салхи усны үйл ажиллагаанд элэгдэн



мөлгөр болж давхраатан цуурч хагарсан, нүх сүв, сэнж олонтой гарсан ажээ. Бударын чулуунд хүрмэн чулууны хэлтэрхий тохиолдож байгаа нь энд хаа нэгтээ унтарсан галт уул байгаагийн гэрч болох юм. Энд хар сүүлтий, хар чоно зэрэг ховор ан амьтадтайгаас гадна хадны сүг зураг, булш нилээд байдаг ажээ. Бударын чулуунд Мухар эрэг зэрэг байгалийн сонин сайхан тогтоцтой газар олон бий.

**22. Онгон сумын** нутаг Тавантолгойд 2 ширхэг хүн чулуу, Шивээтэд бас хүн чулуу бий. Эдгээрийг 1998 онд улсын хамгаалалтанд авчээ. Мөн Шартын хад, Хүнтэд хүн чулуу бий. Сүхбаатар аймгийн урд хэсэгт нийт 30-аад хүн чулуу бий. Эдгээр хүн чулуунуудыг занар, боржин, гантиг, хүрмэн чулуу, хээрийн жонш зэрэг чулуугаар бүтээсэн. Гантигаар хийсэн чулуунууд нь хээ угалз, үрчлээ нугалааг маш нарийн гаргасан уран хийцтэй байна/6.118/ Эндээс эрдэмтэн Д.Наваан Чингисийн алтан ургийн эмэгтэй хүний шарил олсон.

**23. Шарбүрд, Хатавчний хавцалын** талаар 33-р чиглэлээс үз.

**24. Түвшинширээ сумын** Дэлгэрхаан ууланд Цагаан Элэгийн хадны зураг, Хүннүгийн үеийн 200 ширхэг булш, Чулуун хороо, Шивээ зэрэг байгууламжууд бий. Үүнийг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /6.148/

**25. Бүрэнцогтын** тухай 34-р чиглэлээс үз

**26. Баянхутаг уулын** тухай 29-р чиглэлээс үз

**Өөр замд шилжих**

**1. Дорнодын замд**

- Сүхбаатар сумаас Матад 121 км
- Эрдэнэцагаан сумаас Матад 124 км

**2. Дорноговийн замд**

- Баяндэлгэрээс Сайншанд 223 км
- Түвшинширээгээс Дэлгэрэх сум 67 км

**3. Хэнтийн замд**

- Мөнххаанаас Өндөрхаан 126 км
  - Бүрэнцогтоос Өндөрхаан 107 км
  - Түвшинширээгээс Галшар сум 80 км
-

## Дорноговь аймаг

**Дорноговь аймаг.** 109.5 мян ам км нутагтай, 51.5 мян



хүн амтай. Аймагийн төв нь манай улсын төмөр замын нэг гол буудал Сайншанд хот х.ө 45 дугаар зэргэдээс урагшхан /I бүлэг МОГ-д үз/ говь тал нутагт д.т.д. 938 м өндөрт

Улаанбаатараас 463 км зайтай оршино. Аймагийн нутаг нь манай орны зүүн өмнө хэсгийн тал говь нутагт орших бөгөөд нутгийн дундаж өндөр 1200 орчим юм. Хамгийн өндөр уул нь Богд уул 1721 м өндөр. Хайлуур жонш, нефть, чулуун нүүрсний баялаг нөөцтэй, Сайншанд хотын агаарын жилийн дундаж температур нь 3.5°C, 1 сарынх -18.4°C, VII сарынх 23.2°C дулаан байдаг. Манай орны хамгийн дулаан нутгийн нэг юм. Жилд 116.0 мм тунадас унана. Агаарын даралт I сард 911.3 гПа, VII сард 898.5 гПа, салхины жилийн дундаж хурд 4.4 м/с, хамгийн их салхтай V сард 5.8 м/с буюу Сайншанд нь манай орны хамгийн их салхитай газрын нэг юм. Аймагийн нутаг том гол мөрд байхгүй. Жижиг нуур горхи, булаг рашаан олон бий. Харин газрын дорхи усны нөөц ихтэй. Говь тал нутагт орших учраас говь хээрийн амьтан ургамал тархжээ.

Дорноговь аймаг 820.0 мян малтай, малын дотор хонь, ямаа олон. Газар тариалан хөгжөөгүй.

**Говьсүмбэр аймаг.** Дорноговь аймгийн нутагт оршдог. Чойр хотыг 1994 оны V сард Сүмбэр, Баянтал, Шивээговь гэсэн сумтай Говьсүмбэр аймаг болгон өргөтгөн зохион байгуулав. Говь-Сүмбэр аймаг 5.54 мян ам км нутагтай, 12.40 мян хүн амтай, 79 мян малтай. Жилийн дундаж температур нь +0.3ос, Салхины жилийн дундаж хурд 3.2 м/с, жилд 200 мм чийг унана. Чойр хот нь д.т.д 1200 м өндөрт оршино. Манай төмөр замын боомт бөгөөд Чойр хотын орчимд нүүрсний уурхай бий. Энд орших Чойрын хийдийн туурь, Зураагийн зүүн өвөрт орших хүн чулууг 1998 онд улсын хамгаалалтад авчээ.



Дорноговь аймгийн сум хоорондын зай (км)

																			Улаанбаатар															
																			Сайншанд	463														
																			Саймандулан	97	478													
																			Мандах	73	170	457												
																			Алтанширээ	254	181	84	445											
																			Иххэт	88	332	246	162	345										
																			Хөвсгөл	323	245	160	190	161	624									
																			Хатанбулаг	69	392	314	180	260	230	693								
																			Улаанбадрах	159	90	295	217	253	211	133	596							
																			Өргөн	147	306	237	223	145	231	158	61	524						
																			Эрдэнэ	42	105	264	195	265	187	273	200	103	566					
																			Дэлгэрэх	180	198	270	367	298	103	70	307	234	137	448				
																			Хар айраг	176	227	185	257	354	285	100	106	294	173	124	339			
																			Даланжаргалан	25	281	257	210	282	379	310	110	131	319	246	149	394		
																			Сүмбэр /Чойр/	70	101	261	328	286	358	455	386	158	207	237	240	225	238	
																			Замын-Үүд	443	367	342	295	115	157	140	299	230	380	302	388	315	218	681

### **Сайншанд Чойрт очих зам**

1. Галт тэргээр очиж болно
2. Улаанбаатар-Чойр 238 км-Даланжаргалан 76 км-Хар айраг 25 км Сайншанд 124 км, бүгд 463 км.

### **36 дугаар чиглэл**

#### **Улаанбаатар-Дорноговь-Улаанбаатар**

**Зорих гол үзмэр.** Говь нутгийн байгаль, ховор ан амьтан ургамал.

Аймгийн төв Сайншандад Улаанбаатараас галт тэргээр/11 цаг/ очно. Сайншандаас баруун, зүүн гэсэн 2 чиглэлээр аялж болно.

#### **Аялах зам.**

**Баруун чиглэл.** Сайншанд-урагшаа Хамрын хийд 20 км-Зүүнбаян 30 км-зүүн урагшаа Бүрдэнэ булаг 90 км-баруун урагшаа Улаанбадрах сум 105 км-Хөвсгөл сум 90 км-Хатанбулаг сум 69 км-баруун хойшоо Эргэлийн зоо 30 км-Сүйхэнтийн чулуужсан ой 60 км-Цагаанцав 36 км-агнуурын нөөц газрыг дамжин зүүн хойшоо Мандах сум 65 км-Сайхандулаан сум 75 км-зүүн тийшээ Сайншанд 97 км.

Замын урт 830 км, хугацаа 6-7 хоног

#### **Үзэх гол зүйлийн товч тайлбар:**

**1. Хамрын хийд.** XIX зууны үеийн монголын их яруу найрагч ноён хутагт Данзанравжаа"Саран хөхөө" жүжгээ 1830-аад оны үед тоглуулж байсан хийд. Энэ хийдийг 1930-аад оны эцсээр тараан бусниулахад Данзанравжаагийн шавь тахилч Түдэв хийдийн ном судар бурхан тахил бүх юмыг олон арван авдар саванд хийж чаддаг нуун хадгалж үр хүүхдэдээ залгамжлуулан хадгалуулсаар 1990 онд хийдийг сэргээхэд гарган өгчээ. Ингэж дахин сэргэсэн хийд юм. /6.266/

**2. Зүүнбаян.** 1950-аад онд нефть олборлож байсан газар. Одоо дахин олборлохоор бэлтгэж, үйлдвэр барьж байна.

**3. Бүрдэнэ булагт.** Гөлөөн Манхан элсний сонин тогтоц үзнэ. Энд элс зундаа их халдаг учир халуун элсэнд суулгаж хүний мэдрэл, бөөр зэрэг эрхтний эмгэгийг эмнэдэг элсний сувилалыг 1980 оноос ажиллуулж байна.

**4. Эрдэнэ сумын** нутаг Дулааны говьд шинэ чулуун зэвсгийн дурсгал бий. (6.11)

**5. Багабогд уул.** Улаанбадрах сумын төв хавьд Багабогд ууланд эртний бичээстэй бичигт хад, үүнээс зүүн тийш Еншеевт овооны хөшөө бий. Хөвсгөл сумын төв орчимд тооройн төгөл. Гуа тээг зэрэг сонин сайхан газар бий. Хатанбулаг сумын нутагт Бичигт хад, Шивээн булаг, Хутаг уул зэрэг үзэсгэлэнтэй газар бий.

**6. Говийн Бага дархан газрыг** II бүлгийн 11-ээс үз.

**7. Эргэлийн зоо** II бүлгийн 38-г үз *43.-2 үз.*

**8. Сүйхэнт** II бүлгийн 54-ийг үз

**9. Ашиг Хоргын чулуу.** Мандах сумын төв хавьд орших их боржин чулуун хад цохио. Энэ чулуу цохио нь Монголын их боржингийн бүсэнд багтах чулуу юм. Монголын их боржингийн бүсийн тухай Сүхбаатар аймгийн аялах замд /34-р/ дурьдсан.

**10. Сайхандулаан сумын** төвөөс баруун хойш холгүй загийн шугуй бий.

**11. Загийн усны** тухай II бүлгийн 45-аас үз.

**12. Замын үүд.** Хятад улс руу гарах хилийн байнгын боомт.

**Өөр замд шилжих.**

**1. Өмнөговийн замд**

- Хатанбулагаас Ханбогд сум 160 км

- Мандахаас Манлай сум 122 км



**Баянхонгор аймаг**

**Баянхонгор аймаг.** 116 мян орчим ам км нутагтай. 85.7 мян хүн амтай. Аймгийн төв Баянхонгор хот нь Номгон уулын ард Түйн голын хөвөөнд д.т.д. 1859 м өндөрт Улаанбаатараас 630 км зайтай оршино. Баянхонгор аймаг нь

манай орны баруун өмнөд хэсэгт Хангайн нурууны өвөрт, Говь-Алтай уулс, Алтайн ар өвөрийн говийг хамарсан говь хангай хосолсон нутагтай. Нутгийн хамгийн өндөр цэг нь Говь-Алтайн нурууны оргил 3957 м өндөр Ихбогд уул юм. Баянхонгор хотын агаарын жилийн дундаж температур нь  $-0.5^{\circ}\text{C}$ , 1 сарынх  $-18.4^{\circ}\text{C}$ , ҮII сарынх  $15^{\circ}\text{C}$ , жилд 206.7 мм тунадас буудаг Агаарын даралт мөн саруудад адилавтар 810 орчим гПа байна. Салхины жилийн дундаж хурд 2.9 м/с, хамгийн их салхитай V сард 3.9 м/с хүрнэ.

Аймгийн нутагт Түй, Байдраг, Таац зэрэг том гол, Бөөнцагаан, Орог зэрэг том нуурууд. Шаргалжуут зэрэг олон рашаан бий. Аймгийн нутгийн хойд хэсэг ой хөвчтэй, ховор ургамал ургадаг бөгөөд аймгийн нутаг нь манай орны байгалийн 3 бүсэнд оршдог учир тэнд амьдардаг амьтадтай.

Баянхонгор аймаг 860 мян малтай. Малын дотор хонь, ямаа олонтой. Ямаа /1, 3 сая/ хамгийн олонтой аймаг. Газар тариалан бараг хөгжөөгүй, говийн баянбүрдэд дулаан шаарддаг ургамал тарьж ургуулах боломжтой.

**Баянхонгорт очих зам**

**1. Улаанбаатар-Арвайхээр** 430 км-Нарийн тээл сум 135 км-Өлзийт сум 48 км-Баянхонгор 17 км, бүгд 630 км.

**38 дугаар чиглэл**

**Баянхонгор аймгийн урд чиглэл**

**Зорих гол үзмэр.**

**Урд чиглэлд.** Говийн байгаль, Их богд уул, газар хөдлөлийн хагархай, Эхийн голын баянбүрд ховор амьтан ургамал

**Аялах зам.** Баянхонгор-Түйн голыг гаталж зүүн тийш Шаргалжуут голыг өгсөж Шаргалжуут 58 км-баруун урагшаа Өлзийт сум 50 км-Жинст сум 90 км-Холбоолж нуур 20 км-Богд сум 20 км-Орог нуур 20 км-урагшаа уул давж Цагаан хаалгаар гарч Баянлиг сум 95 км-баруун тийшээ Шинэжинст сум 164 км-урагшаа Эхийн гол 176 км-буцаад Шинэжинст сум 175 км-Баян-Өндөр сумаар дамжин-Баянцагаан сум 130 км-хойшоо Бөөнцагаан нуур 80 км-Баацагаан сум 25 км-Нарийн голыг гатлан Баянхонгор 143 км.

Замын урт 1270 км, хугацаа 7-8 хоног.


**Шаргалжуутаас** Угалзын голыг өгсөж даван Хүрэмтийн голыг уруудаж Эрдэнэцогт сумын төвд 45 км очиж болно.

**Үзэх гол зүйлийн товч тайлбар:**

**1. Шаргалжуутын рашаан.** Аймгийн төвөөс зүүн тийш /Эрэнэцогт сумын нутаг/ өндөр уулын бачуу аманд д.т.д 1492 м өндөрт Шаргалжуут голын эрэгт 2 га гаруй талбай эзлэн орших бүгд 100 гаруй халуун булаг рашаан. Усны халуун +90°C хүрнэ. Рашааны халуун уур хөөрөөд жилийн аль ч улиралд уур манан савссан, эхүүн үнэр үнэртсэн нэн сонин орчин үүсгэнэ. Хэвтэж байгаа томоон үхрийн хиртэй нэгэн хадны хоёр талаас гарах усны нэг нь хав халуун байхад нөгөө нь цэл хүйтэн байдаг нь бас хачирхам. Гидрокарбонат-карбонат-сульфат, натри, нүүрсустөрөгчтэй энэ рашааныг тахир дутуу үе мөч, бөөр нуруу, мэдрэл арьсны болон умайн өвчнийг анагаахад ашигладаг. Энд амралт сувиллын газар ажилладаг. Монголын нэртэй сайн рашааны нэг. /20.388/

**2. Шаргалжуутаас** баруун хойш орших Дарагт модон салаа ууланд Дэлхийн хойд хагасын цэвдэгийн урд зах оршдог. /I бүлгийн МОГ-д үз/

### Баянхонгор аймгийн нутгийн зураг



Масштаб: 1 см-т 42 км



**3. Түйн гол.** Хангайн гол нуруунаас эх авч урагшаа 243 км урсан Орог нуурт цутгадаг гол.

**4. Түйн хийдийн балгас.** Түйн гол Шаргалжуут гол хоёрын билчээрт орших чулуун хийдийн балгас. XVI зууны үеийн Монголчуудын барьсан чулуун хийдийн нэг. Түйн голоос суваг татаж энэ хийдэд хиймэл нуур байгуулж байсан.

**5. Уранхайрхан уулын орчимд.** Өлзийт, Баацагаан, Баян-Овоо сумдын нутгийн заагт Нарийн голын хөндийд орших энэ ууланд хуучин чулуун зэвсгийн том дарханы газар ажиллаж байв. Эндээс олон зуун чулуун зэвсэг олджээ. Уранхайрхан уулын олбор нь Манай нутгаас олдсон чулуун зэвсгийн эртний олборын нэг юм. Энэ дурсгалыг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /6.19/

**6. Холбоолж нуур.** Түйн голоос зүүн тийш ойрхон, Жинст сумаас зүүн урагш 20 км-т орших улаан давст нуур. Энд усны шувууд их байдаг ба эртний амьтдын яс олддог.

**7. Богд сумын** нутагт "Алтан говь" жуулчны бааз ажилладаг.

**8. Орог нуур.** Х.ө 45 дугаар зэргэдээс хойшхино Богд сумын нутагт Их элсний захад д.т.д 1198 м өндөрт оршдог 140 ам км талбайтай нуур гадагш урсгалгүй мөртлөө загас элбэгтэй. Зарим гантай жил их ширгэж ус нь багасдаг. Эргэн тойрон орчин элсэнд нь эмийн ургамал чихэр өвс их ургана. Орог нуурын урд талд орших Дулаанбогд болон Ихбогд ууланд аргаль, янгир элбэг бий. Орог нуурт борцгор хотон, хуруут хун, хээрийн галуу, хошуу галуу, хурган тутгалжин зэрэг ховор жигүүртэн шувууд цуглардаг. Алтайн шар загас бий. Рамсарын конвенцийн жагсаалтад орсон. ОУ-ын байгаль хамгаалал гарчигт үз.

**9. Ихбогд уул.** Говь-Алтайн нурууны оргил 3957 м өндөр, 1957 онд энэ ууланд газар 11 баллын хүчтэй хөдөлж араар нь их хагархай үүсэж олон ам жалга дарагдаж, бас булаг горхи их гарсан.

**10. Цагаан хаалга.** Ихбогдын зүүн доогуур урагшаа нэвтрэх “хаалга”.

**11. Цагаан агуй.** Баянлиг сумын нутаг Цахир ууланд орших 40 гаруй м урт энэ агуйд одоогоос 700 мян жилийн өмнө хүн орогнон амьдарч байсан ул мөр олджээ. Энэ бол одоогоор монголоос олдоод байгаа хамгийн эртний хүний буурь юм. Хүн Төв Азид үүссэн гэж үздэг эрдэмтдийн таамаглалыг батлаж байж магадгүй. Баянлиг сумын Ихбаян уулын Бичигтийн аманд сүг зурагтай хад бий. Энэ дурсгалыг хүрлийн үед холбогдох дурсгал гэж үздэг. Эдгээрийг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /6.20/

Энэ Цагаан агуйгаас баруун урагш Баян-Өндөр сумын нутагт орших Чихэн Хөөвөр гэдэг ууланд орших жижиг агуйнаас эртний чулуун зэвсгийн үеийн дурсгал үлэмж ихийг олсон нь бас сонин юм. /6.23/

**12. Цагаан Хаалга.** Говь-Алтайн нурууг урагш нэвтрэн гарах хадан хавцал. Шинэжинст сумын төвөөс урагш гарахад тохиолдоно.

**13. Зуунмодны баянбүрд.** Шинэжинст сумаас хөдөлж Цагаан хаалгаар урагш нэвтрэн гарахад Алтайн өвөр говь нүд алдам цэнхэртэн хөхрөн харагдана. Энэ замд Жартын хөв, Далтын хөв, Зуунмодны баянбүрд зэрэг үзэсгэлэнтэй сайхан тал говь нутгаар явна. Зуунмодны баянбүрд нь их





**19. Бөөнцагаан нуур.** Хангайн өвөр, Говь-Алтайн уулсын хоорондох Бага нууруудын хөндийд д.т.д. 1326 м өндөрт орших 5 нуурын хамгийн том нь 240 ам км талбайтай. 1957 оны газар хөдлөлөөс хойш талбай нь үлэмж нэмэгджээ. Энэ нууранд МУН-д орсон гангар хун, хуруут хүн, хушуу галуу, хээрийн галуу зэрэг ховор жигүүртэн шувууд бий. Алтайн шар загас бий. Рамсарын конвенцийн жагсаалтад орсон. ОУ-ын байгаль хамгаалал гарчигт үз.

**20. Баацагаан суманд** ирж төрийн шагналт зохиолч Ч.Лхамсүрэн гуайн гэр музейг үзнэ.

**21. Адгийн Цагаан нуур.** Бөөнцагаан нуураас зүүн тийш орших нуур Байдраг голын адгийн зүүн салаа Цагаан гол, Адгийн Цагаан нуурт ирнэ. Хангайн сүүлчийн мөстлөг хайлах /одоогоос 100 орчим мянган жилийн урд/ үед Хангайгаас урсах голууд олширч ус ихтэй байсан үед Адгийн Цагаан нуур, Бөөнцагаан, Орог, Хаяа нуурууд, их томорч байснаа мөстлөг хайлж дууссаны дараа голуудын ус татрах үед энэ нууруудын ус татарч эхэлсэн. Адгийн Цагаан нуурт ус их байх үед байсан хуучин дэнжүүд Өнөөгийн нуурын түвшингээс их дээгүүр маш тод харагддаг. Рамсарын конвенцийн жагсаалтад орсон.

**Өөр замд шилжих.**

**1. Өмнөговь аймагт** шилжих замыг 26-р чиглэлээс үз

**2. Өвөрхангайд** шилжих замыг 17-р чиглэлээс үз

**3. Говь –Алтай аймагт**

- Баян-Өндөрөөс Эрдэнэ сум 90 км
- Баянцагаанаас Чандмань сум 105 км
- Бууцагаанаас Дэлгэр сум 110 км
- Баян-Өндөрөөс Захуй /Баянторой/ 210 км

**39 дүгээр чиглэл**

**Баянхонгор аймаг дотор**

**Хойд чиглэл.** Монгол орны хангай нутаг ой хөвч,

---

ус гол горхи, өмнөд хэсэгт говь нутаг, тал хээр нутаг, Баянхонгорт онгоцоор очно. /1 цаг 30 мин/ Баянхонгороос цааш машинаар аялана.

**Аялах зам.** Баянхонгор-баруун хойшоо Баян-Овоо сум 28 км-Сүмбэр, Харгана голуудыг гаталж Галуут сум 61 км-Галуутын хавцал 20 км-Галуут сум 20 км-Ямаатын Дөрөлж давж Цагаантуруу, Буянт, Артээлийн голуудыг гаталж Хагийн Дөрөлжөөр давж Байдраг сум/Байдраг гол/ 80 км-Заг голыг/Заг сум/ гаталж Хөндийн давааг давж Шар Усны голыг уруудаж Гурванбулаг сум 50 км-Хар Усны голыг өгсөж Хөх нуур 30 км-Гурванбулаг сум 30 км-Баянбулаг сум 75 км-Хүрээмарал сум 50 км-Бууцагаан сум 44 км-Цагаан гол, Байдраг голыг гаталж Бөмбөгөр сум 79 км-Нарийн голыг гаталж Баянхонгор хот 95 км.

Замын урт 670 км, хугацаа 4-5 хоног

Энд Баян-Овоо, -Олон нуурын хөндий Арьхадын булан 50 км-буцаж тойроод Галуут сум 60 км гэсэн нэмэлт зам байж болно. Тэгвэл замын нийт урт 730 км болно.

### Үзэх гол зүйлийн товч тайлбар:

**1. Олон нуурын хөндий.** Галуут сумын нутагт Сүмбэрийн голын хөндийд орших/Олгой зэрэг/ олон нуур, Арьхадын булан гэдэг газар бий. Энэ хавийн нуурууд нь хавар намрын цагт нүүдлийн шувуудын чуулга болдог маш баян сайхан нутаг юм. Энд Үүдийн нуур гэж хлор, сульфат натритай шавартай сайн рашаан бий. Үе мөчний өвчин анагаадаг.

**2. Галуутын хавцал.** Галуут сумын төвөөс баруун тийш 20 орчим км-т оршино. Олгой нуураас Галуут гол хойшоо урсан гарахдаа 2 км орчим урт энэ хавцлыг үүсгэжээ. Хавцал нь 100-150 орчим метр гүнзгий эгц цавчим бөгөөд өргөн нь дундажаар 10 метр, хамгийн нарийн газартаа 1 метр орчим болно. Ийм давчуу хавцлаар энэ гол хахан цацан эрчлэн хуйлран урсан өнгөрөх хүч омгийг төсөөлөн хэлэх аргагүй. Энэ хавцлын эгц хажууны хад чулуунд үүссэн ялимгүй тавцангууд дээр хаврын цагт галуу зэрэг

- Гурванбулагаас Отгон сум 100 км

#### **40 дүгээр чиглэл**

#### **Баянхонгор аймаг дотор богино зам**

**А. Баянхонгор** Эрдэнэцогт сум 28 км-Дөш толгой 20 км Хужиртын даваа, Шаргалжуут 45 км-Баянхонгор 58 км гэсэн чиглэл байж болно. Замын урт 180 км. Хугацаа 2-3 өдөр.

**Б. Баянхонгор-Шаргалжуут** 58 км-Эрдэнэцогт 45 км-Өвгөн Жаргалантын зуслан 30 км-Эрдэнэцогт 30 км-Баянхонгор 28 км. Бүгд 200 км. Хугацаа 2-3 хоног

#### **Үзэх гол зүйлийн товч тайлбар:**

**1. Дөш толгой** бол шовгор дүрсээ хадгалан үлдсэн унтарсан галт уул юм. Түүний хайлмал бодис Эрдэнэцогт сумын өнөөгийн төв хүртэл урссан /20 км/ байдаг.

**2. Хачин ламын сүм.** Эрдэнэцогт сумын төв дээр орших сүм. /6.268/

**3. Эрдэнэцогт сумын** Түйн голын зүүн дэнж Шатар чулуу гэдэг газарт буган чулуун хөшөөнүүд, хүн чулуу, булш бүхий цогцолбор дурсгал бий. Үүнийг 1998 онд улсын тусгай хамгаалалтад авчээ. /6, 89/

**4. Шаргалжуутын рашаан.** 38-р чиглэлээс үз

**5. Өвгөнжаргалантын хүүхдийн зуслан.** Түйн голын зүүн гарын цутгал Өвгөнжаргалант голын хөндийн ой модтой үзэсгэлэнт газарт оршдог хүүхдийн амралтын газар зуслан.

#### **Өөр замд шилжих**

##### **1. Архангай замд**

- Эрдэнэцогтоос Түйн голыг өгсөж Хөл

- Саяын дааваагаар давж Архангайн Булган сум 150 км

## Говь-Алтай аймаг



**Говь-Алтай аймаг.** 141.4 мян ам км нутагтай. 64.2 мян

хүн амтай. Аймгийн төв Алтай хот нь Алтайн нуруунд д.т.д.

2181 м өндөрт Улаанбаатараас 1001 км зайтай оршино.

Говь-Алтай аймгийн нутгийн дундуур Монгол Алтайн нуруу

өнгөрдөг. Сутай, Хар Азарга, Бурханбуудай, Хасагтхайрхан зэрэг 3000-4000 м өндөр том уул нуруудтай. Алтай хотод агаарын жилийн дундаж температур нь  $-1.5^{\circ}\text{C}$ , 1 сарынх  $-18.9^{\circ}\text{C}$ , ҮII сарынх  $14^{\circ}\text{C}$ , жилд 171.2 мм тунадас унана. Агаарын даралт 1 ба ҮII сард 780 орчим гПа байна. Салхины жилийн дундаж хурд нь 3.4 м/с бөгөөд хамгийн их салхтай Ү сард 4, 4 м/с хурдтай. Нутгийн хойд захаар Завхан гол урсана. Нутгийн үлэмж хэсгийг говь цөл эзлэнэ. Энд Монголын улаан номонд орсон ургамал амьтад олон бий.

Говь-Алтай аймаг 1.0 сая малтай, малын дотор хонь ямаа олон. Ямааны тоогоор улсад I орно. (880 мян) Тэмээний тоогоор хоёрдугаарт ордог. Газар тариалан бараг хөгжөөгүй, харин зарим баянбүрдэд хөвөн зэрэг ургамал тарьж ургуулах оролдлого хийж байгаа.

### Алтай хотод очих зам

**1. Улаанбаатар Баянхонгор** 630 км-Бөмбөгөр сум 95 км-Бууцагаан сум 79 км-Дэлгэр сум 120 км-Алтай хот 88 км,

Бүгд 1001 км. Алтай хотын ойролцоо "Алтай" гэдэг жуулчны баз бий. Хятад улс руу 1992 онд байгуулагдсан Бургастайн түр боомтоор гарч болно.

### 41 дүгээр чиглэл

#### Улаанбаатар-Говь-Алтай-Улаанбаатар

**Зорих гол үзмэр.** Монгол Алтайн их уулс, Монголын алдарт говь, цөл нутаг, тэдгээрийн ховор амьтан ургамал Улаанбаатараас Алтай хотод онгоцоор /2 цаг гаруй/ очиж цаашаа машинаар аялана.

## Говь-Алтай аймаг

**Говь-Алтай аймаг.** 141.4 мян ам км нутагтай. 64.2 мян



хүн амтай. Аймагийн төв Алтай хот нь Алтайн нуруунд д.т.д. 2181 м өндөрт Улаанбаатараас 1001 км зайтай оршино. Говь-Алтай аймгийн нутгийн дундуур Монгол Алтайн нуруу

өнгөрдөг. Сутай, Хар Азарга, Бурханбуудай, Хасагтхайрхан зэрэг 3000-4000 м өндөр том уул нуруудтай. Алтай хотод агаарын жилийн дундаж температур нь  $-1.5^{\circ}\text{C}$ , 1 сарынх  $-18.9^{\circ}\text{C}$ , VII сарынх  $14^{\circ}\text{C}$ , жилд 171.2 мм тунадас унана. Агаарын даралт 1 ба VII сард 780 орчим гПа байна. Салхины жилийн дундаж хурд нь 3.4 м/с бөгөөд хамгийн их салхтай V сард 4, 4 м/с хурдтай. Нутгийн хойд захаар Завхан гол урсана. Нутгийн үлэмж хэсгийг говь цөл эзлэнэ. Энд Монголын улаан номонд орсон ургамал амьтад олон бий.

Говь-Алтай аймаг 1.0 сая малтай, малын дотор хонь ямаа олон. Ямааны тоогоор улсад I орно. (880 мян) Тэмээний тоогоор хоёрдугаарт ордог. Газар тариалан бараг хөгжөөгүй, харин зарим баянбүрдэд хөвөн зэрэг ургамал тарьж ургуулах оролдлого хийж байгаа.

### Алтай хотод очих зам

**1. Улаанбаатар Баянхонгор** 630 км-Бөмбөгөр сум 95 км-Бууцагаан сум 79 км-Дэлгэр сум 120 км-Алтай хот 88 км,


Бүгд 1001 км. Алтай хотын ойролцоо "Алтай" гэдэг жуулчны баз бий. Хятад улс руу 1992 онд байгуулагдсан Бургастайн түр боомтоор гарч болно.

### 41 дүгээр чиглэл

#### Улаанбаатар-Говь-Алтай-Улаанбаатар

**Зорих гол үзмэр.** Монгол Алтайн их уулс, Монголын алдарт говь, цөл нутаг, тэдгээрийн ховор амьтан ургамал Улаанбаатараас Алтай хотод онгоцоор /2 цаг гаруй/ очиж цаашаа машинаар аялана.

Говь-Алтай аймгийн нутгийн зураг



Масштаб: 1 см-т 48 км





## 7. Ээжхайрхан II бүлгийн 51-ийг үз

**8. Захуйн баянбүрд.** Монгол Алтайн нурууны өвөрт орших говь нутгийн дундах тоорой, заг зэрэг говийн ургамалтай нэрд гарсан баянбүрд юм. Захуйн зүүн залгаанд Зармангийн баянбүрд оршино. Энэ хоёрыг нийлүүлээд Захуй Зармангийн говь гэж нэрлэдэг. Захуйн баянбүрдэд орших сууринг сүүлийн үед Баянтоорой гэж нэрлэдэг болж байна. Энд мазаалайтай тааралдаж магадгүй. Захуйн баянбүрдэд “Жуулчин Алтай” гэдэг жуулчны бааз ажилладаг байсан. Эндээс Говийн их дархан цаазат газарт очиж болно.

**9. Бурханбуудай уул.** Цогт сумаас Бигэрийн хонхор руу орох замд замын зүүн гарт орших том нуруу. Монгол Алтайн гол нурууны хэсэг. Улсын тусгай хамгаалалттай нуруу. II бүлгийн 42-г үз.

**10. Бигэрийн хонхор.** Цогтоос Тахилтын голоор өгсөж Дөтийн даваагаар давж Бигэрийн хонхорт орно. Энд Бигэр сум оршдог. Энэ сумын нутагт Бичигтийн бууц гэдэг газарт орших түрэг бичээс, сүг зураг бүхий хадыг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. Монгол Алтайн нурууны хооронд орших энэ хонхорт Бигэр нуур, баянбүрд бий. Энд ховор амьтан ургамал ихтэй бөгөөд Бигэр сумын төвийн ойролцоо Таванманхан гэдэг газарт элсэн шарлагын эмнэлэг ажилладаг.

**11. Бигэрийн хонхорт** орших Наранбулагаас эртний үлэг гүрвэлийн яс олдсон. Говь-Алтайн энэ замд бөхөн, хулан, ууланд нь аргаль, янгир зэрэг ховор амьтад заг, тоорой, жигд сухай, лидэр зэрэг ховор ургамал үзэж болно.

**12. Ихшархөтөлийн даваа.** Ажбогд уул, Хөвчийн нурууны урд салбар нуруу хоёрын хоорондуур давах д.т.д 1725 м өндөр даваа. Энэ даваан дээрээс урагшаа Хятад улсын нутагт 200 гаруй км хол орших Тэнгэр уулын оройн цас цэлмэг өдөр цайран маш тод сайхан харагдана. Эндээс Алтай суманд очно. Энд Хятад улс руу гарах хилийн Бургастай боомт бий.

---

**13. Алаг нуур.** Загтай хонхорт оршдог нуур. Бороо ихтэй үед хойноос нь Гаханчийн гол орж ирнэ.

**14. Бугат сумын** нутагт Алагхайрхан уул оршино. II бүлгийн 36-г үз.

**15. Хятадын Бархөл** хотоос гарч зүүн хойшоо явж Ажбогд уулын баруун ба зүүн доогуур явж Бигэр сум, Захуй хүрсэн хоёр хуучин зам бий. Энэ зам торгон замын нэг салаа байсан байж болох юм. Мөн Хятадын нутаг дахь Миньшуй хотоос Говь-Алтай аймгийн урд захаар орж Баянхонгор, Өмнөговийн нутгаар явсан хуучин зам бий. Энэ бас торгон замын салаа байсан байж болох юм. Энэ тухай 25-р чиглэлд дурьдсан.

#### **Өөр замд шилжих**

##### **1. Ховд аймагт**

Алтай сумаас Алтайн салбар уулс дундуур 300 гаруй км явж Ховд аймгийн Алтай суманд очих зөрөг зам бий.

2. Ээжхайрханаас Говийн их дархан газарт очиж болно.

##### **42 дугаар чиглэл**

**Аялах зам.** Алтай хот-Жаргалантаар давж Бигэр сум 108 км- Цогт сум 80 км-Ээжхайрхан 60 км- Ажбогд уулын зүүгээр тойрч Алтай сум 180 км-Их Шархөтлөөр давж Алаг нуурын хонхорыг дайрч Бугат сум 195 км-Төгрөг сум 55 км-Шарга сум 69 км-Алтай хот 79 км.

Бүгд 830 км, 6-7 хоног.

- Алтай сумаас хилийн түр гарц **Бургастайгаар** Хятад улс руу гарч болно.

#### **Үзэх гол зүйлийн товч тайлбар:**

**1. Алтай хот.** Бигэрийн хонхор, Таванманх, Ээжхайрхан, Алтай сум, Их Шархөтөл, Алаг нуурын хонхор, Шаргын хонхор, Баарангийн давааны тухай 41 дүгээр чиглэлээс үзэж болно.

2. Энэ замаас Говийн их дархан цаазат газарт очиж болно.

### 43 дугаар чиглэл

**Аялах зам А.** Алтай хот-Бигэр сум 108 км-Чандмань сум 81 км-Эрдэнэ сум 34 км-Зармангийн говийн туулж Баянтоорой/Захуй/ 125 км-Цогт сум 63 км-Бигэр сум 78 км-Алтай хот 108 км,

Бүгд 600 км, 3-4 хоног

**Б. Бигэрээс Халиун сум** 95 км-Шарга сум 95 км-Алтай 79 км гэсэн зам байж болно.

**В. Алтай хот-Дэлгэр сум** 88 км-Чандмань 130 км гээд цааш "А" замд шилжиж болно.

**1. Үзэх гол зүйлийн товч тайлбарыг** 41 дүгээр чиглэлээс үз.

**2. Бигэр сумын** нутаг Бичигтийн бууц гэдэг газар орших Түрэг бичээс сүг зураг бүхий хад. Цогт сумын төвийн дэргэд орших Хиргист хоолойн булшнууд зэрэг түүх соёлын дурсгалыг 1998 онд улсын хамгаалалтад авчээ.

### 44 дүгээр чиглэл

#### Говь-Алтайн хойд чиглэл

**Аялах зам.** Алтай хот зүүн хойшоо Гуулин 90 км-баруун тийшээ Тайшир сум 69 км-Хасагтхайрхан 45 км-Жаргалан сум 20 км-Баян Уул сум 65 км-Хөхморьт сум 69 км-Алдарт Хүйсийн говиор аялаж Дарвийн нурууг давж Дарви сум 120 км-Тонхил сум 31 км-Төгрөг сум 100 км-Монгол Алтайн нурууг 2500 гаруй м өндөр Мааньтын хөтлөөр давж Бугат сум 55 км-буцаад Төгрөг сум Шаргын говиор дамжиж Алтай хот 203 км.

Замын урт 930 км. Хугацаа 4-5 хоног

/Бугат сумаас Алтай сум орж болно. 195 км/

#### Үзэх гол зүйлийн товч тайлбар:

**1. Гуулингийн усжуулалтын байгууламж.** Завхан голоос ус татаж хадлангийн талбайг усжуулдаг. Гуулинд жижиг усан цахилгаан станц ажилладаг.

---

**2. Тайширын хүрмэн.** Тайшир сумын төвөөс дээш /1 км-т орших/ Завхан голын хойд эрэгт орших Цонж буюу Хомбого толгойн зургаан талт баганан хүрмэн чулуу багцлан боож босгосон багана мэт харагдана.

Мөн түүнээс 1 км орчим зайд сумын төвийн дэргэд Завхан голын урд эрэгт мөн 6 талтай баганан хүрмэн чулуу байна. Энэ хоёр толгойн хүрмэн чулуу босоогоороо байгаа нь 2 м өндөр хүрэх бөгөөд чулууны бүдүүн нарийн нь янз бүр 10-аад см-ээс 50 см хүртэл хэмжээтэй бий. Газарт байгаа хэсэг нь алаг чулуун шал шиг хээтэн харагдана. Ийм хүрмэн Дорноговь аймагт бийг бид 37-р чиглэлд дурдсан.



**3. Завхан гол.** Хангайн нурууны өврөөс эх авч баруун тийш 808 км урсаж Айраг нуурт цутгана. Урсгалын эхний хэсэгт өндөр уулаар мөстлөгийн морена дундуур урсах бөгөөд доод хэсэгтээ их тал говь нутаг, элсэн дундуур урсана. Алтайн шар загас бий.

**4. Завхан голд Тайшир сумын** төвөөс дээш 15 орчим км зайтай орших Улаанбоомд усан цахилгаан станц барих ажилд эхлэх гэж байна. 30-50 м өндөр, 100-200 м орчим метр өргөн улаан буурал боржин чулуун хавцлаар Завхан гол урсаж гарах сонин газар юм.

---

**5. Хасагтхайрхан уул.** II бүлгийн 10-ыг үз.

**6. Монгол элс.** Завхан голын дунд хэсгээс голын адаг хүртэл 330 гаруй км үргэлжилж 2724 ам км талбайг эзлэх элс. Манай орны их талбайтай манхт элсний нэг. Энэ элсний захад орших Хөхморьт сумын төв дээрээс элсний байдалтай сайн танилцаж болно.

7. Энэ элсний захад Жаргалан сумын нутагт Завхан голын хөндийд **Эрээн нуур, Ажиг нуур** гэж цэнгэг үзэсгэлэнт нуур бий. Жаргалант сумын төвөөс Эрээн нуур 60 орчим км зайтай. Энд Элсний захад Ажиг, Дөрөө, Бударгана зэрэг хэд хэдэн үзэсгэлэнт нуурууд бий. Жаргалан сум бол манай алдарт бөх дархан аварга Ш.Батсуурийн төрсөн нутаг. Ажиг эрээн нуур орчим газрыг 2003 онд УТХ-д авах санал бий.

**8. Жаргалан сумын** нутаг Сүмийн дэнжид орших 4 ширхэг хүн чулуутай булш, мөн сумын Тоосготод орших хүн чулуу хоёрыг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /6.117/

**9. Хүйсийн говь.** Хөхморьт сум орох, тэндээс буцах замдаа Монголын алдартай 33 говийн нэг энэ говиор явна. Энэ говь нь Дөргөн нуур, Шаргын говь хоёрын хооронд 150 орчим км урт, 50 орчим км өргөн уудам талбайг эзэлсэн говь, тэгш тал нутаг. Дундаж өндөр нь д.т.д. 1200-1300 м. Ховор амьтан ургамалтай.

**10. Ихэс нуур.** Дарви сумын нутагт оршдог давстай нуур. 20 гаруй ам км талбайтай. Энд ОУУН-д орсон үлдмэл цахлай зунждаг.

**11. Сутай уул.** Тонхил сумын төв дээрээс сайхан тод харагдана. Монгол Алтайн зэрэгцээ уулсын нэг 4090 м өндөр. Мөнх цастай. Энэ уулын мөнх цаснаас эх авсан Зүйлийн гол Тонхил сумын төвийг дайрч урсаад Тонхил нуурт цутгана.

**12. Бугатын хавцал.** Бугат сум орох замд Монгол Алтайн гол нурууг давахад нэвтрэх суудлын машин зөрөхгүй хавцал. Энэ замд Монгол Алтайн уулын ар



өвөрөөр явж энэ том уулыг холоос харж, ойртон давж уулын зам гэдгийг үзнэ. Ховор амьтан ургамалтай тааралдана.

13. Тонхил Бугат сумаас Бижийн голд очиж тахь үзэж болно. Тэнд тахь нутагшуулж байгаа.

### Өөр аймгийн замд шилжих

1. **Баянхонгорын замд** шилжихийг 38 дугаар чиглэлээс үзнэ

2. **Завханы замд** Тайшир сумаас Цагаанчулуут сум 60 км

3. **Ховдын замд**


- Ховдын Дарви сум Алтай хотоос 219 км, Хөхморьт сумаас 90 км

- Ховдын Цэцэг сум Тонхил сумаас 75 км

- Чандмань сум Хөхморьт сумаас 165 км

## Булган аймаг

**Булган аймаг.** 48, 7 мян ам км нутагтай, 63.3 мян хүн амтай. Аймгийн төв Булган хот нь Орхон голын савын Ачуутын голын хөвөөнд д.т.д. 1208 м өндөрт, Улаанбаатараас 318 км зайтай оршино. Булган аймаг нь Орхон Сэлэнгийн сав газарт



улсын нутгийн бараг төв хэсэгт уул тал, ой хээр хосолсон нутгийг эзэлж оршино. Аймгийн нутагт зэс молибден, нүүрсний нөөц бий. Унтарсан галт уулстай. Булган хотын агаарын жилийн дундаж температур нь  $-1.5^{\circ}\text{C}$ , 1 сарынх  $-21.3^{\circ}\text{C}$ , VII сарынх  $16.3^{\circ}\text{C}$ , жилд 327.7 мм буюу манай орны манай орны их тунадас унадаг хотын нэг. Агаарын даралт I ба VII сард 880 орчим гПа, салхины жилийн дундаж хурд 2.1 м/с хамгийн их салхитай V сард 3.0 м/с байдаг. Булган аймгийн нутгаар Орхон, Сэлэнгэ зэрэг том жижиг олон гол горхи урсах бөгөөд голууд нь усны эрчим хүчний нөөц ихтэй. Нуур рашаан булаг их бий. Булган аймагт уул тайгаас, говь хээрийн бүсийн амьтан ургамалыг үзэж болно. Хунт нуур, Хануй, Хөөвөр нуур, Сайханхульж зэрэг сайн рашаан бий.

Булган аймаг 1, 4 сая гаруй малтай, манай адуу олонтой аймгийн нэг, малын дотор хонь, үхэр олон Газар тариалан үлэмж хөгжүүлсэн аймаг юм. Булган хот нь анх 1667 онд Ачуут, Зүүн Түрүүний голыг билчэрт байгуулагдсан Түшээт хан аймгийн Дайчинвангийн хүрээнээс эхтэй юм. Булган хотын ойролцоо "Анаг I" гэдэг жуулчин бааз бий. Булган аймгийн нутагт "Залаат", " Хөгнөговь", " Монгол элс" зэрэг жуулчны баазууд бийг дээр дурьдсан.

Булган аймгийн **Сансар, Гурванбулаг, Дашинчилэн, Баяннуур** сумдын нутгаар аялах зам үзэх зүйлийн тухай материалыг 13-р чиглэлийн замаас үз.

**Мянганы зам:** Лүнгээр дамжин Булган аймгийн Баяннуур - Дашинчилэнгээр явж өнгөрнө.

#### **45 дугаар чиглэл**

#### **Булган хүртэл аялах зам**

**Зорих гол үзмэр.** Монгол орны ойт хээр. Булганы хангай, уул ус, Сэлэнгэ, Орхон гол. УТХ-тай Уран, Тогоо, Тулга уулууд

**Аялах зам А.** Улаанбаатараас 18-р чиглэлийн замаар гарч Харбухын гол 240 км хүрээд цаашаа Бүрэгхангай сум 100 км-Шувуутын голыг уруудаж Орхон гол/Орхон сум/ 58 км-Булган 22 км.

Замын урт 430 км.

**Б. Харбухын гол** 240 км-Хишиг-Өндөр сум 80 км-Булган хот 68 км Бүгд 390 км.

**В. Харбухын гол** 240 км, Могод сум 112 км-Хишиг, Өндөр сум 63 км-Булган хот 68 км.

Бүгд 490 км

**Г. Улаанбаатар Баянцогт** 56 км-Хадын даваа 47 км-Туул гол 102 км-Төлөөжин, Шувуут гол уруудаж Орхон сум 100 км, Булган хот 22 км юм. Замын урт 330 км гэсэн замууд байж болно.

---

Энэ замд үзэх гол зүйлийн товч тайлбар:

**1. Харбухын гол** хүртэлх замд үзэх зүйлийн тайлбарыг 13-р чиглэлийн замаас үз.

**2. Могод сумын** төв дээр Сайханхульжийн рашаан бий. 3 м орчим гүн худаг, Хүхэр хүчлийн найрлагатай 38ос халуун рашаан.

Энэ рашааны хөлд Хар нуур гэдэг нуур орших бөгөөд Хар нуур нь үе мөч, хэрэх өвчин, хуян шар ус зэрэг өвчнийг орж анагаадаг. Сульфат, натрийн найрлагатай рашаан юм. /20. 286/

**3. Могод сумын** төвөөс зүүн тийш 4-5 км-т хойшоо хандсан хөндийд 1967 оны газар хөдлөлөөр үүссэн газрын язархай тод мэдэгдэнэ. Могод сумын нутгийн урд зах хавиар МНТ-д гардаг. Цахир Могод, Наху гүн, Саар хээр гэдэг газрууд бий гэж үздэг. /1. 34/

**4. Могод сумын** нутаг Хөл-Асгат гэдэг газар орших Турэгийн алтан тамган дархны бичигт хөшөөг 1971 онд улсын хамгаалалтад авчээ. /6.125/

**5. Хишиг-Өндөр** сумын нутагт аймгийн хамгаалалтад авсан түүх соёлын дурсгалууд бий

**6. Хишиг-Өндөрөөс** Дашинчилэн гээд Хөгнөхаан ууланд очиж болно. II бүлгийн 32-ыг үз.

**Өөр замд шилжих**

**1. Архангайн замд**

- Дашинчилэнгээс Өгийнуур 106 км

- Могодоос Өлзийт сум 50 сум

**46 дугаар чиглэл**

**Булганаас цааш аялах зам**

**Булганд** онгоцоор очиж болно.

**Хойт чиглэл.** Булган—Ачуутын голыг өгсөж Баруунтуруун Чачиртай голыг гаталж Тээлийн голыг өгсөж Түлүүгийн даваа 52 км-Мэргэний хөтлөөр давж Уран уул



хүн чулууны цогцолборыг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /6.132/


**5. Баян-Агт сумын** нутагт Хануйн голд Хануйн рашаан бий. Элэг, цөс, ходоодны өвчинд ууж, үе мөчний өвчнийг орж эмчилнэ. Гидрокарбонат, хлорид натрийн төрөлд багтана. /20.292/

**6. Уран, Тогоо, Тулга, Жалавч уулууд** /II бүлгийн 52-ыг үз/

**7. Сэлэнгэ мөрөн.** Сэлэнгэ бол Монголын хамгийн том мөрөн Хангайн нуруунаас эх авсан Идэр, Хөвсгөлийн уулсаас эх авсан Дэлгэр мөрөн нийлж Сэлэнгэ нэртэй болно. Сэлэнгэ 992 км урсаж Байгал нуурт цутгах бөгөөд манай улсын нутагт 593 км урсана. Зуны цагт их үерлэдэг. Сэлэнгэ мөрний жилийн урсац нь 9, 3 шоо км буюу манай улсын нийт гол мөрний урсацын 30, 6 хувь болно.

Сэлэнгээр өгсөж гол мөрний жижиг онгоц Булган аймгийн Сэлэнгэ сум хүртэл явж болдог. Орхон, Ерөө, Тамир, Туул зэрэг том голууд Сэлэнгэд цутгадаг.

Сэлэнгэд хилим болон тул, зэвэг, цагаан загас, балиус хадран, цурхай, улаан нүдэн, сибирь сугас, бух заарам, мөнгөлөг хэлтэг, булуу цагаан, цулбуурт, гутгаар, алгана зэрэг загас бий. Сэлэнгэ Орхоны сав газар нь манай орны газар тариалангийн гол нутаг юм.



8. Хутаг-Өндөр сум Хатанбаатар Магсаржавын уугуул нутаг.

**9. Байбулагийн (Байбалык) туурь.** Хутаг-Өндөр сумын баруухантай /10 км-т/ Сэлэнгээс хойш оршино. VIII-X зууны үеийн Уйгар улсын худалдааны төв хот байв. Хожим /1588 онд/ нь Монголчууд хэрмэн дотор нь сүм барьж Бийбулагийн сүм гэж нэрлэж байв. Энэ нь Монголын шарын шашны Эрдэнэзуугийн дараа байгуулагдсан хоёр дахь сүм юм. Байбулаг /бийбулаг/-ийн турийг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /6.176/

**10. Тэшиг суманд** буриад ястан амьдардаг. Энэ сумын нутаг нь ой мод, гол горхи элбэгтэй сайхан нутаг. Эгийн гол нутгаар нь урсдаг. Эгийн гол дээр Сэлэнгэд нийлэхээс нь дээш ойрхон усан цахилгаан станц барих санал бий.

**11. Намнан уул,** II бүлгийн 30-д үз.

**Өөр замд шилжих**

**1. Хөвсгөлийн замд**

- Хутаг-Өндөрөөс Тариалан сум 62 км
- Баян-Агтаас Рашаант сум 63 км

**2. Архангайн замд**

- Сайхан сумаас Хайрхан сум 60 км

**47 дугаар чиглэл**

**Булганы зүүн чиглэл**

**Аялах зам.** Булган-зүүн хойшоо Бугат сум 52 км- хойшоо Хужирын голыг уруудаж Сэлэнгэ мөрөн /Эгийн голын адаг/ 45 км-зүүн тийшээ Сэлэнгэ мөрнөө уруудаж Сэлэнгэ сумыг дайрч Хялгантат 55 км-Зөөхийн голыг өгсөж Эрдэнэт 69 км-Бургалтайн голыг гаталж Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сум 65 км-Зүүн тийшээ Амарбаясгалант хийд 45 км Дархан 160 км-Улаанбаатар 219 км.

Замын урт 670 км, хугацаа 4-5 хоног

---





**8. Төмөр толгой орд.** Дархан хотоос зүүн хойш 25 км-т орших төмрийн хүдрийн нөөц ихтэй орд. Энд ил уурхай барих ажил эхэлжээ.

**9. Дархан-Уул аймгийн Орхон сумын** Цант гэдэг газар эртний хотын туурь оршдог. Үүнийг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /6.195/.

**Дархан-Уул аймгийн орчны зай (км)**

Улаанбаатар									
Дархан									219
Эрдэнэт								180	371
Сүхбаатар							272	92	311
Дархан сум						115	175	23	195
Шарын гол					48	163	223	71	236
Номгон (Сайхан сум)				88	40	137	135	45	177
Хөтөл			13	101	53	150	124	58	249
Жимсний САА	103	90	116	68	69	225	45		264

**10. Тужийн нарс.** Их ойн дундуур одох машины шулуун зам хотын урт гудамж мэт нарийсан нарийссаар “жижиг гэгээвч” болон төгсөнө. Их ойд ява юмаа гэхэд үлэмж гэгээтэй ажээ. Өндөр лүглэгэр нарс моддын цайвар ягаан холтос их ойд гэгээ өгдөг ажээ. Орхон голын хөндийгөөс зүүн тийш Цөх гол хүртэл 40 км. Дулаанхан уул, Арангатын давааны араас бараг Сүхбаатар, Алтанбулаг хот хүртэл 30 гаруй км үргэлжилсэн тал газарт орших туж нарс гэдэг энэ юм. Туж нарс гэдэг нь туждаа, нэлдээ нарс, их ой нь нэг төрлийн мод голлосон туждаа нарс гэсэн утгатай үг ажээ. Манай орны ойд нарс бас их бишээ. 2002 онд УТХ-д авчээ. II бүлгийн 27-г үз.

**11. Шаамараас** хүний өвөгийн эрүү ясны үлдэгдэл олжээ.

**12. Буур гол.** Тужийн нарсны хойд захаар баруун тийшээ 30 км урсаж Орхон голд нийлэх жижиг гол. МНТ-д "Буур хээр" гэж гардаг түүхт нутаг мөн гэж үздэг. Зарим эрдэмтэд "Буур хээр"-ийг хилийн гадна бий гэж үздэг. /1.18/

#### **49 дүгээр чиглэл**

#### **Сүхбаатар хотоос аялж болох зам**

**А. Урагшаа Шаамар** 21 км-Орхон голыг гаталж Зүүнбүрэн сум 27 км-Сэлэнгэ мөрнийг гаталж Цагааннуур сум 39 км-Бүтээлийн нурууг Намын даваагаар давж Зэлтэр сум 42 км-буцаад Зүүнбүрэн 81 км-Сант сум 135 км-Ийвэн (Ээвэн) голыг өгсөж Амарбаясгалант хийд 50 км-Сант сум 50 км-Орхон сум 32 км-Хөтөл 20 км – Салхит 30 км-Баянгол 45 км-Зүүнхараа 31 км-Түнхэл 45 км-Улаанбаатар 165 км. Бүгд 810 км.

**Б. Түнхэлээс-Зүүн хараа** 40 км-Баруунхараа / Баянгол/ 31 км-гээд Дарханаас Сүхбаатар хот орох замд нийлнэ. Түнхэлээс Сүхбаатар хот орох энэ зам 240 км болно.


**В. Түнхэлээс-баруун тийш холгүй эртний Хүннүгийн дурсгалт Ноён уул оршдог.** Тайлбарыг 10 дугаар замаас үз.

**Г. Түнхэлээс** Хэнтийн хөвчийн модны машины замаар явж Асралтхайрхан ууланд ойртож болохыг 4 дүгээр чиглэлд дурдсаныг үз.

#### **Үзэх гол зүйлийн товч тайлбар:**

- 1. Орхон гол.** 13 дугаар чиглэлээс үз
- 2. Сэлэнгэ мөрөн.** 46 дугаар чиглэлээс үз
- 3. Сүхбаатар хот.** I бүлгийн МОГ-оос үз. Сүхбаатар хотын хавиас хуучин чулуун зэвсгийн буюу 40-12000 жилийн өмнөх үеийн дурсгалын зүйл олддог

## Хөвсгөл аймаг



**Хөвсгөл аймаг.** 400.6 мян ам км нутагтай. 120.9 мян хүн амтай. Аймагийн төв Мөрөн хот нь Дэлгэр мөрний хөндийд д.т.д. 1283 өндөрт Улаанбаатараас 671 км зайтай оршино. Аймагийн нутгийн баруун ба зүүн хэсэг нь уулархаг

бөгөөд нутгийн ихэнх хэсгийг ой хөвч эзлэнэ. Фосфоритын их нөөцтэй ордууд бий. Мөрөн хотын агаарын жилийн дундаж температур нь  $-1.8^{\circ}\text{C}$ , I сарынх  $-23.8^{\circ}\text{C}$ , VII сарынх  $16.9^{\circ}\text{C}$ , жилд 232.5 мм тунадас унадаг. Агаарын даралт I ба VII сард 870 орчим гПа байна. Салхины жилийн дундаж хурд 2.0 м/с, хамгийн их салхитай IV сард 3, 3 м/с хурдтай байдаг. Аймагийн нутагт Хөвсгөл, Сангийн Далай, Доод зэрэг том нуур, Сэлэнгэ Эг, Дэлгэр зэрэг том мөрд бий. Ховор амьтан ургамал элбэгтэй.

Хөвсгөл аймаг 1.9 сая малтай, малын дотор хонь, үхэр олон бөгөөд үхрийн тоогоор /236 мян/ улсад тэргүүн байрын нэгийг эзлэнэ. Аймагийн нутгийн зүүн хэсэгт газар тариалан хөгжүүлдэг.

(Энэ аймагт халх, буриад, дархад, цаатан, хотгойд ард түмэн амьдардаг. 2000 оны хүн амын тооллогоор манай улсад дархад ястан 19.000 хүн байв.)

Хилийн боомт **Ханхаар** ОХУ-руу гарч болно.

### 51 дүгээр чиглэл

#### Улаанбаатар –Хөвсгөл–Улаанбаатар

**Зорих гол үзмэр.** (Хөвсгөлийн их ой хөвч, шовх оргилт их уулс, уулын гол горхи, нуур, ховор амьтан, ургамал)

**Хөвсгөлд машинаар очих зам.** Улаанбаатараас Булганд очих 45 дугаар чиглэлийн замаар гарч Булганаас цааш 46-р чиглэлээр Хутаг-Өндөр сум-цаашаа Бийбулагийн балгас Намнан уул, Тээлийн ба Улаантолгойн голыг огтолж Хөвсгөл аймгийн Тариалан

сум 62 км-баруун тийшээ Асгатын/Зүлэгтийн/ голыг огтолж Хөндлөн их уулыг харж Их-Уул сум 45 км-Тосонцэнгэл сум 48 км-Ачмаг нуурын эргээр явж Мөрөн 64 км-буцаад Улаанбаатар 671 км.

Замын урт 1490 км, хугацаа 7-8 хоног

Архангай аймгаар дамжин Хөвсгөлд очих замыг 18-р чиглэлээс үз.

Улаанбаатараас Мөрөнд онгоцоор /1 цаг 30 мин/ очиж болно. Онгоцноос Булганы Уран уулыг харна. Мөрөнгөөс цааш машинаар аялах хэд хэдэн чиглэл байж болно.

### **Аялах зам**

**Урд чиглэл.** Мөрөн-Галтын чиглэл. Мөрөн-урагшаа Цагаанбургасныг даваа 30 км-Бүгсэй голыг гаталж Шинэ-Идэр сум 93 км-Идэр голыг гаталж Галт сум 52 км-Идэр голыг өгсөж Ихжаргалант сум 60 км-Шинэ Идэр сум 44 км-Сангийн Далай нуур 59 км-Мөрөнгийн замд нийлэн Мөрөн 188 км

Замын урт 500 км, хугацаа 3-4 хоног.

**Мөрөн хот хүртэл замд** үзэх гол зүйлийн товч тайлбар.


**1. Бийбулагийн туурийг** үзэж болно. Тайлбарыг 46 дугаар чиглэлээс үз.

**2. Намнангийн нуруу.** Тариалан, Хутаг-Өндөр сумын нутгийн заагаар баруун зүүн тийшээ үргэлжлэх д.т.д 2013 м өндөр нуруу, ой мод гол горхи ихтэй сайхан уул. Энэ уулыг 2003 онд 290 ам км талбайгаар УТХ-д авсан.

II бүлгийн 30-ийг үз.

**3. Хөндлөн Их уул.** Тариалан сумаас Мөрөн орох замд Их уул сумын төвөөс зүүн тийш Сэлэнгэ мөрний зүүн гарын эрэг рүү түрж орон баруун зүүн тийшээ 10-аад км үргэлжлэх энэ уулын оройд хүрмэн чулуулгийн үелсэн давхраас нь ил гарсан нь сонин юм. Уул тогтох

Хөвсгөл аймгийн нутгийн зураг



Масштаб: 1 см-т 24 км





хөдөлгөөнөөр газрын царцдас хагарч зөрөн урд жигүүр нь өмрөн доош сууж хойд жигүүрийнхээ доогуур шурган ороход нөгөө хойд жигүүр нь өргөгдөж огшон энэ уул болжээ. Энэ уулын үүсгэсэн давхраас нь 4-5 үеэс тогтсон бөгөөд урд эгц хажуу нь 200 м орчим өндөр юм. Энэ уулыг бас Одос уул ч гэж нэрлэдэг.

**4. Олон голын билчэр.** Идэр, Дэлгэр, Бүгсэй голууд нийлэх уулзвар. Энэ уулзвараас доош Сэлэнгэ мөрөн болон урсана. Энд Сэлэнгийн савд байдаг хилим зэрэг олон зүйл загастай. Энэ үзэсгэлэнтэй сайхан нутгийг Мөрөн орох замдаа Тосонцэнгэл сумын төвөөс зориуд ирж үзэж болно. Очих буцах замын урт нь 86 км болно.

**5. Мөрөн хотоос** баруун тийш 16 км Дэлгэр мөрний хөндийд. Уушгийн өвөрт хүрлийн үеийн /МЭӨ 3000-1000 жилийн өмнөх/ булшний өнцөгт 15 ширхэг буган чулуун хөшөө бий. Энэ буган чулуун хөшөөг 1998 онд улсын хамгаалалтад 42 га-гаар авчээ. Ер нь Хөвсгөл аймгийн нутагт хадны сүг зураг, бичигт хад, буган хөшөө, дурсгалын зүйл 30 гаруй бий. /6.82/ Мөрөн хотоос баруун тийш ойрхон голын хойд эрэгт нүүрсхүчлийн найрлагатай Алтан Улиасны рашаан бий.

**6. Дэлгэр мөрөн** нь Улаантайга уулаас эх авч 445 км урсаж Идэртэй нийлэн Сэлэнгэ мөрөн болно. Ус ихтэй том мөрөн. Сэлэнгийн савд байдаг загас элбэгтэй.

**7. Урандөш уул.** Мөрөнгөөс Шинэ-Идэр сум орох замд Цагаан бургасны даваанаас урагш Эрчмийн нурууны оргилд тагийн бүсэнд орших д.т.д 2471 м өндөр унтарсан галт уул. Эрчмийн нурууны баруун хэсэгт Эрчмийн Цагаан хот гэж XIII зууны үеийн том хотын туурь бий.

**8. Шинэ Идэр сумын** нутаг Хүнгээ гэдэг газарт найман морь сийлсэн буган хөшөө бий. Энэ сумын нутагт Цохиотын голын бэлчэр, Дөрөлжийн ам, Цохиотын хөндийн Ногоонбулагийн ам гэдэг газар орших / Хүрлийн үеийн болов уу/ Буган чулуун хөшөөнүүдийг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /6.89/

---

**9. Идэрийн гол.** Хангайн нурууны араас эх авч 452 км урсаад Дэлгэр мөрөнтэй нийлж Сэлэнгэ болно. Ус ихтэй олон гол горхи нийлүүлж авдаг гол. Сэлэнгийн савд байдаг загас элбэгтэй.

**10. Жаргалант суманд** монголын хамгийн өндөр хүн /2м 64 см/ өндөр Гонгорт зориулсан жижиг музей бий. Жаргалант сумын төвийн дэргэд Хөнжилийн рашаан гэж сульфат хлорид натрит халуун рашаан бий.

**11. Галт сумын нутаг** Бартад орших 6 ширхэг буган чулуун хөшөө, хиргисүүрийн цогцолборыг 1998 онд улсын хамгаалалтад авчээ.

**12. Сангийн Далай нуур.** Хөвсгөл, Завхан аймгийн нутгийн заагт д.т.д. 1980 м өндөрт орших 166 ам км талбайтай гадагшаа урсгалгүй, давстай том нуур, Сангийн Далай, түүний дэргэдэх Гандан нуур нь хурган тутгалжин зэрэг олон зүйлийн ховор шувууд цуглардаг үзэсгэлэнтэй сайхан нуур. Сангийн Далай, Дэлгэр мөрний хавь нутаг бол Монголын их эх оронч Чингүнжавын уугуул нутаг юм. Арбулаг сумын нутагт XIII зууны үед Мөнх хааны амьдарч байсан ордны туурь бас XVIII зууны үеийн Шадар вангийн овоо, Бүрэнтогтох сумын нутагт Чингүнжавын балгасны туурь бий.

**13. Шавар түрүү.** Сангийн Далай нуурын баруун урд Тэсийн голын эхний өргөн уудам хөндийд орших ой мод байгалийн үзэсгэлэн бүрэлдсэн сайхан нутаг. Энд хөндийн хажуугаар том том шинэс модод лүглийн таруу урсган нь сүртэй үзэсгэлэнтэй харагдана. Эндээс Газрын хагархай эхлэж баруун тийш үргэлжилнэ. 1 бүлгийн б. 6

**14. Цагаанбургаснаас давааг** даваад зүүн тийшээ эргэж 73 км яваад Төмөрбулаг сум орж болно. Эргээд Мөрөн хот 73 км. Бүгд 150 км, хугацаа 1-2 хоног.

Төмөрбулаг сумын нутаг Зуны голд буган чулуун хөшөө, хиргисүүдийг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. (6.77)

**Өөр замд шилжих**

хамгийн том нь бөгөөд 64 ам км талбайтай. Арсай зэрэг олон горхи ирж цутгаад ганц Шишгэд гол эх авч урсана. Энд тул, зэвэг, цагаан загас, сибирь хадран, улаан нүдэн, гутаар зэрэг загас элбэгтэй.

**6. Шишгэд гол.** Доод нуураас эх авч урсана. Дэлхийн том мөрний нэг Енисэй мөрний эх юм. Их устай мөрөн. Их ой хөвчийн дундуур нарийн хөндийгээр урсдаг. Энд Цагаан нуурт байдаг загас элбэг. Шишгэдийн савд Бүрхээрнэгийн Долоон нуур гэдэг үзэсгэлэнт газар бий.

**7. Энэ хавийн нутагт** дархад ястан амьдрах бөгөөд өндөр уулуудад нь монголын цаатан ардын амьдралтай танилцаж болно.

**8. Цагаан нуурын** загасны үйлдвэрийн төвөөс морь, цаагаар зуугаад км явж уулын тагт гарч цаатан ардын суурьд хүрнэ. Мөн энэ хавийн уул гол мөрөнд нэн ховор **халиу** уулсад нь **цөөвөр чоно** амьдардаг. **Вансэмбрүү** зэрэг ховор ургамал ургадаг.

**Ринчинлхүмбэ суманд** "Залаат", Цагаан нуур суманд "Цаатан" гэдэг жуулчны бааз ажилладаг.



#### Өөр замд шилжих

Ринчинлхүмбэ сумаас зүүн тийш Жиглэгээр мориор давж Тойлогт 100 км –Хатгал 40 км-ирж болно.

#### 54 дүгээр чиглэл

#### Хөвсгөл аймгийн зүүн хойд чиглэл

**Аялах зам.** Мөрөн-Ханх-Цагаан -Үүр сумын чиглэл. Мөрөн хойшоо Алаг-Эрдэнэ сум 63 км-Хатгал/Хөвсгөл нуур/ 39 км-/Хатгалаас Ханхад машинаар 170 орчим км явна. Даваа , гол ус ихтэй хэцүү зам. Хатгалаас Ханхад усан ба агаарын онгоцоор очих нь зохимжтой/. Хатгал-Сагсагын даваа 18 км-Алагцарын гол 11 км-Хээгцэр, Овоогийн гол, Хөхөөгийн голуудыг гатлан Чандмань-Өндөр сум 59 км-Ариг голыг уруудаж Халхан, Дархинт,

Баян голуудыг огтолж Цагаан -Үүр сум 51 км. Цагаан -Үүр сум хүртэл. Бүгд 241 км

**Ханх.** ОХУ-руу гарах хилийн байнгын боомт бий.

**Үзэх гол зүйлийн товч тайлбар.**

**1. Хөвсгөл нуур.** II бүлгийн 13-ыг үз.

**2. Чандмань-Өндөрөөс Цагаан-Үүр** орох замд Аригийн голыг уруудаж явна. Аригийн гол нь Бадарын уулаас эх авч зүүн тийш 100 орчим км урсан Үүр голд нийлнэ. Ариг голыг МНТ-д Ариг ус гэж гардаг гол мөн гэж үздэг. Үнэхээр уулын ариг цэнгэг устай гол юм.

**3. Хөвсгөлийн их уулс,** ой тайга, уулын тунгалаг уст гол горхи үзнэ. Хөвсгөлийн энэ нутаг нь тэр аяараа их даваа, бартаа, ой мод уул, ус гол, горхи болсон нутаг болохыг мэдэрнэ. Ховор амьтан урга мал үзэж болно.

**4. Цагаан-Үүр суманд** буриад ястан амьдрах бөгөөд эндээс манай алдарт бөхчүүл дархан аварга Д.Дамдин, Ц.Цэвээнравдан, Ч.Бээжин нар төрсөн юм.

**5. Даяндээрхийн агуй.** Цагаан-Үүр сумын төвөөс зүүн урагш 30-аад км т Үүрийн голын зүүн гарын цутгал Дээрх голын хавцалд оршино. Дунд төрмөлийн эриний шохойн чулуу, занараас тогтсон ууланд орших энэ агуй нь хэд хэдэн тасалгаатай бас хоёр давхар бөгөөд нийт урт нь 30 гаруй метр, хоёрдугаар давхарын тасалгаа нь 24 м урт юм. Нийтдээ 224 м урт хонгилтой юм. Агуйг үүсгэсэн шохойн чулуу нь өгөршиж олон нүх сүв хонхорхой, ан цав, сэнж үүсгэсэн бөгөөд шохойн чулууны дусал нь таазнаасаа унжсан бана, шалан дээрээ бүдүүн, нарийн банацар үүсгэж гялалзан харагдах нь нэн сонин. Агуйнаас зүүн тийш 10-аад км-т Даяндээрхийн хийдийн туурь бий.

**6. Эг-Үүр.** /Эрдэнэбулган сумын төвөөс урагш / Эгийн голын урд эрэг дээр "Далд монгол" ХХ компанийн "Улаан хясаа", "Дани толгой" гэдэг жуулчны бааз бий.

Цагаан-Үүр сумаас Мөрөн ороход 3 зам байж болно.

**А. Ирсэн замаараа буцах.** Ингэвэл Цагаан-Үүрээс Мөрөн. Бүгд 486 км

**Б. Ариг голыг өгсөж** /олон дахин гаталж/ Ёлгосын даваагаар давж Эгийн голыг гүүрээр гаталж Түнэл 160 км-Мөрөн 46 км. Бүгд 450 км

**В. Цагаан-Үүрээс** Үүрийн голыг уруудаж Армаг, Уйлган, Дээрх, Үүр зэрэг олон гол горхийг гатлан Эрдэнэбулган сум 100 км /Бас Цагаан-Үүрээс уулаар 60-аад км явж Эрдэнэбулган сум орж болно/. Эндээс Мөрөн 160 км.

Энэ гурван зам гурвуулаа гол ус, намаг даваа ихтэй хэцүү зам юм. Бүгд 560 км.

Замын урт /Ханх орох замгүйгээр/ бүгд 560 км. Хугацаа 5-6 хоног.

#### **Өөр замд шилжих:**

- Эрдэнэбулганаас урагшаа Тариалан сум 80 км. Эндээс Мөрөнгийн замд, бас Булган Улаанбаатарын замд орж болно.

#### **55 дугаар чиглэл**

**Аялах зам.** Хатгал-Жанхай 30 км-Тойлогт 8 км-гээд Жиглэгийн амны адаг хүртэл нуурын эргээр намаг, ус ихтэй, ой модтой замаар 40 км аялаж цаашаа мориор тэр амаар өгсөж 10-аад км яваад Жиглэгийн даваанд хүрч Арсайн голын савруу орж уруудан 45 км яваад Ринчинлхүмбэ сум орж болно. Тойлогтоос замын урт 100 км, нийт хугацаа 3-4 өдөр. Энэ морин замд нуурын эрэгт Онголог, Бага хар ус, Хар-Усны рашаан, Жиглэгийн ам, Жиглэгийн даваа зэрэгт урцанд хонож, амарч болно. Жиглэгийн адгаас мориор явах 80 км зам шавар намаг ус ихтэй, уул, ам хөндийтэй учир амар биш байх болно.


Хатгал орчимд "Жанхай", "Тойлогт", "Хангарьд", "Доод модот булан", "Хөвсгөл", "Далайн түрлэг", "Байгаль үүд", "Хантайга", "Сахура" зэрэг жуулчны баз ажилладаг.

---



**Завхан аймаг**

**Завхан аймаг.** 82.5 мян ам км нутагтай. 86.8 мян хүн амтай, халхчууд. Аймгийн төв Улиастай хот нь Богд голын хөндийд д.т.д. 1760 м өндөрт Улаанбаатараас 984 км зайтай оршино. Аймгийн нутгийн ихэнхи нь Хангайн



нурууны баруун хэсгийн их уулсад оршино. Хамгийн өндөр цэг нь мөнх цаст 4021 м дархан цаазат их тахилгат Отгонтэнгэр уул юм. Улиастай хотын агаарын жилийн дундаж температур нь  $-2.8^{\circ}\text{C}$ , 1 сарынх  $-23.1^{\circ}\text{C}$ , VII сарынх  $15.4^{\circ}\text{C}$  байдаг. Завхан аймгийн зүүн хойд хэсэг нь манай орны хамгийн хүйтэн нутгийн нэг. 1 сард  $-52^{\circ}\text{C}$  өнгөрч хүйтэрч байсан удаа бий. Жилд 219.1 мм тунадас унадаг. Агаарын даралт нь мөн саруудад 820 орчим гПа байна. Салхины жилийн дундаж хурд 1.7 м/с, хамгийн салхитай V сард 2, 7 м/с хурдтай байдаг. Аймгийн нутгаар Завхан, Тэс, Идэр, Богдын, Хүнгий зэрэг олон гол мөрд урсдаг. Тэлмэн, Ойгон зэрэг том нуурууд бий. Отгонтэнгэр зэрэг олон рашаан бий. Аймгийн нутгийн хойд, зүүн хойд хэсэгт ой хөвч хангай, баруун хэсэг нь говийн байдалтай. Завхан аймаг 1.4 сая гаруй буюу манай орны хамгийн малтай аймгийн нэг. Малын дотор хонь, ямаа олон бөгөөд хонины тоогоор /800 мян гаруй/ улсад тэргүүн байрын нэгийг эзлэнэ. Газар тариалан бага хөгжүүлсэн


Арцсур хилийн түр боомтоор ОХУ-руу гарч болно.

**Улиастайд очих зам.**

**1. Улаанбаатар-Цэцэрлэг** хот 453 км/буюу Батцэнгэл сум 393 км-Ихтамир сум 86 км/ /Ихтамир сум 27 км-Тариат сум 140 км-Солонготын даваа 90 км-Тосонцэнгэл сум 94 км-Тэлмэн сум 59 км-Идэр сум 56 км-Загастайн даваа 39 км-Улиастай 27 км, бүгд 1000 км.

**2. Улаанбаатар-Баянхонгор** 630 км-Бууцагаан сум 162 км-Хүрээмарал сум 44 км-Баянбулаг сум 48 км-

Завхан аймгийн нутгийн зураг



Масштаб: 1 см-т 53 км



Завханы Отгон сум 65 км-Цагаанхайрхан 86 км-Улиастай 44 км, бүгд 1100 км.

**Мянганы зам:** Завхан аймгийн нутгаар Загастайн зүүн эхний даваа Идэр, Яруу, Эрдэнэхайрхан сум, Завхан-Тээлийн голын бэлчэр, Завхан голын гүүрээр өнгөрнө.

### **56 дугаар чиглэл**

#### **Завхан аймагт Отгон сумын чиглэл**

**Зорих гол үзмэр.** Хангайн их уулс, ой хөвч гол мөрөн, нуур, говь нутаг, их элс манх, говь-хангай хосолсон нутаг. Мөн ОУН ба МУН-д орсон ховор амьтан ургамал. Улиастайд онгоцоор очно. /2 цаг/ Улиастай бол Манжийн дарангуйлалын үед тэдний нэг чухал түшиц газар байсан билээ. Улиастайгаас цааш аялах зам.

**Отгонтэнгэрийн чиглэл.** Улиастай-урагшаа Ганцын даваагаар давж Цагаанхайрхан сум 44 км-Ширээгийн гол, Төмөртийн голыг гаталж зүүн урагшаа Отгон сум 86 км-хойшоо Завхан голыг өгсөж Буянт 30 км-баруун хойшоо Бадахундага нуур /Отгонтэнгэр уул/ 30 км-буцаад Оломт нуур 20 км-Алтан элс-Буянт 25 км-Отгон сум 30 км-урагшаа Шилүүстэй сум 68 км-баруун хойшоо -Цагаанчулуут сум 61 км-Цагаанхайрхан сум 58 км-Алдархаан сум 41 км-Улиастай 32 км.

Замын урт 570 км, хугацаа 3-4 хоног

#### **Үзэх гол зүйлийн товч тайлбар:**

**1. Ганцын даваа.** Улиастайгаас Цагаанхайрханд очих замын том даваа

**2. Отгонтэнгэр уул.** Бадархундага нуур 1 бүлгийн 8-ыг үз

**3. Оломт нуур.** Буянт голын эх болох Хангайн нуруунаас эх авсан голууд, эртний мөстлөгийн моренад хаагдаж үүссэн олон нууруудын нэг. Эндэх хаагдаж үүссэн цувраа олон нуурууд нь ногоон туяатай устай сонин харагдана. Урт өргөн нь янз бүр 10-аад км урт 3-4 км өргөн бөгөөд моренон хамрыг зүсэж нарийн хавцал үүсгэн түүгээр урсаж Буянт голд усаа өгдөг нуурууд юм.

**4. Алтан элс.** Буянт багийн төвөөс хойш ойрхон Буянт голын баруун гарын эрэгт уулын энгэрт тогтсон элс. Энэ элсийг нутгийнхан усанд уусгаж ходоод гэдэсний өвчин ангиахад уудаг.

**5. Борхын элс.** Цагаанхайрханаас Алдархаан орох замд орших Ширээгийн голын эргийн элс. Энэ элс Завхан голын савд оршдог уудам талбай эзэлдэг Монгол элсний зүүн зах юм.

**6. Завхан гол ба Монгол элсний тайлбарыг 44 дүгээр чиглэлээс үз.**

**7. Шилүүстэй сумын нутаг** Дааган гэдэг газарт оршин 8 ширхэг буган чулуун хөшөөг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /6.73/

**Өөр замд шилжих**

**1. Говь-Алтайн зам**

- Шилүүстэйгээс Гуулин 50 км

- Цагаанхайрханаас Тайшир 120 км

**57 дугаар чиглэл**

**Отгонтэнгэрийн рашааны чиглэл**

**Зорих гол үзмэр.** Отгонтэнгэрийн рашаан, Завханы өндөр сүрлэг уулс, уулын тунгалаг уст гол горхи, ой модот үзэсгэлэнт байгаль.

**Аялах зам.** Улиастай-Отгонтэнгэрийн рашаан 78 км-Улиастай 78 км-бүгд 160 км, хугацаа 2 өдөр.

**Үзэх гол зүйлийн товч тайлбар:**

**1. Богдын голын усан цахилгаан станц** зуны улиралд ажиллана

**2. Отгонтэнгэрийн рашаан.** Мөнх цаст Отгонтэнгэр уулаас чанх хойш 22 км зайтай, Богдын голын баруун гарын цутгал Рашааны голын хойд хөвөөнд д.т.д 2510 м өндөрт оршино. Рашаанаас урагш Бага Отгонтэнгэр уул холгүй оршино. Рашааны ойролцоо Түмбүү, Гурванхалтар,

Цагаан голын нуруу зэрэг нүцгэн шовх оргилт том уулстай. Орчны энэ уулсаар ховор амьтан ургамалтай. Рашаан нь 54 градус хүртэл халуун 30 гаруй булагтай. Сульфат, гидрокарбонат, натрийн төрөлд багтах найрлагатай. Үе мөчний ужиг өвчин, мэдрэл, зүрх судасны ходоод гэдэс дотрын өвчнийг анагаахад орж, ууж хэрэглэнэ. Энэ рашааныг бүр эртнээс хэрэглэж байсан баримт бий. /20.402/

### **58 дугаар чиглэл**

#### **Говийн чиглэл**

**Аялах зам.** Улиастай-Богдын голыг уруудан Яруугийн голыг гаталж Алдархаан 32 км-Дөрвөлжин сум 122 км-Ургамал сум 126 км-зүүн тийшээ Завханмандал сум 62 км-Эрдэнэхайрхан 52 км-Улиастай хот 115 км.

Замын урт 516 км, хугацаа 3-4 хоног

#### **Үзэх гол зүйлийн товч тайлбар:**

- 1. Аргалантын уул.** Говийн байгаль, элс манх
  - 2. Хомын хоолой.** Дөрвөлжин сумаас 167 км. Энд говийн тэжээлийн таримлын туршилгын станц байсан.
  - 3. Борхярын элс** зэрэг манхт элс, говийн чулуурхаг уулуудыг үзнэ.
  - 4. Алдархаан сумын** нутаг Богдын голын Мөнгөтхясаа гэдэг газарт орших 4 хүний зураг бүхий Түрэг хөшөө чулууг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /6.46/
  - 5. Алдархаан сумын** нутаг Алаг ууланд фосфоритын баялаг ордыг түшиглэн боловсруулах үйлдвэр барьж байна.
  - 6. Эрдэнэхайрхан сумын** нутгийн баруун өмнө хэсэгт 374 м урт Бага агуй, 159 м урт Их агуй, 137 м урт Эхийн агуй зэрэг агуй бий.
  - 7. Ургамал сумаас** Айраг нуур хүрч болно.
-



**Өөр замд шилжих**

- Ургамал сумаас элсний хойд захаар явж Сантмаргац сум  
130 км

**Ховд аймгийн замд**

- Хомын станцаас Дөргөн сум 106 км  
- Ургамал сумаас Дөргөн сум 150 км

**59 дүгээр чиглэл**

**Говь-Хангайн чиглэл**

**Аялах зам.** Улиастай-баруун тийшээ. Эрдэнэхайрхан  
115 км Завханмандал 52 км-Ургамал сум 69 км-Сантмаргац  
сум 127 км-Цэцэн-Уул сум 47 км-Сонгино сум 36 км-  
Түдэвтэй сум 45 км-Нөмрөг сум 44 км-Тосонцэнгэл 107  
км-Их-Уул сум 45 км-буцаад Тосонцэнгэл 45 км-Тэлмэн  
59 км-Идэр голыг өгсөж Загастайгаар даваад Чигистэй  
голыг уруудаж Улиастай 122 км.

Замын урт 930 км, хугацаа 5-6 хоног

**Үзэх гол зүйлийн товч тайлбар:**

**1. Борхярын элс.** Хүнгий голын савд орших манхт  
их элс. 180 км урт, 15 км өргөн, 2500 гаруй ам км  
талбайтай

**2. Баян нуур.** /Мухар Хүнгүйн Хар нуур/ Борхярын  
элсний захад оршдог тогтмол нуур. Мухар Хүнгүй гол  
цутгадаг, харин гадагшаа урсгалгүй мөртлөө цэнгэг нуур.  
Ховор шувууд их цуглардаг.

**3. Холбоо нуур.** Сантмаргац сумын төвийн дэргэд  
оршдог 5 орчим ам.км талбайтай. Хавар, намар, зуны  
цагт ховор жигүүртэн шувууд маш их цуглардаг нуур.

**4. Цэцэн-Уул сумын** нутаг Янживын шилд орших хүн  
чулуунуудыг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /6.135/

**5. Ойгон нуур** нь Хангайн арын өндөрлөг талд орших  
том нуурын нэг 62 ам км талбай эзэлнэ.

6. Энэ нуурын хойгуур ойрхнуур 1905 оны газар  
хөдлөлийн хагархай үргэлжилдэг. 1 бүлгийн МОГ-6-д үз.

**7. Баянзүрхийн рашаан.** Нөмрөг сумын төвөөс зүүн хойш 40 км-т орших хүйтэн рашаан, Ходоод гэдэс, элэг цөсний өвчнийг анагаахад уудаг. Кали, натри, магни, сульфат гидрокарбонатын найрлагатай. Нөмрөг сумаас Тосонцэнгэл орох замаас хойшоо бага зэрэг мурийж энэ рашаанд очиж болно. Баянзүрхийн рашаанаас Холбоо, Бүст нуур руу очиж болно. /20.426/

**8. Тэлмэн нуур.** Хангайн том нуурын нэг. 198 ам км талбайтай. Гадагш урсгалгүй нуур.

**9. Тосонцэнгэл.** Манай ой модны үйлдвэрийн нэг том төв. Идэрийн голын эрэг дээр оршино. Тосонцэнгэл нь манай орны хамгийн хүйтэн нутгийн нэг. Өвлийн цагт -52.9 градус хүрч байсан нь манай хамгийн хүйтэрсэн хэмжээний нэг. Эндээс урагшаа Тээлийн даваагаар даваад 80-аад км-т үзэсгэлэнт газар сульфат- карбонат-натрийн найрлагатай халуун Зарт гэдэг сайхан рашаан бий. /20.419/

**Идэрийн гол.** Хангайн гол нуруунаас эх авч хангай, нутгаар 452 км урсаад Дэлгэр мөрөнтэй нийлж Сэлэнгэ мөрөн болно. Сэлэнгэ мөрний эх гэж үздэг их устай том гол. Олон голуудыг нийлүүлж авдаг. Идэрт Сэлэнгийн савд байдаг загас бий. (51-р чиглэлд дурдсан)

**10. Загастайн даваа.** Хангайн гол нурууг давах нэг даваа. Монгол орны том давааны нэг д.т.д 2500 гаруй м өндөрт оршино.

**11. Тосонцэнгэлээс Улиастайд** буцах замдаа Идэрийн голын хөндий уулуудаар сонирхох газар их бий. Энэ замд Тарвагатайн нурууг үзнэ. (II бүлгийн 22)

**12. Тосонцэнгэлээс Улиастай** орохдоо Загастайн даваагаар давахгүй Яруу сумаар дайрч явж болно. Ингэж явбал Тэлмэн сумаас Яруу сум 112 км-Улиастай 56 км болно.

**13. Яруу сумын** нутаг Яруугийн голын эрэгт орших хүн чулуунууд, Хөшөөтийн амны хүн чулуунуудыг 1998 онд улын хамгаалалтад авчээ. /6.128/

---

### **Энэ замаас салж болох зам**

- Ойгон нуураас хойшоо /Түдэвтэйгээс / Баянхайрхан сум 59 км-Баянтэс сум 44 км-Тэс 54 км сумаар аялах замд нийлж болно. Буцаад замаараа явж Түдэвтэйд ирж болно. Ингэж явбал зам 320 км-ээр нэмэгдэнэ. Баянтэс сумын нутагт Тэсийн голын нэгэн аралд хадтай толгой дээр Тэсийн голын Гандантэгчинлэн хийдийн балгас бий. Энэ нь монголчуудын барьсан чулуун хийдийн нэг юм.

Тэс сумаас хилийн түр гарц Арцсураар ОХУ-руу гарч болно.

### **Өөр замд шилжих**


**1. Хөвсгөлийн замд** шилжихийг 52 дугаар, Архангайн замд шилжихийг 18 дугаар чиглэлүүдээс үзнэ.

### **2. Увсын замд**

- Сонгино сумаас Зүүнхангай сум 57 км
- Тэс сумаас мөн Зүүнхангай 47 км
- Тэс сумаас Баруунтуруун 122 км
- Ургамал сумаас Хяргас нуур хүрэх замд нийлэх 92 км

**3. Баянхонгорын замд** шилжихийг 39 дүгээр чиглэлээс үз

## Ховд аймаг



**Ховд аймаг.** 76, 1 мян ам км нутагтай. 88.7 мян хүн

амтай. Аймагийн төв Ховд хот нь Буянт голын хөндийд д.т.д 1405 м өндөрт Улаанбаатараас 1425 км зайтай оршино. Энд Багшийн дээд сургууль, Хөдөө аж ахуйн дээд сургууль

ажилладаг. Ховд аймаг нь Монгол Алтайн их уулсад оршино. Энд Мөнххайрхан Хөхсэрх, Цамбагарав зэрэг 4000 гаруй метр өндөр уулууд олон бий. Ховд хотын агаарын жилийн дундаж температур нь  $0.3^{\circ}\text{C}$ , 1 сарынх  $-25.4^{\circ}\text{C}$ , VII сарынх  $18.9^{\circ}\text{C}$ , жилд 125.9 мм тунадас унадаг. Агаарын даралт 1 ба VII сард 860 орчим гПа байна. Салхины жилийн дундаж хурд 1.6 м/с, хамгийн их салхитай V сард 2, 8 м/с хурдтай байдаг. Аймагийн нутагт Хар Ус, Хар зэрэг том жижиг олон нуур, Ховд, Буянт, Булган зэрэг олон гол мөрдтэй. Аймагийн нутгийн үлэмж хэсгийг говь цөл эзлэнэ. Энд ховор ургамал амьтад бий.

Ховд аймаг нь 1.3 сая малтай, малын дотор хонь, ямаа олонтой. Олон сумдад хүнсний ногоо, амтат гуа тарьдаг. Булган суманд жимсний станц бий.

### Ховдод очих зам.

**1. Улаанбаатар Алтай хот** 1001 км-Ховдын Дарви сум 200 км-Зэрэг сум 66 км-Ховд 141 км,

Бүгд 1400 км.

**2. Завханаар очиж болно.** Замыг 58-р чиглэлээс үз.

Хятад улс руу Булган сум- Таншихан боомтоор гарна. 1960-аад оноос ажилласан. Мөн байтаг-Улиастай боомт бий. 1992 оноос ажилласан.

### 60 дугаар чиглэл

#### Ховд аймаг дотор

**Зорих гол үзмэр.** Монгол Алтайн их уулс, түүний даваа, ам хавцал, ховор амьтан ургамал.

---

Ховдод Улаанбаатараас онгоцоор очно. /3 цаг/

**Аялах зам.** Хойд чиглэл, Ховд хот-Буянт голыг уруудаж Буянт сум 25 км-Ховд голыг гарч Мянгад сум 16 км-Хар-Ус нуурын эргээр Дөргөн сум 61 км-буцаад Мянгад сум 61 км-Эрдэнэбүрэн сум 92 км-Ховд сум 45 км-Ховд хот 32 км.

Замын урт 400 км, хугацаа 2-3 хоног

### Үзэх гол зүйлийн товч тайлбар:




**1. Ховд хот** бол Манжийн дарангуйлалын үед тэдний нэг гол түшиц газар байв. Одоо хэрэм бэхлэлтийн ором нь "Сангийн хэрэм" нэрээр байгаа. /6.183/

Ховд нутаг бол Монголын их эх оронч Ойрадын хаан Галданбошигт мөн Амарсанаа нарын уугуул нутаг. Ховд хот Ямаат Улаан /д.т.д 2077 м өндөр/ гэдэг Нүцгэн улаан буурал боржин чулуу уулын өвөрт орших бөгөөд энэ ууланд янгир бий. Урд Ямаат Улаан уулын өвөрт хаданд Дуслын рашаан гэж рашаан бий. Хойноос нь Ховд хот ороход онгоц Хойд Урд Ямаат уулын хоорондуур Буянт голын хавцлаар өнгөрөхөд хоёр Ямаат ууланд янгир онгоцтой зэрэгцэн яваа нь сонин сайхан харагддаг.

**2. Буянт гол.** Монгол Алтайн нуруунаас эх авч 195 км урсаад Ховд голд нийлнэ. Буянт гол гэсэн сайхан дуу бий.

**3. Ховд гол.** Монгол Алтайн Таванбогд уулын мөнх цаснаас эх авч 516 км урсаад Хар-Ус нуурт цутгана. Цагаан гол, Сагсай зэрэг олон голуудыг нийлүүлж авдаг, уулын ус ихтэй том гол, Алтайн шар загас, хадран зэрэг загас элбэгтэй. Хөндийгөөрөө шугуй ихтэй, ялангуяа Ховд, Баян-Өлгийн зааг нутагт чацарганы шугуй ихтэй. Ховд голд заарт харх бий бөгөөд Булган голын минжийг тавьсан нь нутагших төлөвтэй байна. Ховд голын эрэг дээр Мянгад сум оршдог. Энд мянгад ястан амьдардаг.

Ховд аймгийн нутгийн зураг



Масштаб: 1 см-т 40 км





2000 оны хүн амын тооллогоор манайд 6100 ячнгад ястан хүн байжээ.

**4. Хар Ус нуур.** II бүлгийн 19-ийг үз. Хар-Ус нуураас урсаж Хар нуурт цутгадаг Чонохарайх голын 6-7 км үргэлжлэх хавцал дээр усан цахилгаан станц барьж байна. Энд усанд нь хун өвөлждөг.

**5. Цамбагарав уул.** Ховд, Баян-Өлгий аймгийн нутгийн зааг дээр оршдог мөнх цаст том уул. Гурванцаст уул ч гэж нэрлэдэг. Өндөр нь 4195 м, энэ ууланд алмас /хүн гөрөөс/ байна гэсэн үлэмж үнэмшилтэй мэдээ 1991 оны "Шинжлэх ухаан амьдрал" сэтгүүл. /№ 1/ - д нийтлэгдсэн. Товч тайлбар II бүлгийн 25-д бий. Мөн энэ ууланд Нирун улсын хүнд морин цэргийг дүрсэлсэн хадны зургууд бий. (6.62) Эрдэнэбүрэн сум бол Ойрдын их хаан Галданбошигтын уугуул нутаг. Энд өөлд ястан амьдардаг. 2000 оны хүн амын тооллогоор манайд 15000 шахам Өөлд ястан хүн байжээ.

**6. Ховд сум.** Ховд суманд бол казак үндэстний амьдралтай танилцаж болно.

**7. Ховд сумын** төвөөс урагш ойрхон Сөрт гэдэг газар орших дүрс, тэмдэг бүхий хөшөөг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /6.116/

**8. Ховд хотоос Өлгий** хот орох замд Ховд Баян-Өлгийн хил дээр Хонгор Өлөнгийн давааг давж Баян-Өлгийн нутагт ороод 2584 м Хашаатын давааг давна. Энэ хоёр даваа нь Хөхсэрхийн нуруу Цамбагарав хоёрын хоорондох эдгээр уулсын салбар нурууг давах даваа юм.

**Мянганы зам:** Завхан-Тээлийн бэлчирээс Дөргөн-Мянгад сумдаар дамжин өнгөрч энэ даваагаар давна. Энэ замд Шургийн ба Хонгио голын гүүрээр гарна.

**Өөр замд шилжих.**

**1. Увс аймагт**

- Мянгадаас Өлгий сум 86 км
  - Дөргөнөөс Завхан сум 80 км
-

**2. Баян-Өлгийн замд:**

- Эрдэнэбүрэнгээс Баяннуур сум 60 км
- Ховд хотоос Өлгий хот 211 км

**3. Завханы замд шилжихийг 58 дугаар чиглэлээс үз.**

**61 дүгээр чиглэл**

**Ховд аймгийн урд чиглэл**

**Аялах зам.** Ховд хот-урагшаа Өлийн ба Шивэрийн давааг давж Дуут сум 76 км-Цагаан Бургасны голоор уруудаж /Бороотой, үертэй үед явж болохгүй/ Цэнхэрийн агуйг дайрч Манхан сум /шуудаар 90 км/ тойруугаар 156 км-урагшаа Ботгон хавцлыг дамжиж Мөнххайрхан сум 75 км-Алтайн гол нурууг Бага Улаан /д.т.д 2845 м/ өндөр даваагаар давж, Бодонч голыг гаталж, 2945 м өндөр Их Улаан давааг давж Үенч голын хавцлыг уруудаж Булган сум 250 км-Үенч сум 44 км-Алтай сум 36 км-Бодончийн голыг өгсөж Монгол Алтайн гол нурууг алдарт Даянпангийн даваагаар /д.т.д 2305 м өндөр/ давж Бөөрийн голыг уруудан Мөст сум 203 км-зүүн тийшээ Цэцэг сум 41 км-Мөст сум 41 км-Манхан сум 100 км-Манхны талаар явж Ховд хот 80 км. Энэ зам бол Алтайн их уулсаар аялах зам юм.

Замын урт 1290 км, хугацаа 8-9 хоног.

**Ховд аймаг** бол манай орны казак үндэстэн, захчин, урианхай, торгууд, өөлд, мянгад гэхчлэн олон ястан амьдардаг аймаг учраас тэдгээрийн амьдрал ахуйтай танилцаж болох юм.

**Үзэх гол зүйлийн товч тайлбар:**

**1. Нэвтийн рашаан.** Дуут сумын төвөөс / 1 бүлгийн МОГ 12-д үз/ зүүн хойш уулын давчуу амаар урсах Цагаан Бургасны голын хавцалд оршино. Энэ рашаан гидрокарбонат, кальци, магнийн найрлагатай юм. /20.435/ Дуут суманд урианхай ястан амьдардаг.


**2. Манханы тал.** II бүлгийн 36-г үз.



**3. Хойд Цэнхэрийн агуй.**  
Манхан сумын нутагт сумын төвөөс баруун тийш 25 км-т Хойд Цэнхэрийн голын баруун гарын уулын баруун хажууд Өлийн аманд нилээд дээр голын эрэг талруугаа баруун хойшоо харсан амтай 220 м урт хонгил бүхий агуй. Энэ агуйн дотор хад чулуу ихтэй учир нэвтэрч явахад тийм хялбар биш юм.

Энэ агуйд МЭӨ 20-15 мянган жилийн өмнө буюу хуучин чулуун зэвсгийн үед хүн амьдарч байсан гэж эрдэмтэд баталсан. Энэ агуйн 20-иод метр өндөр тааз ханаар нь янгир, тэмээн хяруул, жигүүртэн шувуудын сүг зураг, их байдаг юм.

Хуучин чулуун зэвсгийн үеийн хадны зураг европд байдаг боловч Хойд Цэнхэрийн агуйн хадны энэ зураг нь Ази тивийн хувьд хуучин чулуун зэвсгийн үеийн цорын ганц дурсгал учраас монгол, ази төдийгүй дэлхийн хуучин чулуун зэвсгийн үеийн хүн төрөлхтний түүх соёлыг судлахад үнэлж баршгүй дурсгал юм гэж ЮНЕСКО үнэлэн "Дэлхийн гайхамшигт үнэт зүйл болох нь" гэдэг зэрэглэлээр 1996 онд дэлхийн соёлын өв гэж бүртгэн авсан бөгөөд манай улс энэ агуйг түүх соёлын дурсгалынх нь хувьд 1971 оноос улсын хамгаалалтад авчээ. (6.58) Агуйн дэргэд "Гурван цэнхэр" гэдэг жуулчны бааз ажилладаг.



**4. Мөн Манхан сумын** нутаг Тахилтын хотгорт хүннүгийн язгууртны булш бий. Үүнийг 1998 онд улсын хамгаалалтад авчээ.

**5. Манхан сумын төвийн дэргэд** Ишгэн толгойн хаданд мал амьтны дүрсийг өвөрмөц аргаар дүрсэлсэн зураг бий. Мөн энд Цэнхэрийн гол дээр усан цахилгаан станц барьсан

**6. Ботгоны хавцал.** Алтайн салбар уулыг хойноос нь давахад хуурай Цэнхэр голын баруун гарын цутгал Ботгоны голыг өгсөх хавцал, Энэ хавцлыг өгсөж д.т.д 2846 өндөр Согоотын Хөтөл, мөн Тавтын хөтөлд ирнэ.

**7. Мөнххайрхан уул.** Монгол Алтайн гол нурууны хэсэг. Баруун хойноосоо зүүн урагшаа 100 км үргэлжилсэн их нуруу. Энд 200 гаруй ам км талбайг эзэлсэн мөнх цас, мөсөн голтой. Оргил нь Таванхумст уул д.т.д 4205 м өндөр.



**8. Мөнххайрхан сумын нутаг** Долоон нуурын Улаан толгойд орших эртний бичээсийг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. Долоон нуур нь өөрөө үзэсгэлэнтэй байгальтай нутаг. Энэ нутагт урианхай ястан амьдардаг. Энд Цэнхэрийн гол дээр усан цахилгаан станц барьсан.

**9. Улаан даваа.** Монгол Алтайн гол нурууг Мөнххайрхан уулын зүүгээр давах их даваа Монгол Алтайн гол нурууг давах Бага Улаан давааг нь д.т.д 2845 м өндөр. Бага Улаан давааг даваад Бодонч голын эх рүү орж уруудаад голоо огтлон өгсөж Монгол Ултайн салбар

уулыг давах Их Улаан давааг /д.т.д 2945 м өндөр/ давна. Энэ даваа бол Монголын хамгийн өндөр даваа юм. Тэгээд Үенчийн хавцал руу орно. Энэ бол мөн нэртэй хавцлын нэг. Энд усан цахилгаан станц барих санал бий.

**10. Харуул овоо.** Үенч сумын нутагт д.т.д 1941 өндөрт зориуд босгосон том овоо. Булган сумын төвөөс харагдана. Энэ овоо нь Булган голын торгууд ястны босгосон 13 овооны нэг. 100 м орчим өндөр эгц хадан



хясаан дээр хавтгай занар чулууг шавраар нааж эвлүүлж зүйж модон шургаагаар бэхлэн босгосон 25 орчим м өндөр овоо. /6.236/ Овооны суурийн голч нь 50 орчим метр. Харуул овоог аймгийн хамгаалалтад авчээ. Булган, суманд торгууд ястан амьдардаг. 2000 оны хүн амын тооллогоор манайд 13 мян шахам Торгууд ястан байжээ.

Булган сумын Булган голын хөвөөнд Хятад улс руу гарах хилийн **Ярант** гарц бий.

**11. Булган гол.** II бүлгийн 40-ийг үз.

**12. Үенч гол.** Мөнххайрхан уулаас эх авч урагшаа их хавцал үүсгэн 150-иад км урсаж Баруунхуурайн хотгорт орж ширгэдэг гол.

**13. Бодонч гол.** Мөнххайрхан уулын хажуугаас эх авч мөн их хавцал үүсгэн урагшаа 180 –аад км урсаад мөн хотгорт ирж ширгэдэг гол. Бодонч голын савд Алтай сумын нутагт Ямаан-Усны булаг занар чулуун өндөр хясаанд МЭӨ 3000-1000 жилийн үеийн хадны зураг бий. Үүнийг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /6.66/



**14. Баруунхуурайн хотгор.** Алтайн өвөр говь, алдарт Зүүнгарын говийн хэсэг. Дотроо Борцонж, Ёлхоны, Хонин Усны зэрэг олон нэртэй говиуд бий. Зүүн хэсэг нь Говийн их дархан газрын“Б” хэсгийн баруун зах болдог. Энд Алтай, Үенч, Манхан зэрэг мөст, цэцэг сумдад захчин ястан амьдардаг. 2000 оны хүн амын тооллогоор манайд Захчин ястан 30 000 шахам байжээ.

**Байтагбогдод** Хятад улс руу гарах хилийн гарц бий.

**15. Хятадын нутаг** дахь овоогийн Цитай /Цонж/ хотоос зүүн хойшоо явж Байтагбогдын зүүгээр орж ирж Ховдын Булган сумаар дайрч Булган голыг өгсөж явсаар Ховд хотод ирж байсан хуучин зам бий. Энэ зам эртний торгон замын нэг салаа байсан байж болох юм.

**16. Алтайн нурууг** Ангирт голыг өгсөж д.т.д 2305 м өндөр Даянпангийн даваагаар давна. Энэ даваа МНТ-ын Арайн даваа мөн байх /1.36/ гэж үздэг.

**17. Мөст сумын** нутаг Бодончийн гол, Баянзүрх гэдэг газруудад орших хиргисүүр, буган хөшөөний цогцолбор, чулуун зэвсгийн үеийн бууцуудыг 1998 онд улсын хамгаалалтад авчээ.

**18. Цэцэг сум.** Энэ суман дээрээс Сутай уулыг харна. Эндээс Дэтэгийн даваагаар давахад энэ ууланд ойртож харна. Энэ суман дээр Ард Аюушийн музей, хөшөөг үзнэ. Ард Аюуш бол 1905 онд манжийн бурангуй ёсыг эсэргүүцсэн ардын хөдөлгөөнийг удирдан зохион байгуулсан түүхэн баатарлаг үйл явдалтай жирийн ард хүн.

**19. Цэцэг сумын** нутаг Халиуны хөтөл гэдэг газар орших хүн чулууг 1998 онд улсын хамгаалалтад авчээ.

**20. Мянган угалзат уул.** II бүлгийн 28-ыг үз.

**Өөр замд шилжих**

**1. Цэцэг сумаас** Дэтэгийн даваагаар давж Дарви сум 103 км

**2. Говь-Алтайн замд**

- Алтай сумаас Говь-Алтайн Биж-Алтай 105 км

- Цэцэг сумаас Төнхил сум 80 км

**3. Баян-Өлгийн замд** шилжихийг 67-р замаас үз

---

## **62 дугаар чиглэл**

### **Ховд аймгийн зүүн-зүүн урд чиглэл**

**Аялах зам А.** Ховд хот-Чандмань сум 146 км-Зэрэг сум 111 км-Дарви 64 км. Ховд 205 км,

Бүгд 530 км.

**Б.** Цэцэг сумаас хойшоо Алтайн нурууны салбар уулсыг Дэтэгийн даваагаар давж Хөшөөтийн голыг уруудаж Дарви сум 103 км-баруун тийш Зэрэг сум 64 км-хойшоо Хөтөлийн давааг давж Чандмань сум 111 км-Ховд хот 146 км.

Бүгд 430 км гэсэн зам байж болно.

### **Үзэх гол зүйлийн товч тайлбар:**

**1. Хар-Ус нуур.** Түүний зэгсэн шугуй шагшуургыг үзнэ. Өвөл мөсөн дээгүүр нь явахад энэ шагшуургад тэмээн сүрэг харагдахгүй байдаг.

**2. Чандмань сум** бол манай сайн хөөмийчдийн уугуул нутаг. Бараг хүн бүр хөөмийдэнэ. Энд халхчууд амьдарна.

**3. Хомын хоолой.** Чандмань сумаас зүүн хойшоо 55 км яваад Хомын хоолойд очно. Хар нуур, Хомын хоолой, Дөргөн нуур нь ховор амьтан ургамал ихтэй сонин нутаг. Энд ховор жигүүртэн их цуглардаг. Зарим жил гангар хун өвөлждөг.

4. 80-аад оны үед Хомын хоолойд Дорнод аймгаас нутагшуулахаар цагаан зээрийн янзага аваачиж тавьсан бөгөөд одоо Чандманы Хүрэн тал. Хомын хоолой зээртэй болж зээрийн сүрэг Жаргалантхайрхан уулын араар үзэгдэх болж өсөж байгаа юм.

**5. Дарви сумаас** Чандмань болон Ховд хот орох замд говь тал нутгийн байгальтай танилцаж ховор ан амьтан үзэж болно.

**6. Манхны талын** тухай II бүлгийн 30-ыг үз.


### **Өөр замд шилжих**

1. Говь-Алтайн замд шилжихийг 41 ба 44 дүгээр чиглэлээс үз.

2. Завханы замд шилжихийг 58 дугаар чиглэлээс үз

---

## Увс аймаг



**Увс аймаг.** 69. 6 мян амт км нутагтай 85.8 мян хүн амтай. Аймгийн төв Улаангом хот нь Увс нуурын хотгорын баруун урд захад д.т.д 939 м өндөрт Улаанбаатараас 1425 км зайтай оршино. Увс аймаг нь манай орны баруун захад

Хархираа, Түргэн, Цагааншувуут, Ханхөхийн том уулс, Увс нуурын их хонхорыг эзлэн оршино. Хамгийн өндөр уул нь 4037 м өндөр Хархираа юм. Аймгийн нутагт давс, нүүрсний нөөц их бий. Улаангом хотын агаарын жилийн дундаж температур нь  $-37^{\circ}\text{C}$ , 1 сарынх  $-33^{\circ}\text{C}$ , ҮII сарынх  $19.2^{\circ}\text{C}$  Улаангом, ер нь Увс нуурын хөндий нь манай орны хамгийн хүйтэн өвөл болдог нутгийн нэг юм. Жилд 138.8 мм тунадас унадаг. Агаарын даралт 1 сард 933, 9 гПа, ҮII сард 901, 7 гПа байдаг. Улаангомд агаарын даралт 1055 гПа хүрдэг нь дэлхийн хамгийн их даралтын төв болдог. Энэ тухай 1 бүлэгт МОГ-д үз. Улаангомдын салхины жилийн дундаж хурд 1, 4 м/с бөгөөд хамгийн их салхитай Ү сард 2, 3 м/с хурдтай байдаг.

Аймгийн нутгаар Тэс, Нарийн зэрэг том голууд урсдаг. Увс, Хяргас, Үүрэг, Ачит зэрэг том нуур, булаг рашаан бий. Увс аймаг нь уулын ба говь цөлийн амьтан ургамалтай.

Увс аймаг 1.4 сая малтай, малын дотор хонь, ямаа зонхилдог ба нутгийн зүүн хэсэгт газар тариалан хөгжүүлсэн.

Хилийн боомт Боршоо газар болон хилийн түр боомт Тэсээр ОХУ-руу гарч болно.


### Улаангомд очих зам

**1. Улаанбаатар-Ховд** хот 1425 км-Буянт сум 25 км-Мянгад сум 16 км-Өлгий сум 86 км-Улаангом 111 км,

Бүгд 1670 км

**2. Улаанбаатар Завханы Тосонцэнгэл 803 км-**

Увс аймгийн нутгийн зураг



Масштаб: 1 см-т 36 км



Нөмрөг сум 107 км-Сонгино сум 80 км-Увсын Наранбулаг сум 260 км-Улаангом 90 км,

Бүгд 1340 км.

**3. Улаанбаатар-Мөрөн хот** 671 км-Цагаан-Уул сум 131 км, Цэцэрлэг сум 78 км-Завханы Тэс сум 161 км-Увсын Баруунтуруун 122 км-Зүүнговь сум 54 км-Улаангом 134 км,

Бүгд 1340 км.

### **63 дугаар чиглэл**

#### **Увс аймгийн зүүн чиглэл**

**Зорих гол үзмэр.** Том уулс, нуур гол ус, говь тал нутаг элс, манх ховор амьтан ургамал. Улаанбаатараас Улаангомд онгоцоор очно. /4 цаг/

#### **Улаангомоос машинаар аялах зам**

**Улаангом-Хархираа** голыг гарч зүүн хойшоо Увс нуураар дамжин Нарийны голыг гаталж Тэс сум 158 км-урагшаа Бөөргийн элсээр явж Зүүнговь сум 54 км-Баруунтуруун 54 км-Хангилцагийн голыг гаталж Цагаанхайрхан сум 53 км-зүүн тийшээ Ханхөхийн нурууг Ихжаргалантын даваагаар давж Өндөрхангай сум 43 км-Зүүнхангай сум 71 км-буцаад Өндөрхангай 71 км-Цагаанхайрхан 43 км-Хяргас 45 км-Малчин сум 78 км-Улаангом 102 км.

Замын урт 720 км, хугацаа 4, 6 хоног

#### **— Үзэх гол зүйлийн товч тайлбар:**

**1. Улаангом хотоос** Түргэн уулын салбар уулсын ард үүссэн байгалийн босоо бүслүүрийг/ Ойн бүсээс дээш орших тагийн бүсийг/ үзэж болно.

**— 2. Чандмань уул.** Улаангом хотын дэргэд орших энэ ууланд МЭӨ VII-VIII зууны /хүрлийн сүүлч/ үеийн 50-иад булш бий. Энэ булшнаас толгойн яс, хэд хэдэн цоорхойтой гавал оджээ. Энэ нь тэр үеийн монголчууд хүний тархинд мэс засал хийж байсныг гэрчилнэ гэж эрдэмтэн Б.Наран үзэж байна. Ер нь Увс аймгийн нутагт Хүн чулуу, булш,



бичигт хад, хөшөө дурсгалын зүйл их олон бий. Улаангом хотын ойролцоо IX зууны үеийн Долоодойн булшны Түрэг, Уйгар бичигт хөшөө бий. /6.68/

### 3. Увс нуур II бүлгийн 9-ыг үз.

✦ **4. Бөөрөгийн элс.** Увс нуурын зүүн талаас зүүн тийшээ үргэлжилсэн /180 орчим км урт, 50 орчим км өргөн/ их элсэн тарамцаг, д.т.д 1000 орчим м өндөрт оршино. Бөөрөгийн элс нь манай орны элсэн тарамцаг дотроос хамгийн их нь буюу 4000 ам км талбайтай элс юм. Өвс ургамлаар бэхлэгдсэн бөөрөг довцогтой элст энэ нутагт өвлийн хахир хатуу цагт олон мянган малтай айлууд өнтэй тавтай өвөлждөг өгөөмөр баян нутаг юм. Харин Бөөрөгийн элсний урд захад оршдог Зүүнговь суманд өвөл их хүйтэн болдог. Энд I сард  $-56.6^{\circ}\text{C}$  хүрч хүйтэрсэн нь манай орны хамгийн хүйтэн болсон явдал юм. Бөөрөгт манхны өндөр нь 70-80 м хүрнэ. Бөөрөгийн зүүн захыг Алтан элс гэж нэрлэнэ. Алтан элс нь Увс нуурын дархан газрын бүрэлдэхүүнд багтдаг.

–**5. Нарийны гол.** Бөөрөгийн элсний хойд захаас эх авч уг элсний хойд захаар нь эмжин 70 орчим км урсаад Увс нуурт очдог гол. Элсэн гулдралаар урсах учраас машинаар туулан гарахад маш болгоомжтой зогсолтгүй явж гарна. Бид нэгэн цуваа энэ голоор гарахад хүч алдан зогсоход машинаа яах ийхийн аргагүй элсэнд шигдэж бид өөр машинаар чирүүлж байж гарч билээ. хэрэв чиргүүлгүй бол 1 цаг болоход л машин нолын элсэнд далд ордог гэсэн. Энд эмчилгээний шавартай Буулт нуур бий.

✦ **6. Бөөрөгийн элсний** хойд зах нь дэлхийн хамгийн хойшоо түрж орсон их талбайтай Манхт элс билээ. I бүлгийн б. МОГ-д үз.

✦ **7. Увс аймгийн** зүүн талын Хяргас, Зүүнговь, Тэс, Малчин зэрэг сумдад баяд ястан амьдардаг. 2000 оны хүн амын тооллогоор манайд Баяд ястан 51000 хүн байжээ.

✦ **8. Тэсийн гол.** Тэсийн гол нь Хөвсгөл Завхан аймгийн нутгийн заагт орших Булнайн нурууны араас эх авч 568 км урсаад Увс нуурт цутгадаг том гол. Хөндийд нь

чацарганын их шугуй бий. Тэсийн голын адаг нь Увс нуурын дархан газрын бүрэлдүүнд II бүлгийн 9-ийг үз.

Тэс сумын нутагт ОХУ-руу гарах Тэс хилийн гарц юм.

**9. Ханхөхий уул.** II бүлгийн 24-ийг үз.

**10. Баруунтуруун сумын** Харцагаан Ус гэдэг газар Түрэг бичээст хөшөө, мөн энэ хавийн сумдын нутагт хүн чулуун хөшөөнүүд олон бий. /6, 56/

**11. Газрын хагархай.** Өндөрхангай, Зүүнхангай сумдын хоорондох замд тааралдана. Тайлбарыг I бүлгийн МОГ-ээс үз.

**12. Өндөрхангай сумын** төв дундуур урсах Чигжээн голыг боож усан цахилгаан станц барьсан.

**13. Зүүнхангай сумын** нутаг Зураагийн Улаанхадны зургийг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /6, 40/

**14. Зүүнхангай сумын** нутагт 30 м урт Агартагийн агуй бий.

**Өөр замд шилжих**

**1. Завханы замд** шилжихийг 59 дүгээр чиглэлээс үз.

**64 дүгээр чиглэл**

**Увс аймгийн урд чиглэл**

**Аялах зам.** Улаангом-урагшаа Хархираа голыг гаталж Тариалан сум 31 км-Наранбулаг сум 80 км-Хяргас нуур /Хартэрмэсийн рашаан/ 22 км-Хяргас, Айраг нуурын хоорондохь Хоолойн базаар дайрч Завхан сум 90 км-баруун тийш Өлгий сум 83 км-Хар-Ус нуурын хөвөөгөөр явж Орлогын голыг өгсөж Өмнөговь сум 27 км, буцаад Өлгий 27 км-Улаангом 111 км. Замын урт 480 км, хугацаа 3-4

**Үзэх гол зүйлийн товч тайлбар**

**✦ 1. Хархираа.** Түргэн уул. Эдгээр уулууд нь манай мөнх цастай том уулууд юм. Монгол Алтайн салбар уулс гэж тооцогддог Хархираа уул нь д.т.д 4038 м, Түргэн уул нь

3965 м өндөр. Энэ ууланд ховор амьтан ургамал их бий. II бүлгийн 9-ийг үз.

→ **2. Тариалан сумын** нутагт Галданбошигтын ухуулж татуулсан 20 гаруй км урт шуудуу, усан сан байсан газар бий. Тариалан суманд хотон ястан амьдардаг. 2000 оны хүн амын тооллогоор манайд 9000 гаруй Хотон ястан байжээ. Тариалан сумын нутаг Халхайтын дэнжид орших булш, хүн чулуунуудыг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /6.123/

**3. Наранбулаг сум** бол манай алдарт бөх аварга О.Балжиннямын нутаг.

**4. Хяргас нуур.** II бүлгийн 24-ийг үз.

→ **5. Хартэрмэсийн рашаан.** Хяргас нуурын хойд эрэг дээр оршино. Дундад төрмөлийн эриний цэрдийн галавын мөлгөр хөр, элсэн чулуу, хувирмал занар зэрэг тунамал чулуун дотроос ундрэн гарах рашаан Гидрокарбонат-сульфат-магни кальцийн найрлагатай. /20.451/

**6. Завхан гол.** тайлбарыг 44 дүгээр чиглэлээс үз. Завхан сумын нутагт Айраг нуурын орчимд адууны зурагтай буган хөшөө бий.

**7. Хар-Ус нуур.** Намирын Хар-Ус нуур ч гэж нэрлэнэ. Өмнөговь сумын нутагт д.т.д 1597 метр өндөрт орших давстай нуур. Хархираа уулын мөнх цаснаас эх авах Орлогын гол ирж цутгана.

**8. Өмнөговь сумын** нутаг Алтанхөхий уулын 2900 м өндөр Хилэнцэт ууланд 1998 оны XII сард уулын оройн нуралт болж, 100-250 м өргөн талбайн хөрс чулуу шороо уруугаа 500-550 м гулсан буужээ. Энд 50 м хүрэх гүн хонхор нүх үүсчээ. Энэ уулын орой нь 700с хүрэх эгц хажуу нь нурсан аж. Энэ нуралт Өмнөговь сумын төвөөс баруун урагш 50 орчим км зайтай газарт болжээ.

#### **Өөр замд шилжих**

Ховдын замд шилжихийг 60 дугаар чиглэлээс үз.

## 65 дугаар чиглэл

### Увс аймгийн баруун чиглэл

#### Аялах зам.

**А. Өмнөговь** сумаас буцалгүй баруун чиглэлд нийлж болно. Өмнөговь сум-баруун тийшээ Шаазгай нуурыг дайрч Шивэр голыг гаталж Ховд сум 76 км –Ачит нуурыг хойгуур нь тойрч Алтангадас голыг гатлан Бөхмөрөн сум 120 км-хойшоо Хамар давааг давж Үүрэг нуурыг дайрч Улаандавааг давж Хөндлөн голыг гаталж Түргэн сум 149 км-Улаангом 34 км.

Замын нийт урт 740 км, хугацаа 5-6 хоног

**Б. Улаангом-Түргэн сум** 34 км-Бөхмөрөн сум 149 км-Ховд сум 120 км-Буцаад Улаангом хот 303 км,

Бүгд 610 км. Хугацаа 5 хоног.

#### Үзэх гол зүйлийн товч тайлбар:

➤ **1. Шаазгай нуур.** Ховд сумын нутагт оршино. Энэ нуур Хужир /буулт/-тай бөгөөд бага зэрэг авч ашигладаг. Эмчилгээний шавартай. Ховд сумын нутагт Шивэр голын Уу-ширэгт 17 м өндөр Гоожуурын хүрхрээ гэж үзэсгэлэнт хүрхрээ бий.

– **2. Ачит нуур.** Манай орны том нуурын нэг. Алтайн уул, Хархираа Түргэн уулын хооронд д.т.д 1464 м өндөрт оршино. 311 ам км талбайтай. Ихсэж байгаа нуур. Алтангадас, Бөхмөрөн зэрэг хэд хэдэн гол ирж цутгана. Усанхоолой гэдэг голоор Ховд голд усаа өгдөг урсгал нуур. Алтайн шар болон монгол хадран загас бий. Усанхоолойн Дэвэл арлыг УТХ-д авсан. Энэ тухай II бүлгийн 44-д үз.

➤ **3. Бөхмөрөн сумын Хөдөөгийн Уушиг** гэдэг газарт эртний Түрэг бичигтэй хөшөө бий. Увс аймгийн баруун, урд ба хойд хэсгийн сумдад дөрвөд ястан амьдардаг. 2000 оны хүн амын тооллогоор манайд 67000 орчим Дөрвөд ястан байжээ.

➤ **4. Үүрэг нуур.** Цагааншувуут, Түргэн уулын хоорондох хонхорт д.т.д 1426 м өндөрт оршдог давстай, тогтмол нуур

237 ам. км талбай эзлэнэ. Орчны байдал нь говирхуу. Гүн нь 42 м хүрнэ.

— **5. Сагил сумын** нутаг Үүрэг нуурын баруун этгээдээс цутгах Цагаанголын аманд орших хадтай хошууг Можоо гэнэ. Энэ хошууны ногоон саарал туяатай хадан дээр аргаль, хүн янгир, тэмээ, нохой, үхэр зэргийн зуран сийлсэн том жижиг зуугаар тоолох зураг бий. Шинэ чулуун зэвсгийн үед холбогдоно гэж үздэг. Энэ дурсгалыг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /6.45/

**6. Улаан даваа.** Манай том давааны нэг. өвлийн цагт ус хальж урсаад мөстөж явахад төвөгтэй болдог. Энэ замд Тариалан суманд хотон, бусад суманд дөрвөд ястны ажил амьдралтай танилцана.

#### **Өөр замд шилжих**

#### **Баян-Өлгийн замд**

- Ховд сумаас Ногооннуур сум 58 км
- Бөхмөрөн сумаас Ногооннуур сум 20 км
- Бөхмөрөн сумаас Цагаануур сум 52 км

#### **66 дугаар чиглэл**

#### **Увс аймгийн хойд чиглэл**

**Аялах зам.** Улаангом-Түргэн сум 34 км-Хөндлөн, Сагил голуудыг огтолж Сагил сум 45 км —зүүн хойшоо Боршоо, Хандгайт, Улиастай голуудыг огтолж Давст сум 100 км-Шүдэн уул 18 км-Давст сумаар дамжин замаараа буцаад Улаангом 137 км

Замын урт 340 км, хугацаа 2-3 хоног

#### **Үзэх гол зүйлийн товч тайлбар:**

**1. Сагил сумын** нутаг Үүрэг нуурын орчимд Можоогийн хадны зургийг улсын хамгаалалтад авсныг 65 дугаар чиглэлд дурдсанаас үз

**2. Сагил сумын** нутагт Хүдэнгийн нүүрсний уурхай бий.

**3. Сагил сумын** Төмөрцорго гэдэг газарт эртний түрэг бичээс бүхий хөшөө бий. /6.228/

**4. Шүдэн уул.** Давст сумын төвөөс зүүн хойш 18 км-т хилийн наахна Давст уулын баруун талд залган оршино. Шүдэн уул бол давсны асар их баялагтай, тэр аяараа цул жамц давсан уул юм. Энэ уулын энгэрт геологчид доош нь 300 м гүн өрөмдөхөд давсны цулыг нэвтлээгүй гэнэ. Лав л 50 сая тонн давсны нөөцтэй гэж тооцоолжээ. Давс ашиглаж байгаа хонхорт орж үзэхэд хонхорын хойд эргийн давсан цул нь хурц хутгаар үсээд авчихсан мэт өө сэвгүй тэгш, эгц цавчим тунгалаг 10-аад өндөр хана мөс мэт хөхрөн цэнхэртэн харагдах нь гайхамшигтай. Энэ бол хад чулуун эрэг биш, цул давсан хана гэж бодоход л ухаанд багтахгүй санагдана. Шүдэн уул үүсэл тогтоцоороо хорвоод хосгүй газрын нэг болох биз. Энэ нутгийнхан чулуун давсаар хоолны таваг хийж чанасан махаа энэ давсан тавгандаа гаргаж огтолсон махаараа давсан тавгаа нэг арчаад идэхэд ходоод гэдсэнд сайн гэдэг ажээ. Давст сум бол Ю.Цэдэнбалын төрсөн нутаг. Түүний музей бий.

**5. Торхлог гол.** Хилийн цаанаас эх авч Шүдэн-уул, Давст уул хоёрын хоорондуур гарч урагшаа 60 орчим км урсаад Увс нуурт ирж цутгадаг гол. Голын адгаараа чацарганы шугуйтай. Иймд Увс нуурын дархан газрын бүрэлдхүүнд орсон.

**6. Давст сумын** нутаг Борнурган гэдэг газар орших 2 ширхэг хүн чулууг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /6.98/

**7. Увс нуурт** баруун хойноос нь цутгадаг Улиастайн голын зүүн хөвөөнд шинэсэн төгөл бий. Говийн бүсэд оршдог Увс нуурын хөвөөнд ийм ойрхон шинэс модон төгөл ургаж байгаа нь байгалийн ховор үзэгдэл билээ.

**8. Хандгайтад** ОХУ-руу гарах Боршоо гэдэг хилийн гарц бий.

**9. Энэ замд** Түргэн, Сагил, Давст сумдад дөрвөд ястан амьдардаг.

**Өөр замд шилжих**

1. Завханы замд шилжих хувилбарыг 59 дүгээр чиглэлээс үзнэ
2. Түргэн сумаас Бөхмөрөнд очих замд орж болно



## Баян-Өлгий аймаг

**Баян-Өлгий аймаг.** 45.7 мян ам км нутагтай 96.9 мян хүн амтай. Хүн амын ихэнх нь казак үндэстэн. Манайд 2000 оны хүн амын тооллогоор 103000 гаруй Казак үндэстэн байжээ. Аймгийн төв Өлгий хот нь Ховд голын хөндийд



д.т.д. 1710 м өндөрт Улаанбаатараас 1636 км зайтай, з.у 90 грдусын голдожид оршино. Аймгийн нутаг нь манай улсын хамгийн баруун захад Монгол Алтайн их уулсад оршино. Энд Монгол орны хамгийн өндөр /4000 гаруй м/ мөнх цаст уулуудад мөсөн голууд бий. Өлгий хотод агаарын жилийн дундаж температур нь  $-0.2^{\circ}\text{C}$ , I сарынх  $-17.8^{\circ}\text{C}$ , VII сарынх  $14.5^{\circ}\text{C}$ , жилд 113.5 мм тунадас унана. Агаарын даралт I ба VII сард 824 орчим гПа байна. Салхины жилийн дундаж хурд 2.7 м/с, хамгийн их салхитай V сард 3.5 м/с Аймгийн нутгаар Ховд гол урсах бөгөөд Толбо, Ачит зэрэг том нуурууд бий. Уулын хээрийн ургамал голлох бөгөөд Алтайн уулсын дээд биед ой модтой, ан амьтан элбэгтэй.

Баян-Өлгий аймаг 1.2 сая малтай, малын дотор хонь, ямаа олон, Газар тариалан багатай, Ховд голын хөндийд ногоо бага зэрэг тариалдаг. Аймгийн төвд хөнгөн үйлдвэрийн хэд хэдэн салбар ажилладаг.


**Мянганы зам:** Ховдын Мянгадаас Баян-Өлгий аймагт, Хашаат -Бураатын даваа-Өлгий-Цагааннуур-Улаанбайшинт гэж явж гарна.

### Өлгийд очих зам

**1. Улаанбаатар-Ховд хот** 1425 км-Эрдэнэбүрэн сум 61 км-Хонгор Өлөнгийн даваа 118 км-Баян-Өлгийн Бугат сум 90 км-Өлгий хот 5 км, бүгд 1700 км.

**2. Өлгий хотод** Увсаар дамжин очиж болно. Энэ замыг 64, 65, 66 дугаар чиглэлүүдээс үз.

Баян-Өлгий аймгийн нутгийн зураг



Масштаб: 1 см : 33 км



**3. Мянганы зам** Ховдын Мянгад сумаас Өлгийд очно.

Өлгий суманд “Алтай тур” жуулчны бааз ажилладаг.

**67 дугаар чиглэл**

**Баян-Өлгий аймгийн урд чиглэл**

**Зорих гол үзмэр.** Алтайн их уулс, их гол нуур, казак ард түмний амьдрал, ховор ургамал.

Улаанбаатараас Өлгий хотод онгоцоор /4 цаг/ очно.

**Өлгий хотоос машинаар аялна.** Өлгий хот-урагшаа Толбо нуурыг дайрч Толбонуур сум 76 км-урагшаа Бэлийн давааг давж Дэлүүн сум 82 км-урагшаа Ганцмодны голыг гаталж Алтайн гол нуруугаар давж Булган сум 136 км-буцаад Дэлүүн 136 км-Толбонуур сум 82 км-Өмнө голыг гаталж Буянт сум 82 км-Алтай сум 40 км-Өлгий хот 112 км.

**Замын урт 670 км, хугацаа 4-5 хоног**

**Үзэх гол зүйлийн товч тайлбар:**

**1. Монгол Алтайн уулс** II бүлгийн 17-г үз

**2. Толбо нуур.** Монгол Алтайд д.т.д 2080 м өндөрт 185 ам км талбай эзэлж оршдог, уулын цэнгэг тунгалаг уст урсгал нуур. Өргөн нь 10 км гаруй, урт нь 18 км, гүн нь 10 гаруй м хүрнэ. Алтайн шар загас бий.

**3. Мөстлөгийн морен.** Өлгий хотоос Толбо нуур орох замд мөстлөгийн морины бул чулуун дундуур явна.

**4. Хөхсэрхийн нуруу.** II бүлгийн 2-ыг үз

**5. Чигиртэйн рашаан.** Дэлүүн сумаас баруун тийш 50 –аад км-т 2480 м өндөрт орших рашаан Хүхэр, устөрөгч хий, ус нүүрстэс агуулсан халуун рашаан юм. /20.442/

**6. Дэлүүн сумаас** Булган сум орох замд Монгол Алтайн гол нурууг Ганцмодны голыг гаталж д.т.д 2575 м өндөр Хар-Усны даваа, д.т.д 2700 гаруй м өндөр Улаан даваагаар давж Булган голыг уруурдан Булган суманд хүрнэ.

### Өөр замд шилжих

- Булган сумаас Ховдын Булган суманд Булган голыг уруудаж олон дахин ус гарсан 120 орчим км замаар явж очно.

- Булган сумаас Ховдын Дуут суманд мөн ус гол гаталсан олон даваатай уулын замаар мөн 120-иод км явж очно.

- Хятад улс руу гарах хилийн боомт Даян.

### 68 дугаар чиглэл

#### Баян-Өлгий аймгийн баруун чиглэл




**Аялах зам.** Өлгий-Сагсай сум 27 км-Цэнгэл сум 52 км-Улаанхус сум 29 км-Өлгий хот 46 км

Замын урт 160 км,  
хугацаа 1-2 хоног

#### Үзэх гол зүйлийн товч тайлбар:

**1. Монгол Алтайн шинэсэн ой.** Цэнгэл сумын төв дээр Алтайн шинэсэн ойг үзнэ. Цэнгэл сум нь Ховд голын эрэг дээр д.т.д. 2000 орчим м өндөрт оршино. Цэнгэл сум бол Монгол улсад Алтайн урианхайчууд амьдардаг сумын нэг юм. 2000 оны хүн амын тооллогоор манайд Тува ястан 4800 шахам хүн байжээ.



**2. Цагаан гол.** Цэнгэл сумын төвөөс хойш 9 км-т Цагаан гол Ховд голтой нийлнэ. Цагаан гол нь цагаан устай гол юм. Цагаан, Ховд гол хоёр нийлсний дараа 500-аад метр газарт Цагаан голын цагаан ус, Ховд голын хар ус хоёр эрс ялгагдах заагтайгаар урсдаг нь сонин юм. Цагаан гол нь Таванбогд уулын мөнх цаснаас эх авах учраас мөнх цас, мөсөн голын наанги шорооноос болж цагаан устай байдаг.

**3. Цагаан гол** багийн хавьд Дэнжийн Улаан үзүүр, Шартээлийн эх гэдэг газарт эртний буган хөшөөнүүд хиргисүүр бий Үүнийг 1998 онд улсын хамгаалалтад авчээ.

**4. Цэнгэл сумын** нутаг Даян нуурын эрэг Ху-уй гэдэг газар орших хүн чулуунуудыг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /6.102/

**5. Цэнгэл сумын** нутагт он нь тогтоогдоогүй чулуун барималууд олон бий. Цагаан голд карбонат-натри-нүүрс устөрөгч бүхий сайн рашаан бий.

**6. Цэнгэл сумын** нутаг Хар нуурт усан цахилгаан станц барих санал бий

**7. Цагаансалаагийн дурсгал.** Улаанхус сумын нутаг Цагаансалаа буюу Бага-Ойгор голын хадны зураг, уулын өврөөр 15 орчим км-т цувсан 10000 орчим зургаас бүрдэх цогцолбор. Шинэ чулуун зэвсэг, хүрэл зэвсгийн үед холбогдох энэ дурсгал ан агнуурын ажлаас мал аж ахуйд шилжих үеийг дүрсэлсэн. Төв Азид хамгийн баялагт тооцогддог энэ дурсгалыг ЮНЕСКО “Дэлхийн гайхамшигт үнэт зүйл болох нь” гэдэг зэрэглэлээр дэлхийн соёлын өв гэж 1996 онд бүртгэн авсан бөгөөд манай улс 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /6.61/

Энд Хар ямаат голын хөндийд орших хүн чулуун хөшөөг мөн 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /6.57/

**8. Цэнгэл сумаас** Таванбогд ууланд очиж болно.

**9. Сагсай сумын** Сагсайн голд чулуун зэвсгийн арвин



олбор бүхий 12 суурин бий. /6.17/

**Өөр замд шилжих:** /Хойд замд орох/

- Улаанхус сумаас Цагаан нуур сум 110 км

- Сагсай сумаас Буянт 100 км

### **69 дүгээр чиглэл**

#### **Баян-Өлгийн хойд чиглэл**

**Аялах зам.** Өлгий хот-Цагааннуур 69 км Хавцлын голыг уруудаж Ногоонуур сум 52 км-Өлгий хот 92 км.

Замын урт 215 км, хугацаа 1-2 хоног

**Үзэх гол зүйлийн товч тайлбар:**

**1. Ачит нуур.** 65 дугаар чиглэлд тайлбарласныг үз. Ачит нуурын Усанхоолой, Ховд голын Дэвэл арлын тухай II бүлгийн 44-д үз.

**2. Ногоонуур сумын** төв дээр орших хүн чулууг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. /6.110/

**3. Ногооннуур сумын** нутагт Бугын зэл гэдэг газарт эртний сүг зурагтай хөшөө бий. /6.110/

4. Энэ замаас Сийлхэмийн нурууг үзэж болно. II бүлгийн 23

**Өөр замд шилжих**

**1. Цагааннуур нь** ОХУ-руу гарах хилийн байнгын гарц

**2. Ногооннуур** сумаас Увсын Ховд сум 58 км

Мөн Бөхмөрөн сум 20 км

### **70 дугаар чиглэл**

#### **Баян-Өлгий аймгийн зүүн чиглэл**

**Аялах зам.** Өлгий хот-Бугат сум 5 км-Хатуугийн гол Хавцлын голыг гаталж Алтанцөгц сум 38 км-Баяннуур сум 63 км-Өлгий 106 км

Замын урт 212 км, хугацаа 2-3 хоног

**Үзэх гол зүйлийн товч танилцуулга**

**1. Бугат сумын** Хатуугийн голд Мөндөш ууланд эртний сүг зурагтай хөшөө бий

**2. Бугат сумын** Эрээн Харганат гэдэг газар орших. Түрэг бичээс бүхий хөшөө чулууг 1998 онд улсын хамгаалалтад авчээ/6.243/

**3. Ховд гол** 60 дугаар чиглэлээс үз

**4. Баяннуур.** Алтанцөгц суманд Ховд гол хөндийд нэн ховор гургуул шувуу амьдардаг

**5. Дэвэл аралд** гургуул амьдардаг учраас 2000 онд улсын тусгай хамгаалалтад авсан. Энэ тухай II бүлгийн 44-д үз

**6. Баяннуур сумын** Цагаан Хөшөөт гэдэг газар орших Түрэгийн үеийн хөшөөг 1998 онд улсын хамгаалалтад авчээ. (6.130)

7. Энэ замаас II бүлгийн 25-д дурьдсан Цамбагарав ууланд очиж болно.

#### **Өөр замд шилжих**

**1. Ховдын замд** шилжихийг 60 дугаар чиглэлээс үз



**Хавсралт № 1**

**Сэдэвчилсэн аялалын зам**

**Агуйн аялал**

- Архангай аймаг 18-р чиглэл, Хорго II бүлгийн 16
- Дундговь аймаг 21, 22-р чиглэл
- Өмнөговь аймаг 24-р чиглэл
- Сүхбаатар аймаг 33-р чиглэл
- Дорноговь аймаг 37-р чиглэл
- Баянхонгор аймаг 38, 39 –р чиглэл
- Хөвсгөл аймаг 54-р чиглэл
- Завхан аймаг 58-р чиглэл
- Ховд аймаг 61-р чиглэл
- Увс аймаг 63-р чиглэл

**Бөхөн үзэх.** Говь-Алтай аймаг 41 –р чиглэл, II бүлэг 30

**Тахь үзэх.** Хустайн нуруу II. 21, Төв аймаг 12-р чиглэл, Говь-Алтайн Тонхил үүр сумаас 44-р чиглэл Бижийн талд тахь үзнэ.

**Хулан үзэх.** Өмнөговь аймаг 24-р чиглэл, Дорноговь аймаг 36-р чиглэл, II бүлэг 11,

**Мазаалай, Хавтгай үзэх.** II бүлгийн 3, Говийн их дархан газар. Баянхонгор аймаг 38-р чиглэл, Говь-Алтай аймаг 42-р чиглэл

**Цагаан зээр үзэх.** Дорнод Сүхбаатар аймаг 31, 33-р чиглэл. II бүлэг 7

**Том даваа үзэх**

- Баян, Босготэнгэрийн, Хангайн, Их ганга-Төв аймаг 8, 13, 26-р чиглэл
- Солонгот, Ороох –Архангай-18-р чиглэл
- Цагаан-Архангай-Булган уул II бүлэг 49
- Цагаанбургас, Тоом, Өл-Хөвсгөл 51, 53-р чиглэл
- Халзансогоот, Ганц, Загастай-Завхан 52, 56, 59-р чиглэл
- Их–Улаан, Бага Улаан, Даянпан, Хонгор Өлөн-Ховд, Бураат-Хашаат 60, 61-р чиглэл
- Дөт, Цагаанхөтөл, Шархөтөл, Жаргалант, Бааран-Говь-Алтай 41, 42-р чиглэл

**Үлэг гүрвэлийн олбортой газар.**

- Нэмэгт уул, Баянзаг-Өмнөговь 23-р чиглэл
- Хэрмэнцав, Нарандаац, Төгрөгийн ширээ-Өмнөговь 26-р чиглэл
- Ногоон цав, Баянхонгор, 38-р чиглэл

**Баянбүрд үзэх**

- Зулганай-Өмнөговь 26-р чиглэл
  - Хонгорын гол-Өмнөговь 23- р чиглэл
  - Зуунмод, Эхийн гол-Баянхонгор 38-р чиглэл
  - Ганга, Дагшин нуур-Сүхбаатар 33-р чиглэл
-

- Захуй, Алаг нуур-Говь-Алтай 41-р чиглэл
- Эрээн нуур, Ажиг нуур-Говь-Алтай 44-р чиглэл
- Сүм Хөхбүрд-Дундговь 20-р чиглэл

**Намаг, усны шувуу ажиглах**

- Өгий нуур, Тэрхийн цагаан нуур-Архангай 18-р чиглэл
- Бөөнцагаан, Орог, Холбоолж нуур-Баянхонгор 38-р чиглэл
- Таацын цагаан нуур-Өвөрхангай 17-р чиглэл
- Хар-Ус нуур –II бүлгийн 19-р зүйл, Ховд 60-р чиглэл
- Айраг нуур-II бүлгийн 24-р зүйл, Завхан 58-р чиглэл
- Монгол дагуур-II бүлгийн 5-р зүйл, Дорнод 32-р чиглэл

**Олон зүйл тогоруу ажиглах**

Дорнод аймаг-Монгол дагуурын дархан цаазат газар II бүлгийн 5-р зүйл, 32-р чиглэл

**Хээр талын ховор ургамал ажиглах**

Дорнод аймаг 31-р чиглэл, Монголын Дорнодын тал II бүлгийн 7-р зүйл

**Уулын босоо бүслүүр, мөнх цас, мөсөн гол үзэх**

- Хархираа, Түргэн уул-Увс аймаг 63-р чиглэл
- Асралхайрхан-Төв аймаг 4-р чиглэл
- Хасагтхайрхан, Сутай-Говь-Алтай аймаг 44-р чиглэл
- Отгонтэнгэр уул-Завхан 56, 57-р чиглэл
- Алтай Таванбогд-Баян-Өлгий 68-р чиглэл

**Их боржин чулуун уулс үзэх аялал**

- Сүхбаатар аймаг 34-р чиглэл. Төрөнгийн чулуунаас эхлэн
- Хэнтий аймгийн 29-р чиглэл,
- Дорноговь аймгийн 36-р чиглэл.
- Дундговь аймгийн 20, 21, 22-р чиглэл,
- Өвөрхангай аймгийн 17-р чиглэлийн зам

**Улсын тусгай хамгаалалттай 50 газраар аялах.** II бүлгээс үзнэ.

**Рашаанд очих зам**

- Жанчивлан, Хундган, Өлзийт, Ихтөхөм, Бөөрөлжүүт, Дэвсэнбулаг, Төв аймаг 7, 9, 11, 27-р чиглэл
- Хужирт, Мойлт, Үүртийн тохой, Хүрэмт, Хүрэнхад, Могойт, Гятруун, Хамрын рашаанууд-Өвөрхангай аймаг 13, 14, 17-р чиглэл
- Гурваннуур, Аварга-Тосон-Хэнтий 27, 28-р чиглэл
- Хадат, Нэмэгт-Өмнөговь 23, 26-р чиглэл
- Эрээнтолгой, Талбулаг, Далайбулаг-Сүхбаатар 33, 34, 35-р чиглэл
- Барьхамбын рашаан, Дундговь 21-р чиглэл
- Хөхсүм, Цэнхэр Архангай 18-р чиглэл
- Утаатминчүүр Дорнод 32-р чиглэл
- Далантүрүү, Халзан уул, Бүрдэнэбулаг, Элсэн сувилал-Дорноговь 36, 37, 38-р чиглэл
- Отгонтэнгэр-Завхан 56-р чиглэл
- Шаргалжуут-Баянхонгор 38-р чиглэл

Ш.Шагдар:

Монгол орноор жуулчлах зуун зам

- Таванманх элсэн сувилал-Говь-Алтай 41-р чиглэл
- Нэвт-Ховд 61-р чиглэл
- Дуслын рашаан - Ховд, 60-р чиглэл
- Сайханхульж, Хануй, Номын булгийн рашаан 13, 45, 46-р чиглэл
- Чигэртэй-Баян-Өлгий 67-р чиглэл
- Хартэрмэс-Увс 64-р чиглэл

**Дэлхийн хойд хагасын агаарын даралтын бүс**

- Увс аймаг, Улаангом (МОГ.1)

**Дэлхийн хамгийн хойшоо түрж орсон манхт элсээр аялах**

- Увс аймаг 63-р (Бөөрөг), (ОГ 2)

**Дэлхийн хойд хагасын хамгийн урагшаа түрж орсон ул хөрсний цэвдэг**

- Баянхонгор аймаг 38-р чиглэл (Шаргалжуут орчим), (МОГ.3)

**Дэлхийн усны гурван ай савын хагалбар төв. 7-р чиглэл, (МОГ.5)**

**Унтарсан галт уул үзэх**

- Сүхбаатар аймаг. 33-р чиглэл
- Архангай аймаг 18-р чиглэл II бүлгийн 16
- Баянхонгорын 38, 40-р чиглэл

**Газар хөдлөлийн хагархай (МОГ 6), Баянхонгор 38, Увс 63, Завхан 59, Хөвсгөл 51-р чиглэл, Булганы 45-р чиглэл**

**Их говийн хотгор дамжиж аялах**

- Сүхбаатар аймгийн нутгийн зүүн зах Цагаантэмээт-Суваргын говиос эхлэн баруун урагшаа Дорноговь аймгийн нутгийн дундуур өнгөрч Өмнөговь галбын говьд хүрэх 900 орчим км зам байж болно (Сүхбаатар аймгийн 33-р чиглэлээс эхлэнэ)
- Шаргын говь, Хүйсийн говь, Говь-Алтай 44-р чиглэл

**Элсээр аялах зам**

- Өмнөговь
- Монгол элс
- Хонгорын элс 23-р чиглэл
- Говь-Алтай 44-р чиглэл,
- Бөөрөгийн элс, Увс 63-р чиглэл,
- Борхярын Завхан элс 59-р чиглэл,
- Борхын элс 56-р чиглэл,
- Молцогийн элс, Онгон элс Сүхбаатарын 33,
- Монгол элс Өвөрхангайн 13-р чиглэл,
- Энхийн элс, Таван, Чивчидийн элс Төв аймгийн 12-р чиглэл

## 2 дугаар хавсралт

### ТҮҮХ СОЁЛЫН ЗАРИМ ДУРСГАЛ

#### Чулуун зэвсгийн үеийн зарим дурсгал

- Төв аймгийн 1-р чиглэл
- Их тэнгэр, Гачуурт
- Мойлтын ам-Өвөрхангай 13-р чиглэл
- Мухар булаг-Өвөрхангай 17-р чиглэл
- Тэвш уул-Өвөрхангай 17-р чиглэл.
- Цэнхэр сум
- Архангайн 18-р чиглэл
- Ярх уул-Дундговь 22-р чиглэл
- Баянзаг-Өмнөговь 23-р чиглэл
- Оцон мааньт-Өмнөговь 24-р чиглэл
- Цахиурт-Өмнөговь 26-р чиглэл
- Рашаан хад-Хэнтий 30-р чиглэл
- Тамсаг-Дорнодын 31-р чиглэл
- Устай Бургастай-Сүхбаатар 35-р чиглэл
- Цагаан агуй, Чихэн агуй, Уранхайрхан уул зуух- Баянхонгор 38-р чиглэл
- Дулаан говь-Дорноговь 36-р чиглэл
- Янживийн шил-Завхан 59-р чиглэл
- Хойд Цэнхэрийн агуй-Ховд 61-р чиглэл
- Цагаан салаа-Баян-Өлгий 68-р чиглэл
- Сагсай-Баян-Өлгийн 68-р чиглэл

#### Хүрлийн үеийн дурсгал

- Дэл уулын хадны зураг-Дунговийн 21-р чиглэл
- Рашаант хад-Хэнтийн 30-р чиглэл
- Цохиотын хөшөө-Хөвсгөл 51-р чиглэл
- Дэлгэр мөрөн-Хөвсгөл 51-р чиглэл
- Чандмань уул-Увс 63-р чиглэл
- Гачуурт, Их тэнгэрийн хадны зураг-Төв аймаг 1-р чиглэл (УБ орчим)

#### Хүннүгийн үеийн дурсгал

- Ноён уул Төв аймаг 10-р чиглэл
- Борбулаг, Дуурлиг нарс, Хэнтий 28-р чиглэл
- Дэлгэрхаан уул Сүхбаатар 35-р чиглэл
- Байдлаг гол Төв 27-р чиглэл
- Цагаан гол Говь-Алтай 41-р чиглэл

#### Түрэгийн дурсгал.

- Кулчурийн хөшөө-Төв 9-р чиглэл
- Орхон, Хөшөө цайдам-Архангай 13-р чиглэл
- Увш ахай-Өвөрхангай 17-р чиглэл
- Тоньюкукийн хөшөө-Төв 27-р чиглэл
- Хөд Асгат-Булган 45-р чиглэл



- Мөнгөт хясаа-Завхан 58-р чиглэл
- Авдрант уул-Хөвсгөл 52-р чиглэл
- Хар цагаан ус-Увс 63-р чиглэл
- Эрээнхарганат-Баян-Өлгий 70-р чиглэл
- Бичигтийн бууц-Говь-Алтай 44-р чиглэл

**Уйгарын дурсгал**

- Хар балгас-Архангай 13-р чиглэл
- Байбулаг-Булган 46-р чиглэл
- Троян хааны дурсгал-Архангай 19-р чиглэл

**Нируны дурсгал**

- Өнгөт уул-Төв 11-р чиглэл
- Цамбагарав-Ховд 60-р чиглэл

**Хятаны дурсгал.**

- Байдлаг гол-Төв аймаг 27-р чиглэл
- Харбухын балгас, Чин толгой-Булган 13-р чиглэл
- Хэрлэнбарс хот-Дорнод 32-р чиглэл
- Өглөгчийн хэрэм, Рашаант хад-Хэнтий 30-р чиглэл

**Хүн чулуу үзэх**

- Сүхбаатар аймаг 33, 35-р чиглэл
- Баян-Өлгийн 68, 69,
- Төв 9,
- Хэнтий 28,
- Дорнод 31,
- Говь-Алтай 44,
- Завханы 59,
- Увсын 64, 66,
- Баянхонгорын 40,
- Ховдын 61-р чиглэл

**Эртний торгон замын салаа**

- Өвөрхангай 13-р чиглэл,
- Өмнөговь 25-р чиглэл,
- Говь-Алтай 41-р чиглэл,
- Ховдын 61-р чиглэл

**Хадны сүг зураг.**

- Дундговийн 21,
  - Баян-Өлгийн 68,
  - Төв аймгийн 1,
  - Говь-Алтайн 41,
  - Завханы 58,
  - Өмнөговийн 25,
  - Баянхонгорын 38,
  - Увсын 63, 65,
  - Архангайн 18-р чиглэлүүд
  - Гачуурт, Их тэнгэрийн зураг-Төв аймаг 1-р чиглэл
-

**XIII-зуунаас хойших үеийн дурсгалууд**

Манзушир хийд-Төв аймаг 1-р чиглэл  
Сонгинохайрхан /Дадарт/ уул-УБ 1-р чиглэл  
Зуунмодны төгөл-Төв 2-р чиглэл  
Гүнжийн сүм-Төв 2-р чиглэл  
Цогтын цагаан байшин-Төв 13-р чиглэл  
Цогтын хадны бичээс /Дуутын бичигт хад/-Төв 20-р чиглэл  
Эрдэнэзуу-Өвөрхангай 13-р чиглэл  
Хархорум-Өвөрхангай 13-р чиглэл  
Шанхын хийд-Өвөрхангай 13-р чиглэл  
Төвхөн хийд-Өвөрхангай 16-р чиглэл  
Ширээт цагаан нуур-Өвөрхангай 16-р чиглэл  
Хувилайн цэргийн хот /Сүрийг бадруулагч хотын туурь, Хөгшин тээл/-Өвөрхангай 17-р чиглэл  
Сангийн далай хийд-Дундговь 21-р чиглэл  
Онгийн хийд-Дундговь 21-р чиглэл  
Үнстийн хийд-Дундговь 21-р чиглэл

**Манжийн ноёрхлын үеийн суурь өртөө, түүний төв, Сайр-Ус-Дундговь 21-р чиглэл**

Галбын гурван хийд-Өмнөговь 24-р чиглэл  
Бэрээвэн хийд-Хэнтий 30-р чиглэл  
Биндэр овоо-Хэнтий 30-р чиглэл  
Өглөгчийн хэрэм-Хэнтийн 30-р чиглэл

**Эзэн Чингисийн өлгий нутаг, Монголын нууц товчооны газрууд**

- Хэнтий аймгийн 27, 28, 29, 30-р чиглэл
- Төв аймгийн 1, 8-р чиглэл
- Дорнод аймгийн 31, 37-р чиглэл
- Сэлэнгэ аймгийн 48-р чиглэл
- Булган аймгийн 45-р чиглэл
- Баянхонгор аймгийн 39-р чиглэл
- Ховд аймгийн 61-р чиглэл

**Чингисийн далан.**

- Хэнтий аймгийн 28-р чиглэл
- Дорнод аймгийн 32, р чиглэл
- Өмнөговь аймгийн 25-р чиглэл

**Амарбаясгалант хийд**

- Сэлэнгэ аймгийн 49-р чиглэл

**Харуул овоо**

- Ховд аймаг 61-р чиглэл

**3 дугаар хавсралт**

**Монголын ястан угсаатны амьдралтай танилцах.**

**Баяд ард түмний** ажил амьдралтай танилцах  
Увс аймаг 63-р чиглэл

**Дөрвөд ард түмний** амьдралтай танилцах  
Увс аймгийн 65-р чиглэл

**Мянгад ард түмний** амьдралтай танилцах  
Ховд аймаг 60-р чиглэл

**Урианхай ард түмний** амьдралтай танилцах  
Баян-Өлгий аймаг Цэнгэл сум 68-р чиглэл  
Ховд аймаг Дуут сум 60-р чиглэл

**Захчин ард түмний** амьдралтай танилцах  
Ховд аймаг 61-р чиглэл

**Өөлд ард түмний** амьдралтай танилцах  
Ховд аймаг 60-р чиглэл

**Торгууд ард түмний** амьдралтай танилцах  
Ховд аймаг 61-р чиглэл

**Буриад ард түмний** амьдралтай танилцах  
Хөвсгөл 54-р чиглэл,  
Сэлэнгэ 48-р чиглэл,  
Дорнод 32-р чиглэл,  
Хэнтий 28-р чиглэл,  
Булганы 46-р чиглэл,  
Төв Мөнгөнморьт 6-р чиглэл

**Хотгойд ард түмний** амьдралтай танилцах  
Хөвсгөлийн 52-р чиглэл

**Цаатан ард түмний** амьдралтай танилцах  
Хөвсгөл аймаг 53-р чиглэл

**Дархад ард түмний** амьдралтай танилцах  
Хөвсгөл аймгийн 53-р чиглэл

**Казак ард түмний** амьдралтай танилцах  
Баян-Өлгий аймаг, Ховд аймгийн Ховд сум 60-р чиглэл

**Хөөмийн аялгуу сонсох**  
Ховд аймгийн Чанмань сумын 62-р чиглэл

**Монгол ардын уртын дуу сонсох.**  
Дундговь аймаг 20-р чиглэл, Сүхбаатар аймаг 33-р чиглэл

Ш.Шагдар.

Монгол орноор жуулчлах зуун зам

**Уран нугараа үзэх.**

Ховд аймаг Цэцэг сум 61-р чиглэл

**Айрагтай нутгаар аялах**

Булган баруун ба урд зам,  
Өвөрхангай, Дундговийн зам

**Дарьганга ард түмний амьдралтай танилцах, шимийн монгол  
архитай нутгаар аялах**

Сүхбаатар аймгийн урд зүгийн сумд

**Үзэмчин ард түмний амьдралтай танилцах**

Сүхбаатар аймаг, 33-р чиглэл,  
Дорнод аймаг 32-р чиглэл

**Хотон ястны амьдралтай танилцах**

Увс аймгийн 64-р чиглэл

**Халх Монгол үндэстний амьдралтай танилцах**

Монголын бүх замд